

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ISSN: 2313-6170

Түлхүүр үг: Orçuulgazuj

ОРЧУУЛГАЗҮЙ

VI

(Орчуулгын онолын хөгжлийн чиг хандлага)

Эрхлэн хэвлүүлсэн: Г.Элдэв-Очир

Улаанбаатар

2018

DDC
418.02'015
О-497

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ОРЧУУЛГАЗҮЙ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ЦУВРАЛ

№06 (481)

Ариутган хянах зөвлөл

Эрхлэгч:	М.Чимэдцэеэ (доктор, дэд профессор)
Нарийн бичгийн дарга:	Г.Элдэв-Очир (доктор, дэд профессор)
Гишүүд:	Э.Равдан (ШУ-ны доктор, профессор) Го.Аким (доктор, профессор) С.Эрдэнэмаам (доктор, профессор) Л.Чулуунбаатар (доктор, профессор) Г.Буяннэмэх (доктор, профессор) О.Чинбаяр (МОЭ-ийн ерөнхийлөгч) Ш.Эгшиг (доктор, дэд профессор) К.Окада (Токиогийн ГСИС, доктор, профессор) Б.Баярмэнд (ӨМИС-ийн МСС, доктор, профессор) В.В.Мароши (Новосибирскийн УБИС, доктор, профессор) Мари Доминик Эвен (ФҮШУСТөв, доктор, профессор) Хоу Ваньжуан (Бээжингийн их сургуулийн Монгол судлалын төвийн зөвлөх, профессор)

Санаачлагч: МУИС, ШУС, ХУС, Орчуулгазүйн профессоровын хамтлаг

Хянан засварласан:	Г.Элдэв-Очир
Хуудасны хэмжээ:	A4
Хэвлэлийн хуудас:	27.3 хх
Хэвлэсэн тоо:	150 ш
Хэвлэлийн газар:	“Удам соёл” ХХК

ISBN 978-99973-7324-3

NATIONAL UNIVERSITY OF MONGOLIA

ISSN: 2313-6170

Key title: Орчуулгазүж

TRANSLATION STUDIES

VI

Compiled by: G.Eldev-Ochir

Ulaanbaatar

2018

DDC
418.02'015
O-497

NATIONAL UNIVERSITY OF MONGOLIA

TRANSLATION STUDIES

RESEARCH SERIES

№06 (481)

Editor:

Chimedtseye.M (National University of Mongolia, Mongolia)

Secretary:

Eldev-Ochir.G (National University of Mongolia, Mongolia)

Editorial Boards:

Ravdan.E (National University of Mongolia, Mongolia)
Akim.G (Ph.D, Professor, Mongolia)
Erdenemaam.S (Mongolian State University of Education, Mongolia)
Chuluunbaatar.L (National University of Mongolia, Mongolia)
Buyannemekh.G (National University of Mongolia, Mongolia)
Chinbayar.O (President of the Mongolian Translators Union, Mongolia)
Egshig.Sh (National University of Mongolia, Mongolia)
Okada.K (Tokyo University of Foreign Studies, Japan)
Bayarmend.B (Inner Mongolia University, P.R.China)
Maroshi.V.V (Novosibirsk State Pedagogical University, Russia)
Marie-Dominique Even (French National Center for Scientific Research, France)
Hou Wanzhuang (Center of Mongolian studies of Peking University, P.R.China)

Founder:

Professors Team for Translation Studies, Division of Humanities,
School of Arts and Science, National University of Mongolia
Edited by Eldev-Ochir.G

Paper size: A4
Number of pages: 27.3
Number of prints: 150
Press: "Udam soyol" printing company

ISBN 978-99973-7324-3

ГАРЧИГ

Өмнөтгөл үг	7
-------------	---

ОРЧУУЛГЫН ОНОЛЫН АСУУДАЛД

Д.Бүрнээ	Орчуулга ба тользүй	11
С.Дугармаа	Нэр томъёо ба хэрэглээ	18
Ш.Эгшиг	Монголчуудын тогтоосон орчуулгын онол, зарчим	24
Ц.Магсар	Уран зохиолын орчуулгад тавих шаардлага: “Дүйцэл” ба “Нийцэл” ойлголтуудын тухайд	38
Л.Чулуунбаатар	Орчуулгад эх хэлний үүрэг	45
М.Амартайван	Дүрс бичлэгийн орчуулгад анхаарах зарим зүйл	51
Г.Элдэв-Очир	Орчуулгын дүйцлийн тухай асуудалд	66
Б.Нарантуяа	Өвөрмөц хэлцийн орчуулгын асуудалд	70
Б.Удвал	Жулиан Хаусын загвараар орчуулгын чанарыг үнэлэх нь	76
А. Өлзийнаран, Б. Наранчимэг	Монгол хэлэнд илэрч буй неологизм ба түүний орчуулгын асуудалд	87
Ж.Эрдэнэбат	Машины орчуулгын хөгжил ба хэрэглээ	93
Н.Оюунзаяа	Компьютер, мэдээллийн технологитой холбоотой зарим нэр томъёоны орчуулгын асуудалд	99

ОРЧУУЛГЫН ШИНЖИЛГЭЭ

Го.Аким	“Утгын таяг”-ийг тулж “Эрдэмийг цэнгэл болгох”-ын үүдийг нээсэн нь	105
Н.Мөнх	МНТ-д буй зарим нангиад хүний нэрийн франц орчуулга	112

А.Цэрэнчулуун	Монгол, герман хэлний ахуй, соёлын холбогдолтой дүйцэлгүй үг, хэлц үгийн орчуулга	117
М.Чимэдцэеэ	Ц.Базаррагчаагийн орчуулгын урнаар найруулахуйн эрдэм	126
М.Нарангэрэл	Ф.Х.Бөрнэтийн “Нууц цэцэрлэг” зохиолын монгол орчуулгад хийсэн ажиглалт	140
Ж.Ариун	Орчуулгын онол, дадлага хичээлийн хөтөлбөрийн уламжлал, шинэчлэл	147
Б.Энхтүшиг	Томас Майн Ридийн “Морь унасан толгойгүй хүн” Зохиолын орчуулгад найруулгазүйн ажиглалт хийх нь	151

ХАВСРАЛТ

Г.Буяннэмэх	С.Пүрэв “Нялх салхи” өгүүллэгийн франц орчуулга	163
Г.Буяннэмэх	Ч.Лодойдамба “Тунгалаг Тамир” зохиолын франц орчуулга	164
Д.Золбоо	Мо Янь “Эрэгчин” өгүүллэгийн орчуулга /англи хэлнээс/	176
Д.Ундрах, Отгонгэрэл	“Умарш дайлсан хойдох тэмдэглэл” сурвалжийн орчуулга	188
А.Цэрэнчулуун	А.Цэрэнчулуун “Малчны хүү” тэмдэглэлийн герман орчуулга	197
Р.Оргил	Фү Лэй “Захидал” өгүүллэгийн орчуулга /хятад хэлнээс/	217

ӨМНӨТГӨЛ ҮГ

“Орчуулгазүй” сэтгүүл хэвлэгдэн гарч эхэлснээс хойш эдүгээ таван жил өнгөрч, зургаа дахь дугаар маань ийнхүү хэвлэгдэн гарч байна. Сэтгүүлийн өмнөх дугаарууд манай улсын орчуулгын судалгааны хөгжлийн байдлыг таньж мэдэх, тандах нэгэн талбар болсныг хүмүүс ярих болжээ. Орчуулгын судалгаа шинжлэл нь хэдэн жилийн өмнө зөвхөн практик дадлын, тус тусын хэлний орчуулгыг оногдохуун болгосон, нэгэн хэвийн, явцуу, өөр хэлний орчуулгын судалгаа хийдэг хүмүүст төдий л хүртээлтэй бус, орчуулгын шинжилгээг үзэх эрдэмтдэд өөрийн мэддэг хэлнээс өөр хэлний судалгаа байвал анхаарч тоож үзэх нь дулимаг байх хандлагатай байв. Сэтгүүлийн зорилго нь тэрхүү орчуулгын судалгааны хүртээмжтэй бус, тус тусын мөрийг хөөсөн хандлагыг нэгэн чигт чиглүүлэн, орчуулагч хэлмэрч нарын нийтлэг онцлогийг илрүүлэн гаргах судалгаа шинжилгээ хийх, онолын талын судалгааг хөгжүүлэх хэрэгтэй хэмээн үзсэний үндсэн дээр “Орчуулгазүй” сэтгүүлийн энэ дугаараас эхлэн онолын судалгааны чиглэлийн эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны ажлыг илүү хөхиүлэн дэмжих, судлаачдыг энэ чиглэлд хандуулахаар зорьж эхэллээ. Манай сэтгүүлийн дөрөв дэх дугаараас эхлэн орчуулгын судлалын ерөнхийгөөс тодорхой руу шилжиж, дугаар бүртээ ямар нэгэн сэдвийг гол болгон, тэр сэдвийн хүрээнд эрдэмтдийн санаа бодлыг түлхүү оруулах чиг барьж эхэлсэн юм.

Орчуулгазүйн профессорын багийн ойрын үеийн ажлын хүрээнд орчуулгын үйлчилгээний стандарт нэвтрүүлэх, гадаад хэлний үгийг оновчтой тэмдэглэх галигийг цэгцлэн тогтоох, орчуулгазүйн орчин үеийн судалгааны үндсэн чиглэлийн дагуу судалгааг хийх, нэр томъёоны судалгааг эрчимжүүлэх зэрэг ажил багтаж байсан бөгөөд эдгээр ажил эхнээсээ биеллээ олж эхэллээ. 2015 оноос эхлэн хятад хэлний үеийн галигийг цэгцлэн нэг мөр болгон тогтоохоор зорьж, ажлаа төлөвлөн, үе шаттай ажлыг гүйцэтгэсний үндсэн дээр “Хятад хэлний үеийн галиг”-ийг тогтоон гаргаж, Монгол Улсын Хэлний бодлогын Үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэн, 2016 онд батлуулж мөрдөж эхлээд байна. Цаашид солонгос, япон, англи, франц зэрэг хэлний оноосон нэрийн галигийг тогтоох ажлыг хийхэд энэ туршлага хэрэг болох нь дамжиггүй. Мөн МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Хүмүүнлэгийн ухааны салбарын “Гадаад хэлний орчуулга” хөтөлбөрийн багийн ахлагч доктор (Ph.D) Г.Элдэв-Очир, нарийн бичгийн дарга доктор (Ph.D) Б.Аззаяа, гишүүн доктор (Ph.D) Ш.Эгшиг, доктор (Ph.D) Д.Отгонтуяа болон орчуулгын товчоодыг төлөөллөөс магистр Б.Одонтунгалаг, Ц.Мөнхцэцэг нар оролцон орчуулсан “Орчуулгын үйлчилгээ. Орчуулгын үйлчилгээний шаардлага MNS ISO 17100:2017” стандартыг Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2017 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 03 дугаар тогтоолоор батлан, 2017 оны 03 дугаар сарын 23-ны өдрөөс дагаж мөрдөхөөр болоод байгаа билээ. Мөн 2017 оны 9-р сарын 30-нд Олон Улсын Орчуулагчдын

өдрөөр салбарын нийт төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлэг МУИС-д болж, цаашид тогтмол хийж байхаар тогтлоо. Эдгээр ажил бол чухамхүү манай улсын орчуулгазүйн салбарынхны нэгдмэл үйл ажиллагаагаар хэрэгжиж, амьдралд нэвтэрч буй явдал бөгөөд энэ бүхний цаана салбарынхны нэгэн зорилгын төлөө чармайн зүтгэж байгаа сэтгэл зүрх оршиж байгаа юм.

Сэтгүүлийн шинэ дугаарт залуу судлаачдын цөөнгүй өгүүлэл орсон байгаа нь Монгол улсын хэмжээнд орчуулгазүйн ба хэлмэрчлэхүйн хөтөлбөрөөр сургалт судалгаа эрчимжиж, орчуулгазүйн шинэ залуу судлаачид төрөн гарч байгаагийн илрэл болж байна.



Энэхүү дугаарт “Орчуулгын онолын асуудал”, “Орчуулгын шинжилгээ”, “Хавсралт” гэсэн буланг багтаасан болно.

Цаашид эрдэмтэн судлаач, дуун хөрвүүлэгч гүүш нар, номын садан, уншигч түмнээс сэтгүүлийн талаархи санал, шүүмж, зөвлөгөө хийгээд бүтээл туурвилаа байнга ирүүлнэ гэдэгт итгэлтэй байна.



Номын цагаан буян дэлгэрэх болтугай!

“Орчуулгазүй” эрдэм шинжилгээний сэтгүүлийн ариутган хянах
зөвлөлийн гишүүн, хэлбичгийн ухааны доктор Ш.Эгшиг

2017 оны 12-р сарын 29-ний билэгт сайн өдөр



ОРЧУУЛГЫН ОНОЛЫН АСУУДАЛД



ОРЧУУЛГА БА ТОЛЬЗҮЙ

(Монголчуудын төвөд хэлний толь бичиг
орчуулж байсан уламжлалаас)

Д.Бүрнээ¹

Товч утга: Монголчууд дэлхий дахины утга зохиолтой эрт дээр үеэс танилцаж орчуулж ирсэн түүхтэй. Монгол орчуулгын түүхээс үзвэл бурханы шашны утга зохиолыг зонхилон төвөд хэлнээс орчуулж иржээ. Төвөдийн гэлүмба шашны урсгал Монголд хүчтэй дэлгэрсэн 17-18 зуунд төвөд хэлнээс ном судар орчуулах үйл өрнөн хөгжиж, түүнийг дагаж орчуулгын гарын авлага толь бичиг олныг зохиож бас төвөд хэлний толь бичиг орчуулан хэрэглэж байжээ. Манай улсын болон дэлхийн бусад орны номын санд ийм орчуулсан толь гар бичмэлээр цөөн бус хувиар тааралдаж байгаа нь монгол түмний дунд дэлгэрсэн болохыг харуулж байна. Энэхүү өгүүлэлд монголчуудын нэг болон хоёр хэлний толь зохиохдоо ашиглаж байсан төвөд хэлний “Самадог” (Охь хуурцаг), “Агдон” (Хэлний зул), “Лиш гүрхан” (Лишийн орд харш) хэмээх гурван толийн бүтэц, төрөл зүйл болон монгол орчуулгын зарим онцлогийн талаар өгүүлсэн болно.

Төвөд толь бичгийн орчуулгыг судлах нь монгол орчуулгын уламжлал, төвөд-монгол хоёр хэлний толь зохиож байсан арга зүйг шинжлэхэд чухал хэрэглэгдэхүүн болно гэж үзэв.

Түлхүүр үг: монгол орчуулга, төвөд хэлний толь, “Самадог”, “Агдон”, “Лиш гүрхан”, толийн орчуулга

Монголчууд түүхэндээ дэлхийн олон хэлнээс орчуулж байжээ. Төвөд хэлнээс шашин номын холбоотой ном зохиолыг зонхилон орчуулж ирсэн байна. Бидэнд олдож буй мэдээгээр бүр 13-14 зуунаас төвөд хэлнээс бурханы шашны утга зохиолыг орчуулж эхэлсэн түүхтэй. Энэ үед орчуулсан буддын шашин гүн ухааны утга агуулгатай олон ном судрын тасархай хуудас Турфаны цуглуулгаар уламжилж ирснээс гадна Чойжи-Одсэр, Шаравсэнгэ нарын орчуулсан “Алтангэрэл”, “Банзрагч” зэрэг хөлгөн судрууд бүрэн эхээрээ иржээ. Монгол оронд төвөдийн гэлүмба шашны урсгал 17-18 зуунд дэлгэрсэн нь бурханы шашны утга зохиолын орчуулга өрнөн хөгжихөд ихээхэн нөлөөлсөн байна. Энэ үед төвөд хэлнээс бурханы шашин, утга зохиолыг орчуулсан олон нэртэй орчуулагч гүүш нар төрөн гарчээ. Тэдгээрийн дундаас Хөх хотын Ширээт гүүш цорж, Гунгаа-Одсэр, Дархан лам Самдансэнгэ, Дай гүүш Агваандампил, ойрдын Зая бандид Намхайжамц, халхын гүүш Алтангэрэл увш, цахар гэвш Лувсанчүлтэм, буриадын Лувсанринчен зэрэг алдартай гүүш нарыг дурдаж болно. 18 дугаар зуунд төвөд хэлнээс буддын шашин утга зохиолын их

¹ МУИС, ШУС, ХУС-ын МХХШТ-ийн профессор, доктор

цоморлиг Ганжуур, Данжуурыг орчуулан дуусгаж барласан явдал монгол орчуулгын түүхэнд онцгой үйл явдал болов. Тэр цаг үеэс монгол орчуулгын үйл 20 дугаар зууны эхэн хүртэл хөгжиж, улмаар 1921 оны ардын хувьсгалын үеэс 1990 он хүртэл тухайн үеийн үзэл суртлын нөлөөгөөр зарим талаар тасалдаж байсан боловч бүрмөсөн зогсолгүй үргэлжилсээр байсан юм. Монгол орчуулгын түүхэнд төвөд хэлнээс монгол хэлнээ үгчлэн буулгах судрын орчуулгын зэрэгцээ, утга санаа агуулга, уран сайхныг буулгах бичгийн болон аман орчуулга хөгжсөн байна.

Үе үеийн дуун хөрвүүлэгчдийн чухал гарын авлага бол дохионы бичиг буюу төвөд-монгол хэлний толь байжээ. Төвөд-монгол хоёр хэлний толь бичиг зохиох ажил 18 дугаар зууны эхэн үеэс үүсэн хөгжиж бидэнд уламжилж ирсэн баримтаар 18-20 дугаар зууны хооронд олон арван толь бичиг зохиогдсон байна. 20 дугаар зууны эхэн үеэс 21 дүгээр зуун хүртэл төвөд-монгол хоёр хэлний толь бичиг өмнөх үетэй харьцуулахад цөөн боловч гарчээ. Энэхүү өгүүлэлд монголчуудын толь бичиг зохион хэрэглэж байсан зарим нэг арга туршлага тухайлбал төвөд хэлний толь бичиг орчуулж байсан уламжлалын тухай “Самадог”, “Агдон”, “Лиш гүрхан” зэрэг толь бичгийн жишээн дээр өгүүлнэ. Эдгээр толь бичгийг монгол толь зүйчид нэг болон хоёр хэлний толь зохиохдоо ашиглаж байжээ.

Нэг. “Самадог” хэмээх толь бичгийн орчуулгын тухай

“Самадог” толийн бүтэн нэр төвөд хэлээр *Bod kyi brda'i bstan bcos legs par bshad pa rin po che'i za ma tog bkod pa zhes bya ba bzugs so*, монгол хэлээр *Töbed-ün dokiyan-u šastar-a sayitur nomlayсан erdeni-yin oki qayurčay jokiyaγsan kemekü orosibai* хэмээх болно. Тус толийг төвдийн их хэлмэрч Шалу Ринченчойжинсамбуу (1444-1527) 1514 онд санскрит хэлний зүйн бичгүүд болон Томи Самбодагийн зохиосон *Sum cu ba, rTags 'jug* тэргүүтэн төвөд хэлний зүйг ашиглан зохиосон байна. Эх бичвэрийн онцлогийн тухайд зарим төвөд үгийн доор санскрит бичлэг хадаж, зарим үгийг төвдөөр тайлбарласнаас гадна санскрит толь зүйн аргаар зохиож², төвөд хэлний үг бүтэх зарчмыг үндэс болгож үгсийг дараах байдлаар дараалуулжээ. Үүнд:

а) дан үсэг буюу угтвар аваагүй үгс

б) Ba, Ga, Da, A, Ma таван угтвараар угтуулсан үгс, дан болон угтвартай зүүлтэт үгс

в) Толгойт үсгээр хэлбэржсэн үгсийг тус тус жагсааж, мөн өмнөх үгийн төгсгөлөөс хойно залгах сул үгийн бичлэг хамаарах үгсийг долоон бүлэгт ангилан хувааж өгүүлсэн байна.

Тус тольд үгсийг долоон үеэр нэг шадад тэнцүүлэн найруулжээ. Төвөд хэлний үг дан болон давхар үсгээс бүтдэг, мөн дагавар, угтвар, дахин орсон дагавар нь үг бүтээх, утга ялгах үүрэгтэй болохыг тодорхой жишээн дээр тулгуурлаж ангилан хуваасан ба

² Burnee D, A review of the Tibetan-Mongolian lexicographical tradition, The Mongolia-Tibet interface, PIATS 2003: Tibetan Studies, Proceedings of the Tenth Seminar of the International Association for Tibetan Studies, Oxford, Managing editor: Charles Ramble. Brill, 2007, pp.371-379; Madhukar M.Patkar, United printing Co., Maujpur, Delhi-110153, 1980 History of Sanscrit lexicography, 1980, pp.20.

төвөд хэлний үг бүтэх ёсыг дэс дараатай илтгэн харуулсан байна. Тус зохиолд төвөд хэлний зүй, үгийн бүтцийг таниулахыг чухалчилжээ. Түүнээс гадна толгой үг нэг буюу түүнээс дээш үеэс бүтсэн болохыг харгалзан үзэж хоёр буюу гурван үгийг нэг мөрөнд (нэг шадад) оруулсан байна. Толгой үгд бие даасан үг төдийгүй үг бүтээх үүрэгтэй сул үгийг ч сонгон авчээ. Жишээ нь: *glang chen thal kar yungs kar za: yeke cagan jagan kici idemui* гэсэн жишээнд 'kar' гэдэг үг өмнөх 'thal', 'yungs' гэсэн үгстэй нийлж "цагаан заан", "гич" гэсэн үгийг бүтээжээ. Энд 'kar' гэдэг сул үгийг толгой үгд авч үг бүтээх үүрэгтэйг нь таниулсан учраас төвөд хэлний үг бүтэх ёсыг заан сургахыг чухалчилсан нь тодорхой. Сул үгээс гадна төвөд хэлний ижил үг, ойролцоо үг, төсөөт үгийн жишээн дээр үгийн бүтцийг харуулжээ. Дан салангид үгээс гадна нийлмэл үг, өгүүлбэрийг ч жишээнд авсан нь тааралдана. Төгсгөлийн бүлэгт төвөд хэлний зүйн хураангуй дүрмийг бичиж, ямар эх сурвалж ашигласан, ямар зорилгоор бичсэнээ дурджээ. Тус толийг зохиогч *ūsūg-tū bičikūi kiged ōgūlkūi kiged nomlaqu kiged tuyurbiqu terigūten qotala-dur tusalaqu-yin tulada teyin čayan sanal-iyar...tuyurbiysan* гэж дурджээ. Өөрөөр хэлбэл, төвөд хэлээр алдаагүй зөв найруулан бичиж сурахад зориулж энэхүү гарын авлагаа туурвисан байна. Тус толийн хэдэн зүйлийн эх уламжилж иржээ. Үүнд: Монголын Үндэсний номын санд (МҮНС) төвөд-монгол хадмал³, дан монгол орчуулга бүхий⁴ хоёр эх, ОХУ-д хоёр гар бичмэл, БНХАУ-д найман зүйлийн бичмэл эх байна. Монгол орчуулгын эдгээр арван хоёр эхийн арван нэгийг уйгаржин монгол бичгээр, нэгийг тод үсгээр бичжээ⁵. Эдгээрээс цаг хугацааны тухайд хамгийн сүүлийн эх бичвэр бол Судар бичгийн хүрээлэнгийн ажилтан агсан орчуулагч Гэлэгжамц дооромбын төвөд- монгол хадмал 1924 оны гар бичмэл болно.

Монголчууд тус толийг хөрвүүлэхдээ төвөд толгой үгд хадсан санскрит үг хэллэгийг зарим эхэд орхисон, зарим тайлбарыг орчуулжээ. Тус толийн хэдэн зүйл орчуулгын хувилбарыг үзэхэд утгын ялгаа зөрөөгүй, үгийн сан, хэл найруулгын төдий л ялгаатай. Тухайлбал *Za ma dog* гэсэн толийн нэрийг *Oki qayurčay* гэхээс гадна *Oki saba, Qayurčay*⁶ гэж хөрвүүлсэн байна. Цаашлаад зарим жишээг авч үзвэл төвөд хэлний *kla klo* гэдэг үгийг *ters*⁷, *mletstsha*⁸, *tetürü buruū* гэж гурван янзаар орчуулжээ.

Тус толийг монгол хэлнээ орчуулах ажлыг халхын Анхдугаар богд санаачилсан байх бөгөөд Ламын гэгээн Лувсанданзанжалцан тэргүүтэй мэргэд төвөд хэлнээс 1686 онд

³Монгол улсын Үндэсний номын сангийн монгол судлал гар бичмэл номын фондод буй, дансны дугаар - 12424.

⁴Монгол судлал, гар бичмэл номын фонд, дансны дугаар- 3889/96, 12424.

⁵Дундад улсын эртний монгол ном бичгийн ерөнхий гарчиг, Beijing Library Press. 1999, 1202-р тал.

⁶Yakhontova N.S, Collection of bilingual dictionaries in the Institute of Oriental Manuscripts, Proceedings of the Chinese Fourth International Symposium on Mongolian Studies, Inner Mongolia Academy of Social Science, Chinese Association for Mongolian Studies, Huhhot, China, 2015.8.21-22, pp.214.

⁷Үндэсний номын сангийн 12424 дансны дугаартай гар бичмэлийн 36 тал. Санскрит хэлний *tirtika* гэдэг үгээс үүсэлтэй гэж О. Сүхбаатар бичжээ. Үз. Монгол хэлний харь үгийн толь, Монгол хэл соёл 15, Редактор Д.Төмөртоогоо нар, Улаанбаатар, 2014, 212-р тал.

⁸Үндэсний номын сангийн 3889/96 дансны дугаартай гар бичмэлийн 2а тал. Энэ үг бол санскрит хэлний *mleccha* хэмээх үгийн галиг болно.

хөрвүүлсэн тухай Зая бандид Лувсанпэрэнлэй (1639-1704) бээр *Товъёог салви мэлон* хэмээх төвөд хэлээрх түүхэн сурвалждаа тэмдэглэжээ⁹. Ингэж үзвэл Брова равжамба Гунгаажамц 1718 онд төвөд-монгол толь бичгээ зохиохоос өмнө *Oki qayurčay* толийг орчуулсан буюу хоёр хэлний толь зохиохоос өмнө төвөд толийг орчуулж байжээ гэж дүгнэх үндэслэл байгаа юм.

Хоёр. “Агдон” хэмээх толь бичгийн орчуулгын тухай

Төвөд хэлээр *Bod kyi brda'i bye brag gsal bar byed pa'i bstan bcos tshig le'ur byas pa mkhas pa'i ngag gis gron me*, монголоор *Töbed-ün dokiyan-u ilyal-i todudqan üyiledügči šastar üges-yi bölüglen üyiledügsen merged-ün kelen-ü jula* хэмээх толийг Балхан Агваанчойжижамц (1456 онд төрсөн) 1538 онд зохиожээ. Тус судар гар бичмэлээр тархсан байна¹⁰. Үүнд төвөд-монгол хадмал болон дан монгол бичгээр бичсэн эх бичвэрээс гадна тод үсгээр бичсэн орчуулга ч байна¹¹. МҮНС-д 2, ОХУ-д 3, БНХАУ-д төвөд-монгол хадмал 4 зүйл гар бичмэл байна. Өмнө дурдсан тольтой адил долоон үеэр шүлгэлсэн хэлбэрээр бичигдсэн, зарим төвөд үгийн доор санскрит хэлээрх дүйх хэллэгийг бичсэн байдалтай. Өмнөх толиос ялгаатай нь дан болон давхар бүтэцтэй үгийг цагаан толгойн дарааллаар жагсааж нэг бүлэгт оруулсан байна. Тиймээс үг эрж олох, ашиглахад өмнөх толиос илүү хялбар болжээ. Тус толийн төгсгөлд өмнөх “Самадог”-ийг сайжруулах зорилгоор бичсэн тухай тодорхой өгүүлжээ. Тухайлбал, *olan merged-ün jokiyaγsan dokiya-a-u sastir-ün toy-a olan bolbaču jarim-ud üge delgerenggüi kereg-ün udq-a čögen, jarim-ud qoyaγula-yieng quriyan, jarim-ud qayučin bičig lüge ülü neyilen*¹², *jarim-ud yučitu kiged belge oruqui terigüten-eče γayča-qayča*¹³ *tegün-ü tula üge čögen udq-a delgerenggüi sayitur nomlaqui egün-i üyiledbei*¹⁴ гэж өмнө гарсан толь бичгүүдийн ололттой болон дутагдалтай талыг онцлон тэмдэглээд, цөөн үгээр утгыг тодорхой гаргах зорилгоор эл судраа бичсэн тухайгаа *egün dūr öberün sanay-a ber bui busu bölüge. Kemjiy-e tegüsügsen yool dur üneker sitüjü sine qayučin doqiy-a* тэргүүтнийг ашиглан зохиосон гэжээ.

Тус толь өмнөх толийн нэгэн адил төвөд хэл сурах, сургах зориулалттай. Бүтцийн хувьд гурван бүлгээс бүрдэнэ¹⁵. Үүнд:

⁹Бүрнээ Д, Ламын гэгээний орчуулсан нэгэн толь бичгийн онцлог, Монгол улсын их сургууль, Монгол хэл соёлын сургууль, эрдэм шинжилгээний бичиг, Том XXXI (328), 2010, 61-р тал.

¹⁰Манай Үндэсний номын сангийн Монгол судлал, гар бичмэл номын хөмрөгт 12434/97 тоот данс бүхий эх хадгалагдаж байна.

¹¹Yakhontova N.S, Collection of bilingual dictionaries in the Institute of Oriental Manuscripts (Russian Academy of Sciences), Proceedings of the Chinese Fourth International Symposium on Mongolian Studies, Inner Mongolia Academy of Science, Chinese Association for Mongolian Studies, Huhhot, China, 2015.8.21-22, pp. 214.

¹² 3501 тоот дансны дугаар бүхий эхэд “ülü joqildumui” гэжээ.

¹³ 3501 дансны дугаар бүхий эхэд qarsildumui гэжээ.

¹⁴Töbed-ün dokiyan-u ilyal todudqan üyiledügči šastar bölüglen üyiledügsen merged-ün kelen-ü jula, YHC, МСГНФ, 316.

¹⁵Burnee D, A review of the Tibetan-Mongolian lexicographical tradition, The Mongolia-Tibet interface, PIATS 2003: Tibetan Studies, Proceedings of the Tenth Seminar of the International Association for Tibetan Studies, Oxford, 2007, Managing editor: Charles Ramble, pp. 373.

- 1) Угтвар тэргүүтэн үсгийн барилдлагыг дэлгэрэнгүй үзүүлсэн
- 2) Тийн ялгал ба сул үгийг номлосон
- 3) Үсгийн эндүүрлийг тэвчих тухай өгүүлсэн гэсэн бүтэцтэй.

Үгийн бүтцэд чухал үүрэг бүхий дагавар, угтвар, дахин орсон дагавар, эгшиг тэргүүтнээр жишээ авч өгүүлсэн нэгдүгээр бүлэг хамгийн дэлгэрэнгүй бөгөөд төвөд хэлний зүй болон зөв бичих зүйн хэм хэмжээг сахих тухай тусгайлан өгүүлсэн хоёр, гуравдугаар бүлэг хураангуй товч болно. *Üsüg-ün barilduly-a dur endegürebesü udq-a niyud-i endegürekiü-yi ögülekiü yaγun kereg* хэмээн алдаатай буруу бичих аваас утгын хувьд алдаа мадагтай болох нь лавтай болох тухай өгүүлжээ. Тус тольд үгийг эндүү ташаа бичихээс сэргийлж зөв бичих, улмаар утга эндүүрэхгүй, үнэн зөв найруулан бичихийг чухалчилсан байна.

Тэргүүн хэсэгт долоон үеэр тэнцүүлсэн мөр бүрт үгийг энгийн дан хэлбэрээс нийлмэл хэлбэр үрүү орох дарааллаар жагсаасан байх бөгөөд үгсийн байрлалыг авч үзвэл үг бүтээх үүрэг бүхий сул үгийг таниулахыг чухалчилсан нь “Самадог”-тай адил болно. Өөрөөр хэлбэл үг бүтээх үүрэг бүхий сул үгийг тусад нь биш харин нийлмэл үгийн бүтэц дотор нь толгой үгд оруулж цагаан толгойн дараалалд оруулсан нь өмнөх тольтой адил болжээ. Тухайлбал: *Glang chen thal kar ber kas brdungs* гэсэн жишээг орчуулбал “цагаан зааныг бэрээгээр жанчив” гэж байгаа бөгөөд дээрх жишээнд гарч буй **kar** гэсэн үг бол “цагаан”, **kas** бол **ber ka** буюу “бэрээ саваа” гэсэн үгийн бүтцэд орсон, **s** бол үйлдэхийн тийн ялгалын нөхцөлийн үүрэг гүйцэтгэж байна. Энэ хоёр үгийн эхнийх нь “цагаан” гэсэн үгийн хувилсан хэлбэр, хоёр дахь нь сул үг бөгөөд эл хоёр үгийг цагаан толгойн дараалалд оруулж үг бүтээх үүргийг нь холбоо үгийн жишээгээр харуулжээ. Ингэхдээ холбоо үгсийн утгын холбоо хамаарлыг ямар нэгэн хэмжээгээр анхаарчээ. “Агдон”-гийн монгол орчуулгууд утгын ялгаа зөрөөгүй, үг үсгийн болон найруулгын төдий ялгаатай нэг эхийн олон хуулбар бололтой. Орчуулгын төгсгөлд орчуулагчийн нэрийг тодорхой тэмдэглээгүй байна.

Гурав. “Лиш гүрхан” хэмээх толь бичгийн орчуулгын тухай

Шалу Ринченчойжонсамбуугийн шавь Жогдон лозава Ринчендаш (15 зууны сүүлд төрсөн?) төвөд хэлээр *bod kyi skad las gsar rnying gi brda'i khyad par ston pa legs par bshad pa li shi'i gur khang zhes bya ba bzhugs*, монгол хэлээр *Töbed kelen-ü sin-e qaγučin ayalγus-un iγal-i üjegülegči sayin ügetü lisi-yin ordu qarsi kemegdekü orosibai* нэрт толио 1536 онд бичжээ. Тус толь төвөд-монгол гар бичмэлээр тархсан байх бөгөөд бар хэлбэрээр Санкт-Петербург, Хөх хот, Бээжингийн номын санд хадгалагдаж байна. Төвөд хэлээрх эх сударт санскрит үг хэллэгийг зарим газар хаджээ. Цагаан толгойн дарааллаар үгсийг жагсаагаагүй.

Тус толийг нэрт дуун хөрвүүлэгч урад гүүш Билгийн далай төвөд хэлнээс 1742 онд орчуулж Бээжинд барласан байна. Билгийн далай бол Бээжин дэх Сүн жү сы буюу Ариун суурин хэмээх сүмийн даа лам байсан бөгөөд тэр бээр Чойжи-Одсэрийн орчуулсан “Бодичарьяаватара”-г найруулан хөрвүүлснээс гадна

“Жадамба” (rgyad stong pa) тэргүүтэй бусад судрыг орчуулжээ. Толийн орчуулгын тухайд *ilyuysan-u sayin jarliṅ-i urid qojid orčiṅyuluṅsan nuṅud-un ayalu sin-e qayučin dokiyan-i uqayuluṅči egün-i ilangyuy-a sinjileküi-tü ayay-a tekemlig blo bzang chos 'phel imayta bas bas eyin orčiṅyulqui-yi kereglemüi kemen duraduṅsan-dur ariṅun sayurin ner-e-tü keyid-ün terigün blam-a ayay-a tekemlig dooradu öteles urad bilig-ün dalai asuru neng olan mergen-nügüd-e öčijü, asaṅyad egün-i mongyol-un kelen-dür orčiṅyuluṅsan buyu* хэмээн төгсгөлийн үгд бичсэнээс үзвэл гүүш Билгийн далай олон мэргэн гүүш нарыг шүтэж орчуулсан байна.

Тус толийн бүтэц, орчуулгын зарим онцлогийн тухай Б.Я.Владимирцов бичихдээ Билгийн далай төвөд хэлний хуучин болон шинэ үг хэллэгийг дүйх монгол үг хэллэгээр буулгахыг чармайсан, хуучин үг хэллэгийг монгол хэлний үгийн сангаас эрэлхийлсэн гэжээ¹⁶. Тухайлбал, “Лиш гүрхан”-д *tsang mang ni nags tshang ngam me khang* гэснийг *bayurčin-u ger inu idegen-ü ger ba boro ger* гэж буулгажээ. Энэ жишээнд гарч буй *tsang mang* гэсэн үгийг төвөд-монгол толь бичгүүдэд “идээний гэр”, “галын гэр”, “суух байшин”, “суух орон”, “сангийн гэр”, “бор гэр” гэж хөрвүүлсэн бол Билгийн далай *bayurčin-u ger* гэжээ. Түүнчлэн *Mdun khang ngam bkad sa ni 'dug sa* гэсэн өгүүлбэрийг *Emüne-dü baišing ba bayurčin-u ger inu sayuqu yajar* гэж хөрвүүлсэн байна. Энэ өгүүлбэрт гарч буй *bkad sa* гэсэн үгийг мөн *tsang mang* гэсэн үгийн адил “буурчины гэр” гэж Билгийн далай хөрвүүлжээ. Ю.Н.Перих *tsang mang* гэснийг “кухня” буюу “гал тогой”, *bkad sa* гэснийг “харчевня (трактир, закусочная с дешёвыми и простыми кушаньями), постоялый двор, собственное жилище, гостиная, кухня” гэж орчуулжээ. Я.Цэвэлийн тольд “буурч” хэмээх үгийг 1. явдал аяны хүний бууж түр амарч хооллож ундлах газар 2. тогооч; “Хорин наймтын тайлбар толь”-д “буурчины гэр” гэснийг “тусгайлан гэр бэлдэж цааш нааш явах явдлын хүнээс ацаг аван хонуулах гэр орныг” хэлнэ, “буурч” бол “аливаа ихээхэн хот зээлийн газарт албан ажлын хэргээр аялан явах хүнийг ацаг хөлсөөр хонуулах өнжүүлэх гэр орон” гэжээ. Б.Владимирцов “буурч” гэдэг үг бол эртний монгол хэлнээ “хоол хүнс болон уух ундыг эрхэлсэн” томхон албан тушаалтныг хэлж байсан гэжээ¹⁷. Хожим нь энэ утга “Лиш гүрхан” толиос үзвэл үгүй болсон ч Билгийн далай төвөд хэлний хуучин үг хэллэгийг утга дүйх эртний монгол үгээр онож буулгасан нь Б.Владимирцовын тэмдэглэсэнчлэн түүний “Бодичарьяаватара”-г орчуулсан туршлагаас үүдэлтэй бололтой.

Тус толийг үндэс болгож Жанжаа хутагт Ролбийдорж *Merged yarqu-yin orun neretü toyṭayaṅsan dagyig*-ийн *Sin-e qayučin dokiyan-u ayimaṅ* -ийг бичсэн байх бөгөөд Агваандандар *Blo gsal mgrin can* нэрт шинэ хуучин дохионы толио зохихдоо бас ашиглажээ. Тус толь цагаан толгойн дарааллаар бичигдээгүй боловч монголчууд өөрсдийн хэрэгцээндээ зориулж үсэг дараалуулж бичсэн эх ОХУ-д хадгалагдаж

¹⁶ Владимирцов Б.Я., О тибетско-монгольском словаре Li-ṣiḡigur-khañ, Работы по монгольскому языкознанию, сост. Слесарчук Г.И., М.: Восточная литература, 2005, стр. 138-141.

¹⁷ Владимирцов Б.Я., О тибетско-монгольском словаре Li-shi gur-khang, Доклады Академии наук СССР, 1926, стр. 28.

байна¹⁸. Энэ нь нэг талаас тус толийн хэрэгцээг харуулахаас гадна монголчуудын төвөд толь зүйг судлахад оруулсан хувь нэмрийг ямар нэг хэмжээгээр илтгэн харуулж байгаа хэрэг юм.

“Лиш гүрхан” толь бүтцийн хувьд гурван хэсгээс бүрдэнэ. Нэгдүгээр, шинэ хуучин дохионы хэсгийн хойно санскрит болон хятад гаралтай, бас цөөн тооны монгол гаралтай үг, цаашлаад бонбо, шаншүн хэлний үгс ч оржээ. Тус толийг Агваандандараас гадна Сумадираднаа ашигласан байна.

Төвөд хэлнээс орчуулсан дээрх толь бичгийн төрөл зүйлийг авч үзвэл “Самадог” болон “Агдон” бол төвөд хэл сурах, “Лиш гүрхан” бол шинэ хуучин дохионы толь болно. Төвөд-монгол хадмал болон дан монгол орчуулгаар дэлгэрсэн эдгээр толь бичиг нь төвөд-монгол толь зүйг судлахад чухал хэрэглэгдэхүүн болох юм. Учир нь монгол толь зүйчид хоёр хэлний толь зохиохдоо төвөд толь зүйг үндэс болгож байсан учраас толгой үгийг цагаан толгойн дарааллаар хэрхэн байрлуулсан, үг хэрхэн сонгосон, утгыг ялгасан, ялангуяа хоёр хэлний толь бичиг зохиохдоо толгой үгийг хэрхэн орчуулж байсан арга зарчмыг судлахад чухал үүрэгтэй.

Резюме

Монголы перевели с тибетского языка большое количество буддийской литературы с 13-14 вв. Наряду с переводом были составлены тибетско-монгольские двуязычные словари, которые служили важным руководством для монгольских переводчиков. В данной статье рассматриваются переводы известных тибетских словарей как “Самадог”, “Агдон”, “Лиш гурхан” составленные тибетскими авторами в 16 веке. Эти переводы встречаются в виде рукописи в библиотеках не только у нас в Монголии, но и в России и в Китае. Автор статьи рассматривает некоторые текстологические и переводческие особенности данных словарей и делает вывод что, изучение переводов тибетских словарей послужит важным руководством в изучении тибетской лексикографии, которая тесно связана с тибетско-монгольской лексикографией.

¹⁸ Яхонтова Н.С, Рукописные тибетско-монгольские словари в собрании ИВР РАН, - Культурное наследие монголов. Рукописные и архивные собрания Санкт-Петербурга и Улан-Батора, УБ., 2014, стр.236

НЭР ТОМЬЁО БА ХЭРЭГЛЭЭ

С.Дугармаа¹

Товч агуулга: *Шинжлэх ухааны салбарын олон зуун нэр томьёог шинээр оноон тогтоож, тэдгээр нь шинжлэх ухааны салбар бүртээ хэвишин тогтоож улмаар монгол хэлний үгийн санд нэвтэрч, нийтэд хэрэглэгдсээр байна. Иймээс аливаа хэлэнд утга зохиолын хэлний хэм хэмжээг дагаж мөрдөн шинжлэх ухааны салбар бүрийн нэр томьёог байнга боловсронгуй болгож, зөв оноож, жигдэлж байх нь чухал. Нэр томьёонд нөлөөлж буй хэлний болоод хэлний бус шалтгаан нөхцөл тэдгээрийг судалж, улмаар асуудлыг шийдэхэд мэдээллийн технологийг ашиглах зайлшгүй шаардлага үүсэж байна. Монгол хэлний үг бүтээх дүрэм баримтлан нэр томьёог бүтээх, зөв оноон орчуулах болон цаашид нэр томьёог боловсронгуй болгоход технологийг ашиглах асуудлыг хөндөн хэлэлцүүлж байна.*

Түлхүүр үг: *шинжлэх ухаан, технологи, үг бүтээх арга, корпус хэлишинжлэл, хуулбарлах арга, галиглах арга*

Шинжлэх ухааны нэр томьёо түүний хэрэглээний асуудалд

Лаборатори, стандарт, станц, механик, энерги, бетон, систем, диаграм, параметр, температур зэрэг олон үг угтаа явцуу хэрэглээний нэр томьёоны чанартай байгаад яваандаа хэн бүхний мэддэг нийтийн хэрэглээний үг болсоор байна. Иймээс нэрт хэл шинжлэгч Г. Винокур нэр томьёо бол тусгай үг биш зөвхөн тусгай үүрэгтэй үг юм гэж оновчтой тодорхойлсон байна.

Нэр томьёог оноож тогтооход аль болох оновчтой, товч тодорхой, ганц утгатай, ойролцоо утга бүхий үггүй байх зэрэг үндсэн шаардлагыг харгалзан үздэг байна. Нэр томьёо нь ерийн үгээс чухам юугаараа эрс ялгаатайг тодорхойлж хэлбэл:

-тодорхой нэг ухаан, мэргэжилд хамаарна.

-тухайн салбартаа нэгэн нэгдмэл утга илэрхийлэх тул зөвхөн тэр ойлголтоо заасан ганц утгатай байна.

-сэтгэл хөдлөлийг илтгэсэн өнгө аяс бараг байдаггүй.

-утгынхаа хувьд ерийн үгтэй харьцуулахад илүү болзмол чанартай байдаг.

-нэр томьёо бол тайлбар биш байх ёстой” (Шагдарсүрэн Ц., 1984, х.60) зэрэг шаардлагуудыг хангасан байна гэж судлаач үзсэн байна.

Монгол хэлний нэр томьёо бүтэх аргыг нарийвчлан судалсан оросын эрдэмтэн нэр томьёо бүтээх аргыг дараах байдлаар хуваан үзжээ.

1. Нэр томьёо бүтээх үг зүйн арга
2. Нэр томьёо бүтээх үг зүй-өгүүлбэр зүйн арга/үг нийлэх/
3. Нэр томьёо бүтээх өгүүлбэр зүйн арга

¹ ШУТИС, ГХИ, Англи хэл судлалын тэнхим, дэд профессор, доктор

4. Нэр томьёо бүтээх эх сэдэв-утга зүйн арга
5. Нэр томьёо бүтээхэд хэлний бэлэн бүтэц ашиглах
6. Үг товчлох нь ухагдахуун тэмдэглэх нэг арга гэжээ. (Г.Ц.Пюрбеев 1984. х.

175)

Монголын эрдэмтэн судлаачид Д. Дашдаваа, Э. Равдан нар нэр томьёонд

- 1.Шинэ үг
- 2.Нийтэд хэрэглэдэг үгийн сангийн хэрэглүүрийн үндсэн дээр үүссэн үг

хэллэг

- 3.Зээлдсэн үг/үгчилсэн орчуулгаар орж ирсэн үг хэллэг

- 4.Үг нийлж бүтсэн үг хэллэг

5.Галиглан буулгасан үг хэллэг (дуудлага хөрвүүлсэн) эдгээрийг хамруулан үзнэ гэжээ. (Д. Дашдаваа, Э. Равдан 1980 х.12)

Эдгээр ангиллаас дүгнэн хэлэхэд нэр томьёо бүтэх арга нь зөвхөн үг бүтэх зүй тогтлоор хязгаарлагдахгүй, үгийн сан утга зүйн аргаар бүтдэг, өөрөөр хэлбэл бүтэх боломжоороо хэлний бусад нэгжээс давуу талтай байна.

Нэр томьёог шинжлэх ухааны үндэслэлтэй боловсронгуй болгох зорилт өнөөдөр ч гэсэн мэргэжлийн эрдэмтэд, хэл судлаачдын өмнө тулгамдсан хэвээр байна. Иймээс судлаач эрдэмтэд эрдэм шинжилгээний өгүүлэл болон ном, сурах бичиг, хичээлийн хэрэглэгдэхүүн болон мэргэжлийн ном зохиолыг орчуулан эргэлтэнд оруулахдаа цаашид

хуулбарлан орчуулах аргыг ашиглан нэр томьёо бүтээж (accumulator-зай хураагуур, collector- цуглууруур, booster-өдөөгч, sensor-мэдрэгч, inverter-хувиргагч гэх мэт үгийг галигчлан буулгаж хэрэглэх нь элбэг байна) харь үгийг цөөлөх хэрэгтэй байгаагаас гадна нэр томьёог гадаад хэлнээс орчуулан хэрэглэхдээ монгол хэлний үг бүтээх дагаврыг зөв хэрэглэхийг анхаарах ёстой. Жишээ нь: хувьсамж (хувьсах гүйдэл) , porosity- сүвэрхэгшил (сүвэрхэг чанар), хавтгайшил(хавтгай хэлбэртэй болох)

Бид техник технологийн нэр томьёог лавлахдаа Ч.Зундуйсүрэн, Д.Дашпүрэв нарын 2003, 2006 оны “Шинжлэх ухаан техникийн тайлбартай толь бичиг”-ийг ашиглаж байна. Энэ нь металлурги, машин байгууламж, архитектур, зам барилга, ус хангамж, дулаан, цахилгаан холбоо, хэмжих хэрэгсэл, электроник, тооцоолох техник, мэдээлэл зүй, уул уурхай, түлш-хийн хангалт, геологи, төмөр зам, нисэх хүчин, тээвэр, материал, байлдааны зэвсэг, техник хэрэгсэл, хими, физик, эдийн засаг, менежмент зэрэг 26 салбар ухааны нэр томьёог тусгасан нь олон салбар ухааны нэр томьёог нэг дороос үзэх боломжтой. Орос үгээр толгойлж англи орчуулга хадсан нь нэг нэр томьёог харьцуулан харахад ойлгомжтойн зэрэгцээ шинээр гарсан техник, технологийн нэр томьёог багтаасан бөгөөд техник технологийн олон салбарыг хамарсан бөгөөд тухайн салбарын мэргэжилтнүүдийг оролцуулан зохиосон нь оноолт оновчтой болсон гэж үздэг. ШУТИС-ийн инженер технологийн мэргэжлийн багш нарын бүтээсэн 40 гаруй толь хэрэглэгдэж байгаагаас Ч.Батхуяг, Ч.Зундуйсүрэн нарын “Эрчим хүчний нэр томьёоны тайлбартай толь” 1987, Х.Намсрай “Компьютерийн программчлал, мэдээлэл зүйн англи-монгол нэвтэрхий толь”, Б.Сүхбаатар “Мэдээлэл холбооны техникийн англи-монгол толь бичиг” 2007,

Ч.Авдай, Т.Аюурзана, Х.Даваасамбуу нарын “Машин механизмын онолын англи-герман-орос-монгол нэр томьёоны толь” 2000, С.Оюунгэрэл, Л.Жаргал, С.Дашдаваа “Англи-орос-монгол геологийн толь” 2004, С.Цэдэнжав “Уул уурхай монгол-орос-англи-герман толь” 2010 зэрэг толь нь ШУТИС-ын төв ном сангийн хандалтын тоогоор хамгийн эрэлт хэрэгцээтэй бүтээл болох нь ажиглагдсан байна.

Орчин цагийн монгол хэлний нэр томьёог системтэй тогтоож ирсэн уламжлал 1925 Судар бичгийн хүрээлэнгийн дэргэд Улсын нэр томьёоны комисс байгуулагдсанаас эхтэй бөгөөд 1957-1980 онд Улсын нэр томьёоны комиссын мэдээ (УНТКМ) сэтгүүлийн дугаар 124 гарч мөн нэр томьёоны сэдэвчилсэн толь 30 орчим, нэгдсэн нэр томьёоны толь 3 хэвлэгдэн орос, англи хэлээр дамжин орж ирж буй нэр томьёог цэгцлэх ажил хийгдэж байсан. (Туул Д., 2012. х.32)

Өнөө үед техник, технологийн нэр томьёо, үг хэллэг нь голдуу англи хэлээр дамжин орж ирж нэр томьёог зээлэн хэрэглэх гэсэн хялбар арга хайх, орчуулж болохгүй учраас зээлэн хэрэглэх нь зөв гэх зэргээр тайлбарлах нь салбар бүрт нэр томьёоны хэрэглээний нэг эмзэг асуудал болж байна. Иймээс нэр томьёог жигдлэх зөв хэрэглэхэд хэл шинжээч болон тухайн салбарын мэргэжилтэнтүүд хамтран ажиллах нь зүйтэй. ШУТИС-ийн “Эрдмийн чуулган-2017” Профессор багш нарын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлд хэвлэгдсэн доктор О.Жавхлан нарын “Эртний шургалтын бүсд хуримтлагдсан гялтагнуурт занарын геохимийн онцлог, метаморфизм” өгүүлэлд террейн, эклогит, ортогнейс, коллиз, региональ метаморфизм, офиолит, формац, эпидот-амфиболит фац, шельф, тектоник симплектит текстур зэрэг нэр томьёог галигчлан буулган хэрэглэсэн бөгөөд энэ нь тухайн салбарт ойлгомжтой байж болох ч зарим нэр томьёонд тайлбар зүүлт хийж өгсөн бол бусдад ойлгомжтой болох юм.

Мөн доктор Б.Лхагвадулам нарын “Магхемит нано бодисын синтез ба түүнийг үйлдвэрийн бохир усан сан дахь хромын цэвэрлэгээнд ашиглах нь” адсорбент, сорбент, адсорбци, десорбци, мутаци, дерматит, аллерги, стандарт пик, синтезлэх, протонжсон зэрэг нэр томьёог галигчлан буулгаж хэрэглэснээс гадна төмрийн оксид (төмрийн исэл), мутаци (mutation-хувирал, хувьсалт), дерматит (dermatitis-арьсны үрэвсэл), аллерги (allergy-харшил), стандарт пик (standard peak -стандарт максимум утга) зэргээр орчуулах бололцоотой байгааг анхаармаар санагдлаа.

Нэр томьёоны өгөгдлийн сан үүсгэх нь

Монгол хэлний нэр томьёог корпус хэл шинжлэлийн аргаар боловсруулах, тухайн салбарын нэр томьёог стандартчлахад агуулга, хэлбэрийн болон техникийн асуудлыг шийдэх арга замыг тодорхойлох асуудлыг аажмаар шийдсээр ирлээ. Жишээ нь ШУТИС-ийн англи хэлний багш Г.Баярмаа өөрийн докторын ажлаараа (2014 онд) нэр томьёог машинаар боловсруулахын үндэс суурь болсон өгөгдлийн сан /DATABASE/-г мэдээлэл холбооны салбарын жишээн дээр үүсгэв. Энэхүү сан нь 99940 нэр томьёог багтаасан англи-монгол хэлний параллель сан байхаас гадна нэр томьёог бүтээх зарим арга /идэвхтэй дагаврууд/-ыг тэмдэглэж /tagging/өгснөөрөө тухайн салбарт үг бүтэх түвшний судалгаа хийж болох онцлог бүтээл болсон байна.

Энэ санг бусад мэргэжлийн судлаачид улам хөгжүүлэн салбар тус бүрээр үүсгэж, нэр томьёоны дорвитой нэгдсэн хөмрөг үүсгэж болох юм.

1960 аад оноос хойших компьютерийн өгөгдлийн баазад хадгалагдаж байгаа корпорацийн эмхэтгэл болон дүгнэлтүүд нь корпус хэл шинжлэл хэмээх шинэ салбарыг бий болгосон.

Корпус хэл шинжлэл бол хэл шинжлэлийн бүх салбарт болон олон янзын програм хангамжуудад текст болон эхийг тодорхой хэмжээнд автоматаар ангилан ялгаж, боловсруулж, хэлийг судлах эхийн өгөгдлийн санд тулгуурласан хэл шинжлэлийн шинэ чиглэл бөгөөд корпус нь хэлний эхийн өгөгдлийн санг байгуулж, бүрдүүлж, боловсруулж, ашигладаг компьютерийн хэд хэдэн программын баазад суурилсан судалгааны талбар юм. Корпус хэл шинжлэл нь төгс судлагдаагүй боловч хэлний хэрэглээ болон бүтцийн тодорхойлолтуудыг сайжруулж буй нэг эх сурвалж ба хэлийг машинаар боловсруулах болон хэлийг хэрхэн сурах болон заах талаар ойлголтыг багтаасан олон төрлийн хэрэглээний цогц юм.

Хэлний эхийн өгөгдлийн санг хадгалахдаа зүгээр нэг үгсийн цуглуулга биш үгсийн аймгаар таниулж, хэлзүйн хэлбэржилтийн тэмдэгтийг нь хадах зэргээр тусгайлан боловсруулсан мэдээллийг компьютерт таниулсан байдлаар бүрдүүлнэ. Ингэснээр хэлний зүй тогтлыг нарийвчлан судалж (бодит баримт, тоон үзүүлэлтэд тулгуурлан) нээн гаргах боломж бий болох төдийгүй цаашид хэл шинжлэлийн олон салбарын хэрэгцээ шаардлагаас үүдэн эхийн өгөгдлийн санг нэмэн баяжуулах, улам боловсронгуй болгох, эхийн өгөгдлийн сангаас хэрэгцээт зүйлээ аль болох бага цаг зарцуулан эрж олох зэрэгт зориулсан тусгай программыг хийх нөхцөл бүрддэг.

Орчин үед нэр томьёоны үүрэг нь нэг хэлний хүрээнээс хальж, олон хэлний хүрээнд техник технологийн дэвшил ашиглан харилцах, тусгай мэргэжлийн санг бүтээхэд чухал нөлөөтэй болсон. Ийм учраас технологийн хурдацтай энэ эринд нэр томьёо тогтоох үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, олон улсын стандартыг хэрэгжүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх зорилготой Олон улсын нэр томьёоны мэдээллийн төв—(International Information centre for terminology)-ийг 1971 оноос НҮБ болон Австрийн стандартын хүрээлэнгийн хоорондын гэрээгээр байгуулжээ.

Эрдэмтэн Д.Болд “...Сүүлийн арав гаруйхан жилийн хугацаанд компьютер хэл шинжлэл корпус буюу “махбод хэл шинжлэл” компьютерт суурилсан орчуулга, нэр томьёо судлал зэрэг эрчимтэй хөгжиж, нэр томьёоны хэдэн зуугаар тоологдох томоохон электрон бааз үүсч, тэдгээрийг дэмжсэн хэрэглээний программууд бий болжээ. Нэр томьёоны тусгай программуудад / нэр томьёоны өгөгдлийн баазууд, нэр томьёоны удирдлагын системүүд, нэр томьёоны солилцох форматууд г.м./ зориулсан өгөгдлийн загварчлалын хувьд Олон улсын Стандартчиллын байгууллага, олон улсын экспертүүдийг оролцуулан ISO/TC37 нэр томьёо боловсруулах арга зүйн стандартуудыг гаргаж, түүнд тулгуурлан хөгжингүй улс орнууд өөр өөрийн үндэсний нэр томьёоны өгөгдлийн баазуудыг үүсгэжээ” хэмээн дүгнэжээ (Болд.Д.,2009, х.45)

Энд дурдсан ISO/TC37 байгууллага нь Олон улсын стандартын байгууллагын доторх Техникийн хороо юм. Terminology and other language and content resources

буюу Нэр томьёо, олон хэл түүний эх сурвалж гэдэг нэртэй агаад олон улсын стандартын үйл ажиллагааг удирддаг дараах таван салбартай. Үүнд:

- ISO/TC 37/SC 1 Нэр томьёоны стандартын зарчим болон аргыг тогтоох (Principles and methods)
- ISO/TC 37/SC 2 Нэр томьёо судлалын болон үгийн сангийн судалгаа хийх (Terminographical and lexicographical working methods)
- ISO/TC 37/SC 3 Нэр томьёоны ухагдахуун, агуулга, тогтолцоог удирдан зохион байгуулах (Systems to manage terminology, knowledge and content)
- ISO/TC 37/SC 4 Хэлний эх сурвалжийг зохицуулах (Language resource management)
- ISO/TC 37/SC 5 Технологийн талаарх орчуулга, тайлбар, танилцуулга (Translation, interpreting and related technology) хийх гэсэн үндсэн үүрэгтэй байна. www.ISO/TC37

Техник технологийн дэвшлийн эрин үед бид монгол хэлний үгийн санд орос, англи зэрэг хэлний үг замбараагүй орж ирэхээс сэргийлж шинжлэх ухаан технологийн салбарын нэр томьёог монгол хэлнээ орчуулах, оноох, жигдлэх болон хэвшүүлж хэрэглэхэд байнга анхаарах нь чухал. Иймээс нэр томьёог цаасан хэлбэрээр толь бичиг, нэр томьёоны санг үүсгэхээс цааш компьютер болон сүлжээнд суурилсан нэр томьёоны өгөгдлийн баазуудыг бий болгох нь нэр томьёог оноох, тогтоох, нэг стандартад оруулах, улмаар жигдлэх, хянахад илүү дэвшилттэй бөгөөд өнөөгийн шаардлагад нийцнэ. (Г. Баярмаа, 2014 х. 94)

Монгол хэлний нэр томьёоны өгөгдлийн санг байгуулах талаар БНХАУ-ын ӨМӨЗО-ны эрдэмтэд багагүй зүйл хийж “Монгол хэлний нэр томьёог журамжуулах DITA” корпусыг үүсгэн ажиллуулжээ. Энэ корпуст 300 салбар мэргэжлийн нэр томьёог оруулахаар төлөвлөснөөс одоогийн байдлаар 25 тусгай мэргэжлийн нэр томьёог оруулаад байгаа юм байна. (Нэр томьёо судлал №15 Уб., 2013, х.117)

Корпуст үгсийг хадгалахдаа зүгээр нэг үгсийн цуглуулга биш үгсийн аймгаар таниулж, хэлзүйн хэлбэржилтийн тэмдэгтийг нь хадах зэргээр тусгайлан боловсруулсан мэдээллийг компьютерт ойлгуулсан байдлаар бүрдүүлнэ. Ингэснээр хэлний зүй тогтлыг нарийвчлан судалж (бодит баримт, тоон үзүүлэлтэд түшиглэн судлах) нээн гаргах боломж бий болох төдийгүй цаашид хэл шинжлэлийн олон салбарын хэрэгцээ шаардлагаас үүдэн хөмрөгөө нэмэн баяжуулах, улам боловсронгуй болгох, корпусаас хэрэгцээт зүйлээ аль болох бага цаг зарцуулан эрж олох зэрэгт зориулсан тусгай программыг бий болгох нөхцөл бүрдэх юм. Гэвч монгол хэлний хэлзүйн хэлбэржилтийн тэмдэгт/тааг/ одоогоор хийгдээгүй байна. МУИС-ийн ХШУИС-ийн Машин оюуны лабораторийн хэл боловсруулалтын багаас монгол хэлний тааглалтыг хийх ажлыг нэлээд хэдэн жил хийж байгаа ч нийтийн хүртээл болоогүй байна. Тухайн компани буюу байгууллага өөрийн үйл ажиллагаанд хэрэглэгддэг нэр томьёо болон товчилсон нэр томьёог цуглуулан хадгалж, байн байн шинэчилж байх шаардлагатай болсон өнөө үед нэр томьёоны менежмент /terminology management/ хэрэглэж байгаа нь орчуулагчдын цаг хугацаа, хөдөлмөрийг хэмнэсэн технологи болжээ. (Vanessa D., 2016 p.7) Бид ШУТИС-д

одоогоор уул уурхай, эрчим хүч, барилгын нэр томъёог сонгон авч нэр томъёоны файл үүсгэж байгаа ч нэгэнт цуглуулсан нэр томъёог дотроо зүйлчлэн ангилаагүй үндсэн ба дэд салбарын ялгааг гаргахад бэрхшээлтэй, нэр томъёоны ойролцоо утга ихтэй учир хүндрэлтэй асуудал их байна.

Дүгнэлт

Нэр томъёог оноон тогтоох, жигдлэх асуудлыг нэгдсэн бодлогоор хангах хэрэгцээний үүднээс тухайн салбарын мэргэжилтнүүд болон хэлний салбарын судлаачид хамтран ажиллах тухайн салбар дотроо нэр томъёогоо жигдэлсний дараагийн асуудал нь стандарт буюу олон улсын буюу улс хоорондын стандартанд тааруулах зайлшгүй шаардлагатай байдаг учраас энэ талаар энэ талаар судлах хийж гүйцэтгэх ажил их байна.

Нэр томъёог боловсронгуй болгох компьютер ашиглан боловсруулан сан хөмрөг үүсгэхдээ үгийн бүтцийг хэлзүйн дүрмийг баримтлан үг бүтээхийн зэрэгцээ, шинжлэх ухааны салбарын ангиллыг зөв баримтлах нь цаашид олон улсын стандартаар ангилсан тогтолцоог боловсруулах ажилд дөхөмтэй болох юм.

Ашигласан ном хэвлэл

1. Баярмаа, Г., Мэдээлэл холбооны технологийн нэр томъёо, түүний цахим сан бүрдүүлэх нь /2014 х. 94/
2. Болд,Д., Нэр томъёоны өгөгдлийн сан байгуулах нь. “Хавсарга хэл шинжлэл” No02, 1/2009, х.45
3. Дашдаваа,Д., Равдан, Э., “Нэр томъёоны тухай” Уб., /1980 х.12/
4. Нэр томъёо судлал №15 Уб., /2013, х.117/
5. Туул, Д., Техник технологийн нэр томъёог тогтоох, жигдлэх асуудалд “Хавсарга хэл шинжлэл” No 06, 1/2012, х.32
6. Шагдарсүрэн, Ц., Монгол нэр томъёоны одоогийн байдал, цаашдын төлөв. “ШУА” сэтгүүл, No6.1984, х.60
7. Пюрбеев Г.Ц. “Современная монгольская терминология” /М., 1984., х.175/
8. Vanessa Drexler *I don't translate, I create An online Survey on Uniformity Versus Creativity on Professional Translations.* Hamburg Anchor Academic Publishing /2016., p.7/
9. www.ISO/TC37

Resume

New terms are translated from English and these terms are widely used in modern Mongolian language. When these terms are used in communication they should carefully follow language standards and rules and therefore we should pay attention on how these terms are properly used in writing and speaking language.

Language and non-language reasons need to be considered in the study for terms and many problems by these situations can be solved by using information technology applications.

МОНГОЛЧУУДЫН ТОГТООСОН ОРЧУУЛГЫН ОНОЛ, ЗАРЧИМ

Ш.Эгшиг¹

*Утгын өвгөн үгийн таяг тулж,
уламжлалт тогтоосон даягаа түшин
их хөлгөн судруудаа орчуулсан,
харийн утга зохиолоос тана шүрийг нь шүүрдэж,
өөрийн зохиол лугаа монголжуулсан
эртний соёлт үндэстэн
эдүгээ дэлхийн ухаадын онол зарчмаас хүртэн тунгааж
даяаршсан ертөнцөд ондооших эрмэлзэлтэй аж төрөн оршоор...*

摘要：蒙古人很早就开始翻译世界经典并利用各种翻译方法及原则进行翻译工作。时间长了，蒙古民族游牧生活特色对蒙文翻译作品反映了影响，很多蒙古学者及翻译家都归纳那些翻译作品而结论蒙古翻译的理论及原则。本文将从历代翻译原则形成、发展论述到当代蒙古翻译理论相关问及挑战。

Түлхүүр үг: *Мэргэд гарахын орон, монгол орчуулгын онол, орчуулгын зарчим, хэлмэрчлэхүй, орчуулгын монголжих үзэгдэл, нутагших үзэгдэл, хувиргалын зарчим*

Монголчуудын орчуулгын уламжлал олон зууны түүхтэйг хэн хүнгүй мэднэ. Тэрхүү орчуулгын охь ундаргаас оюунт монголчууд олон үеэрээ хүртэн, гадны зохиол бүтээлийг эх хэлээрээ уншиж сонсдог байсан төдийгүй монгол их гүүш, дуун хөрвүүлэгч нар нь монгол зохиол бүтээлийг гадаад хэл рүү, тэр байтугай гадны зохиол бүтээлийг өөр нэгэн гадаад хэл рүү орчуулан буулгаж байсан баялаг уламжлалтай соёлт ард түмэн билээ. Орчуулан буулгах арвин их туршлага хурааж, тэрхүү уламжлал туршлагаасаа орчуулгын монгол онол, зарчмыг тунгаан авч, “Мэргэд гарахын орон нэрт тогтоосон даяг оршвой” хэмээх монгол орчуулгын онолын томоохон бүтээлийг туурвисан байдаг. Монголчууд эдүгээ хүртэл энэхүү орчуулгын онол, зарчмыг үндэс болгон, төр шашны болон иргэний зохиол бүтээлийн орчуулгын судалгааг хийсээр иржээ. “Мэргэд гарахын орон”-ыг бүтээн туурвихаас өмнө монгол дуун хөрвүүлэгч, гүүш нар хэдэн зууны турш гадаад хэлнээс арвин их зохиол бүтээлийг орчуулж ирсэн туршлагадаа дулдуйдан орчуулга нь хүн тус бүрийн бүтээл байдаг гэдгийг мэдсэн хийгээд нэг хүн гагцаар хийхээргүй Ганжуур, Данжуур лугаа адил төр шашны том том бүтээлийг орчуулахад зайлшгүй хэрэгцээт нэр томъёог оноон тогтоох, орчуулах онол зарчмаа хэлэлцэн тогтох ёстой гэдгийг бултаар зөвшин, XVIII зууны эхээр Данжуурыг орчуулахаар хийсэн бэлтгэл

¹ МУИС, ШУС, ХУС-ын Ази судлалын тэнхим, дэд профессор, доктор

ажил нь уг хөлгөн судрыг орчуулсан хугацаанаас урт хугацаа зарцуулж “Мэргэд гарахын орон” хэмээх нэр томъёоны толийн модон барыг 1742 онд сийлэн хэвлэсэн нь олон зуунаар хуримтлуулсан туршлагынх нь үр шим байсан² гэж Ц.Шүгэр өгүүлэлдээ дурдсан байдаг.

Тэрбээр “Мэргэд гарахын орон нэрт тогтоосон даяг оршвой”-д буй орчуулах гол зарчмуудыг өнөө цагийн ойлгомжит хэлээр³ дараахь мэтээр бичжээ.

- Орчуулагч өөрт сэжигтэй санагдсан бүхнийг нэрэлхэж, цээрлэлгүй мэдэх хүнээс асуух ба өөрийн дураар бүү нэрлэ, нийтээр мэдэх утга дүйсэн жин таарсан үгийг сонгож ол, тэр үг нь урд хойд үгэндээ харшлах ёсгүй.
- Зарим газар өгүүлбэрийн утга санаанд гэм үл болох үгийг орхиж, зарим газар утга тодруулах үг нэмж болно.
- Олон утгаар ойлгож болох үгийг тун сайн нягталж байж авах хэрэгтэй хийгээд таарах үг олдохгүй бол эх зохиолын үгийг авч болно.
- Оноосон нэрийг орчуулахдаа эх зохиолын нэрийг тэр чигээр нь тавиад ар талд нь юуны нэр гэдгийг бичнэ.
- Зохиогчийн санааг алдагдуулж болохгүй, сайжруулах нэрээр хүний зохиолыг засч үл болно.
- Зохиолчийн далд утгатай бичсэнийг ил утгатай болгох хэрэггүй.
- Шүлэг орчуулахдаа толгой холбох нь зүйтэй боловч, толгой холбосноор олон үг ордог болохыг анхаарууштай.

Д.Дагвадоржийн “Монголын гүн ухааны уламжлалт тогтсон таалал”⁴ гэдэг номд Мэргэд гарахын орны тогтоосон орчуулгын 16 зарчим баримжаа байгааг жагсаасан байдгийг энд зориуд тоочин орууллаа.

1. Гол нэрийн үгс төвд хэлнээ ямар утга хадгалсан байсныг монгол хэлнээ орчуулахдаа утгыг алдагдуулахгүй тэр ёсоор орчуулах зарчмыг баримтлах.

2. Төвд хэлний үгийг орчуулахдаа хэлний байрлалыг харгалзан сольж болох боловч утгыг гээгдүүлж үл болох, энд үгийн чадал гаргагч буюу үгийг онож, хэллэг тодорхой байх зарчмыг баримтлах.

3. Төвд хэлний үг монгол хэлээр олон үг буюу үсгээр илэрхийлэгдэж болох боловч утга алдагдах бол илүү үгийг хасаж найруулах.

² Ц.Шүгэр, “Мэргэд гарахын орон нэрт тогтоосон даяг оршив”, Орчуулах эрдэм, Улаанбаатар, 1972, 10-р тал.

³ Мөн тэнд, 9-11-р тал.

⁴ Д.Дагвадорж, “Монголын гүн ухааны уламжлалт тогтсон таалал” (Мэргэд гарахын орон дээж бичгийн сурвалжаар), Алтан гадас одонт Улсын Багшийн Их сургууль, Улаанбаатар, 1994, 11-12-р тал.

4. Зарим үед үгийг нэмж байж утгын чадал илэрхийлэгдэх байвал утгыг тодорхойлохын үүднээс үг нэмэн орчуулах зарчмыг баримтлах.

5. Нэг нэр олон утга илэрхийлэх учир утгад тохируулан орчуулах ба хэрэв утга санаа бүрэн илрэх боломжгүй бол төвд үгээр тавих.

6. Хүний ба газар усны нэр тэргүүтнийг орчуулж болох боловч энэтхэг ба төвд нэрийг заавал тавих.

7. Их гол нэрийн зүйлийг урьд орчуулсантай тохирч буй эсэхийг шалган нэгэн мөр болгон орчуулах.

8. Хэрэв үгсийг орчуулахад зөрөө гарч маргавал эсэргүүцэгч, хариулагчийн саналыг сайтар харгалзахын хамт тухай бүр тусгай комиссоор хянуулан шүүлгэж аль үнэнийг олж тавих.

9. Магтах, магадлах, гайхах, уйтгарлах, айхын утга агуулсан үгсийг монгол хэлэнд хөрвүүлэхдээ хотлоор алдаршсан бөгөөд утга илэрхийлэн сэтгэл хөдөлгөж чадахуйц үгсээр орчуулах.

10. Голын утга санаа тод илрэгдэхгүй буюу буруу номолсон нь илэрхий байсан ч засвар нэмэлтгүйгээр зохиогчийн анхны утга санааг алдагдуулахгүй байх зарчмыг баримтлах. Энэхүү ёс алдагдвал багш нарын таалсан ёс солигдоход хүрч, утга алдагдахад хүрнэ гэдгийг зарчим болгох.

11. Зохиолын гол зүйлд тухайлбал бурхан, эд, тоо тэргүүтний нэрийг нууц далд үгээр илэрхийлсэн бол тэр ёсыг баримтлан орчуулах. Хэрэв жинхэнэ нэрээр орчуулбал далд утгын агуулга хаягдахад хүрэх учир үүнийг хатуу баримтлах.

12. Зохист аялгуу зэрэг яруу найрагт үгсийг илт өгүүлэхгүйгээр өгүүлсэн бол өөрийн нь биш ёгт нэрийн далд утгаар орчуулах. Жишээ нь: Илжгийг сайн хоолойт гэсэн бол түүгээр илэрхийлсэн мэт.

13. Гүн ухааны ба бусад аймгуудад үг олон утгаар илэрхийлэгдэх учир өөр өөрийн гол ёсонд ямар утгыг хадгалдаг бол тэр ёсоор үйлдэх. Үүний тулд аймаг тус бүрийн утгыг сайтар хөөн мэдэж орчуулах.

14. Бүтээсэн, бүтсээр, бүтэх мэтчилэн өнгөрсөн, одоо, ирээдүйн үгсийн ялгалыг шинжилж, зохих утгыг алдагдуулалгүйгээр байрлуулан тавих.

15. Шүлэглэсэн хийгээд үргэлжилсэн үгс тус бүрийн ялгалыг сайтар анхаарч, шүлгийг орчуулахдаа утга төгс мэдэхүйг хялбар байлгахын дээр монгол хэлэнд алдаршсан толгой холбох мэтээр үйлдэх. Гэхдээ их голын утгыг илүү үгээр нэмэн засварлахыг хориглох.

16. Дохио найруулгын үгсийг шинээр найруулж болох боловч уул үгийн утгыг анхны хүрээнд байлгаж, түүний гол ба учир шалтгаанд харшуулалгүй онож орчуулах зарчмыг баримтлах.

Д.Дагвадорж гүүш энэхүү 16 зарчим баримжааг “Нэрийтгэн найруулах” хэмээн нэрийдэж, эдгээр зарчмуудыг цаазлан тогтоосон нь зөвхөн Данжуурыг төдийгүй цаашдын орчуулгын онолын суурь дэвсгэр болж өгсөн гэжээ.

Монгол орчуулгад утгыг гол болгох үндсэн зарчимтай байсан хэдий ч, бурхны шашны зохиол бүтээлийн орчуулгад “дуу”-г гол болгох зарчим ч чухал байсан тул тухайн зохиолын агуулгын утгыг шүтэхээс илүүтэйгээр үгчлэн буулгах хандлага төвд, самгарди хэлнээс орчуулсан шашны зохиолд илүүтэй ажиглагддаг талаар эрдэмтэд⁵ ихээхэн анхааран тэмдэглэсэн байдаг билээ. Тэгээд ч энэхүү хоёр зарчмаар төвд хэлнээс нэг зохиолыг судрын орчуулга, аман судрын орчуулга хэмээн хоёр өөр хэлбэрээр орчуулан, нэг нь номын шидийг үзүүлэх, шашны уншлагын хэрэгцээт орчуулга болж, нөгөө нь энгийн ардын дунд ойлгомжтой хэлээр тархан түгж байсан нь мөнөөхөн манай өвөг дээдэс ямархан их ухаантайгаар орчуулгын ажлыг хийдэг байсны гэрч юм.

Манай нэрт төвдөч, орчуулгазүйч Л.Хүрэлбаатар бол орчуулгын харьцуулсан судалгааг дорвитой хийсэн эрдэмтэн билээ. Тэрээр орчуулгыг харьцуулан судлахдаа төвд хэл мэдэхгүй хүнд ч ойлгомжтой байхуйцаар “Төвд эхийг үгчлэн орчуулбал”⁶ хэмээгээд, өөрөө үгчлэн буулгаж бичсэний хойно бусад гүүш нарын орчуулгыг зэрэгцүүлэн тавьдаг нь өөрөө судлахын дээр бусад судлаач нарт харьцуулан харахад нь улам хялбар дөт болгож өгсөн байдаг. Ийм орчуулгын судалгаа тийм их тохиолддоггүй. Л.Хүрэлбаатар багштан бас төвд эх ба төвд эхийн үгчлэн орчуулсан хэсэгт эх ба орчуулгын дүйх дүйх газарт нь тухайн төвд эхийн үгийг хэрхэн буулгасныг тоогоор тэмдэглэн онолдуулсан⁷ нь харьцуулан үзэхэд бүр ч ойлгомжтой болгосон байдгийг түүний номыг үзсэн хүмүүс анзаарсан буй заа. Их эрдэмтний энэ арга бол өнөө бидний үед орчуулгын ангийн оюутанд “Орчуулгын дүн шинжилгээ” хэмээх хичээлийг заахад ихээхэн хэрэглэдэг арга бөгөөд үнэндээ хэрвээ орчуулгын судалгаа хийх гэж байгаа бол ийм аргаар судлахаас өөр яах билээ хэмээн багштаны номыг үзэх бүртээ боддог юм. Нэрт орчуулгазүйчийн судалгаанд тухайн үеийн монгол орчуулагчдын орчуулгын талаархи дүгнэлтийг Цахар гэвш Лувсанцүлтэмийн орчуулгаар жишээлэн “Сайн үгт эрдэнийн сан Субашид”-ын

⁵ Д.Цэрэнсодном, “Орчуулгын зохиолын өв уламжлалаас”, Орчуулах эрдэм, Улаанбаатар, 1972, 21-р тал., Л.Хүрэлбаатар, Монгол орчуулгын товчоон, Улаанбаатар, 1995, 9, 62-р тал г.м. Р.Гүрбазар, Орчуулгын онол дадлагын үндэс, Улаанбаатар, 1996 он

⁶ Л.Хүрэлбаатар, Монгол орчуулгын товчоон, Улаанбаатар, 1995,

⁷ Мөн тэнд

орчуулгуудыг харьцуулан үзээд хэрхэн хийснийг судлаач, орчуулагч Д.Үржиндорж⁸ онцгой олж тэмдэглэснийг энд бас дурдсу.

1. Төвд эхэд байгаа шашин номын санааг ертөнцийн хүний амьдралд тохируулж иргэншүүлсэн;
2. Төвд эхэд өгүүлсэн зүйлээс зөвхөн санаа төдийг нь авч, бусдыг нь бүр шинээр боловсруулан зохиосон;
3. Төвд эхэд товч бүдэг өгүүлсэн санааг ихээхэн баяжуулж нийгмийн тодорхой учир холбогдолд оруулсан;
4. Хаад, ноёд ихэст хандаж сургасан зүйлийг энгийн ард, нийт хүмүүсийн зан харилцаанд тохируулан өргөжүүлж, хэн хүнд хамаатай сургаал болгосон;
5. Энэтхэг, Төвдийн ахуйг монголжуулсан;
6. Монгол шүлгийн онцлогийг бүрэн тусгасан;

Энэ мэт Л.Хүрэлбаатар багштан монгол хэлээр орчуулж байсан гүүш, дуун хөрвүүлэгч нарыг нэгбүрчлэн тодорхойлж бичиж, нийтлэг монгол орчуулгын зарчмыг нарийвчлан тодорхойлон гаргаж өгч, бидний үед хүргэсэн хэрэг юм. Олон удаагийн хийгээд олон хүний орчуулгын практик ажлаас онолын асуудлыг боловсруулан гаргаж ирнэ. Энэ нь далай дотроос сувд, шүр шүүрдэхийн адил амаргүй ажил боловч тэрхүү онолыг гаргаж авч гэмээ нь орчуулгын ажилд байнга тохиолдох нарийн төвөгтэй асуудлыг шийдэхэд эргээд маш их тус нэмэр болдог билээ.

Нанхиадын гүн ухааны сонгодог зохиол бүтээл хийгээд сонгодог уран зохиолоос яруу найраг, тууж, романыг монгол их гүүш нар монгол хэлнээ буулгахдаа ихэвчлэн утгачлан орчуулах зарчмыг барьж байсан байдаг, нанхиадын түүхэн дэх иргэний шинжтэй зохиолын орчуулгыг тэгж ч хийхээс өөр замгүй, чингэхдээ зохиолын өмнөтгөл утгын чимэг болсон шүлэг сэлтийг нь орчуулахдаа монгол шүлгийн үндсэн хэлбэрт ойртуулж, ихэвчлэн толгой холбосноос болж, хятад эх дэх шадын үе ба үгийн тоо хэтрэх нь нийтлэг ажиглагддаг байна. Уран зохиолын орчуулгын хувьд нанхиадын иргэний шинжтэй уран зохиолын доторхи өгүүлэмж агуулга нь монголчуудын хувьд өөр соёлын хийгээд сонин содон, ээдрээ ихтэй байдаг тул үүнийг монгол ахуйдаа ойртуулах, өөрчлөх, шинээр зохиомжлох, өөриймшүүлэх олон арга замаар монголжуулсан үзэгдэл түгээмэл байсан нь угаас монголчуудын нүүдэлчин ахуйгаас үүдэлтэй болох тухай орчуулга судлагч нар ямагт анхааран тэмдэглэж ирсний жишээ бол Б.Ринчен, Ц.Дамдинсүрэн, Л.Хүрэлбаатар нарын их эрдэмтдийн судалгаанаас харагддаг⁹ билээ. Гадаадын эрдэмтэд ч энэ талаар бүр дорвитой судалгаа¹⁰ хийн гаргасан байна.

⁸ В.Н.Комиссаров, Орчуулгын онол, Орос хэлнээс орчуулж, монгол оюутнуудад зориулан боловсруулсан Л.Үржиндорж, Улаанбаатар, 2008, 213-214-р тал.

⁹ Ринчен.Б "Жанр *bengsen-ü üliger* в монгольском фольклоре", - Studia Mongolica, Tomus I, Fasc. 19, Улаанбаатар, 1959, стр. 5, 8

Орчин үеийн орчуулгын судлалын гол чиглэл бол хэнд орчуулж өгөх вэ, зөвхөн санааг хөрвүүлэн хүргэх гэсэн энэ хоёр чиглэлд илүү анхаарч судалгаа хийх ёстой хэмээн үзэх болжээ. Улмаар энэ нь өөр өөр хэлт үндэстний соёлыг хөрвүүлэн орчуулах тухай асуудалд хүргэсэн бөгөөд “соёлыг орчуулах” хэмээх олон ухааны дундаас үүссэн шинэ ухагдахуун үүсэн, энэ чиглэлд орчуулгазүйн сүүлийн үеийн чиг хандлага төвлөрч байна. Орчуулгын онолын ойлголтуудад Ю.А.Найдын идэвхт дүйцэл, Р.Якобсоны ялгарлын дүйцэл, Ж.Катфордын хөрвүүлэг, Ж.Хаусын ил ба далд санааг нягтлах, Г.Ч.Спивакийн постколониализм ба олон ургальч соёлын асуудал гээд соёлын зүйлийг орчуулах тухай онолын олон тодорхойлолт, дэвшүүлсэн санаа бий. 2002 онд С.Хервей ба Я.Хиггинс нарын дэвшүүлсэн томъёолол¹¹ орчуулгын нутагших үзэгдэлд тохирч байгаа юм. Тэдний томъёолол бол **этгээд ухагдахуун-дуурайлган буулгах-соёлоосоо зээлэх-орчуулах/хэлмэрчлэх- шинэ соёл нутагших** гэсэн томъёолол бөгөөд энэ санаа нь дээр өгүүлсэн уран зохиолын нөлөөллийн зүй тогтолтой мөн ямар нэгэн байдлаар холбоотой байгаа юм. Энд томъёолсон **этгээд ухагдахуун** ба **шинэ соёл нутагших** гэдэг хоёр ойлголт бол нийгмийн дотор бодитоор оршиж буй үйл үзэгдэл бөгөөд хүний ухамсраас ангид оршино. Харин **дуурайлган буулгах-соёлоосоо зээлэх-орчуулах/хэлмэрчлэх** хэмээх дэс дараатай үйл явц бол орчуулагч, хэлмэрч хүний тархин дотор болж буй тодорхой үйлдэл хөдөлгөөн хэмээн ойлгож болохуйц байна. Өөрөөр хэлбэл уран зохиолын орчуулга дахь эх зохиолын ба орчуулсан эх нь үндсэндээ өөр өөр соёлыг төлөөлсөн эх болох юм. Чингэхээр монголчуудын уламжлалт нүүдлийн соёл иргэншил өөрөө бусад үндэстний соёлын зүйлийг нутагшуулан авах илүү чадамжтай соёл байжээ гэж өмнө өгүүлсэн баримтаас дүгнэж болохоор байна. Орчин үеийн орчуулгын онолын төвшинд орчуулгаар дамжин өөр соёлын зүйлс нутагшин орж ирдэг зүй тогтлыг хэдийн тогтоожээ. Монголчууд харин олон зууны тэртээгээс тэрхүү зүй тогтлоор гадны соёлын зүйлийг орчуулгаар дамжуулан монголжуулан авч үндэстний соёлынхоо хүрээг тэлж баяжуулсаар ирсэн байна.

Эдгээр зарчмыг сайтар нягтлан үзвээс эхийн санааг алдагдуулахгүй байх, чингэхдээ онож орчуулах, үүний тулд хатуу үгчлэхээс зайлсхийх, утгад тохируулан

Ш.Эгшиг, *Хятадаас орчуулсан зохиолд монголчуудын Бэнсэний үлгэр холбогдох нь*, - Эрдэм шинжилгээний бичиг (МУИС, Гадаад хэл соёлын сургууль), Боть 180 (2), Улаанбаатар, 2011, 233-р тал

Г.И.Михайлов “Литературоведческое концепции Б.Я.Владимирцова”, Филология и история монгольских народов, АН СССР, Институт Востоковедения, Москва, 1958, стр. 55-57.

Б.Нямямгар, *Гүүш цорж Мялын бум дууллын орчуулгад үндсэн эхийн санааг монголжуулсан нь*. Хэл зохиол судлал. Уб., 2011.Т-IV (36), fasc. 34. 115-122-р тал

陈岗龙著, “**本子故事的史诗化**” 《蒙古英雄史诗〈锡林嘎拉珠巴图尔〉——比较研究与文本汇编》《中国民俗学年刊》(2000-2001年合刊), 学苑出版社 2002年, 第 142-156 页

Ш.Эгшиг “Монголчуудын орчуулгын бүтээлийн монголждог уламжлал”, Монгол хэлний тользүй, орчуулга судлал, “Монгол судлал ба тогтвортой хөгжил” сэдэвт Олон Улсын Монголч Эрдэмтний XI их хурал, 2016.08.15-18, Улаанбаатар.

¹⁰ 王浩, *翻译文学本土化命题的理论阐释*, 启蒙与建构, 策 - 达木丁苏伦蒙古文学研究, 北京大学出版社, 北京, 2016年

¹¹ Alireza Sadeghi Ghadi, Cultural translation, All new theories and concepts about translation in new century <https://www.scribd.com/document/249401273/All-Theories-in-translation>

орчуулах зарчим барьж байсныг үзвээс, бусдын соёлын зүйлийг аль болох ойлгомжтой буулгах чиг барьж байсан нь орчуулгын монголжих үйл явцад ямар нэгэн тогтор болохооргүй зарчим тогтоосон нь илт байгаа юм.

Орчуулгаас уламжлан монголжих үзэгдлийг онол ба аргазүйн талаас нь тайлбарлан үзэх нь судалгааны ач холбогдолтой болгоно. Ер нь уран зохиолын орчуулгын арга барилыг эрдэмтэн Р.Гүрбазар

- Бүрэн төгс
- Үгчилсэн
- Хялбарчилсан
- Тайлбарласан гэж ангилж болно гэж үзжээ.

Р.Гүрбазарын ангиллаар гадаад хэлнээс орчуулсан уран зохиолыг монголждог гэдэг үүднээс яривал, бүрэн төгс, хялбарчилсан, тайлбарласан орчуулгын хувьд ярих болно. Үгчилсэн орчуулга бол Монголын орчуулгын түүхэнд гагц шашны зохиол бүтээлийг орчуулахад хэрэглэдэг арга байсан гэж үздэг. Орчуулга бүрэн төгс байвал монголжих үйл явцад хамгийн дөхөм, хялбарчилсан ба тайлбарласан орчуулга нь угаас орчуулах уран зохиолын эхийн яруу тансаг байдлыг алдагдуулдаг талтай, гэвч монголчуудын орчуулгын түүхэнд байгаа монголжсон орчуулгын хувьд гол нь сэдэв ба өгүүлэмж, үйл явдал гол болохоос, эх зохиол нь бүрэн бүтнээрээ орчуулагдсан байна уу, эсвэл орчуулгаасаа гээгдсэн, агуулга, өгүүлэмж нэмэгдсэн эсэхийг нэг их тооцдоггүй байжээ. Бүрэн төгс орчуулахын гол шалгуурын нэг нь орчуулгын хэлний уран төгс найруулгын тухай асуудал байдаг. Эх зохиол дахь утга санаа, өнгө аясыг бүрэн дүүрэн ойлгож, санаагаа орчуулах хэл рүү хөрвүүлэн найруулахдаа яруу сайхан буулгах юм бол төгс орчуулгад дөхнө. Ийм сайн найруулгатай орчуулгыг манай дээдэс гүүш нар хийснээр цаашид эхийн монгол хэлээрх гадны соёлын санаа монголжиход илүү дөхөмтэй. Харин найруулгыг дорой хийж, өнгө аясыг нь өөрчлөх аваас, монголжихдоо огт өөр санаа өгүүлэмж болон хувирах магадлал нь ихэснэ.

Орчуулгын нутагших буюу монголчуудын хувьд монголждог энэхүү үзэгдлийг эцсийн байдлаар томъёолбол, гадны соёлын ба ахуйгаас бүтсэн утга зохиолын бүтээлч санааг авч өөрийн ахуйд тааруулан дахин бүтээн туурвих үйл явц гэж үзэж байна.

Монголын орчуулгазүйн ерөнхий хандлагыг түүхэн өнгөрсөн ба одоо цагийн хөгжлийн өндөрлөгөөс эргэн харвал, “монгол орчуулгын онол” хэмээх онолыг жинхэнэ сонгодог утгаар нь томъёолон, орчуулагч бүр нийтээр даган сайшааж, хэвших хэмжээнд хүртэл боловсруулсан бүтээл хараахан гараагүй байгааг гучаад жилийн тэртээ Г.Аким¹², Т.Содномдаржаа зэрэг орчуулга судлаач нар хөндсөн байдаг ба эдүгээ орчуулгын судлал эрчтэй хөгжлийн шатандаа байгаа хэдий ч мөнөөхөн орчуулгын онолын асуудал тулгамдсан асуудал хэвээрээ л байгаа юм.

¹² Г.Аким, *Орчуулгын онолыг хөгжүүлэх асуудалд*, Орчуулах эрдэм No.6, УХГ, Улаанбаатар, 1989 он, 3-8-р тал.

Гагцхүү “монголын” гэсэн орчуулгазүйн зарчим ба арга барил, уран чадварын асуудлыг л яриад байгаагаас бус дэлхийн бусад орон шиг утга зохиолын ба соёл дамнасан судалгааны нэг гол ухаан болсон орчуулгазүйг онолын төвшинд гартал нь өндөрт өргөх хэмжээний шинжлэх ухаанч судалгааны бүтээл одоо хэр нь гараагүй байгаа билээ.

Шинэ цагийн орчуулгын онолын гол санааг Б.Ринчен, Ц.Дамдинсүрэн, Ш.Лувсанвандан, Р.Гүрбазар, Г.Аким, Д.Дашдаваа, Ж.Баянсан, Я. Хишигт, О.Адъяа нар гаргасан байдаг билээ. Эдгээрт,

- Уран зохиолыг орчуулахад эхэд буй хүний сэтгэл хөдөлгөх тэр санааг мөн орчуулан гаргах хэрэгтэй, тэгж байж монгол хүн гадны зохиолчийн санааг амтлан мэдэх болно. Үүнийг Р.Гүрбазар “дүрийг сэргээн амилуулах” гэдэг үгээр илэрхийлэн хэрэглэж байв.
- Дүйцэлгүй нэрийг орчуулах зарчим, аргыг тодорхойлоход орос зэрэг хэлээс орчуулагч нар нэлээд судалж тогтоосон байдаг, үүнийг мөн зарим орчуулга судлаачид “реали”¹³, үндэсний онцлогт үг¹⁴ хэмээсэн нь бий.
- Шүлэг орчуулахад агуулга хэлбэрийг аль алийг нь бодолцон буулгах зарчмыг барих бөгөөд монгол шүлгийн онцлогоор толгой холбох, эсвэл орчуулж буй зарим хэлний онцлог болох сүүл холбохыг мөн орчуулгад тусгах, шүлгийн хэмнэл, шадын доторхи үг ба үеийн тоог чацуулах зэрэг аргуудыг хэрэглэх хийгээд шүлгийн уян яруу зохирлыг орчуулгад нь шингээх явдал чухал гэж Б.Ринчен нарын эрдэмтэд үзсэн¹⁵ байдаг.
- Орчуулга хийх хоёр хэлийг орчуулагч хүн аль алийг нь гаргууд сурах нь орчуулга хийх хамгийн гол түлхүүр бөгөөд, ялангуяа эх хэлний мэдлэг

¹³ Ё.Баярсайхан, *Орос хэлний реалийн орчуулгын зарим асуудалд*, Орчуулах эрдэм No.6, УХГ, Улаанбаатар, 1989 он, 101-106-р тал.

Ё.Баярсайхан, *Орос хэлний реали бүхий хэлц үгийн тухай*, Шинжлэх ухаан амьдрал No.6, Улаанбаатар, 1984 он, 66-68-р тал.

¹⁴ Д.Дашдаваа, *Үндэсний онцлог бүхий үг, хэлц үгийг орчуулах нь*, Орчуулах эрдэм No.1, Улаанбаатар, 1972 он, 127-132-р тал.

Ё.Баярсайхан, *Орос хэлний реали бүхий хэлц үгийн тухай*, Шинжлэх ухаан амьдрал No.6, Улаанбаатар, 1984 он, 66-68-р тал.

¹⁵ Б.Ринчен *"Шүлэг орчуулах эрдэм"*, - Орчуулах эрдэм № 1, 1972, 91-99-р тал

Б.Ринчен *"Энэтхэг яруу найргийн амт үнэрийг үлдээхсэн гэж..."*, Орчуулгазүйн сан хөмрөгөөс, Орчуулгазүй Боть 4(422), МУИС, 2015, 170-176-р тал.

Б.Явуухулан *"Яруу найргийн орчуулгын асуудалд"* Яруу найраг миний амьдралд, Улаанбаатар, 1983, 149-152-р тал.

С.Дулам, *"Орчуулгын онолын гурван цаг, дөрвөн зарчим"*. Дэлхийн яруу найргийн XXVI их хуралд зориулан хийсэн “Яруу найргийн орчуулгын тулгамдсан асуудлууд” сэдэвт эрдэм шинжилгээний хурал, Илтгэлийн эмхтгэл, 2005, Улаанбаатар.

А.Шархүү *"Яруу найргийн орчуулгад шүлгийн ур хийцийг нь дамжуулах асуудалд"* Орчуулгазүй, Боть 2, МУИС, ГХСС, 2013, 7-11-р тал.

Д.Бүрнээ *"Зохист аялгууны онол ба монгол орчуулга"*, ”, Орчуулгазүй, Боть 4(422), МУИС, 2015, 130-138-р тал.

Ш.Эгшиг, *"Хятадын эртний яруу найраг орчуулах нь"*, Орчуулгазүй, Боть 4(422), МУИС, 2015, 7-18-р тал.

чадварт зөв бичих, найруулан бичих, яруу мэдрэмжит байдлыг орчуулгад тусгах¹⁶ зэрэг орох нь дамжиггүй.

- Орчуулахдаа утгыг шүтэх нь илүү оновчтой болох хэдий ч хэлбэрийг барьсан үгчлэх аргыг бас орхигдуулж болохгүй.
- Орчуулагч хоёр хэлийг мэдэх гэдэг нь хоёр хэлээр яригч ард түмний үндэсний соёл заншлыг сайн мэдэх, байнга хэрэглэдэг хэлц үг, зүйрлэлийг мэддэг¹⁷ байж гэмээнэ нь утгачлан орчуулахад тустай. Энд мөн хэлшинжлэлийн харилцааны онол¹⁸ ба танихуйн ба сэтгэц хэлшинжлэлийн¹⁹ үүднээс орчуулгад хандвал илүү зөв оновчтой орчуулга болно гэдгийг сүүлийн үед ихээхэн ярих болсон билээ.

Орчуулгын ухааныг шинжлэх ухаанчаар судлан тайлбарлаж, ангилж, өрнийн орчуулгазүйн онол зарчмыг нь монгол хэлнийхээ онцлогт тааруулан тохируулах ажлыг Р.Гүрбазар, Г.Аким нар хийсэн байдаг. Тэдний онцолж байсан зарчим бол хэлшинжлэлийн хэлбэр судлалын ба хэлзүйн төвшинд хийх хувиргалыг зайлшгүй хийж байж орчуулга хийнэ хэмээсэн зарчим юм. Р.Гүрбазарын бас нэг хамгийн гол үзэл нь орчуулагч хүн бол орчуулах эхийн санаагаар орчуулагдах хэлээр дахин цоо шинээр эх боловсруулах бүтээлч хөдөлмөрийн үр дүн бол орчуулгын явц дахь хэл хоорондын бүх хувиргал²⁰ бөгөөд “Дүрийг сэргээн амилуулах” гэдэг зүйл орчуулгад байдаг гэж үзсэн явдал. Эдгээр хувиргалд өгүүлбэрийг нэгтгэн нийлүүлэх, салган задлах, шилжүүлэх хувиргал, солилт, нөхөлт, нарийвчлалт буюу тодруулалт, нэмэлт, орхилт, ерөнхийлөл зэрэг өдий төдий хувиргал багтана. Харин Г.Аким гуай хэлзүйн хувиргалын талаар орос хэлээс монгол хэлнээ орчуулах явц дахь жишээгээр тайлбарласан өгүүлэл²¹ бичсэн байдаг юм.

Гадаадын онол үзлээс илүүтэй, монгол хэлний мөн чанараас нь буюу хэлний дотоодоос нь гаргаж тогтоосон орчуулах хэлмэрчлэхэд тус дөхөм болох онолын баримтлал бол Ш.Лувсанвандангийн “Хэлний хийсвэрлэн сэтгэх арга”²² юм гэж үзэж байна. Хийсвэрлэн сэтгэх нь хүний амьтнаас ялгарах онцлог төдийгүй, энэ нь алив юмсын талаар хөгжил хөдөлгөөнд нь цогцоор нь авч үзэх тархины сэтгэж буй үйл явц боловч, хэлэхүйн хувьд бодат бөгөөд ухамсраас ангид орших талаар өнөөгийн түгээмэл хэлшинжлэлийн онолоор үүнийг тайлбарлаж байна. Орчуулах хийгээд хэлмэрчлэх явцад хүний тархинд болдог энэхүү хийсвэрлэн сэтгэх үйл явц

¹⁶ Ш.Чоймаа, “Монгол бичгийн хэлний орчуулга”, Орчуулгазүй, Боть 1, МУИС, ГХСС, 2013, 49-55-р тал.

¹⁷ М.Чимэдцэеэ, “Соёл хийгээд орчуулга”, Орчуулгазүй, Боть 1, МУИС, ГХСС, 2013, 56-65-р тал.

¹⁸ Я.Хишигт, Ж.Баянсан “Харилцааны онол, орчуулга”, Орчуулах эрдэм № 6, Улаанбаатар, 1989, 9-13-р тал.

¹⁹ Э.Равдан, Хэл шинжлэлийн түүхийн товчоон, Улаанбаатар, 2002 он, 230-258-р тал, Н.Нансалмаа, “Ерөнхий хэлшинжлэл”, Улаанбаатар, 2012, 171-173, 176-178-р тал.

²⁰ Р. Гүрбазар, Орчуулгын онол дадлагын үндэс, Улаанбаатар, 1996 он, 138-р тал.

²¹ Г.Аким, Орчуулгын санг уудлахад, Улаанбаатар, 1984 он, 37-53-р тал.

²² Ш.Лувсанвандан, Хэл шинжлэлд хийсвэрлэх аргын холбогдох нь, Хэл Зохиол судлал, IX боть, II дэвтэр, Улаанбаатар, 1972 он, 15-17-р тал.

хамгийн дээд хүчин чадлаар ажилладаг юм. Чингэхээр Ш.Лувсанвандан багштан угаас хэлний алив үзэгдлийг монгол хэлний дотоодоос нь олж тогтоодог эрдэмтэн судлаач байсан нь өнөөгийн орчуулгазүйн ухаанд монгол эрдэмтний оруулсан онолын шинжтэй “хур чанар” бөгөөд монголчууд бидэнд өвлүүлэн үлдээсэн монгол онол болох юм. Хэлний хийсвэрлэн сэтгэх аргыг гадаад хэл сургах, орчуулах эрдэмд сургахад хэрэглэхийн чухлын талаар багш эрдэмтэд мэдлэг туршлагаасаа эрдэм шинжилгээний хуралд илтгэсэн²³ баримт цөөнгүй, энэ нь мөн л угаас хийсвэрлэн сэтгэх нь хүний дотоод мөн чанарт байдаг зүйл учраас ямагт гадагш илрэн гарч байдгийн жишээ болж байна.

Орчин үеийн орчуулгазүйн онолын болон хөгжлийн өнөөгийн хандлага нь Соёлын нэвчлийн судлал (Intercultural Studies) ба Орчуулгазүй (Translation Studies) хэмээх хоёр ухааныг хамтатгасан **“Соёлын нэвчлийн орчуулгазүй”** гэсэн ухаан сүүлийн үеийн өрнөдийн онолчдын голд чиглэл болж байна. Мөн орчуулга дахь ижилсэх ба ондооших үзэгдлийн тухай яриа мэтгэлцээн ч их болдог. Энэ талаар манай орчуулгын судлаачид мөн л анхааран монгол орчуулгын уламжлал ба орчин үеийн байдлыг дүгнэн шинжилсэн бүтээл буй. Тухайлбал, М.Чимэдцэеэ багш “Үгчлэх, утгачлах, идээшүүлэх, ондоошуулахын харилцан шүтэлцээ” өгүүлэлдээ “...Орчуулахуйн ухааны дээрх хосмолжин ухагдахуун нь хос хосоороо харилцан сүлэлдсэн, харилцсан эсрэгцсэн, бас харилцан давхацсан нэр томъёонууд бөгөөд үгчлэх, утгачлахын тухайд хэлний бүтэц, өнгөн давхарга хэмээх нэг өнцгөөс авч үздэг бол идээшүүлэх, ондоошуулахын тухайд хэлний хэлбэр, соёлын агуулга хэмээх хоёр өнцгөөс авч үздэг, идээшүүлэх хийгээд утгачласнаар орчуулга ойлгомжтой болж, хүлээн авч орчуулж буй хэлний хэлзүйн хэв журамд нийцэж байдаг бол ондоошуулах хийгээд үгчилснээр орчуулга эх зохиолтойгоо дүйцэж, эх зохиолын хэв журамд нийцэж байдаг ажгуу.”²⁴ хэмээжээ. Мөн энэ чиглэлээр МУИС-ийн орчуулгын онолч нар болох Н.Нансалмаа, Г.Элдэв-Очир нар соёл хоорондын харилцаа ба соёлын утгаас нь орчуулгын онол аргагүйгээ тодорхойлох тэр чиглэлд орчин үеийн орчуулгын чиг хандлага явж байгааг дурдаж байгаа юм. Чингэвч бас өнөөгийн орчуулгын судалгаанд анзаарагдаж байгаа нэг асуудал бол даяаршлаас үүдэж, орчуулгын онол зарчимд гадны соёлын болон техник технологийн дэвшлээс болж, хэт ижилсэх хандлага давамгайлж, үндэстний хэлний дархлаа сулрах үйл явц хурдасч байгаа нь мэдэгдэж эхэлсэн тул энэ талд зарим судлаачид, ялангуяа эх хэлээ хамгаалах, эвдэхгүй байх талаар бичиж байгаа юм. Эрдэмтэн Ц.Шагдарсүрэн²⁵, С.Дулам²⁶, Я.Хишигт²⁷, Ц.Базаррагчаа²⁸ зэрэг олон

²³ Ц.Отгонсүрэн, *Гадаад хэл рүү орчуулга хийхэд хийсвэрлэл чухал*, Орчуулах Эрдэм IV, Орчуулгын тулгамдсан асуудлууд: Сургалт, Туршлага” сэдэвт онол практикийн бага хурал, Илтгэл өгүүллийн эмхэтгэл, 2012, 115-128-р тал.

²⁴ М.Чимэдцэеэ, “*Үгчлэх, утгачлах, идээшүүлэх, ондоошуулахын харилцан шүтэлцээ*” Орчуулгазүй, Боть 2, МУИС, ГХСС, 2013, 53-р тал.

²⁵ Ц.Шагдарсүрэн, “*Эх хэлээ эвдэхгүй юмсан*” Улаанбаатар, 2010.

²⁶ С.Дулам, “*Орчин үед тулгамдаж байгаа зарим нэр томъёог монголчлох асуудалд*” Орчин үед тулгамдаж байгаа зарим нэр томъёог монголчлох асуудалд. «Монгол нэр томъёо судлал-90 жил» ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, 2014, Улаанбаатар хот. 197-201-р тал.

эрдэмтэн судлаачдыг энд нэрлэж болно. Чингэхээр буруу орчуулга, яруу бус найруулга нь эх хэлийг эвдрэхэд хүргэнэ. Тэрхүү буруу орчуулж, уран яруу найруулахгүй байгаа орчуулагч эсвэл хэлмэрч этгээд бол эх хэлээ муу мэдэгч нар бөгөөд тэд эх хэлээ эвдэж сүйдлэх уршиг удаж байгаа хэрэг. Даяаршлын нөлөөнөөс гадны нөлөө ба дотоодын боловсролын бодлогын алдаанаас эх хэлний боловсролын тогтолцооны гэгээрүүлэх чанар нь доголдож, нэгэн үеийн “монгол хэлээ мэддэггүй” монголчууд төлөвшиж байгаа нь ч нэрмээс болж байгаа юм. Энэ нь манай “Мэргэд гарахын орон нэрт тогтоосон даяг оршвой”-д гардаг *“Хоор монголын тус тус орны үг гол адил олон болбоос бээр үзлэг өчүүхэн адил бус олон. Ялангуяа номыг орчуулахуй дор нэр дохио, нэрийдэх ёсыг цаазлан тогтоосон мэт нэгэн үгүйн тулд олон хэлмэрч нар өөр өөрийн зоргоор элдэв зүйл, үл зохилдох нэрийтгэл найруулбаас сонсох сэтгэхүйг дагагчдад мэдэх бэрх...”* гэсэнтэй агаар нэгэн адил байна. Угаас гадаад хэл эзэмшүүлэх өрнийн сургалтанд орчуулах ба орчуулагдах хоёр хэлийг тэнцүү төгс эзэмшсэн хүн сайн орчуулагч хэлмэрч болдог гэдгийг онолоор баталдаг, гэтэл үүнийг ч бас тэртээ XIII-XIV зуунд Монголчуудын Төрийн Хөвгүүдийн сургуульд баримталж сургадаг байсан талаар Д.Наран доктор баримтаар нотолсон²⁹, үүнийг Ц.Базаррагчаа багш мөн “эх хэл+гадаад хэл=сайн орчуулга, сайн хэлмэрч” гэсэн ном дүрэмтэй байсан гэж бичсэн нь бас л монголчуудын орчуулгын нэгэн баримтлах зарчим яахын аргагүй мөн. Саяхан нэрт орчуулга судлаач М.Чимэдцэеэ багш үе үеийн хятад хэлний орчуулагч нарын багш Ц.Базаррагчаа бол орчуулгын дэг сургуулиа үүтгэн буй болгосон³⁰ гэж дүгнэсэн билээ. Аливаа шинжлэх ухаанд онолын чиг хандлага буй болж буйн илрэл нь ямар нэгэн онол, зарчим тодорхойлогчдын үүсгэсэн дэг сургуулиар тодорхойлогдож ирснийг бид бэлхэнээ мэднэ. Олон хэлээс орчуулж, хэлмэрчилж ирсэн монголчуудын хувьд хэл хэлнээс орчуулж хэлмэрчилж ирсэн түүхтэй, тэдгээр хэл тус бүрд оноогдсон мэргэн гүүш, яруу найруулагч нар бий. Тэр бүгд өөр өөрийн дэгээр онолын санаа дэвшүүлж болно, чингэвч бүхий л хэлний нийтлэг чанарт ирж зангидагдах нь гарцаагүй.

Дүгнэлт

Бид орчуулгазүйн онолын асуудлыг сүүлийн үед нэлээд ярих болсон үед Монголын уламжлалт орчуулгын онол зарчмуудаа эргэн харах, шинээр нээж илрүүлэх замаар орчуулах ба хэлмэрчлэхүйн үйлд ашиглах хэрэгцээ их байна. Үүний зэрэгцээ орчуулгазүй хэмээх шинжлэх ухаан дэлхийн төвшинд хэр зэрэг хөгжиж, ямар төвшинд байгааг давхар судалж мэдэх, орчуулгын онолын гол гол бүтээлүүдтэй танилцах, харьцуулах ч хэрэгцээ буй болоод байна. Аливаа улс үндэстэн мандан бадарч, амар амгалан оршин байх ахуйдаа хэл соёлоо дээдэлж,

²⁷ Я.Хишигт, *“Сэтгэц, ухамсар, сэдэхлэгээний хоруу, орчуулгын асуудалд”* Орчуулах Эрдэм IV, Орчуулгын тулгамдсан асуудлууд: Сургалт, Туршлага” сэдэвт онол практикийн бага хурал, Илтгэл өгүүлийн эмхэтгэл, 2012, 74-86-р тал.

²⁸ Ц.Базаррагчаа, *“Хэдэн үеэ бүрэлгэх хэлний гамшиг”* МУИС, МХСС-ийн ЭШБ, 1999.

²⁹ Д.Наран, Монголын төр ёсны боловсролын түүх (13-14 дүгээр зуун). УБ., 2001.

³⁰ М.Чимэдцэеэ, *“Ц.Базаррагчаа багштаных орчуулгын дэг сургууль”* Хятад судлалын салбар-Нэгэн жаран, МУИС, Улаанбаатар, 2017, 243-258-р тал.

гадаад хэл соёлыг давхар үнэлж, орчуулгын ажил нь ч өрнөдөг³¹ гэж зарим эрдэмтэн үзжээ, чингэвч монголчуудын тухайд түүхэн аль ч үедээ орчуулгын ажлыг хийсээр ирэхдээ онолтой, зарчимтай, арга барилтай байсан юм.

Монголчуудын дэлхийн орчуулгын ухаанд оруулсан хувь нэмэр багагүй. Үндэсний сэтгэлгээний онцлог нэг тал нь бусдын соёлын гайхамшгаас орчуулгаар дамжуулан шимэн хүртдэг уламжлалтай байсанд оршино гэж үзэхээр байгаа юм. Орчуулгын онолын сэтгэлгээний уламжлал нь зэргэлдээх соёлт үндэстнүүдийн орчуулах хэлмэрчлэх ухааны онолын сэтгэлгээнээс түрүүлж явснаас бус, хоцорч байгаагүйн шалтгаан бол монголчууд ямагт дэлхийн сонгодог зохиол бүтээлийн агуу орчуулагч хийгээд ард нийтээр тэгш хүртдэг ард түмэн байсан учраас юм. Монголчууд орчуулгын онол зарчмаа ямагт тогтоож ирсэн ба орчин үед хэлшинжлэлийн онолын төвшний сүүлийн үеийн хурдацтай хөгжил ч онол, арга, зарчмыг улам боловсронгуй болгох судалгааг эрчимжүүлэхийг нэхэж байна.

Номзүй

1. Аким.Г, *Орчуулгын онолыг хөгжүүлэх асуудалд*, Орчуулах эрдэм No.6, УХГ, Улаанбаатар, 1989 он.
2. Аким.Г, *Орчуулгын санг уудлахад*, Улаанбаатар, 1984 он.
3. Базаррагчаа.Ц, *“Хэдэн үеэ бүрэлгэх хэлний гамшиг”* МУИС, МХСС-ийн ЭШБ, 1999.
4. Баярсайхан.Ё, *Орос хэлний реалийн орчуулгын зарим асуудалд*, Орчуулах эрдэм No.6, УХГ, Улаанбаатар, 1989 он.
5. Баярсайхан.Ё, *Орос хэлний реали бүхий хэлц үгийн тухай*, Шинжлэх ухаан амьдрал No.6, Улаанбаатар, 1984 он
6. Бүрнээ.Д *“Зохист аялгууны онол ба монгол орчуулга”*, Орчуулгазүй, Боть 4(422), МУИС, 2015.
7. Гүрбазар.Р, *Орчуулгын онол дадлагын үндэс*, Улаанбаатар, 1996 он.
8. Дагвадорж.Д, *“Монголын гүн ухааны уламжлалт тогтсон таалал” (Мэргэд гарахын орон дээж бичгийн сурвалжаар)*, Алтан гадас одонт Улсын Багшийн Их сургууль, Улаанбаатар, 1994.
9. Дашдаваа.Д, *Үндэсний онцлог бүхий үг, хэлц үгийг орчуулах нь*, Орчуулах эрдэм No.1, Улаанбаатар, 1972 он.
10. Дулам.С, *“Орчуулгын онолын гурван цаг, дөрвөн зарчим”*. Дэлхийн яруу найргийн XXVI их хуралд зориулан хийсэн “Яруу найргийн орчуулгын тулгамдсан асуудлууд” сэдэвт эрдэм шинжилгээний хурал, Илтгэлийн эмхтгэл, 2005, Улаанбаатар.
11. Дулам.С, *“Орчин үед тулгамдаж байгаа зарим нэр томъёог монголчлох асуудалд”* Орчин үед тулгамдаж байгаа зарим нэр томъёог монголчлох

³¹ Х.Наранхүү, *“Орчуулга ба хөгжил”*, Орчуулах Эрдэм IV, Орчуулгын тулгамдсан асуудлууд: Сургалт, Туршлага” сэдэвт онол практикийн бага хурал, Илтгэл өгүүллийн эмхэтгэл, 2012, 95-р тал.

- асуудалд. «Монгол нэр томъёо судлал-90 жил» ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, 2014, Улаанбаатар хот
12. Комиссаров В.Н., Орчуулгын онол, Орос хэлнээс орчуулж, монгол оюутнуудад зориулан боловсруулсан Л.Үржиндорж, Улаанбаатар, 2008, 213-214-р тал.
 13. Лувсанвандан.Ш, *Хэл шинжлэлд хийсвэрлэх аргын холбогдох нь*, Хэл Зохиол судлал, IX боть, II дэвтэр, Улаанбаатар, 1972 он
 14. Нансалмаа.Н, *“Ерөнхий хэлишинжлэл”*, Улаанбаатар, 2012.
 15. Наран.Д, Монголын төр ёсны боловсролын түүх (13-14 дүгээр зуун). УБ., 2001.
 16. Наранхүү.Х, *“Орчуулга ба хөгжил”*, Орчуулах Эрдэм IV, Орчуулгын тулгамдсан асуудлууд: Сургалт, Туршлага” сэдэвт онол практикийн бага хурал, Илтгэл өгүүллийн эмхэтгэл, 2012, 95-р тал.
 17. Няммыгмар.Б, *Гүүш цорж Мялын бум дууллын орчуулгад үндсэн эхийн санааг монголжуулсан нь*. Хэл зохиол судлал. Уб., 2011.Т-IV (36), fasc. 34.
 18. Отгонсүрэн.Ц, *Гадаад хэл рүү орчуулга хийхэд хийсвэрлэл чухал*, Орчуулах Эрдэм IV, Орчуулгын тулгамдсан асуудлууд: Сургалт, Туршлага” сэдэвт онол практикийн бага хурал, Илтгэл өгүүллийн эмхэтгэл, 2012.
 19. Равдан.Э, Хэл шинжлэлийн түүхийн товчоон, Улаанбаатар, 2002 он.
 20. Ринчен.Б *"Шүлэг орчуулах эрдэм"*, - Орчуулах эрдэм № 1, 1972.
 21. Ринчен.Б *"Энэтхэг яруу найргийн амт үнэрийг үлдээхсэн гэж..."*, Орчуулгазүйн сан хөмрөгөөс, Орчуулгазүй Боть 4(422), МУИС, 2015.
 22. Ринчен.Б, Монгол бичгийн хэл, Монгол бичгийн хэлний зүй-Удиртгал, ШУАХ, 1964
 23. Ринчен.Б, *О историй перевода в Монголии*, Мастерство перевода, сборник восьмой, 1971 «Советский писатель» , Москва
 24. Ринчен.Б *"Жанр bengsen-ü üliger в монгольском фольклоре"*, - Studia Mongolica, Tomus I, Fasc. 19, Улаанбаатар, 1959
 25. Хүрэлбаатар.Л, *Монгол орчуулгын товчоон*, Улаанбаатар, 1995.
 26. Хишигт.Я, *“Сэтгэц, ухамсар, сэдэхлэгээний хоруу, орчуулгын асуудалд”* Орчуулах Эрдэм IV, Орчуулгын тулгамдсан асуудлууд: Сургалт, Туршлага” сэдэвт онол практикийн бага хурал, Илтгэл өгүүллийн эмхэтгэл, 2012.
 27. Хишигт.Я, Баянсан.Ж “Харилцааны онол, орчуулга”, Орчуулах эрдэм № 6, Улаанбаатар, 1989.
 28. Цэрэнсодном.Д, *“Орчуулгын зохиолын өв уламжлалаас”*, Орчуулах эрдэм, Улаанбаатар, 1972.
 29. Чимэдцэеэ.М, *“Үгчлэх, утгачлах, идээшүүлэх, ондоошуулахын харилцан шүтэлцээ”* Орчуулгазүй, Боть 2, МУИС, ГХСС, 2013.
 30. Чимэдцэеэ.М, *“Ц.Базаррагчаа багшитаны орчуулгын дэг сургууль”* Хятад судлалын салбар-Нэгэн жаран, МУИС, Улаанбаатар, 2017.
 31. Чимэдцэеэ.М, *“Соёл хийгээд орчуулга”*, Орчуулгазүй, Боть 1, МУИС, ГХСС, 2013. Чоймаа.Ш, *“Монгол бичгийн хэлний орчуулга”*, Орчуулгазүй, Боть 1, МУИС, ГХСС, 2013.

32. Шагдарсүрэн.Ц, “Эх хэлээ эвдэхгүй юмсан” Улаанбаатар, 2010.
33. Шархүү.А, “Яруу найргийн орчуулгад шүлгийн ур хийцийг нь дамжуулах асуудалд” Орчуулгазүй, Боть 2, МУИС, ГХСС, 2013.
34. Шүгэр.Ц, “Мэргэд гарахын орон нэрт тогтоосон даяг оршив”, Орчуулах эрдэм, Улаанбаатар, 1972
32. Эгшиг.Ш, “Хятадын эртний яруу найраг орчуулах нь”, Орчуулгазүй, Боть 4(422), МУИС, 2015.
33. Ш.Эгшиг, *Хятадаас орчуулсан зохиолд монголчуудын Бэнсэний үлгэр холбогдох нь*, - Эрдэм шинжилгээний бичиг (МУИС, Гадаад хэл соёлын сургууль), Боть 180 (2), Улаанбаатар, 2011
34. Ш.Эгшиг, *Хятад-Монгол орчуулгын түүхэн хандлага*, Орчуулгазүй No.5(452), Улаанбаатар, 2016
35. Явуухулан.Б “Яруу найргийн орчуулгын асуудалд” Яруу найраг миний амьдралд, Улаанбаатар, 1983.
36. 王浩, *翻译文学本土化命题的理论阐释*, 启蒙与建构, 策一达木丁苏伦蒙古文学研究, 北京大学出版社, 北京, 2016年
37. Alireza Sadeghi Ghadi, Cultural translation, All new theories and concepts about translation in new century <https://www.scribd.com/document/249401273/All-Theories-in-translation>
38. Михайлов Г.И. “Литературоведческое концепции Б.Я.Владимирцова”, Филология и история монгольских народов, АН СССР, Институт Востоковедения, Москва, 1958
39. Ulrich Weisstein, Comparative Literature and Literary Theory: Survey and Introduction, English and German Edition, Indiana University Press, 1974

УРАН ЗОХИОЛЫН ОРЧУУЛГАД ТАВИХ ШААРДЛАГА: “ДҮЙЦЭЛ” БА “НИЙЦЭЛ” ОЙЛГОЛТУУДЫН ТУХАЙД

Ц.Марсар¹

Товч утга: Уран зохиолын орчуулгын чанарын нэг гол шалгуур бол орчуулга эхтэйгээ дүйцэх ба нийцэх тухай ойлголтууд билээ. Орчуулга судлалд эдгээр ойлголтыг ялгаж салгаж хэрэглэхгүй байгаагаас орчуулгын чанарын үнэлгээний янз бүрийн түвшинг оновчтой томъёолох, алдаа оноог эрэмбэлэх, ялангуяа магистр, докторын судалгааны бүтээлүүдэд бодитой арга зүй хэрэглэхэд учир дутагдалтай байгаа юм. Энэхүү өгүүлэлд уг сэдвийн талаарх онолын ойлголтыг жишээ баримтын хамт тусгав.

Түлхүүр үг: уран зохиол, орчуулга, шалгуур, шаардлага, чанарын үзүүлэлт

Орчуулгын онолын нэг тулгуур ай болох дүйцэл (эквивалентность) ба нийцэл (адекватность) хэмээх орчуулгын чанарын хэмжээс ойлголт нь хувиргалын түвшний орчуулга, тэр дундаа уран зохиолын орчуулгын үнэлгээний нэн чухал үзүүлэлтүүд билээ. Монгол орчуулгын уламжлалд үсэгчлэн орчуулах, утгачлан орчуулах, зохиомжлон найруулж орчуулах гэсэн бичгийн орчуулгын гурван хэлбэр байдгийг төвдөч эрдэмтэн, орчуулга судлаач Л.Хүрэлбаатар агсан тэмдэглэсэн нь бий [3, 120]. Энэ арга хэлбэрийг нэр томъёоны үүргээр ашиглан орчин үеийн онол баримтлалтай уялдуулах байдлаар хэрэглэх боломжтой юм. Тухайлбал, уламжлалт хадмал орчуулгын арга гэж нэршсэн, өнөө цагт ч судар номын орчуулгад ашигласаар буй үсэгчлэн орчуулах буюу орчуулах эхийн хар зураг гаргах (уран зохиолын орчуулгын тухайд зөвхөн шинжлэх ухааны зорилгоор байж болох), утгачлан орчуулах буюу үг утгасын бүрдэл, өгүүлбэрзүйн бүтцийг хадгалан мэдээлж буй санааг бүрэн гаргах (уран зохиолын тухайд уран яруу орчуулгын өмнөх шат байж болох), уран зохиолын буюу хэл, хэлэхүйн зөв хэм хэмжээнд яруу хэрэглүүрийн дүйцлийг хадгалан төгс төгөлдөр найруулж орчуулах хэлбэрүүдийн талаарх асуудал яриад байгаа билээ. Эдгээрийг нэг талаас, орчуулгын арга буюу уламжлалт орчуулгаар бол эхийн чанар хийгээд хэлний мэдлэг чадварын түвшингээс хамаарсан тус тусдаа ажил, нөгөө талаас, тухайн орчуулгын зорилготой уялдсан хэлбэр гэж үзэж болно. Бид энд зөвхөн монгол орчуулгын уламжлалт ангиллыг дурьдаж байгаа боловч орчин үеийн европ орчуулгын үзэл онолууд мөн л нэг иймэрхүү гурав дөрвөн арга хэлбэрийг судалгаандаа мөрдлөг болгон баримталж байгаа билээ. Энэ дотроос бидний онцлоод буй арга буюу хэлбэр бол уран зохиолын орчуулга юм. Нэн түрүүн энэ хэлбэрийн орчуулга туйлын адармаатай, чамгүй авьяас, бас хэлний мэдрэмж шаардсан ажил гэдийг ухварлан ойлгууштай бөлгөө. Уран яруу найруулга бол байнгын хөгжил хөдөлгөөнд байдаг, цаад ажлын онцлог талаас нь авч үзвэл түүнийг бүтээгч хийгээд

¹ МУБИС, НХУС-ийн профессор, доктор

орчуулагчийн аль нь ч ялгаагүй “сэтгэл хөдөлтөл онож хэлэхийн эрэлд хатаж байдаг” ихээхэн ярвигтай нэгэн зүйлийн үйл юм. Ерөөсөө тэр нь тэгээд уран зохиолын найруулгын оршин тогтнох үндэс болдог. Яаж өөрөөр хэлэх вэ, яаж илүү гоёор хэлэх вэ гэсэн асуултан дор зохиолч, орчуулагчийн ажил явах агаад уран зохиол бүтэх нь өөрөө тийм зүй тогтолтой учраас орчуулахад мөн тэр зүй тогтол хадгалагдах нигууртай гэсэн үг. Чухамдаа сэрэл мэдрэхүйгээ сэтгэл хөдөлтөл илэрхийлдэгт энэ найруулгын гоозүй оршин тогтнож, ингэсний үр дүнд уншигчид, сонсогчид, үзэгчдийн сэтгэлийн хөдөлгөөн, сэрэл мэдрэхүйд аанай л мөн чиглэж, тиймийн учир дүрслэн илэрхийлэх арга давамгайлж байх учир холбогдолтой үр дүн гарах ёстой. Гэтэл найруулгын өөр бусад төрлүүд (тухайлбал, албан хэргийн, шинжлэх ухааны зэрэг) огтоос тийм биш. Тэдгээрийн орчуулгад хэлний тухайн бүтцийг хадгалан томъёолох асуудал гол зорилго болно. Харин уран яруу орчуулахад хэлэхүйн чанараар нь дүйцүүлэх нь тэргүүн зэрэгт тавигдаад хэлний бүтцийг хадгалах нь түүндээ захирагдах байдалтай байдаг. Үүнээс үүдээд нэг хэлээр бүтсэн зохиолыг нөгөө хэлний хэрэглүүрээр шинээр бүтээх тухай асуудал ярьдаг. Үүнээс үүдээд орчуулга эхэд нийцсэн, төгс нийцсэн, эс бөгөөс нийцээгүй тухай ярьдаг. Мөн үүнээс үүдээд эхийг уран чанараар нь орчуулах ажлын эргэн тойронд маргаан тасардаггүй. Уран зохиолын орчуулгын онцлог ийм юм.

Уран зохиолын орчуулгын чанарын үзүүлэлтэд олон төрлийн шалгуур хэрэглэдгийн дотроос нийтлэгийн жишээ болгож оросын эрдэмтэн В.Н.Комиссаровын дэвшүүлснийг үзвэл: хэлц болон хэлний дүрслэн илэрхийлэх хэрэглүүрүүдийг оновчтой дүйцүүлэн сонгож хэрэглэсэн байдал; өвөрмөц хэллэг, онч үгсийг тодорхой хэлбэрүүдээр нь дүйцүүлж орчуулсан байдал; орчуулгаа утгаар нь эхэд ойртуулсан байдал; утгын алдаа гаргасан эсэх; эхийн найруулгын онцлогийг бүдгэрүүлж гуйвуулсан алдаа гаргасан эсэх; үсгийн дүрмийн болон хэлзүйн алдаа гаргасан эсэх; өгүүлбэрзүйн байгууламж нь зөв хадгалагдсан эсэх; эхийн прагматик шинж төлөвийг зөв хадгалж чадсан эсэх гэх мэт шалгуур үзүүлэлтүүд байна [1, 211-252]. Иймэрхүү, мөн бас бус олон шалгуур байх боловч ерөнхий чанараар нь хэрэглэвэл зохимжтой шалгуур үзүүлэлт бол “дүйцэл”, “нийцэл” ухагдахууныг зөв оноож хэрэглэх явдал гэж үзүүштэй юм. Учир нь эдгээр ойлголтууд дээр дурьдагдсан бусад шалгуур үзүүлэлтийг агуулдаг.

Орчуулгыг дүйцүүлэх тухай бид зөвхөн уран зохиолын гэлтгүй бусад төрлийн эхийн орчуулгын тухайд ч ярьж хэрэглэсээр буй билээ. Дүйцүүлж орчуулах гэдэг нь хэд хэдэн түвшинд яригдаж болно. Тухайлбал, утгын, найруулгын, бүтцийн (хэлбэрийн), үүргийн дүйцэл, коммуникатив буюу ойлголцох байдлын дүйцэл, прагматик буюу хэрэглэх байдлын дүйцэл, төрөл зүйлийн дүйцэл, үүнийгээ цааш нь бүрэн дүйцэл, хагас дүйцэл гэх мэтээр зэрэглэн ангилж ч болно. Бас чанарын үзүүлэлтүүдийг эрэмбээр нь чухалчилъя гэвэл бүх төрлийн эхийн тухайд утгыг зөв дамжуулж зөв мэдээлэл өгч буй байдал, түүний дотор уран зохиолын эхийн тухайд яруу чанарыг хадгалж сэтгэл хөдлөлийг зөв илэрхийлж буй байдал гэх зэрэг тодорхой зарим шалгуурыг тэргүүн ээлжинд тавьж болно. Гэхдээ дүйцүүлэх хийгээд нийцүүлж орчуулах нь хоорондоо харилцан уялдаатай, чанарын хамааралтай

ойлголтууд юм. Жишээ нь, дүйцүүлэх чанарыг эх, орчуулга хоёр хоорондоо тухайн тодорхой утгаараа туйлын ойртсон, үг нь утгаараа, өгүүлбэр нь байгууламжаараа таарч тохирсон гэдгээр илэрхийлж байхад нийцүүлэх чанарыг найруулгын онцлогуудыг алдаж гээлгүй хадгалсан, хэлц үг, өвөрмөц хэллэг мэтийг аналог шинжээр нь яв цав сонгож хэрэглэсэн, утгазүйн болон прагматик шинж төлөвийг оноож орчуулж чадсан гэдгээр илэрхийлсэн байж болно. Хэлзүйн болон үсгийн дүрмийн алдааг эрдэм шинжилгээ, дипломат болон хууль эрхийн акт, албан бичгийн орчуулгад байж боломгүй зүйл гэж үзэх атал уран зохиолд анхдагч эхэд нь баатрын хэл яриа, дүр байдлыг илэрхийлэх зорилгоор хэрэглэсэн бол орчуулгад ч мөн хэлбэрээ олж хадгалагдах ёстой. Хэдийгээр энэ ойлголтууд ийнхүү харилцан уялдаатай боловч эхийн агуулсан мэдээлэл бодитой зөв дамжиж эзэндээ алдаа мадаггүй хүрэх үүргээр нь бол ямар ч эхийн орчуулгын үнэлгээнд дүйцүүлж орчуулах чанар тэргүүн зэрэгт, нийцүүлэх нь удаах зэрэгт тавигдана. Харин орчуулгад гүйцэтгэх үүрэг, ач холбогдол талаасаа эдгээр нь эн тэнцүү ойлголтууд юм.

Орчуулгын нийцэх чанарын тухай ойлголтыг өнөөдөр монгол орчуулгын судалгаанд харьцангуй бага хэрэглэж байна. Зарим судалгаанд “адекватность” гэдгийг “тэнцүү чанар” буюу утгын болоод хэлбэрийн давхцал гэх маягаар хэрэглэж байгаа нь учир дутагдалтай. Орчуулгын онолдоо эхийн прагматик шинж төлөвийг давамгайлсан судалдаг германы эрдэмтэн Альбрехт Нойберт нийцлийг эхийн доторх прагматик харьцаанаас хамааралтай гэж үзээд уг харьцааны дөрвөн хэв шинжийг дурьджээ. Нэгд, анхдагч эх ба орчуулга нь тэдгээрийг хэрэглэгч буюу рецепторын хувьд нийтлэг хэрэгцээнд чиглэсэн нэг зорилготой байвал орчуулга нийцтэй болох магадлал туйлын өндөр (жишээ нь, сурталчилгааны, шинжлэх ухааны, техникийн сэдэвт эхүүд); хоёрт, анхдагч эх зөвхөн өөрийн хэлтэн хэрэглэгч буюу рецепторын тусгай хэрэгцээнд зориулагдсан бол орчуулга нийцтэй болох магадлал харьцангуй бага (жишээ нь, хууль, нийгэм-улстөрийн сэдэвт эх, орон нутгийн чанартай мэдээ); гуравт, уран зохиол өөрийн хэлтэн уншигчдад зориулагддаг учраас орчуулга нийцтэй болох магадлал мөн харьцангуй бага, гэхдээ уран зохиол нийт хүн төрөлхтөний ашиг сонирхлыг илэрхийлдэг гэдгээрээ нийтлэг хэрэгцээнд чиглэсэн зорилготой, бас төрөл зүйл тус бүр өөрийн онцлогтой (жишээ нь, хүүрнэл зохиол яруу найргаас илүү нийцтэй орчуулагдах магадлалтай); дөрөвт, гадаад хэлэнд орчуулах зориулалтын эх тухайн зорилгоо дагаад нийцтэй орчуулагдах магадлал маш өндөр (жишээ нь, гадаад улс оронд зориулсан нийтлэлүүд) гэжээ. Тэрээр орчуулга нийцтэй болох хэд хэдэн үзүүлэлт байж болно гэж үзжээ [2, 23]. Жишээ нь, шүлэг орчууллаа гэхэд хэлбэрийн орчуулга, мөрийн орчуулга, үг үгээр нь хадмал орчуулга, тайлбарласан орчуулга, яруу тод орчуулга, чөлөөтэй зохиомжилсон орчуулга гэх мэт. Энэ нь Нойберт нийцлийг прагматикийн үүднээс үзэж буй хэрэг бөгөөд ингэсэн тохиолдолд мэдээллийн нийц, үнэлгээний нийц, хэлбэрийн нийц гэх мэтээр төрөлжүүлбэл илүү ойлгомжтой болно.

Нийцлийг оросын эрдэмтэн А.А.Смирнов үзэхдээ зохиолчийн зүгээс дүр дүрслэл, үгийн өнгө, хэмжээ хэмнэл зэрэг бүхий л нөөц бололцоог ашиглан

уншигчдад нөлөөлөх гэсэн сэтгэлийн хөдөлгөөн, үзэл санаа, уран сайхны олон талт хүсэл эрмэлзлийг тэр хэмжээнд нь гаргаж чадсан орчуулгын тухайд хүлээн зөвшөөрөх ёстой, гэхдээ дээр дурьдсан арга хэрэгслүүд эцсийн зорилго биш, харин зорилгод хүрэх хэрэгсэл байх учиртай гэжээ [8].

Дүйцэл ба нийцлийн ялгааг тодорхойлж оросын эрдэмтэн А.Д.Швейцер бичихдээ “Дүйцэл нь орчуулсан эх анхдагч эхтэй таарч байгаа эсэх тухай асуултын хариу байх бол нийцэл нь орчуулгын явц тухайн харилцааны нөхцөлд таарч байгаа эсэх тухай асуултын хариу болно” гэжээ [4, 95]. Тэрээр нийцлийг тайлбарлахдаа орчуулах явцад орчуулагчийн гаргаж буй шийдвэртэй уялдуулж, харин дүйцлийг анхдагч эх, орчуулга хоёрыг харьцуулсан үр дүнтэй нь холбожээ. Иймд нийцэх гэдэг нь харилцааны тухайн тодорхой нөхцөлд зүй зохистой байх хувилбарын тухай яриа юм. Ингэж үзвэл орчуулсан эх анхдагч эхтэйгээ дүйцээгүй байх атал орчуулга нь тодорхой утгаараа нийцсэн байх боломжтой гэсэн үг.

Одоо үүнийг тодорхой жишээ баримтад тулгуурлан авч үзье. Ингэхдээ асуудлыг илүү тод харагдуулах үүднээс “орчуулга дутуудсаны алдаа ташаарал” гэсэн нэг л хэмжүүрээр сонгосон хялбар товч жишээ баримтыг түшиглэн дүйцэл ба нийцлийн чанарын ялгаатай танилцъя. Энд дурьдаж буй нийтлэг хэв шинжийн арван төрлийн “алдаа” нь тухайн тодорхой нөхцөлд эхтэйгээ нийцсэн, иймд алдаа гэхэд хэцүү (заримыг ташаарал гэж нэрлүүштэй), эс бөгөөс зөвхөн найруулгыг нь залруулаад хэлбэр төрхөө олох магадлалтай (тухайлбал, сурах бичгийн дасгал хийх түвшинд). Гэвч дүйцэл талаас нь өгч буй залруулгыг эхийн түвшинд, өөрөөр хэлбэл уран зохиолын орчуулгын түвшинд зайлшгүй байх найруулгын нэг хувилбар гэж ойлгохоос аргагүй юм. Бидний авсан жишээ баримтад тулгуурлан алдаануудыг дараах байдлаар ангилж болно.

Соёлын мэдлэг дутмагаас үүдэх алдаа. Энэ нь уран зохиолын орчуулгад хамгийн ноцтой гэж үзэхээр алдааны төрөл боловч гадаад хэлийг соёлынх нь түвшинд эзэмшээгүй орчуулагчдад цөөнгүй тохиолддог билээ. Жишээ нь, «Spiritus quidem promptus est, caro autem infirma» /Евангелийн судраас/ гэсэн латин эхийг оросоор «Спирт хорош, а мясо протухло» /Спирт дажгүй, харин мах муудчихаж/ гэж орчуулсан оюутны хувилбарыг бүрэн нийцсэн орчуулга гэж үзэж болно. Харин сударт байгаа санаа нь «Дух бодр, плоть же немощна» /Оюун санаа эрчтэй, харин махан бие дорой байдаг/ гэж огт өөрөөр буух ёстой байв [6, 1]. Оюутны орчуулсан хувилбар тухайн өгүүлбэрийн утгад нийцсэн ч эхийн түвшиндээ дүйцээгүй гэсэн үг юм. Явуухулангийн “Мөнгөн хазаарын чимээ” шүлгийн бидний урьд өмнө дурьдаж байсан орос орчуулгад “өнчин дэрэн дээр нойр хулжин ухаангүй дурлалын урхинд” хүлээн хэвтэж байгаа нь эмэгтэй биш, эрэгтэй нь болчихсон (“лежал без сна, сгорая в нетерпенье”) тохиолдол мөн л соёлын мэдлэг дутмагаас үүдэлтэй нэгэн зүйл ташаарал, дүйцлээ олоогүй орчуулгын жишээ юм.

Эх хэлний хэрэглээ сайнгүйгээс гарах алдаа. Ийм төрлийн алдаа нийтлэг талдаа орно, учир нь үүнийг хаана ч, хэн ч бараг л залруулахгүй байгаа юм. Орчуулгын редакторын үүрэг хэлбэр төдий болсон өнөө үед алдааг хянах түвшинд ч анзаарахгүй, орчуулга хэвлэгдсэний дараа ч шүүн хэлэлцэхгүй буруу практик нэгэнт

тогтоод байгаа бөгөөд эх хэлний хэм хэмжээ алдагдах тийш орчуулга доройтож байна уу гэмээр сэтгэгдэл төрөхөөр болжээ. Жишээ нь, олон нийтийн газар өлгөсөн “Stop talking!” анхааруулах бичвэрийг “Бүү ярь!”, “Амаа хамхи!” гэсэн хувилбараар орчуулсныг хүлээн зөвшөөрлөө гэж бодъё. Гэтэл монгол хэлэнд тогтсон хэлбэр нь “Чимээгүй!”. Ингэснээр анхааруулга сая зөв хэрэглээндээ дүйцнэ. Эх хэлний хэрэглээ сайнгүйг ч, соёлын мэдлэг дутууг ч илтгэн харуулдаг орчуулгын мөн л нийтлэг нэг алдаа бол зүйр үг, хэлц үг тэргүүтний нүднээ илэрхий үгчилсэн болхи орчуулга байдаг. “A fault confessed is half redressed” гэдгийг “Муу нуухаар сайн илчил” гэмээр атал “Буруугаа хүлээх нь оногдох ялыг хөнгөлнө”, “A friend in need is a friend indeed” гэдгийг “Зовох цагт нөхрийн чанар танигдана” гэхийн оронд “Ядрахад тус болсон нөхөр бол жинхэнэ нөхөр”, “A bird in the hand is worth two in the bush” гэдгийг “Маргаашийн өөхнөөс өнөөдрийн уушиг дээр” гэсэн бэлэн үг байсаар байтал “Тарт буй нэг шувуу шугуйд буй хоёр шувуунаас үнэтэй” гэх мэтээр орчуулаад байвал монгол орчуулагчийн тухайд эх хэлээ ч ядмаг болгож, өв соёлоо ч гээж буй дүр зураг харагдана гэсэн үг.

Утгын хүрээллээс (буюу хам сэдвээс) хамааралтай алдаа. Ийм төрлийн алдаа хэлний мэдлэгийн түвшингээс илүүтэй хамаарна. Уран зохиолын орчуулгад иймэрхүү алдаа гаргах нь инээдтэй үр дагаврыг авчрахаас гадна уншигчдыг эргэлзээ төрүүлсэн, ойлгомжгүй байдалд оруулдаг. Жишээ нь, “Оценить по достоинству” гэдгийг хам сэдвээ харгалзаагүйгээс “Зохих ёсоор үнэл” гэж орчуулсан нь дүйцлийнхээ түвшинд “Авах шийтгэлээ аваг” гэж орчуулах ёстой байсантай нь харьцуулбал бараг л эсрэг утгатай болжээ.

Үгчлэн орчуулдаг алдаа. Уран зохиолын түвшний орчуулгад “орчуулснаа дахин орчуул” гэсэн бичигдээгүй нэг зарчим бий. Жишээ нь, “Ну и дела!” гэж уулга алдаад хэлсэн байж болох үгийг “Үгүй мөн ажил аа!” гэж үгчлэн орчуулжээ. Ер нь бол нийцэл талаас нь авч үзвэл тэгж хэлсэн ч болно. Гэтэл “Арай ч дээ!” гэвэл утга илүү тодорхой болж хэрэглээнд ч ойртоно. Үүнийг анзаарвал орчуулснаа дахин орчуулж байгаа нэг хэлбэр байна.

Урьд өмнө тогтсон орчуулгыг мэдэхгүйгээс гарах алдаа. Манай телевизийн сувгуудаар байсгээд гардаг “Адмирал” уран сайхны кинонд “Временное правительство” гэснийг “Түр зуурын засгийн газар” гэж орчуулаад байна. Ерөөсөө ийм үгийг анх удаа сонсч байгаа хүнд бол нийцтэй орчуулга. Гэтэл түүхийн сурах бичгүүдэд үүнийг “Түр засгийн газар” гээд хэвшсэн үг байх. Уг нь орчуулагч үүнийг сурвалжлан нягтлах ёстой байв.

Нөхцлийг анзаараагүйгээс гарах алдаа. Буруу ярьж зөв ойлгодгийн үлгэрээр орчуулах эхэд өгөгдсөн хэллэгийн нөхцлийг үл анзаарснаас дүйцэмжгүй орчуулга болох магадлалтай. Жишээ нь, “Закрой рот и ешь!” гэж эх нь хүүхдээ загнасан утга бүхий өгүүлбэрийг “Амаа хамхиад гудар!” гэж орчуулжээ. Уг нь “Дуугүй наад хоолоо ид” гэвэл жинхэнэ дүйцсэн зөв орчуулга болох байж.

Төлөөний үгийн хэрэглээг эндүү ойлгосноос гарах алдаа. Зөвхөн төлөөний үг ч биш, ерөөсөө хэлний бүтцийн онцлог, хэлзүйн тогтолцооны зөрүүн дээр үүсэх

алдааны төрөл бий. Тухайлбал, монгол хэл европ хэлүүдтэй харьцуулбал биеийн төлөөний үгийн хэрэглээ хязгаарлагдмал. Иймд уран зохиолын орчуулгад төлөөний үгийг орчуулахдаа нэрийг давтах, өөр бусад аргаар тодруулга хийж өгөх шаардлага олонтаа гарна. Жишээ нь, “Доярка сошла с трибуны и на нее сразу влез председатель” гэсэн өгүүлбэрийг “Саальчинг индрээс буухад дарга шууд л түүн дээр гарав” гэж орчуулснаар ойлгомжгүй байдал үүснэ. Зүй нь “Саальчин ч индрээс буулаа, дарга ч индэрт гарав” гэх маягийн орчуулга байх учиртай аж. Орос хэлний байдлын ай утгын ямаршуу зөрөө үүсгэж мэдэхийн нэг жишээ “Он сдавал экзамен, но не сдал” гэсэн өгүүлбэрийг “Тэр шалгалт өгсөн, гэвч өгсөнгүй” гэвэл (“өгч чадсангүй”, “уначихлаа” гэлгүйгээр) дүйцлийн хувьд дутуу орчуулга болно.

Эхийн хоёрдмол утгаас үүдэлтэй алдаа. Үгийн болоод эхийн доторх мэдээллийн салаа утга ямагт асуудал үүсгэдэг талтай. Жишээ нь, “Дети выдаются родителям только в трезвом состоянии” гэсэн зарлалыг цэцэрлэгийн хаалганы дэргэд өлгөжээ. Зарлалыг “Хүүхдүүдийг эцэг эхэд нь зөвхөн эрүүл хүлээлгэж өгнө” гэж орчуулсан байна. Энд салаа утгыг анзаараагүйгээс хэн нь эрүүл байх ёстой нь тодорхойгүй утгатай өгүүлбэр үүсч байна. Уг нь “Хүүхдүүдийг эцэг эх нь зөвхөн эрүүл үедээ хүлээж авна” гэсэн байдлаар найруулж байж сая утгадаа дүйцнэ.

Утгын алдаа. Уран зохиолын орчуулгад өгүүлбэрийн байгууламж, үгийн холбоцоос эхлээд утгын хүрээлэл, учир зүйн дараалал, хэлц үг, өвөрмөц хэллэг, соёл, ахуйн зүйлийн нэр, бүр үгийн утгын орчуулгад хүртэл цөөнгүй гардаг маш “баялаг” алдаа бол утгын алдаа юм. Орос хэлний “распущенный” гэдэг үгийг буруу утгаар нь авч орчуулсан нэг онигоог орчуулга судлаач блогтоо тавьсан нь: “Ресторан не работает, официантки все распущенные” гэсэн зарлалыг “Зоогийн газар ажиллахгүй, үйлчлэгчид бүгд завхарсан” гэх маягаар орчуулчхаж гэнэ. Мэдээж монгол хэлэнд арай ч ингэж орчуулахгүй ч өөр зарим хэлэнд нийцтэй хувилбар гарах байсныг үгүйсгэх аргагүй. Зүй нь, “Зоогийн газар ажиллахгүй, үйлчлэгчид бүгд явчихсан” гэх ёстой байж. “There were never many girls at all at the football games. Only seniors were allowed to bring girls with them” гэсэн өгүүлбэрийг “Хөл бөмбөгийн тэмцээн дээр охид үргэлж цөөхөн. Зөвхөн ахлах ангийн охидод л зөвшөөрнө” гэж орчуулжээ. Энд seniors ... to bring girls with them гэснийг орчуулгадаа гүйцэд тусгаагүйгээс алдаа үүссэн байна. Зүй нь “Зөвхөн ахлах ангийнхан л тэмцээн дээр найз охидоо дагуулан ирж болдог” (оюутан Б.Оюундэлгэрийн шүүмжээс) гэсэн байдлаар орчуулах хэрэгтэй байв [7].

Эхийн алдаанаас үүдэлтэй алдаа. Эх өөрөө үг үсгийн болоод олон төрлийн алдаатай байх явдал бишгүй. Тийм бөгөөс орчуулагч алдааг ялгаж таньж, эх үүсвэрээ магадлах учиртай. Жишээ нь, “Казнить нельзя помиловать” гэсэн хааны зарлигт таслалыг орхигдуулснаас алах, аврахын аль вэ гэдэг нь ойлгомжгүй болжээ. Тухайн тохиолдолд “Цаазал, бүү өршөө”, “Бүү цаазал, өршөө” гэсэн хоёр хувилбарын аль нь ч нийцтэй байж мэднэ. Иймд зөв хувилбараа олж тогтооход судалгаа хэрэгтэй гэсэн үг.

Энэ бүхнээс үзэхэд уран зохиолын эхийн орчуулга хэлний хэрэглэгдэхүүнээр нийцэвч үүргээрээ болон уран яруу чанараараа нийцээгүй, зарим тохиолдолд уран

чанараар нийцэвч хэлний хэрэглэгдэхүүнээрээ нийцээгүй байх мэдлэл их байдаг байна. Нийцлийг тухайн тодорхой мэдээллийн хэлбэр, агуулгын нэгдэлтэй холбон үзэж байхад дүйцлийг эхийн үүргийн найруулгатай илүүтэй уялдуулан авч үзүүштэй байна. Түүнээс гадна дүйцүүлэн сонгож орчуулахыг төсөөтэй хувилбаруудаас оновчтойг нь авч хэрэглэх тухайд яривал илүүтэй тодорхой болно. Дүйцлийг уран зохиолын эхийн орчуулгын түвшинд, тэр дундаа уран яруу үүргийн найруулгаар нь орчуулахын тухайд илүүтэй ярьж хэрэглэх нь илүү оновчтой, ойлгомжтой болж байна. Агуулга болоод хэлбэрийн хувьд нийцсэн орчуулга үүргийн найруулгаараа болон прагматик шинж төлөвөөрөө дүйцлээ олохын тулд зарим нэг үг утгас, эсвэл хэлний хэрэглэгдэхүүнийг яалт ч үгүй “гаргуунд гаргах” нь түгээмэл байдаг асуудал. Чухам дээрээ чингэхийг зохиолын гоо зүй шаардах ажээ.

Abstract: The one of the main criteria for literary translation is the concept of being adequate and equivalent to the original. By not distinguishing these concepts clearly in translation studies, it is defective to formulate appropriate level of translation quality assessment and sort out advantages and disadvantages, especially in usage of concrete techniques in master's and doctoral studies. The article "Requirements for literary translation: the concept of equivalence and adequacy" reflects the theoretical basis of the subject and examples.

Ном зүй:

1. Комиссаров В.Н. Теория перевода /лингвистические аспекты/. Москва, Высшая школа, 1990
2. Мошкович В.В. Адекватность и эквивалентность как основополагающие критерии оценки качества перевода /диссертация/. Челябинск, 2013.
3. Хүрэлбаатар Л. Монгол орчуулгын товчоон. Улаанбаатар, 1995.
4. Швейцер, А. Д. Теория перевода: статус, проблемы, аспекты. Москва, Наука, 1988.
5. Neubert, A. Text and Translation. Übersetzungs wissenschaftliche Beiträge. – Leipzig: VEB Verlag Enzyklopädie, 1985.
6. <https://ru.wikipedia.org/wiki/>
7. <https://www.facebook.com/translationclub.UH/>
8. <http://febweb.ru/feb/litenc/encyclop/le8/le8-5121.htm>

ОРЧУУЛГАД ЭХ ХЭЛНИЙ ҮҮРЭГ

Л.Чулуунбаатар¹

Товч агуулга: Орчуулга хийхэд заавал хоёр хэл шаардагдана. Гадаад хэлнээс эх хэл рүүгээ эсвэл эх хэлнээсээ гадаад хэл рүү орчуулах хэрэгтэй болдог. Аль алиныг нь хийсэн ч заавал эх хэлний өргөн мэдлэг шаардагдана. Тийм болохоор гадаад хэлнээс гадна эх хэлээ сайн мэдэхгүйгээр орчуулга хийнэ гэвэл бүтэшгүй асуудал.

Түлхүүр үг: Орчуулга, орчуулагч, эх хэл, гадаад хэл, найруулга

Орчуулгын тухай шинжлэх ухаан нь хэлшинжлэл, утга зохиол судлал, танихуйн ухаан, соёлын антропологи зэрэг олон салбар ухааны зааг дээр орших орчуулгын онол, орчуулгын судалгаа, орчуулгад суралцах арга зүй, болон машины орчуулга гэх хэд хэдэн салбартай хавсарга хэлшинжлэлийн нэгэн төрөл юм.²

Орчуулга хийхэд заавал хоёр хэл шаардагдана. Гадаад хэлнээс эх хэл рүүгээ эсвэл эх хэлнээсээ гадаад хэл рүү орчуулах хэрэгтэй болдог. Аль алиныг нь хийсэн ч заавал эх хэлний өргөн мэдлэг шаардагдана. Тийм болохоор гадаад хэлнээс гадна эх хэлээ сайн мэдэхгүйгээр орчуулга хийнэ гэвэл бүтэшгүй асуудал. 2016 оны 8 сард Олон Улсын Монголч Эрдэмтдийн XI Их Хурал болж, Англи, Америк улсад англи хэлийг ус цас шиг эзэмшсэн олон сайхан залуус ажиллахаар ирж бүртгүүлсэн байна. Гэхдээ монгол хэл, түүх соёл, угсаатны зүй зэрэг монгол судлалын илтгэлүүд орчуулах болсон чинь бүгд шахуу чадахгүй хэмээн зугтаацгаасан байна. Учир нь тэдний ярьдаг өдөр тутмын монгол хэл нь зорилгоо хангаж чадсангүй. Тийм болохоор орчуулагч болно хэмээн шийдсэн бол эх хэлээ заавал төгс мэдсэн байх шаардлагатай.

Орчуулагч хүн гадаад хэлийг сайн сурахын зэрэгцээгээр орчуулгаа эх хэлнийхээ хэлзүй, найруулгазүйн нарийн ёс горимд яв цав нийцүүлж чаддаг торгон мэдрэмжтэй байх шаардлагатай аж. Ийм чадваргүй орчуулагчийн орчуулсан “зохиолын амт нь алдагдаж, найруулга нь болхи болохоор барахгүй монгол хэлний найруулгын ёсыг эвдэн гутаадаг”³ гэм хортой ажээ.

Гадаад болон эх хэлээ гаргууд мэддэг орчуулагчийн ямагт анхаарч байх нэгэн зүйл бол зохиол орчуулахдаа цаад хэлний хэрэглүүртэй эн тэнцэх үг хэллэгийг олж сонгох чадвар юм. Энэ нь уран зохиолыг албархуу үг хэллэг, албан бичгийн найруулгаар орчуулж болохгүй. Харин “уг зохиолч нь цаад хэлнийхээ үгийн сангаас сонгон хэрэглэсэн үг нь судрын хэлний үг байвал монгол судрын хэлнээс түүнтэй дүйх сайхан үг сонгон олж, номын хэлнээс хэрэглэсэн үг байвал монгол номын хэлний зохих үг шигшин шилэн сонгож хэрэглээд, бичгийн хэлний үг хэрэглэсэн

¹ МУИС, ШУС, ХУС-ын профессор, доктор

² Н.Нансалмаа, Ерөнхий хэлшинжлэл, УБ., 2012, х 189

³ Б.Ринчен, СССР ба Ардын ардчилсан орны хийгээд дэлхий дахины дэвшилт утга зохиолын орчуулгын тухай, Б.Ринчен, Марк Твений минь махы нь идэж дээ. УБ, 1991, х.81-98

байвал монгол бичгийн хэлний үг хэрэглэж, хар үг хэрэглэсэн газар мөн түүнтэй амт санаа дүйх хар үг тэнсэн олж хэрэглээд, эх зохиолын хуучин үгий нь монгол хэлнийхээ хуучин үгээр найруулна”⁴ гэсэн үг болой.

Дашрамд өгүүлэхэд, “үргэлжилсэн үгийн зохиолд шүлгийн хэмжээг тааруулахтай адил зүйл нь үгийг найруулахуйн ёсон”⁵ хэмээн Б.Ринчен багш үзэж байлаа.

Мөн түүнчлэн ямар ч орчуулагчийн хэрий нь үзүүлж, тары нь таниулж, тамиры нь мэдүүлдэг юмны нэг нь алив салбар ухааны нэр томьёо, хүн, зохиолын баатар, газар ус, хот суурин зэргийн нэр ажгуу.

Орчуулагч нарт тавьдаг нэгэн зүйл шаардлага бол уран бүтээлийн буюу бичиж туурвих авьяас юм. Ийм авьяастай байж гэмээнэ орчуулагч хүн эх зохиолын сэтгэл хөдөлгөх чадлыг буулгаж чадах аж. Энэ тухайд Б.Ринчен багш: “Зохиолыг орчуулахдаа уг эх зохиолыг тэр зохиолын эх хэлээр нь бахдагч хүний сэтгэлд төрдөг санаа бахдал, баяр хорслын хөдөлгөөнийг монгол үзэгчийнхээ сэтгэлд төрүүлэх”⁶ гэж эрмэлзэн хичээх нь орчуулагч хүнд онцгой чухал болохыг анхааруулсан байдаг. Өөрөөр хэлбэл уг зохиолыг эх хэлээр нь уншигч хүний “Хөмсөг зангиддаг газар хөмсөг зангидуулж, магнай тэнийлгэдэг газар магнай тэнийлгүүлэн чадах тийм монгол найруулгаар орчуулах хэрэгтэй”⁷ хэмээн тов тодорхой өгүүлжээ. Эх хэлээ мэдэхгүй бол ингэж орчуулна гэж санахын хэрэггүй юм. Ри багшийн нэг шог яриа байдаг. Ри багшийг Анагаах Ухааны Дээд Сургууль урьжээ. Оюутнууддаа орос хэл хялбархан сургах аргыг мэдүүлэх гэж хичээжээ. Гэтэл Ри багш:

-Эхлээд

Эх хэлээ даамай сур!

Ойроор нь

Орос хэлийг дараа нь сур!

Хөтөлгөө морь

Эмээллэсэн хүнд

Хүрэх газар

Ойртоод ирнэ

Эмч болох хүнд

Герман хэл чухал

Эрдэм зузаалах сэхээтэнд

Англи хэл чухал гэж зөвлөжээ. Мэс заслын үед мэдрэлийг мэнэрүүлэн нойрсуулдаг эмч:

⁴ Б.Ринчен, Шүлэг орчуулах эрдэм, Б.Ринчен, Марк Твений минь махы нь идэж дээ. УБ, 1991, х.139-147

⁵ Б.Ринчен, Хэтдээ бодвоос зохих зарим асуудал, Б.Ринчен, Марк Твений минь махы нь идэж дээ. УБ, 1991, х.184-187

⁶ Б.Ринчен, Сондгойруулахгүйг эрхэм болгохуй, Б.Ринчен "Марк Твений минь махы нь идэж дээ. УБ, 1991, х. 148-162

⁷ Б.Ринчен Хэтдээ бодвоос зохих зарим асуудал// Б.Ринчен "Марк Твений минь махы нь идэж дээ. УБ, 1991, х.184-187

-Ри гуай! Гадаад хэлийг унтаагаар сурч болдог гэж гадаадын сэтгүүлд бичсэн байх юм. Энэ хэр зэргийн сайн арга вэ? гэсэнд:

-Ухаантай сэрүүндээ

Сураагүй хүн

Унтаж, унгаж хэвтэхдээ

Сурна гэдэг

Улсын наадамд

Чавганц барилдахтай адил буй за хэмээжээ.⁸

Залуусын дунд нэг эндүүрэл байдаг л даа. Би монгол хүн, монголоор ярьж бичиж чаддаг болохоор монгол хэлээ сайн мэднэ. Тийм болохоор монгол хэлээ сурна гэж юу байхав дээ хэмээн омог бардам бодох нь бий. Гэвч өдөр тутмын харилцааны хэрэгцээнд 200-500 үг нь шаардлагатай байдгийг эрдэмтэд тогтоон гаргажээ. Тэгтэл орчуулга хийхэд даруй 2000-5000 үгийн нөөц эн түүрүүнд шаардлагатай болдог. Ийм шаардлага гарсан үед өдөр тутмын хэрэгцээний тэр хэдэн үг шаардлага хангаж чадахгүй. Ажил мэргэжил, хувь хүний онцлог, өссөн орчин зэргээс болоод аав ээж нарын маань бидэнд амлуулсан монгол хэл тэр бүр монгол хэлний бүх үгсийн санг бидэнд олгож чаддаггүй. Тийм болохоор орчуулагч болохын хүссэн ухаант залуус монгол эх хэлэндээ суралцах хэрэгтэй болно. Ри багшийн бас нэг шог яриа байдаг. Аятайхан нэг эмэгтэй орчуулагч болохоор зориг шулууджээ. Учир нь тэрбээр орос сургууль төгссөн монгол бүсгүй бөгөөд, орчуулга хийвэл алдар, ашиг хоёрыг ууталж болно гэдгийг ухаарсан нэгэн санж. Хялбардуухан нэг номыг хавтсыг нь салтал барьж, явсаар орчуулж дуусгасныгаа их дуун хөрвүүлэгч Ринчин гуайд үзүүлэв. Залуу хүнийг, тэгэх тусмаа юм хийх дуртай хүнийг ихэд дэмждэг өвгөн хайран сайхан цаг заваа үрж мөнөөх орчуулгыг улаан алаг болгоод:

-За хүү минь, сонин сэвүүн зохиолыг сонины хэлээр орчуулж болохгүй. Ардынхаа амттай сайхан хэлээр орчуулж бай! гээд буцааж гэнэ. Бүсгүй бас ахин ном орчуулжээ. Тэрбээр Ринчин гүүшээр “бөөсөө” түүлгээд, ном хэвлүүлэх арга олсондоо урамшсан нь тэр санж. Ри гүүш орчуулгыг гүймэгхэн уншаад:

-Үг нь монгол, өгүүлбэр нь орос байна гэж цохоод буцаажээ. Бүсгүй ер халширсангүй ахин ирсэнд:

-Чадал муутай хүн орчуулга хийх гэж махаа идэх нь царай муутай эм, эр эргүүлж нэрээ баасдахтай ижил бус уу хэмээнээс хойш ахин үзэгдэхээ больсон гэдэг.⁹

С.Галсан: “Манай олонх орчуулга доголлон болдог. Учир нь доголлон бус байхын тулд гадаад болон эх хэлний мэдлэг нь тэгш байх ёстой. Чухам ийм тэгш мэдлэг “Рэ” багшид л байсан. “Рэ” багшийн орчуулах арга барилд өөр өвөрмөц сонин зүйл их бий”¹⁰ хэмээн нутласан байна.

2012 оны 4 сарын 27-ны өдөр МУИС-ийн ОУХС-ийн Дипломат орчуулгын тэнхимээс зохион байгуулсан “Орчуулгын тулгамдсан асуудлууд: сургалт туршлага”

⁸ Т.Галсан, Домогт Ринчингийн домгууд оршивай, УБ., 2005, х 48

⁹ Т.Галсан, Домогт Ринчингийн домгууд оршивай, УБ., 2005, х 96


¹⁰ Галсан С. Гурван их хүний нэг// "Утга зохиол", 1991.04.26 №15(1801)

хэмээх хуралд доктор Л.Дорждэрэм “Уран зохиолын орчуулгын алдаа оноог шүүн үзэх нь”¹¹ хэмээх илтгэлдээ Энэтхэгийн Нобелийн шагналт зохиолч Р.Тагорын өгүүллэгийг оросоос монгол хэлэнд Т.Юмсүрэн хэмээх хүний орчуулсан орчуулгыг жишээ татан улаан эрээн болгосноо жишээ болгон ярьж байсан билээ. Түүнд байгаа ганц өгүүлбэрийг жишээ татан өгүүлбэл: *“Голын дэргэд тоосго шатаахад бэлэн болсон туурь усны дээгүүр сүндэрлэн, голын өглөөний түрэлтэнд гүйхэн усанд зогсоолд хуйс модноос уяатай зогсож байгаа загасчны завь дайвалзана”* хэмээсэн өгүүлбэр байна. Энд үг сонголт болоод найруулгын илэрхий олон алдаа байна. *“Тоосго шатаахад бэлэн болсон туурь”* хэмээх хэсэгт тоосго шатаахад бэлэн болсон юм бол шинээр барьсан, өрсөн тоосго шатаах зуух юм уу бааюу байх ёстой, хэрэв туурь юм бол хуучин хот балгадын туурь хэмээхэд холбогдож ор, үлдэгдэл, туурь, буурь байх ёстой. Туурь бус тоосго шатаах зуух байлаа ч голын тээгүүр сүндэрлэж үл чадна. Голын дэргэд байгаа өндөр байшин эсвэл уул байсан бол сүндэрлэж болно. Тийм болохоор утгын илэрхий том зөрчилдөөн энд байна. Дараах өгүүлбэр нь *“голын өглөөний түрэлтэнд гүйхэн усанд зогсоолд”* гэсэн хэсэг байна. Гол мөрөн далай тэнгисийн ус өглөө түрж, орой татдаг жамаар усан зогсоол их устай байх ёстой. Яав ч гүйхэн байх ёсгүй. Мөн энд түрэлтэнд, усанд, зогсоолд гээд гурван үгэнд ойр ойрхон өгөх оршихын тийн ялгалын нөхцөл залгасан нь агуулгыг бүр ч их будлиантуулсан байна. Гуравдахь хэсэг *“хуйс модноос уяатай зогсож байгаа загасчны завь”* хэмээсэн хэсэгт нэг их ноцтой зүйл алга мэт боловч завийг амьджуулж морь уяатай зогсож байгаа мэтээр сэтгэхээр болсон байна. Эсвэл илүүдээд байгаа зогсож хэмээх үгийг нь бичилгүй уяатай байгаа гэсэн ч болох байсан байна. Зүй нь завиа аргамжих хэмээн ярьдгийн дагуу аргамжаатай гэсэн бол бүр ч дээр болох байсан мэт. Өгүүлбэрийг бүхэлд нь уншихад яруу сонсголонгүй бөгөөд хэг маг хийсэн эрхгүй л монгол үгүүдийг холбон орчуулсан нь харагдана. Ийм орчуулга олширвол монгол хэл маань юу болох нь мэдээж хэрэг юм. Энэ бол маш зоригтой хийсэн халтуурын ажил буюу судлах ямар ч менталитет байхгүй орчуулгын хамгийн муу жишээ юм.

Ардынхаа амттай сайхан үгсээс байнга суралцаж, зохиол бүтээл туурвигч орчуулагчдын орчуулга яруу сайхан байдаг нь нэн тод жишээ юм. Ч.Чимид зохиолч нэг удаа “Би энэ орчуулагч нараас юугаараа илүү гэвэл орос хэл сайн мэддэгээрээ биш харин монгол хэлээ сайн мэддэгээрээ л илүү юм” хэмээн хэлсэн нь үүний баталгаа юм. Сансрын нисгэгч Герман Титов Монгол улсад айлчилж хүндэтгэлийг цайллага болоход Ч.Чимид зохиолч орчуулж байсан билээ. Цайллага дуусахад Титов баатар “Я очень рад как будто съел свежие огурчики” хэмээн хэлсний нь “Би хонины шинэ шөл уусан юм шиг маш сайхан боллоо” хэмээн орчуулж байсан билээ. Хэрэв “Би шинэ өргөст хэмх идсэн юм шиг сайхан боллоо” хэмээн орчуулсан бол монгол хүний сэтгэлд тийм сайхан санагдахгүй байсан биз. Магадгүй зарим хүн ногоо идсэндээ юундаа баярлаад байгаа юм бол хэмээн ундууцах байсан биз ээ. Шинэ шөл ууна гэдэг бол монгол хүний сэтгэхүй таашаалд хамгийн сайхан нийцсэн өвөрмөц

¹¹ Л.Дорждэрэм, “Уран зохиолын орчуулгын алдаа оноог шүүн үзэх нь”, Орчуулах эрдэм №4, УБ., 2012, х149

хэлц гэдгийг зохиолч, орчуулагчийн арвин баян туршлагаасаа мэдэж байсан хэрэг юм. Хотжих явц хүчээ авч, монгол ахуйгаасаа алслан холдож байгаа энэ цаг үед хот газар өссөн залуус энэ үгийн утга болоод тэр таашаалыг мэдэхгүй байж мэдэх юм. МҮИС-ийн БИС-ийн багш А.Солонгоо “Залуучуудын үг хэллэгийн хэрэглээний онцлог” хэмээх судалгаа хийсэн өгүүлэлдээ “Залуус тансаг баялаг эх хэлээ бүрэн ашиглаж, зөв хэрэглэж чаддаггүй. Үүнийг юутай холбож ойлгодог вэ? хэмээх асуултад 50 хувь нь эх хэлний мэдлэг хомс /үгийн баялаг тутмаг/, 32 хувь нь гадаадын соёлын нөлөөнд хүчтэй автсан, 18 хувь нь интернетийн хэрэгцээ нэмэгдсэн гэсэн хариултуудыг өгчээ”¹² хэмээсэн байна. Энэ нь манай хотын залуусын эх хэлний мэдлэгийн мөн чанарыг харуулж байгаа хэрэг юм. 2012 онд хийсэн нэгэн судалгаагаар Та монгол хэлний хичээлд тийм ч сонирхолтой биш бол, Яагаад?хэмээх асуултад доорх байдлаар хариулсан байна.



Хэлийг хамгаалах нь улс үндэстний, хамт олны үйл хэрэг боловч, тухайн хэлийг өвлөн авч яваа хувь хүний идэвх зүтгэлээс шууд хамаарна гэж хэл шинжлэлтнүүд бичжээ. Энэ бол гарцаагүй үнэн. Та монгол хүн юм бол, монгол хэл, бичгээ зайлбаргүй мэддэг байх ёстой хэмээсэн бичигдээгүй хуулийг хэрэгжүүлж, бас монгол хэлээ мэддэггүйгээ мэддэггүй хүмүүсийг ухааруулах аваас монгол хэлний дархлаа буй болно.¹³

Тийм болохоор л монгол хэлээ суралцах хэрэгтэй хэмээн хэлээд байгаа юм. Тэд зохиол бичихийн тулд далай баян монгол хэлний үгсийн сангаас цуцалтгүй үгийн шүр сувдыг эрж хайж, суралцаж байдаг болохоор үг нь ончтой, найруулга нь тансаг байдаг. Монгол хэл сая гаруй үгсийн сантай хэмээн манай нэрт эрдэмтэн Б.Ринчен, Ш.Лувсанвандан нар хэлсэн нь бий. Ийм үгийн сантай болохын тулд үлгэр тууль, эртний уран зохиол, Ч.Лодойдамбын “Тунгалаг тамир” мэтийн олон сайхан роман, тууж, орчуулгын сайхан бүтээлүүдийг уншиж, монгол хэлний

¹² А.Солонгоо “Залуучуудын үг хэллэгийн хэрэглээний онцлог”, МҮИС-ийн Эрдэм шинжилгээний бичиг, 2015, №4(9), х 169

¹³ Ш.Чоймаа, Хэлний экологи,МУИС,ЭШБ, 2009, XXX, 125-134 тал

нэвтэрхий толь, нутгийн аялгууны толь, орчуулгын толь зэрэгтэй нөхөрлөж, монгол хэлний хэлзүйн номуудыг үзэн судлах хэрэгтэй болно. Тэгж чадвал монгол хүн болсны бахархал бий болж, сайн орчуулагч болохын үүд хаалга цэлийтэл нээгдэнэ. Миний оюутан цагийн анд, МУИС-ийн багш, манжич, доктор Г.Буянтогтох залуу багш байхдаа “Би Лу багшийн Монгол хэлний зүй, Ри багшийн Монгол бичгийн хэлний зүйн номыг бүгдийг нь уншаад судалсны дараа монгол хэлний талаар мэргэжлийн хүмүүстэй маргахад гартахгүй болсон шүү” хэмээн хуучилж байж билээ. Энэ нь монгол хэлээ судлан шимтсэний ач үр юм даа. Саяхан Монголын Үндэсний Телевизээр гарсан эх хэлний тухай нэвтрүүлэгт судлаач Д.Ганхуяг хэмээх хүн “Социализмын үед 4 нүүрээр гардаг байсан “Үнэн” сонины үгийг тоолж үзэхэд 5200 үг байдаг байлаа. Одоогийн сонинуудын үгийг тоолж үзэхэд 420 үг болж байна” хэмээсэн нь монгол хэлний үгсийн сангийн хэрэглээ ядуурч байгаагийн үзэгдэл яах аргагүй мөн бөгөөд ийм үед онцгой анхаарч, орчуулагч болох хүн зөвхөн орчин үеэр хязгаарлахгүй суралцах шаардлагатай болсныг харуулж байна. 2016 оны “Утга зохиол урлаг” сонинд Ш.Нямсүрэн гэдэг хүн “Төрөлх хэлээ төвөгшөөгөөд байгаа юм биш үү” хэмээх өгүүлэл бичиж гадаад хэлний үгийн замбараагүй хэрэглээг шүүмжлээд “Харь хэл үгээр чамирхаад ирэхээр хүний бүтээлч сэтгэлгээг боогдуулж, бэлэнчлэх, зогсонги байдалд оруулж аливаа төрөлх хэл устаж эхэлдэг юм” хэмээн мэргэн дүгнэсэн байна.¹⁴ Орчуулагч хүн эх хэлээсээ, уламжлалаасаа салбал урагшгүй орчуулагч болохын цондон мөн.

Summary

Two languages are demanded when making translation. It needs to translate from foreign language into mother language or from mother language into foreign language. Both translations are demanded the mother language's good knowledge. If someone doesn't know mother language well, thinking of translation is unrealizable. So, the first of all, it needs to learn mother language well.

Ном зүй

1. С.Галсан, Гурван их хүний нэг// "Утга зохиол", 1991.04.26 №15(1801)
2. Т.Галсан, Домогт Ринчингийн домгууд оршивай, УБ., 2005
3. Л.Дорждэрэм, “Уран зохиолын орчуулгын алдаа оноог шүүн үзэх нь”, Орчуулах эрдэм №4, УБ., 2012
4. Н.Нансалмаа, Ерөнхий хэлшинжлэл, УБ., 2012
5. Б.Ринчен "Марк Твений минь махы нь идэж дээ. УБ, 1991
6. А.Солонгоо “Залуучуудын үг хэллэгийн хэрэглээний онцлог”, МУИС-ийн Эрдэм шинжилгээний бичиг, 2015, №4(9)
7. Б.Чойжил, Орчуулагчийн жаргал, зовлон, УБ., 2005
8. Ш.Чоймаа, Хэлний экологи, МУИС, ЭШБ, 2009, XXX
9. Ш.Нямсүрэн, “Төрөлх хэлээ төвөгшөөгөөд байгаа юм биш үү” , 2016, 011/2496

¹⁴ Ш.Нямсүрэн, “Төрөлх хэлээ төвөгшөөгөөд байгаа юм биш үү” , 2016, 011/2496 дугаар

ДҮРС БИЧЛЭГИЙН ОРЧУУЛГАД АНХААРАХ ЗАРИМ ЗҮЙЛ

М.Амартайван¹

Түлхүүр үг: *дүрс бичлэгийн орчуулга, хадмал орчуулга, дэлгэцийн хадмал, дуу оруулах орчуулга, кино орчуулга*

Дэлхий ертөнц нэгэн сувгаар нэн далайцтай холбогдож, ажил хэргээ бүтээж, асууж сурснаа эрж олох болсоор нэлээд жилийг үдлээ. Энэ суваг бол та бидний мэдэх интернет сүлжээ. Интернетээс өмнө зурагт гэгдэх “шидэт хайрцаг” тив дэлхийг эзэгнэж, үзэл суртлын том зэвсэг, үндэстэн угсаатны мэдээлэл сурталчилгааны гол хэрэгсэл болж байсан билээ. Зурагтын дутууг гүйцээж дундуурыг дүүргэн, зурагтын нэвтрүүлгийг хүртэл утас, компьютерээсээ үзэх боломжтой болгосон интернет сүлжээгээр хүмүүс хоорондоо хормын зуурт холбогдож, хов живээс өгсүүлээд хорвоо дэлхийн мэдээг ч солилцох болсон энэ цаг үеийг Мэдээллийн эрин үе гэх нь бий. Мэдээллийн далайд живчхэлгүй үнэн худлыг ялгаж салгаж үр шимийг нь хүртэнэ гэдэг бас л яггүй цаг зав, хүч зүтгэл шаардсан ажил.

Цаг хугацаа хэмнэж, орон зайг ойртуулагч интернет сүлжээнд мэргэжлийн хүмүүс төдийгүй ер нь л хэн дуртай нь юу хүссэнээ оруулж болдог болсон ажээ. Сайнтай муутай мэдээ мэдээлэл сар жил биш агшин хормын дотор олон олон хүний нүдэнд өртөж сэтгэлд хадагдаж байна. Тэр дунд чухал байр эзэлж, өч төчнөөнөөрөө хүмүүст хүрч байгаа нь дүрс бичлэг. Үүнтэй уялдан хэл хэлний дүрс бичлэг хийх, орчуулах хэрэгцээ шаардлага өссөөр байгааг хэлэхэд илүүц биз ээ.

Миний бие ОУУБИС-ийн эрдэм шинжилгээний цувралд “Хадмал орчуулгын тухай ойлголт ба зарим бодит жишээг ажихад²” өгүүллийг хэвлүүлж байсан бөгөөд, энэ удаа тус агуулгыг дэлгэрүүлэн баяжуулж, илүү олон хүнд хүргэх сэн гэж сэтгэл шулуудан ийнхүү үг өгүүлбэр холбож сууна. Дээрх өгүүлэлд дүрс бичлэгийн орчуулгын эрэлт хэрэгцээг анхаарахын сацуу энэ төрлийн орчуулгыг чанаржуулах үүднээс юуны өмнө зөв ойлголттой болж, ямар аргаар хэрхэн хийдгийг нь мэдэж авахад нэмэртэй байгаасай гэж хадмал орчуулгын тухай ерөнхий ойлголт, хадмал орчуулгын үндсэн хэлбэрүүд, орчуулах зарим арга, түүнчлэн цөөн хэдэн жишээг дурдаж тайлбарласан билээ.

Юуны өмнө энэ өгүүлэлд олон удаа дурдагдах “хадмал орчуулга” гэж чухам юуг хэлж байгааг товч тайлбарлая. *Хадмал орчуулга гэхээр эртний ном, орчуулгын*

¹ ОУУБИС, Олон улс – орон судлалын тэнхим, багш

² М. Амартайван, Хадмал орчуулгын тухай ойлголт ба зарим бодит жишээг ажихад, “ОУУБИС-ийн эрдэм шинжилгээний сэтгүүл”, 2016, 43-51-р тал.

онолын бүтээлд гол төлөв аль нэг хэлээр бичсэн өгүүлбэрийг үг тус бүрийн харалдаа дээд хэсэгт гадаад үгээр харгуулж бичсэнийг буюу үгчилсэн орчуулгыг хэлсэн байдаг. Гэтэл орчин цагт дүрс бичлэгийн орчуулгын нэг хэлбэр, тодруулбал дүрс бичлэгийн дэлгэцнээ хэн нэгний хэлж ярьж байгааг бичгээр буулгаж орчуулсныг “хадмал орчуулга” гэж нийтээр хэрэглэж бараг хэвижээ. Тэгэхээр онолын нэр томъёог эргэж харж нэр томъёог цэгцлэх шаардлага нэгэнт урган гарчээ. Хэл анх сурч байгаа хүмүүсийн хэрэглэдэг, бас эртний эх сурвалжийн судалгаанд ашигладагчлан үг бүрийн дээр хадаж орчуулсан орчуулгыг “номын хадмал”, “үгчилсэн хадмал”, харин эдүгээ элбэг хэрэглэж байгаа кино, нэвтрүүлгийн хадмалыг “дүрс бичлэгийн хадмал”, эсвэл зүгээр “дэлгэцийн хадмал” гэх санал дэвшүүлж байна³.

Дүрс бичлэгийн орчуулга гэж юу вэ?

Бичгээр орчуулах бичвэрийг төлөв байдлаар нь бичгийн бичвэр, дуу дүрсний бичвэр гэж ангилдаг⁴. Энэхүү дуу дүрсний бичвэрийг орчуулах үйлийг бүхэлд нь дүрс бичлэгийн орчуулга гэнэ. БНСУ-ын “Медиа орчуулга” орчуулгын товчооны сайтад, “Дүрс бичлэгийн орчуулга бол дуу дүрсний нийлмэл хэлбэрээр бүтээгдсэн бүх төрлийн дүрс бичлэгийг орчуулах үйлийг хэлэх агаад, дүрс бичлэгийн агуулга зориулалтаас хамаарч захиалагч, хэрэглэгчийн шаардлагад зайлшгүй нийцүүлэх хэрэгтэй байдгаараа бичиг баримтын орчуулгаас ялгаатай⁵” гэж тодорхойлсон байдаг. Чухамдаа олон сайн орчуулагчтай орчуулгын үйлчилгээ эрхэлдэг байгууллага байлаа ч дүрс бичлэгийн орчуулгын талаар буюу хадмалаар орчуулах, дуу оруулахад зориулж орчуулах талаар нарийн мэдлэг, арвин туршлагагүй бол мэргэжлийн түвшинд орчуулж барахгүй. Иймд цаг үеийн эрэлт хэрэгцээний дагуу дүрс бичлэгийн орчуулга хийдэг мэргэжлийн орчуулагчийг бэлдэх зайлшгүй шаардлагатай байгааг дурдууштай. Тухайлбал, БНСУ-ын томоохон телевизүүд болох KBS, SBS, MBC бүгд харьяа академи байгуулж дүрс бичлэгийн орчуулгын сургалт явуулж байгаагаас MBC телевизийн дүрс бичлэгийн орчуулгын сургалтын хөтөлбөрт⁶

Дүрс бичлэгийн орчуулгын тухай ойлголт

Ном хэвлэлийн орчуулга ба дүрс бичлэгийн орчуулгын ялгаа

Хэвлэл мэдээллийн хэл ярианы онцлог ба хянаж магадлах журам

Солонгос хэлний зөв бичих дүрэм

Дуу оруулах орчуулгын аргазүй ба онцлог

Телевизийн дуу оруулах киноны үгийг бичих орчуулах дадлага

Баримтат кино орчуулах арга дадлага

Хүүхэдэйн киноны орчуулгын онцлог ба орчуулгын дадлага

Хадмал орчуулгын онцлог

³ М.Амартайван, Хадмал орчуулгын тухай ойлголт ба зарим бодит жишээг ажихад, “ОУУБИС-ийн эрдэм шинжилгээний сэтгүүл”, 2016, 43-51-р тал.

⁴ 정호정, 제대로 된 통역 번역의 이해, 한국문화사, 2016, 202 쪽.

⁵ <http://tline.kr> (Media translation орчуулгын товчоо)

⁶ <http://www.mbcac.com> (MBC академи)

Хадмал орчуулгын дадлага(Кабелийн телевиз, видео, ди ви ди-ний орчуулга)

Кинотеатрын кино орчуулах арга дадлага

Кино наадмын хадмал орчуулга ба кино наадмын орчуулагчийн шалгалтад бэлдэх дадлага

Дуу оруулах киноны дуу бичүүлэх

Дуу оруулах киноны орчуулгад анхаарах гол зүйл

Дуу хэрхэн оруулж байгаагаар танилцах дадлага

Кинотеатрын киноны орлого ба орчуулга

Төгсөлтийн ажил зэрэг агуулга багтжээ. Монголд телевизийн хөтлөгч, нэвтрүүлэгч, дуу оруулагч бэлдэх сургалт байгаа боловч хадмал орчуулга хийх аргачлалыг тусгай сургалтаар заадаг газар хараахан үгүй учир дээрх хөтөлбөрөөс санаа авч мэргэжлийн сургалт явуулбал тун тус буянтай ажил болох нь дамжиггүй.

Бас бичгийн орчуулгын хоёр үндсэн төрөл болох *ном хэвлэлийн орчуулга* ба *дүрс бичлэгийн орчуулгын* гол ялгааг орчуулагч Ким Ү-Ёл, нэгд, *ном хэвлэлийн орчуулгыг марафон гүйлттэй зүйрлэвэл дүрс бичлэгийн орчуулгыг ойрын зайн гүйлттэй зүйрлэж болох бөгөөд, хоёрт, ном хэвлэлийн орчуулга ерөнхийдөө бичиг байдаг бол дүрс бичлэгийнх яриа байдаг.*⁷ гэж өгүүлжээ. Энэ нь дэлгэцийн хадмалыг харьцангуй богино хугацаанд орчуулах шаардлагатай байдаг, түүнчлэн ярианы хэлийг бичгээр орчуулдаг онцлогийг нь илэрхийлсэн зүйрлэл харьцуулалт юм. Үнэндээ номын орчуулгыг хугацаа тулгуу өгөх нь ховор атал, кино, компанийн танилцуулга зэрэг дүрс бичлэгийн орчуулгыг нэлээд шахуу хугацаанд орчуулах хэрэг гардаг.

Дүрс бичлэгийн орчуулгын үндсэн хоёр төрөл нь дуу оруулах, хадмаллах юм. Дүрс бичлэгт дуу оруулах бол хоёр хэлбэр бий.

А. Бичлэгийн эх дууг дарж шинэ дуу бичлэгийн файлаар оруулах хэлбэр.

Б. Бичлэгийн эх дууг султгаж дээр нь шинэ дуу бичлэгийн файлыг тод сонсогдохоор эвлүүлэх хэлбэр⁸. Аль алинд нь агуулгыг эхлээд бичгээр орчуулж, орчуулгыг нь хожим дуу оруулагч нар орчуулагч, орчуулгын найруулагчийн хяналтын дор дуу оруулж “дахин амилуулдаг”.

Тэгвэл *хадмал орчуулга* нь *дуу оруулах орчуулгаас* юугаараа ялгарах вэ? Юуны өмнө хадмалыг дэлгэцээр гаргах учир нэг удаад тодрох хадмал (Тус өгүүлэлд үүнийг “нэгж хадмал” гэж дурдав.) 3 мөрөөс хэтрэхгүй байх ёстой бөгөөд, мөн хэт урт байж болдоггүй. Харин дуу оруулах зорилгоор орчуулж байгаа тохиолдолд дуу оруулагч нь дуу авианд орчуулгыг тааруулж уншиж жүжиглэх ёстой учир орчуулга нь хэлсэн үгнээс хэт богино, хэт урт байж болохгүй, яг зэрэг эхлээд зэрэг дуусаж байх учиртай. Богино бол орчуулалгүй орхилоо, урт бол “амны хайрцаг” таарахгүй байна гэж үзэгч шүүмжилнэ. Хүүхэлдэйн кино, олон ангит кинонд дүрүүдийн амны хайрцаг их тод харагддаг учир тэр болгоныг нарийн баримтлах гэсээр баримтат кинонд дуу

⁷ 김우열, 나도 번역 한번 해볼까, 잉크, 2011

⁸ 함혜숙, 영상번역가로 먹고살기, 왓북, 2009

оруулахаас хавьгүй бэрх байдаг. Дуу оруулахад зөвхөн өгүүлбэрийг орчуулаад орхичхож болохгүй. Аялга үг, амьсгал, ярианы өнгө аяс, сэтгэл хөдлөлийг хүртэл илэрхийлэх ёстой болдог. Иймд яриа түр зогсох хэсэгт /, удаан зогсох хэсэгт // гэж тэмдэглэхээс гадна сэтгэл хөдлөл, төрх байдлыг дугуй хаалтанд (уурлан), (амьсгаадангаа) гэх мэтээр тэмдэглэдэг. Аль аль нь ярианы хэл боловч хадмал орчуулга дэлгэцэнд бичгээр гардаг учраас зөв бичих дүрмийг чанд баримтлах ёстой. Аялга үг, олон давтсан үг болгоныг нэг бүрчлэн хадмалаар орчуулах хэрэг байдаггүй. Харин онцгой тохиолдолд, тухайлбал сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулсан хадмал бол эдгээрийг орчуулж болох талтай. Товчхондоо хадмалыг чихээр сонсох биш нүдээр харахад зориулдаг учир цэгцтэй, уншихад эвтэйхэн, зөв бичих дүрмийг баримталсан байх ёстой юм. Жишээ нь:

<i>Дуу оруулах орчуулга</i>	<i>Хадмал орчуулга</i>
<i>Яачхаад байгаа юм бэ, ер нь? / Чи чинь өөрийн ухаантай байна уу?</i>	<i>Чи өөрийн ухаантай байна уу? Ер нь яачхаад байгаа юм бэ?</i>
<i>Яаж байгаам бэ? / Явсан и дээ.</i>	<i>Яаж байгаа юм бэ? Явсан шүү дээ.</i>
<i>Өө хөөрхий. / За за, бүр ийм дээрээ тулаа юу?</i>	<i>Бүр ийм дээрээ тулаа юу?</i>

Хадмал орчуулгыг ерөнхийдөө агуулгаар нь *нэвтрүүлэг кино, сурталчилгаа, сургалтын* гэж гурав ангилдаг. Нэвтрүүлэг киноны хадмал орчуулга орчуулагчийн хэл ярианы мэдрэмж, илэрхийлэх чадвар, соёлын мэдлэгийг шаарддаг нэг төрлийн зохиол гэж болох учир Солонгост “орчуулгын зохиолч”⁹ гэж нэрлэх болжээ. Дүрс бичлэгийг дуу оруулахад зориулж орчуулж болохоос гадна хадмалаар орчуулдаг. Хадмаллахад нэг мөрөнд орох үе, үгийн тоог тэмдэгт¹⁰-ээр хязгаарладаг учир утгыг алдагдуулахгүй товчилж орчуулах үе ч бий. Харин дуу оруулах бол дүрс бичлэгийн үг яриатай орчуулгын урт богино, түргэн удааныг сайтар тааруулж, дүрүүдийн онцлогийг гаргахын тулд өгүүлбэр дэх гишүүдийн байрлалыг хүртэл харгалзаж орчуулдаг. Сургалтад зориулсан хадмал орчуулгыг тухайн мэргэжлийн мэдлэг боловсрол бүхий орчуулагч орчуулах нь хамгийн зохимжтой.

Нөгөөтээгүүр Монголд орчуулгын кинонд дуу оруулдаг хүмүүсийг нарийн мэргэжлийнхэн, жүжигчид мөн гэж саяхнаас зөвшөөрч “орчуулгын киноны жүжигчин” гэх болсон нь сайшаалтай явдал мөн. Кино орчуулагч Х.Мэргэн “Өнөөдрийн киноны баатруудын амны хайрцагт дөхүүлсхийгээд, сэтгэлийн хөдлөл зэргийг нь ойртуулсхийгээд хаядаг энэ дуу оруулалт бол тухайн цаг үеийн завсрын үзэгдэл биз ээ. Угтаа бол бүрэн жүжиглэлтэй, уруул амны хөдөлгөөнд орчуулга нь яв цав таарсан тийм л дуу оруулалт байх ёстой”¹¹ гэж бичсэн байдаг нь үүнийг нотолж байна.

⁹ 영상번역작가

¹⁰ Уг хоорондын сул зайг тэмдэгтийн тоонд оруулж тооцдог.

¹¹ <http://kakadumn.blogspot.com> (Х.Мэргэн: “Сүүлийн үеийн кинонуудын орчуулгын тухай”)

Киног хадмалаар орчуулах уу, дуу оруулах уу гэдгийг шийдэхэд захиалагчаас гадна үйлчлүүлэгчийн хүсэл сонирхол нөлөөлдөг. Ялангуяа кинотеатрын үйлчлүүлэгч нар гадаад киног голдуу эх хэлээр нь, эх дуу авиагаар нь монгол хадмалтай үзэхийг илүүд үздэг боловч хэдхэн секунд дэлгэцэнд тодроод арилдаг хадмал орчуулгыг унших боломж чадвар дутмаг хүүхэд багачууд, настан буурлууд, гадаад хэл мэдэхгүй зарим иргэд дуу оруулсан орчуулгыг хүсдэг. Үзэгчдийн зүгээс кинотеатруудын удирдлагад ядаж хүүхэлдэйн киног театрт гаргахдаа дуу оруулж гаргаж байх санал хүсэлт их гаргадаг ажээ. Учир нь хүүхдүүдтэйгээ кино үзэхээр очоод киноны хадмал орчуулгыг давхар уншиж өгөх, киноны агуулгыг үе үе хэлж тайлбарлах нь үзэж байгаа үзүүлж байгаа аль алинд нь төвөгтэй санагддаг гэдэг. Телевизийн сувгуудаар гаргаж байгаа кинонууд олон хүнд хүртээмжтэйг бодож дуу оруулах нь элбэг боловч, IPTV-гийн хэрэглэгчдэд зориулсан кино үзвэр, бас HBO зэрэг зарим нэг кино суваг хадмал орчуулгыг сонгон хэрэглэж байна. Үүний зэрэгцээ гадаад хэл сонирхон судлах хүн олширсон өнөө цагт гадаадын киног эх хэлээр нь, гадаад болон монгол хэлний хадмал орчуулгатай үзэхийг хүсдэг хүүхэд залуус цөөнгүй байгааг онцолъё. Монгол хэл сурч байгаа гадаад хүн монгол хадмалтай, гадаад хадмалтай монгол нэвтрүүлэг кино шимтэн үзэхийг сонирхон сураглаж асуусаар байдаг билээ. Дүрс бичлэгт хадмал хийх аргыг сураад авбал орчуулагчтай хамтраад интернет сүлжээнд байгаа ганц мөч хэртэй үргэлжлэх TED, 세바시(세상을 바꾸는 시간) гэх мэт олон сайхан сонирхолтой бичлэгийг монголоор орчуулан сургалтад ашиглах, өөрсдийн хийсэн бичлэгийг ч хадмаллан оруулах боломж, тэр бичлэгийг нь үзэж сурах эрэлт хэрэгцээ бийг энд хэлэхэд илүүц болов уу.

Дэлгэцийн хадмалын хэлбэрүүд

Хадмал орчуулгыг харагдах байдлаар нь дөрвөн хэлбэрээр хийж болдог.

А. Хадмалыг дүрсний доод хэсэгт байрлуулах үндсэн хэлбэр.

Б. Хадмалыг дэлгэцийн дээд доод талд залгасан “хадмалын дэвсгэр”¹² ба дэлгэцийн дүрсэн дээр тэгнүүлж байрлуулах хэлбэр.

В. Дэлгэцийн доод талын хадмалын дэвсгэр дээр хоёр мөрөөр хадмалыг байрлуулах хэлбэр.

Г. Дэлгэцийн дүрсний доод хэсэгт хагас тунгалаг тууз оруулж, уг туузан дээр хадмалыг байрлуулах хэлбэр.

¹² 레터박스

Зураг 1. Хадмалын дөрвөн хэлбэр



Дэлгэцийн хадмал орчуулгад анхаарах цөөн хэдэн зүйл¹³

Цэг тэмдэг:

Таслалыг зайлшгүй үед л хэрэглэдэг. Нэгэнт хоёр мөрөөр тасалж оруулдаг учир мөрийн эцэст таслал тавих шаардлага байдаггүй.

Цуваа гурван цэгийг яриа тасрах үед ард нь, залгагдах үед урд нь тавьдаг.

Цэг тэмдэг давхардуулахгүй. Анхаарлын тэмдэг хоёр гурваар нь, эсвэл асуултын тэмдэгтэй хамт оруулах нь тун зохисгүй.

Өгүүлбэрийн цэг тэмдгээс бусад тэмдэг оруулж болохгүй.

Нэгж шилжүүлэх:

Хэмжих нэгжийг ихэвчлэн орчуулж байгаа оронд хэрэглэдэг нэгжээр шилжүүлэн тооцож бичнэ.

Нэг мөр байх:

Нэрийг нэг мөр болгоно. Дүрийн ярианы онцлогийг нэгтгэнэ.

Дэлгэцэнд тодрох хадмал, хаяг зэрэг бичгийг орчуулах:

Эх дүрс бичлэгт гарч байгаа зурвас, хаяг, тайлбар хадмалыг орчуулж оруулах ёстой.

Өгүүлэгдэхүүн өгүүлэхүүнийг ойртуулах:

Үзэгчийг төөрөгдүүлэхгүйн тулд өгүүлэгдэхүүн өгүүлэхүүнийг аль болох ойртуулах хэрэгтэй.

¹³ 함혜숙, 영상번역가로 먹고살기, 왓북, 2009

Хэлзүйн хувиргал ашиглах:

Илэрхийллийг утгачлах шаардлагатай бол хэлзүйн хувиргалыг зохистой хэрэглэнэ.

Хадмал орчуулгын бодит жишээ, зарим алдаа дутагдал

Одоо Монголд хийж байгаа хадмал орчуулгын бодит жишээний зарим алдааг өгүүлье. Хадмалыг дэлгэцийн доод хэсгийг дүүртэл 3-аас олон мөрөөр гаргах нь тун бүдүүлэг хэрэг. Энэ бол үзэгчийг үл хүндэтгэж байгаа явдал мөн. Жишээ нь Стар ТВ-ийн Talk With Me ярилцлагад энэ алдаа давтагдсаар байна. Хадмал орчуулгын нэгээс хоёр мөр нэг бичвэр 2-7 секунд харагдахаар байх нь зохимжтой. Гэтэл ингэж олон мөрөөр 30, 40 үгтэй, нэг мөрөндөө 60, 70 үсэгтэй агуулгыг богино хугацаанд дэлгэцийн дүрсийг ажингаа уншина гэдэг тун ядаргаатай, ярвигтай гэдгийг ойлгох хэрэгтэй. Дэлгэц бол номын хуудас биш шүү дээ. Тиймээс агуулгыг бүрэн гаргах хэмжээнд товчилж зохих хэсгээр нь мөрөөр хувааж, хэлж ярьж байгаа цагтай нь тааруулж оруулах ёстой юм.

Бодит жишээнээс харъя.

Зураг 2. Стар ТВ-ийн Talk With Me ярилцлага: Хадмалын алдаа



Жнь: Тиймээс миний гол үүрэг бол гэр хороололд очин айлуудад судалгаа хийж, төслийг хэрхэн явагдаж буйг мөн төсөл хэрхэн тэдний орлого болон амьдралын хэв маягийг сайжруулж байгаа зэргийг харахаар очдог байсан.


Үүнийг хоёр хадмалд хувааж

1. Гэр хорооллын айлуудаас судалгаа авч төслийн явцтай танилцаж...

2. ... амьжиргаагаа хэрхэн дээшлүүлж байгааг харахаар очдог байсан.

гэхэд нүдийг бага ядрааж, хадмалыг уншиж байгаа үзэгчийг бага бухимдуулах байв. Дэлгэцийн доод хэсэгт сунайн багширч гарах хадмалыг унших гэсээр дүрс бичлэгээ үзэх сонирхол буурах ч сөрөг талтай байж болохыг анхаарууштай.

Зураг 3. Стар ТВ-ийн Talk With Me ярилцлага: Хадмалын алдаа



Бас холбоо үг, утгат хэсгийг дундуур нь цавчиж тасалж байгаа нь тун тоогүй. Жишээ нь: *Таны вэб хуудсыг уншиж, таньтай өдрийн цайны үер хууч хөөрсний дараа таныг феминист гэдгийг би мэднэ.* Үүнийг

1. *Вэб хуудсыг тань уншиж өдрийн цайны үеэр...*
2. *... ярилцсаны дараа таныг феминист гэж ойлголоо.*

гэвэл болох мэт санагдана.

Бас бичгийн алдаа, найруулгын алдаа багагүй харагддаг. Гэвч хадмалаар үзэгчдэд утгыг ойлгуулах гэсэн хичээл зүтгэлийг магтууштай.

Хадмал орчуулгыг ойлгомжтой байлгахын тулд хоёр хүний богино яриа нэг дор гарвал хоёр дахь хүний яриаг дараагийн мөрөөс эхэлж, тус тусын өмнө зураас тавьж ялгадаг. Жишээ нь:

- Битгий мартаарай.
- За, мартахгүй ээ.

НВО кабелийн сувгаар үүнийг сайн баримталдаг. Магадгүй англи хэлний хадмал файлыг ашиглаж монголоор орчуулдаг байх гэж бодогддог. Кинотеатруудын орчуулга бас бичгийн алдаа, найруулгын алдааг эс тооцвол хэлбэрийн хувьд хадмалын зарчмыг харьцангуй сайн баримталсан харагддаг.

Дүрс бичлэгийн орчуулгад анхаарах зарчим

Мэдээллийн технологийн хөгжилтэй уялдан улс орнуудын хил хязгаарт баригдалгүй интернет орон зайд хүмүүс бараг чөлөөтэй харилцах болсон билээ. Энд бараг гэсний учир гэвэл мэдээллийн эрх чөлөөг зарим байдлаар хорьж цагддаг хориг хязгаарлалтыг дурдсан гэж ойлгоорой. Дүрс бичлэгийн орчуулгын хэрэгцээ шаардлага, хэрэглээ ихэссэнээр энэ төрлийн орчуулгын ач холбогдол өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж байна. Иймд дүрс бичлэгийн орчуулгын онцлог, орчуулгад баримтлах зарчмыг сайтар үзэж танилцах хэрэгтэй.

Дүрс бичлэгийн орчуулгын онцлогийг М.Шатлворт, М.Кови нар,

- Цогц мэдээллийн хэрэглээ
- Олон нийтэд хандсан орчуулга
- Хэлний хэмнэлтийн эрхэмлэх явдал

- Орчуулгын хэрэглэгчид үнэнч байдал
- Соёлын агуулгыг харгалзаж зуучлах үүрэг¹⁴ гэж үзжээ.

Тодруулбал, дуу дүрсний мэдээллийг хамт хүргэдгээрээ цогц мэдээллийг хэрэглэж, эх хэл, орчуулгын хэлний хэрэглэгчийн аль аль нь өөр хэл соёлтой учраас тодорхой бүлэг хүмүүсийн боловсролын түвшин хүсэл найдварт нийцүүлэхээсээ илүүтэй ерөнхийдөө олон нийтэд хандаж орчуулах болдог, дэлгэцийн хэмжээ ба амны хайрцагт тааруулах ёстой байдгаас товч хэмнэлттэй байдлыг чухалчилж, бас орчуулах эх бичвэрийн агуулга ба зохиолчийн санааг анхаарах боловч түүнийг сонсож уншиж хүлээж авах хүмүүст ойлгомжтой амар дөт байгаа эсэхийг давуу авч үздэг тул орчуулгын хэрэглэгчид үнэнч байх бөгөөд, соёлын зөрүүгээс үүсэх үл ухагдах тохиолдлыг багасгахыг хичээн хоёр соёлын агуулгыг харгалзаж зуучлах үүрэгтэй¹⁵ гэж болох ажээ.

Дүрс бичлэгийн орчуулгад баримтлах ерөнхий зарчим гэвэл,

- Цаг хугацаа, орон зайн хязгаарлалтыг дагах
- Илэрхийллийг хэмнэхийг хичээх
- Дуу, дүрсний мэдээллийг зэрэг хэрэглэх
- Дэлгэцийн мэдээлэл ба орчуулгын бичвэрийн агуулга таарч байгаа эсэхийг нягтлах¹⁶ эдгээр болно.

Цаг хугацаа, орон зайн хязгаарлалтыг дагах гэдэг нь дүрс бичлэг үзэгчийн уншиж сонсох дундаж чадвараар жишиг тогтоож, уншиж сонсож амжихуйц урт богинын хэмжээг чанд баримтлахыг хэлнэ. Ойлгоход энгийнээр тайлбарлавал, ярьж байгаа агуулгатай хадмал орчуулга, эсвэл дуу оруулах орчуулга зэрэгцэж байх ёстой, хэт түрүүлж, хэт хоцорч болохгүй гэсэн үг.

Үүнтэй уялдан илэрхийллийг хэмнэхийг хичээх хэрэгтэй болдог. Өөрөөр хэлбэл, дуу дүрсний мэдээллээр нөхөгдөх боломжгүй агуулгыг зайлшгүй орчуулах боловч ялангуяа хадмал орчуулгад зөв бичих дүрмийг баримталснаар товч илэрхийлэх шаардлагатай болдог.

Дүрс бичлэгийн орчуулга учраас дуу, дүрсний мэдээллийг зэрэг хэрэглэх нь зайлшгүй бөгөөд, эцэст нь дэлгэцийн мэдээлэл ба орчуулгын бичвэрийн агуулга таарч байгаа эсэхийг нягтлахгүй бол хоорондоо зөрөх, бичгийн алдаа ажиглагдах талтайг мартаж хэрхэвч болохгүй.

Хадмаллах аргачлал

Энэ хэсэгт зарим байгууллагын хадмаллах аргачлалыг танилцуулъя. Үүнээс санаа авч олны санааг уралдуулан монгол хэлний дэлгэцийн хадмалын стандарт, аргачлалыг боловсруулж хэрэгжүүлэх нь зүйтэй болов уу.

Дэлгэцийн нэгж хадмалын хязгаарлалт БНСУ-д кино болон бусад дүрс бичлэгийн орчуулгад ялимгүй ялгаатай бөгөөд, киноноос бусад дүрс бичлэгт гол төлөв мөрөнд 16 үе, 2 мөр, нийт 32 үеэс хэтрүүлэхгүй бичих ёстой бол, кинонд нэг

¹⁴ 정호정, 제대로 된 통역 번역의 이해, 한국문화사, 2016, 216 쪽

¹⁵ 정호정, 제대로 된 통역 번역의 이해, 한국문화사, 2016, 216 쪽

¹⁶ 정호정, 제대로 된 통역 번역의 이해, 한국문화사, 2016, 217 쪽

мөрөнд 12 үе, 2 мөр, нийт 24 үед багтах ёстой байдаг. Дээхэн үед БНСУ-д кинотеатрын суудлын налуу бага байх үед дэлгэцийн баруун талд босоогоор 7, 7 үеэр 3 мөр, нийт 21 үе, эсвэл нэг мөрөнд 8 үе байхаар 2 мөр, нийт 16 мөр хадмал оруулдаг байжээ¹⁷.

Их Британийн өргөн нэвтрүүлгийн корпорац /BBC/-ын хадмал хийх аргачлалд¹⁸ бичвэр засах, мөр хуваах, цаг тааруулах, өнгө тохируулах, байрлал, тоо, дуу гэх мэтийг хэрхэн хадмаллахыг дэлгэрэнгүй зааварлажээ. Үүнээс мөр хуваах тухайд зурагтынх бол латин үсгээр нэг мөрөнд 37 тэмдэгт байна гээд, онлайн бол 16:9 харьцаатай дэлгэцийн өргөний 68 хувь, 4:3 харьцаатай дэлгэцийн өргөний 90 хувиас хэтрэхээргүй байх ёстой гэж заасан байна. Ерөнхийдөө нэг удаад нэг л өгүүлбэрээр хадмаллаж, хурдан яриа, богино өгүүлбэр бол хоёр өгүүлбэр байж болно гэжээ. Нэг удаа дэлгэцэнд тодрох хадмал буюу нэгж хадмал 2 мөр байх боловч онцгой тохиолдолд дэлгэцийн чухал дүрсийг халхлаагүй бол 3 мөр байхыг зөвшөөрнө гэсэн байна. Бас мөр хуваахад холбоо үг, хэллэгийг дундуур нь таслахгүй байхыг ч дурджээ.

Жишээлбэл,

We are aiming to get a better television service.	<i>We are aiming to get a better television service.</i>
---	---

Youtube сайтаас бидний олон удаа харж байсан  дүрс бол Closed captions¹⁹ гэсэн үгний товчлол бөгөөд, сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулсан хадмал юм. Ийм хадмалд дуу оруулж орчуулах, жүжигчдэд зориулсан кино жүжгийн үгтэй адил (санаа алдав), (хонх дуугарав) гэх мэт дуу авиа, чимээ шуугианыг хүртэл тусгаж хаалтанд тайлбарлаж оруулах хэрэгтэй байдаг. Subtitles for the deaf or hard-of-hearing (SDH) гэж өөр нэг нэр томъёо байдаг нь Америкийн DVD үйлдвэрлэлийнхнээс гарсан агаад, сонсголын бэрхшээлтэй хүмүүст зориулагдсанаас гадна үзэгч үзэж байхдаа хэн нь хэлж байгааг мэдэхгүй тохиолдлыг ч тодруулж хамдаллахыг хэлдэг ажээ.

Жишээлбэл,



¹⁷ 함혜숙, 영상번역가로 먹고살기, 왓북, 2009

¹⁸ <http://bbc.github.io/subtitle-guidelines/#Appendix-2--Sample-EBU-TT-file>

¹⁹ [https://en.wikipedia.org/wiki/Subtitle_\(captioning\)](https://en.wikipedia.org/wiki/Subtitle_(captioning))

1. Дэлгэцэнд дүрс нь гараагүй хүмүүсийн хэн юу хэлж байгаа нь тодруулсан нь
2. Дэлгэцэнд гарж байгаа, гараагүй дуу чимээг хадмалласан нь
3. Дууны төрөл жанрыг, мөн тоглож байгааг тодотгосон нь
4. Дууны үгийг хадмалласан нь

Дэлгэцийн хадмалыг тод харагдуулахын тулд үсгийг сүүдэрлүүлэхээс гадна үсгийг хүрээг тодруулах аргыг бас ашиглаж болдог.

Нэгж хадмалын дэлгэцэнд гарах хугацааг яриатай яв цав тааруулах тун чухал. Гэхдээ уншиж амжихаар байх ёстойг бодолцоно. Иймд хугацааны хувьд ч гэсэн нэг удаад 2 мөр хадмал л гаргах нь тохиромжтой байдаг. Богино нэг үг гарлаа гэхэд л багаар тооцоход 1.5 секунд харагдах ёстой. Гэвч түргэн яриа бол үүнээс бага хугацаанд халти харагдаад өнгөрч болно. Аль болох нэг мөрөнд 2 өгүүлбэр оруулахгүй байхыг бодно²⁰.

ВВС-ийн аргачлалд²¹ хугацааны тухай дараах заавар байгааг сайтар бодолцох нь зүйтэй.

Үүнд:

Стандарт хугацаа	
1. Богино, тогтмол хэрэглэдэг хэллэг бол 1.12 - 2 секунд. Ж1: Hello. Ж2: Excuse me.	2. Нэг мөрний хагас бичвэр бол 2 - 2.12 секунд. Ж1: Where do you live? Ж2: See you tomorrow.
3. Нэг мөр бол 2.12 – 3 секунд. Ж1: How long will it take us to go home? Ж2: He's got a real headache.	4. Нэг мөрнөөс ялимгүй урт бол 3.12 секунд. Ж: How long will it take Johanna to go home?
5. Нэг мөр хагас бол 4 - 4.12 секунд. Ж: It is important to tell her about the decision we made.	6. Хоёр мөр бол 5 - 6 секунд. Ж: I think it would be a very good idea to keep dangerous dogs on a leash.
7. Хоёр мөрнөөс ялимгүй урт бол 6.12 секунд. Ж: How long will it take the whole cast to come home by taxi to Duals, North Dyfed?	8. Хоёр мөр хагас бол 7 секунд. Ж: The best thing about going abroad is that you don't have to put up with the British weather.
9. Гурван мөр бол 7.12 - 8 секунд. Ж: What will the City do about the Tory Government's humiliating defeat in the House of Commons last night?	

²⁰ <https://www.engagemedia.org/blog/best-practices-for-online-subtitling>

²¹ http://www.bbc.co.uk/guidelines/futuremedia/accessibility/subtitling_guides/online_sub_editorial_guidelines_vs1_1.pdf

Харин кирил үсэг хэрэглэдэг Орост олон улсын кино наадмын кино түгээж, хадмал хийдэг Сине Промо²² компанийн сайтад дурдсанаар хадмалын нэг мөрөнд 35 тэмдэгт байх ба, үүнийг 40 хүртэл нэмж болох хэдий ч энэ тохиолдолд үсгийн хэмжээг багасгаж багтаана гэсэн байгааг бид бас харгалзах нь зөв биз ээ.

Интернет дэх дүрс бичлэгүүдээс хэрэглэгчдийн хамгийн их үздэг дүрс бичлэгийн нэг бол яах аргагүй TED-ийн бичлэг гэдгийг хэн ч үгүйсгэхгүй болов уу. Энэхүү тусгай илтгэл лекцийн орчуулгын төсөл анх 2009 онд 40 хэлний сайн дурын 200 орчуулагч, 300 орчим орчуулга хийснээр эхэлж байсан бол, эдүгээ 107 хэлний сайн дурын 20000 орчуулагч 70000 гаруй орчуулга хийсэн гэдэг тоо баримт байдаг ажээ. Үүнээс 2015 оны 10 сарын байдлаар монгол хэлний 140 гаруй орчуулга, бүртгэлтэй 100 гаруй орчуулагч байдаг юм байна.

Ингээд TED-ийн дүрс бичлэгт хадмал хийхэд баримтлах аргачлалыг²³ хэл тус бүрээр дээрх төслийн орчуулагч нарт зориулан сайтад оруулсан байдгаас монгол хэлнийхийг товч танилцуулъя²⁴.

Хадмал орчуулгын хэл	Монгол
Хадмал гарах хугацаа	1-7 секунд
Мөрийн тоо хамгийн ихдээ	2 мөр
Нэг мөрийн дээд хэмжээ	42 тэмдэгт
Нэг удаа дэлгэцэнд гарах үсгийн дээд хэмжээ	84 тэмдэгт
Эхлэх хугацаа	Аудио эхлэхээс өмнө 100мс дотор
Мөр шилжүүлэх	Өгүүлбэр зүйн нэгжийг хуваахгүй байх
Хадмал орчуулгын бүтэц	Хоёр тусдаа өгүүлбэрийг нийлүүлэхгүй байх
Бичвэр хуваах	Хурд, урт хэтрээгүй бол өгүүлбэрийг олон хуваахгүй байх
Дуу чимээг илэрхийлэх	Дугариг хаалтанд тэмдэглэх
Дэлгэцэнд гарах бичвэр	Дөрвөлжин хааланд тэмдэглэх

Харин үеэр бичдэг солонгос, япон хэлний хадмал орчуулгад нэг мөрөнд 21 үе, нэг удаад 2 мөрөөр нийт 42 үеэс хэтрэхгүй байна гэж хязгаарлажээ. Мөн хоёр мөрний харьцааг 50 хувиас хэтрэхээргүй байхаар зааж, хадмалыг хуваарилахдаа хэт богино, хэт урт байхаас болгоомжил гэж анхааруулсан байна²⁵

Үүнээс гадна орчуулагч нарт хандан,

- Илтгэгчийн хэлсэн үг бүрийг биш, сул үгийг хасаж, илэрхий алдааг засаж хадмаллана.

²² <http://www.cinepromo.ru/blog/teoriya-kino/555-obshchemirovye-standarty-po-izgotovleniyu-subtitrov.html> Общемировые стандарты по изготовлению субтитров

²³ http://translations.ted.org/wiki/TED_Translator_Resources:_Main_guide (TED-ийн орчуулагч нарт зориулсан үндсэн аргачлал)

²⁴ <http://translations.ted.org/wiki/Mongolian>

²⁵ <http://translations.ted.org/wiki/Korean> TED 한국어 번역 포탈

- Нэгж хадмал орчуулгад зөвхөн нэг өгүүлбэр бичнэ.
 - Хадмал илтгэгчийн ярианы хурдтай таарч байх ёстой ч унших хурдаас хамаарч зарим тохиолдолд зөрж болно. Харин илтгэгчийг яриагүй үед хадмал орчуулга гарах ёсгүй.
 - Урт өгүүлбэрийг хоёр мөрт хуваахдаа утгын нэгжээр хуваана. Аль болох холбоо үгийг салгалгүй хуваана.
 - Таслалыг зөвхөн шаардлагатай үед хэрэглэнэ.
 - Аливаа нэршлийг сайн судалж орчуулна.
- гэх мэтээр цөөнгүй зөвлөгөө өгсөн байдгийг үзэж танилцаарай.

Дүрс бичлэгийн орчуулгын үнэ хөлс, орчуулгын чанар

Орчуулгын үнэ хөлсний тухайд киноны орчуулгаар жишээлбэл ихэвчлэн үргэлжлэх хугацаагаар (10 минутын жишиг үнэлгээгээр), киноны үг байгаа тохиолдолд хуудасны тоогоор тооцдог. Түүнчлэн гадаад хэлнээс эх хэлээр үү, эх хэлнээс гадаад хэлээр үү, агуулга хүнд үү гэдгээс шалтгаалан үнийн хэлбэлзэл багагүй байж болно. Телевизийн дүрс бичлэгийн орчуулгын тухайд тус телевизээс тогтмол цалинтай орчуулагчийг ажиллуулж үнэлгээнд тохирсон ажил даалган шийдэж болох талтай. Харин компанийн танилцуулга, зар сурталчилгаа, хурал семинар, сургалтын агуулга бүхий дүрс бичлэгийн орчуулгыг дүрс бичлэгийн орчуулга хийх мэдлэг чадвартай мэргэжлийн орчуулагч нараас бүрдсэн товчоо байгуулж орчуулгын ажлыг гэрээгээр гүйцэтгүүлэх нь зүйтэй мэт. Хувиараа, сонирхлоороо зохиогчийн эрхийг хүндэтгэн дүрс бичлэгийн орчуулга хийж түүнийгээ хэрхэн үнэлүүлж солилцох нь мэдээж нээлттэй хэвээр үлдэнэ.

Түүнчлэн аливаа хадмал орчуулгын дараа орчуулагчийн нэрийг барагтай бол дурдахгүй байгаа нь орчуулагчийг, орчуулгын бүтээлийг түгээж байгаа байгууллагыг хариуцлагагүй байлгах нэг шалтаг болж байна уу гэлтэй. Зөвхөн хадмал ч гэлтгүй дуу оруулах орчуулгад ч мөн адил. Жишээлбэл, орчуулгын киноны анги бүрийн эцэст ямар хэлнээс хэн орчуулсныг, орчуулгын найруулагч, дуу оруулагч жүжигчдийн нэрийг хэлэх нь ажил мэргэжилдээ сэтгэл зүтгэлтэй хандах, ухамсартай хариуцлагатай байхад нөлөөлж, хийж бүтээснээрээ бахархаж урамших нэгэн хөшүүрэг болох байх гэж санагдана. Мөн хожим үүх түүхийн баримт болж, судалгаа шинжилгээний чухал судлагдахуун болохыг үгүйсгэх аргагүй.

Харин орчуулгын чанарын асуудлын талаарх саналаа судлаач М.Саруул-Эрдэнийн үгээр орлуулъя. *“Орчуулагч нар муудсан гэж харагдаад байгаан цаад учир нь телевиз, театрууд жинхэнэ орчуулагч нараа биш тааруухан хүн хөлслөөд байгаад л байна. Тааруухан хүнийг хямдхан хөлслөөд байгаан учир нь сайн орчуулагч нарыг өндөр цалингаар ажиллуулмааргүйд байгаа юм. Харамчдаа биш зах зээлийнхээ хуулиар, угаасаа кино эфиртээ гаргаад хир ашиг олж байгаатай нь л орчуулагчийнх нь харамж дүйж байгаа хэрэг... Киноны орчуулгыг сайжруулъя гэвэл сайн орчуулагч нарт хангалттай хөлс өгч орчуулуулж бай. Тэр зарсан мөнгөө буцааж олъё гэвэл кино гээчийг үзэхэд үнэтэй, нэр хүндтэй зүйл чигээр нь байлга... Киноны нэр хүндийг өргөхийг хүсвэл бүх телевизээр хууль бус бичлэг бүхий кино гаргахыг хоригло... Хууль дүрмээ жаахан янзлаад орхивол зах зээл өөрөө зохицуулаад*

өгнө. Муу орчуулгатай кино гаргадаг телевизийг үзэхгүй, тэгэхээр компаниуд рекламаа өгөхгүй, харин сайн киногоор бизнес хийхийн тулд сайн орчуулагч нарыг булаацалдах болно.”²⁶ Энэ бол зөвхөн киноны орчуулгад биш дүрс бичлэгийн бүх төрлийн орчуулгын чанарыг сайжруулахад нэн тэргүүнд анхаарах зүйлийн нэг мөн.

Дүгнэлт

Дүрс бичлэгийн орчуулгын тухай, орчуулахад юуг анхаарах талаар бичлээ. Хүн хэдий ухаантай ч хэлэхээс наашгүй гэдэг. Энд хөндсөн асуудлаас нэгийг ч болов ойлгож хэрэгжүүлээсэй гэж хичээнгүйлэн хүснэм. Ерөөс зүгээр хадаад л орчуулчихаар хадмал орчуулга болчихгүй. Хадмал орчуулгад анхаарах, баримтлах зүйл цөөнгүй бий. Дүрс бичлэгийн орчуулгын нэг хэлбэр болох дэлгэцийн хадмал орчуулгад “Юу сайхан? Дур сайхан” гэх аятай хандаж болохгүй. Хүн мэдэхгүй юмныхаа дайсан гэгчээр болсноосоо болоогүй нь хайхрахаасаа хайхраагүй нь их байна. Хайхрах цаг нь нэгэнт болсон шүү. Онцлогийг нь ялгаж мэдэж, орчуулах арга барилд суралцах зайлшгүй чухал болжээ.

Ойрын нэг жишээ гэхэд нэгэн сургууль (Энд сургуулийн нэр нүүрийг бодож тус сургуулийн нэрийг зориуд дурдсангүй)-ийн ойн баяраар хадмал орчуулга хэрэглэнэ гэж бэлдүүлсэн боловч баяр болох танхимын онцлогийг харгалзаж саадгүй уншиж болохоор бэлтгээгүйгээс гадна, цаг хэмнэх гэсэндээ агуулгыг нь хөтлөгч зүгээр уншиж танилцуулаад дүрс бичлэгийг ч гүйцэд үзүүлээгүй нь наанадаж дүрс бичлэгээр мэндчилгээ үзэж сонсож байгаа хүмүүсийг хүндлээгүй, цаанадаж дүрс бичлэгээр мэндчилж байгаа эрхэм хүмүүсийг хүндлээгүй явдал болсон билээ. Үүнд хадмал орчуулгын онцлог, ач холбогдлыг мэддэггүй, үл ойшоодог байдал нөлөөлсөн гэж болно. Хойшид энэ мэт алдааг багасгаж, хадмал орчуулгад хандах хандлагыг өөрчлөх шаардлагатай байна.

Түүнчлэн зурагтын нэвтрүүлгээр, тухайлбал Mongol HD TV, Dreambox TV зэрэг сувгаар хүүхдийн дууг уншаад дагаж дуулж сургах зорилгоор хадмалтай гаргаж байгаа нь агуулга, арга барил, хэлбэр байдлын хувьд сайшаалтай боловч ярианы хэлээр гаргах, бичгийн алдааг хянаагүй байх гэх мэт алдаа мадаг мэр сэр байгааг засаж залруулах хэрэгтэй байна. Ингэснээр эх хэлний сургалтын талаас ч тун өгөөжтэй нэвтрүүлэг болох болно.

Тэгэхээр цаашид юу хийх ёстой вэ гэвэл, нэгд, хадмал орчуулга, дүрс бичлэгийн орчуулгатай холбогдох нэр томъёог нэг мөр болгох; хоёрт, нийтэд хадмал орчуулгын талаар үнэн зөв ойлгуулах өгүүлэл, нийтлэл бичиж, ном, сурах бичиг гаргах; гуравт, орчуулагч бэлддэг сургууль, сургалтын төв, багш, мэргэжилтнийг дэмжиж хадмал орчуулгын тухай агуулгыг хөтөлбөр төлөвлөгөөнд тусган сургалтад нэвтрүүлж сургалтын орчин нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

²⁶ М.Саруул-Эрдэнэ, “Шадар гурван шумуул” оюуны өмч хоёр ямар холбоотой вэ?, Зугаатай хэл шинжлэл, УБ, 2013, 133-134-р тал

Summary

Nowadays video translation demand, especially subtitle translation demand is increasing day by day. Most of the mongolians understand ‘khadmal orchuulga’ as subtitle translation. But in a translation term of Mongolia, ‘khadmal orchuulga’ means word-for-word translation, exactly type like text below, translation above. Therefore now ‘khadmal orchuulga’ is one of the vague terms. How we can solve this problem? One solution is to make a difference of meaning, defining ‘word-for-word translation’ as a ‘nomiin khadmal’ or ‘ugchilsen khadmal’, and ‘subtitle translation’ as ‘delgetsiin khadmal’ or ‘durs bichlegiin khadmal’.

Ашигласан ном, сайт:

1. М.Амартайван, Хадмал орчуулгын тухай ойлголт ба зарим бодит жишээг ажихад, ОУУБИС-ийн эрдэм шинжилгээний сэтгүүл”, 2016, 43-51-р тал.
1. М.Саруул-Эрдэнэ, Зугаатай хэл шинжлэл, УБ, 2013
2. 김우열, 나도 번역 한번 해볼까, 잉크, 2011
3. 정호정, 제대로 된 통역 번역의 이해, 한국문화사, 2016
4. 함혜숙, 영상번역가로 먹고살기, 왓북, 2009
5. <http://blog.naver.com/hamsuk77> (“Дүрс бичлэгийн орчуулга” блог)
6. <http://kakadumn.blogspot.com> (Х.Мэргэн: “Сүүлийн үеийн кинонуудын орчуулгын тухай”)
7. <http://tline.kr> (Media translation орчуулга” товчооны сайт) “Медиа
8. http://translations.ted.org/wiki/TED_Translator_Resources:_Main_guide (TED-ийн орчуулагч нарт зориулсан үндсэн аргачлал)
9. <http://www.mbcac.com> (MBC телевизийн академи)

ОРЧУУЛГЫН ДҮЙЦЛИЙН ТУХАЙ АСУУДАЛД

Г.Элдэв-Очир¹

Товч утга: 20 дугаар зууны 30-аад оны үеэс Зөвлөлтийн судлаачид дүйцлийн тухай ойлголтыг дэвшүүлэн гаргаж иржээ. Ингээд орос хэлэнд “эквивалентность”, “адекватность”, “полноценность”, “тождественность” зэрэг нэр томьёо бий болж, судлаачид өөр өөрсдийн байр сууринаас хандах болжээ. “Дүйцэл” буюу “эквивалентность” хэмээх ойлголт нь 18 зууны сүүл үеийн бодит байдлаас урган гарсан бөгөөд тухайн үед орчуулгах эхийг өөрчлөн хувиргаснаа “өөрийн хэлний өнгө аяс”-д оруулж буй явдал зэргээр тайлбарлаж байв. Энэхүү байдал яван явсаар 20-р зууны эхэн үетэй золгож, үүнийг шинжлэх ухааны үүднээс, орчуулгын онолын талаас авч үзэх болжээ.

Түлхүүр үг: орчуулгын дүйцэл, утгын дүйцэл, хэлбэрийн дүйцэл, үйл явдлын дүйцэл

Орчуулгыг хэл хоорондын харилцааны нэгэн хэлбэр мөн хэмээн үзвэл утгазүйн асуудал чухал үүрэгтэй юм. Учир нь утгын хувьд харилцан ойлголцол буюу дүйцэл байж байж сая бодит харилцааны үндэс тавигдана. Иймээс Оросын нэрт орчуулгын онолч В.Н.Комиссаров хоёр ондоо ард түмний хувьд орчуулга хамгийн чухал үүрэгтэй бөгөөд орчуулгад хэл, хэлэхүйн нэгжийн утгын дүйцлийг судлах ёстой хэмээн үзжээ. Үүнтэй холбоотой “орчуулгын дүйцэл” /переводческая эквивалентность/ хэмээх нэр томьёо бий болсон бөгөөд эдүгээ орчуулгын онолын судлалд чухал ойлголт болжээ.

В.Н.Комиссаров “орчуулгын утгазүй” /семантика перевода/ хэмээх ойлголтыг бий болгож, энэ чиглэлээр нарийн судалгаа хийжээ. Тэрбээр, орчуулгын утгазүйн асуудал нь хэлний агуулгатай холбоотой бөгөөд нэг талаар хэлшинжлэлийн утгазүйн судалгааг гүнзгийрүүлж, нөгөө талаар хэлний утгазүйн тогтолцооны бүтэц хийгээд уялдаа холбоог илүү тодорхой судлахад ач холбогдолтой юм хэмээн үзжээ.

Орчуулах эх болон орчуулсан эх хоёрын дүйцэл хамгийн чухал бөгөөд судлаачид үүнийг орчуулгын үндсэн онцлог буюу орчуулгын бүтээл бий болох нөхцөл хэмээн үзэж, дараах дүгнэлтүүдийг хийжээ. Үүнд:

1. Дүйцэл хэмээх ойлголтыг орчуулгын тодорхойлолтод нарийн тусгах ёстой.
2. “Дүйцэл” хэмээх ойлголт нь шүүмж буюу үнэлэмжтэй холбоотой байдаг бөгөөд дүйцсэн орчуулга нь “сайн”, “оновчтой” гэж үнэлэгддэг. Хэрэв орчуулсан эх нь орчуулах эхтэй дүйцэхгүй байвал, “тааруу”, “оновчгүй” орчуулжээ хэмээн буруутгагддаг.

¹ МУИС, ШУС, ХУС-ын Ази судлалын тэнхимийн дэд профессор, доктор

3. Дүйцэл бол орчуулсан эх бий болох үндсэн нөхцөл юм бол орчуулгын тухай тодорхойлолтод нарийн, тодорхой зааж, хэрхэн дүйцүүлэх талаар тусгах ёстой.

Дээрхээс үзэхэд, судлаачид “дүйцэл” хэмээх ойлголтод илүү анхаарал хандуулж, орчуулсан эх ямар байх ёстой талаар нэлээд чухалчилжээ. Өөрөөр хэлбэл, орчуулга үнэндээ ямар ямар шаардлагад нийцсэн байх ёстой, яаж орчуулах ёстойг дурдахыг хичээжээ. Үүнээс гадна, зарим судлаачид орчуулах эхийн агуулгын хэвээр хадгалагдах хувь хэмжээг “дүйцлийн хэм хэмжээ” хэмээн үзэж, тэрхүү агуулга, өнгө аяс орчуулгад заавал үлдэж хоцрох ёстой гэжээ. В.Н.Комиссаровын үзэж буйгаар эдгээр судалгаа нь тодорхой ач холбогдолтой хэдий ч орчуулгын дүйцлийн асуудлыг бүрэн шийдвэрлэж чадаагүй байна. Тэрбээр, орчуулгазүй бол хэлшинжлэлийн судлагдахуун бөгөөд орчуулгын дүйцэл нь хэлшинжлэлийн ухагдахууны үүрэг гүйцэтгэж, хоёр хэлний хооронд буй аливаа утгын холбоо хамаарлын үүднээс авч үзэх ёстой гэжээ. Орчуулах болон орчуулсан эхийн хоорондын утгын холбоо хамаарлыг хэлшинжлэлийн үүднээс судалж, утгазүйн хувьд ижил байх боломж, хүрээг тогтоож, хэлний болон орчуулагчийн субъектив хүчин зүйл, мөн орчуулгаас шалтгаалахгүй зарим нөлөөлөл, үүнээс үүдсэн нөхцөл байдал зэргийг ялгамжаатай авч үзэх ёстой байна. Өөрөөр хэлбэл, эх болон орчуулгын хэлний тогтолцоо, эх бичвэрийн бүтэц, онцлог зэргээс хамаардаг. Гэвч эхийн хэлбэр, агуулгыг тодорхой хэмжээнд хадгалан орчуулахад зарим хүчин зүйл нөлөөлдөг бөгөөд үүнийг шийдвэрлэхэд дүйцлийн тухай ойлголт чухал байр суурьтай юм.

В.Н.Комиссаров англи, орос хэлний орчуулгын жишээгээр харилцааны зорилгын дүйцэл, үйл явдлын дүйцэл, үйл явдлыг дүрслэх арга хэлбэрийн дүйцэл, өгүүлбэрийн утгын дүйцэл, утгын дүйцэл зэрэг хэд хэдэн дүйцэл байгааг тогтоожээ.

1. Харилцааны зорилгын дүйцэл

Харилцааны зорилго нь хамгийн түгээмэл үүрэгтэй бөгөөд хэлэхүйд утга санааг дамжуулах ёстой юм. Энэхүү дүйцэл нь орчуулах эхийн харилцааны зорилгыг хадгалж үлдээх учиртай бөгөөд хоёр хэлний үгийн сан, хэлзүй хэдийгээр ялгаатай ч орчуулах эхийн өгүүлсэн утга санааг заавал дамжуулах ёстой гэсэн үг юм. Жишээ нь:

Maybe there is some chemistry between us that doesn't mix.

Бывает, что люди не сходятся характерами.

That's a pretty thing to say.

Постыдился бы!

2. Үйл явдлын дүйцэл

Энэ нь харилцааны зорилгыг хадгалахаас гадна, мөн орчуулах эхийн хэлж буй санаа нь ямар хэрэг явдалтай холбоотойг дамжуулж, хэлний бус нөхцөл байдал, илэрхийлж буй арга хэлбэр зэргийг гаргах ёстой гэсэн үг юм. Жишээ нь:

He answered the telephone.

Он снял трубку.

You see one bear, you have seen them all.

Все медведи похожи друг друга.

3. Үйл явдлыг дүрслэх арга хэлбэрийн дүйцэл

Энэ нь харилцааны зорилго болон тохиолдлыг хадгалахаас гадна, мөн орчуулах эх юуг яаж илэрхийлж буйг дамжуулах ёстой гэсэн үг юм. Жишээ нь:

Scrubbing makes me bad-tempered.

От мытья полов у меня характер портится.

London saw a cold winter last year.

В прошлом году зима в Лондоне была холодной.

4. Өгүүлбэрийн утгын дүйцэл

Энэ нь үйл явдлыг дүрслэх арга хэлбэрийн дүйцлийн үдсэн дээр орчуулах эхийн өгүүлбэрийн бүтцийн утгыг хадгалж гаргахыг хэлдэг. Уг дүйцэл нь гурван үндсэн хэлбэртэй.

А) Ижил утгатай бүтэц ашиглах. Жишээ нь:

I told him **what I thought** of her.

Я сказал ему **своё мнение** о ней.

Б) Үгийн дэс дарааллыг өөрчлөх. Жишээ нь:

A meeting in deference of peace was held in Trafalgar Square yesterday.

Вчера на Трафальгар-сквер состоялся митинг в защиту мира.

Дээрх жишээнд, англи хэлний өгүүлбэрийн өгүүлэгдэхүүн нь тодорхойгүй ялгац гишүүнтэй, тухайн харилцааны төв болж байна. Харин орос хэлний өгүүлбэрт энэхүү харилцааны төв нь өгүүлбэрийн төгсгөлд байна. Иймд орос орчуулгад үгийн дэс дараалал ондоо болжээ.

В) Бүтэц хоорондын холбоо хамаарал, төрөл зүйлийг хувиргаснаар өгүүлбэрийн тоо болон төрөл нь өөрчлөгддөг.

Хоёр ондоо хэлний өгүүлбэр хэдийгээр ижил төрлийнх байлаа ч утга болон найруулгын үүрэг нэгэн янз байдаггүй. Жишээ нь:

There might be some small pickings left, from those who would be willing to continue, and later it would be necessary to decide if they were worthwhile.

Кто-то ему еще, наверно, останется – от тех, кто захочет продолжать дело. А дальше уже придется решать, стоит ли этим заниматься.

5. Утгын дүйцэл

Өгүүлэмжийн агуулга нь тухайн тохиолдлын үүрэг, чадамжийн талыг багтаахаас гадна, мөн цэвэр хэлний талыг (утгазүй болон өгүүлбэрзүй) агуулдаг. Хоёр хэлний өгүүлбэр нь нэгэн ижил ухагдахуунаар адил тохиолдлыг дүрсэлж, ижил харилцааны зорилгыг илтгэж байлаа ч магадгүй агуулга нь ондоо байхыг үгүйсгэхгүй. Хэрэв агуулга нь ижил байлаа гэхэд тухайн өгүүлбэрт орсон үгийн сангийн нэгж, тэдгээрийн хоорондын өгүүлбэрзүйн холбоо хамаарал ондоо байдаг.

В.Н.Комиссаровын дээрх судалгаанд үндэслэж эрдэмтэн В.Г.Гак мөнхүү дүйцлийн талаар өөрийн саналыг дэвшүүлэн гаргасан байдаг. Тэрбээр, өгүүлэмжид үг болон хэлзүйн хэлбэр тодорхой ухагдахуун илтгэдэг. Иймд орчуулгын дүйцэл нь хэдийгээр хэлбэр ондоо ч утга нь ижил байх, эсвэл, дүрслэл нь ойролцоо байхыг шаарддаг. Үүнээс үүдэн хэлбэрийн дүйцэл, утгын дүйцэл, үйл явдлын дүйцэл гэсэн дүйцлийн гурван хэлбэрийг дэвшүүлжээ. Ингээд В.Г.Гак орос, франц хэлний жишээгээр дээрх гурван дүйцлийг авч үзжээ.

1. Хэлбэрийн дүйцэл

Тухайн хоёр хэлээр нэгэн ижил утга санаа илэрхийлэх үед хэлний хэлбэр нь ондоо, эсвэл, ойролцоо байх тохиолдол юм. Жишээ нь:

La delegation francaise arrive aujourd'hui a Petersbourg.

Французская делегация прибывает сегодня в Петербург.

Энэ хоёр өгүүлбэрийн утга ижил, харин хэлбэрийн хувьд франц эхэд ялгац байгаа ч, тийн ялгал байхгүй зэрэг ялгаатай ажээ.

2. Утгын дүйцэл

Тухайн хоёр хэлээр илэрхийлэх утга санаа нь нэгэн ижил ч арга хэлбэр нь ондоо байх тохиолдол юм. Жишээ нь:

La delegation a quitte Moscou par avion a destination de Paris.

Делегация вылетела из Москвы в Париж.

Энэхүү хоёр өгүүлбэрийн ерөнхий утга нь ижил боловч илэрхийлж буй хэлбэр нь өөр ажээ. Орос эхэд үйл үг ашигласан байхад франц эхэд нэр үг байна. Үйл хөдлөлийн чиглэлийн хувьд орос өгүүлбэрт угтвараар гаргасан байхад франц өгүүлбэрт үйл үгийн нөхцөл ашиглажээ.

4. Үйл явдлын дүйцэл

Тухайн хоёр өгүүлэмж хэлний хэлбэрийн хувьд ч, үндсэн утгын хувьд ч ондоо байх боловч нэгэн ижил үйл явдлыг дүрсэлсэн байдаг. Жишээ нь:

Французская делегация вылетела на родину.

La delegation francaise regagne Paris.

Ерөнхийд нь дүгнэж үзвэл, орчуулагчид ихэнхдээ хэлбэрийн дүйцлээс илүүтэйгээр утгын болон үйл явдлын дүйцлийг чухалчилдаг болох нь ажиглагддаг. Үүнд янз бүрийн учир шалтгаан байхыг үгүйсгэхгүй. В.Г.Гак болон В.Н.Комиссаров нарын дэвшүүлсэн дүйцлийн тухай ойлголтыг орчин цагийн орчуулгын онолын хүрээнд хэдийн хүлээн зөвшөөрсөн боловч зарим судлаач дүйцлийн тухай ойлголтод арай өөр байдлаар хандах, эсвэл, ондоо байдлаар ангилан авч үзсээр байна.

Ашигласан номзүй

1. Бархударов.Л.С, Язык и перевод, Москва, 1975
2. Комиссаров.В.Н, Лингвистика перевода, Москва, 1980
3. 王磊, 苏联翻译理论研究 70 年, 中国翻译, 1989
4. 杨仕章, 俄语现代翻译理论之概述, 解放军外国语学院学报, 2002

ӨВӨРМӨЦ ХЭЛЦИЙН ОРЧУУЛГЫН АСУУДАЛД

Б.Нарантуяа¹

Түлхүүр үг: *өвөрмөц хэлц, үгийн сангийн утга, хэлцийг олж таних, хам сэдэв, дүйцэл*

Өвөрмөц хэлц нь олон зуун жилийн хөгжлийн явцад хөгжин үндэсний сэтгэлгээ болон хэл ярианд хэвшин тогтдог тухайн хэлээр яригч үндэстний амьдралын хэв маяг, зан заншил, соёл сэтгэлгээ, амьдрах орчин, түүхийн өвөрмөц байдлыг шингээсэн хэлний системийн харьцангуй хөдөлгөөнгүй, тогтвортой, царцанги бүтэц юм.

Үгийн утга санаа нь хойдох, урьдах үгтэйгээ хамт нэгэн бүрэн иж болж ганц ганцаар салангид хэрэглэгдэхгүй байдаг ёс бий. Үүнийг өвөрмөц хэллэг гэж хэл шинжлэлд нэрлэж заншжээ. Ийнхүү хэд хэдэн үг нийлэн, нэг утга ухагдахуун бүхий болох ёс бүх хэлэнд байдаг түгээмэл үзэгдэл юм. Энэ өвөрмөц хэлцийн утга санаа нь бүтэн хэлцээс гарахаас биш, үг тус бүрд ногддоггүй байна. Тийм учраас өвөрмөц хэлцийг махчлан орчуулж болдоггүй. (С. Мөөмөө, 1996: 65)

Эрдэмтэн Чой.Лувсанжав “Орос-Монгол өвөрмөц хэллэгийн толь бүтээлдээ” “Өвөрмөц хэлц энгийн хорин үгээр гаргах санааг ганц хоёр үгэнд хураагаад хүний ой ухаанд тов тод оруулж өгөх ид шид, чадал хэл хэлний өвөрмөц хэллэгт байдаг” гэж тодотгосон байдаг.

Иймд зарим хэлцийн дотор багтсан үгийг утга зүйн хувьд нэг нэгээр нь салган авч үзэж огт болохгүй. Цөмөөрөө нийлж нэгэн санаа илтгэх бөгөөд үг тус бүрийн тодорхой утга нь алдагдсан байдаг.

Бүлэг үгсийг бүрдүүлж байгаа үг тус бүрийн үгийн сангийн утга нэгэнт алдарч нэгэн цогц утга буюу олдмол утга илэрхийлж байгаа холбоо үгийг өвөрмөц хэлц гэнэ. Ийм хэлцийн утга санааг түүний үг тус бүрд оногдуулан ойлгож болохгүй, харин түүний бүхэл бүтэн цогцсоос нь ухаж мэддэг ажээ. Өвөрмөц хэлцийг харь хэлэнд тэр хэвээр нь үгчлэн орчуулбал ойлгогдохгүйд хүрдэг байна. Ийм учраас тэр хэлнээс тохирох өвөрмөц хэлцийг сонгон оноох буюу эсвэл утгыг тайлбарлан орчуулдаг юм. (Ж. Төмөрцэрэн, 1998: 234)

Хоёр хэлний хооронд орчуулга хийхэд өвөрмөц хэлц нь орчуулагчид нэлээн бэрхшээл учруулдаг хэлний нэгж билээ. Өвөрмөц хэлцийг орчуулахад гарч болох хүндрэл бэрхшээлүүдийг хоёр хэсэгт ангилан үзэж болох юм. Үүнд:

¹ МУИС, Орхон салбар сургууль, Англи хэлний багш

1. Өвөрмөц хэлцийг олж таних, ойлгох чадвар
2. Орчуулах хэл рүү тухайн өвөрмөц хэлцийн утгын хүчин зүйлүүдийг дамжуулахад гарах бэрхшээл зэрэг болно.

Өвөрмөц хэлцийг олж таних, ойлгох нь

Орчуулагчийн хувьд өвөрмөц хэлцийг зөв таньж мэдэх нь чухал юм. Учир нь өвөрмөц хэлцийн олон хэлбэрүүд бий. Заримыг нь хялбархан олж таньж болно. Ийм хэлцүүд үнэн бодит байдлаас гажуудсан өвөрмөц утга санааг илэрхийлдэг. Тухайлбал, *нүүр хагарах, элэг эмтрэх, it's raining cats and dogs, jump down someone's throat, ам хэлээ билүүдэх, гэдсэндээ хөлөө хийлцэх, гэр хагартал, далан хэлтэй...* гэх мэт.

Түүнчлэн, хялбархан таньж болох өвөрмөц хэлцийн хэлзүйн хэлбэр бүтэц нь тухайн хэлнийхээ хэлзүйн дүрэм, хэм хэмжээг илт зөрчсөн байх нь бий. Жишээлбэл, англи хэлний *trip the light fantastic, the powers that be, put paid to* хэмээх хэлцүүдийн хэлзүйн бүтэц дүрмээс эрс өөр байгааг амархан харж болно.

Монгол хэлэнд *шиг, мэт, адил* зэрэг үгээр (*буруу ишилсэн сүх шиг, хоёр үзүүртэй зүү адил*), *морь мэт зүтгэх, уургын морь шиг*, англи хэлэнд *like, as* гэх мэт үгээс бүтсэн (*work like a horse, like a bat out of hell, as fat as an elephant*) зүйрлэсэн утга бүхий хэлц (simile) элбэг тохиолддог. Ийм үг бүхий хэлцийг олж харах, танихад амархан билээ.

Ер нь шууд ойлгоход хүндрэлтэй, тухайн хам сэдэвтээ утга нь авцалдахгүй байх үг хэллэгүүд ихэвчлэн өвөрмөц хэлц байдаг талтай. Учир нь ийм үг хэллэгийг шууд үгчлэн орчуулбал өгүүлбэрийн логик утга санаа алдагддаг.

Хэрэв гадаад хэлээр уншиж байгаа уншигч, эсвэл орчуулагч тухайн өвөрмөц хэлцийн утгыг урьд өмнө нь мэддэггүй бол мөнөөх хэлцийн утгыг эндүүрэн ойлгох хоёр тохиолдол байж болно.

1. Зарим хэлц өвөрмөц бус шууд, ил утгатай мэт эндүүрэгдэх тохиолдол бий. Аливаа хэлэнд ийм хэлцүүд цөөнгүй тааралдана. Жишээлбэл, Англи хэлний *I heard the prisoner had kicked the bucket in his cell* гэсэн өгүүлбэрт *kick the bucket* гэдэг хэлц үгчилсэн утгаараа *хувинг өшиглөх* хэмээн буюу *Гэмт хэрэгтэн шоронгийн өрөөндөө хувингаа өшиглөсөн гэж би сонслоо* гэж ойлгогдохоор байна. Ийнхүү ойлгосноор энэ хэлцийн шууд утга нь хам сэдэв болон тухайн өгүүлбэртээ тохирч байгаа мэт. Гэтэл, үнэн хэрэгтээ, *Гэмт хэрэгтэн шоронгийн өрөөндөө амьсгал хураасан гэж би сонслоо* хэмээх өвөрмөц утга бүхий хэлц билээ.
2. Зарим нэгэн өвөрмөц хэлц орчуулгын хэлэнд өнгөн бүтцээрээ нэлээд төстэй дүйцэлтэй мэт боловч утгаараа хэсэгчлэн болон бүрэн эс дүйцэх тохиолдол байдаг. Тухайлбал, *in cold blood* хэмээх өвөрмөц хэлцийг *хүйтэн цустай ...* гэж шууд ойлгож болохгүй юм. Англи хэлний *Has the cat got your tongue?* гэх

хэлцтэй хэлбэр, бүтцээрээ төстэй *Donner sa langue au chat (to give one's tongue to the cat)* хэмээх нэгэн хэлц франц хэлэнд байгаа боловч илэрхийлэх утга нь хоёр өөр байна. (Англи хэлц нь монгол хэлэнд *Чи бүлх залгичахаа юу? Амнаас чинь алт унах гээд байна уу?* гэсэн дүйцэлтэй бол, франц хэлц нь тоглоом наадам, оньсого тааварт хожигдсоноо хүлээн зөвшөөрсөн *далан таваараа бууж өгөх* гэх хэлцтэй дүйцэж байна.)

Энэ мэт бүтцээрээ ижил эсвэл ойролцоо боловч эх ба орчуулгын хэлэнд илэрхийлэх утгаараа ялгаатай өвөрмөц хэлцүүд нь сэрэмж муутай, хайхрамжгүй орчуулагчдыг орчуулгын алдаа гаргахад хүргэдэг байна.

Өвөрмөц хэлцийг орчуулах нь

Оруулагчийн хувьд өвөрмөц хэлцийг нэгэнт олж таниад утгыг ойлгосон бол дараагийнх нь алхам орчуулах явдал билээ. Өөрөөр хэлбэл өвөрмөц хэлцийн тухайн хам сэдэв дэх утгын хүчин зүйлүүдийг орчуулах хэл рүү хэрхэн оновчтой дамжуулахаа шийдэх хэрэгтэй юм.

Өвөрмөц хэлцийг орчуулахад гарч болох хүндрэл бэрхшээл нь хэлцийг олж таних, утгыг нь ойлгоход гарах хүндрэлүүдээс эрс ялгаатай байдаг.

Өвөрмөц хэлцийг орчуулахад гарах хүндрэл бэрхшээлийг доорхи байдлаар тайлбарлаж болох юм.

- Эх хэлний өвөрмөц хэлц орчуулах хэлэнд тохирох дүйцэлгүй байх.

Аливаа хэлэнд утга санааг илэрхийлэх арга, утгыг илэрхийлэхэд хэрэглэх хэлний нэгжүүд адилхан байх албагүй бөгөөд нэгэн хэлэнд тухайн утгыг илэрхийлэхэд ганц үгээр, хоёр дахь хэлэнд хэвшмэл хэллэг байдлаар, харин гурав дахь хэлэнд өвөрмөц хэлцээр, бүр өгүүлбэрийн түвшинд ч илэрхийлдэг байж болно. Ийм учир, зарим тохиолдолд орчуулах хэлнээс утга дүйцэх өвөрмөц хэлцийг олох боломжгүй билээ.

It's raining cats and dogs-Энэ хэлцтэй шууд тохирох дүйцэл зарим хэлэнд байхгүй байх жишээтэй. Энэ хэлцийн утгыг монгол хэл рүү *усан бороо орох...* гэх мэтчилэн тайлбарлан орчуулсан нь дээрх хэлцийн дүйцэл биш юм. Мөн монгол хэлний *эсгий хийх газар нохой хэрэггүй, гүү саах* зэрэг олон хэлцийн дүйцлийг бусад харь хэлнээс олоход амаргүй билээ.

Ер нь үндэстний соёлын онцлог бүхий хэлцийн дүйцлийг орчуулгын хэлнээс олох ажил орчуулагчийн мэдлэг чадварыг шалгасан шаггүй ажил байдаг.

- Эх ба орчуулах хэлний хэлцүүд бүтцээрээ ижил ч, хам сэдэв болон коннотацаараа ялгаатай байх.

Англи хэлний *to pull hair out* нь монгол хэлний *толгойтой үсээ зулгаах*-тай бүтэц ижил боловч хэрэглэгдэх хам сэдэв, илэрхийлэх коннотаци нь ялгаатай ажээ. Мөн

англи хэлэнд *буй to sing a different tune*-тэй ижил төстэй *chang-dui-tai-xi* хэмээх өвөрмөц хэлц хятад хэлэнд байгаа боловч нэг нь эсрэгцсэн утга, нөгөө нь баталсан утга санааг илэрхийлж байна.

- Өвөрмөц хэлцийг бичгийн өгүүлэмжид хэрэглэх ёс, давтамж нь эх ба орчуулах хэлэнд өөр өөр байх

Англи хэлний хувьд өвөрмөц хэлцийг төрөл бүрийн текстэд ашиглах боловч шар хэвлэл, зар сурталчилгааны хэл найруулга, текстэд түгээмэл хэрэглэж байгаа ажиглагддаг. Харин бичгийн болон ярианы өгүүлэмж нь эрс ялгаатай, бичгийн хэлний ёс жаяг өндөр зарим хэлэнд бичгийн хэл найруулгад өвөрмөц хэлцийг түлхүү хэрэглэхээс зайлсхийдэг ажээ.

Өвөрмөц хэлцийг орчуулах боломжтой аргууд

Өвөрмөц хэлцийг орчуулахад үгчлэн орчуулах, эсвэл тайлбарлан орчуулах байдал нийтлэг ажиглагддаг. Энэ нь тэр бүр дүйцэл хангасан оновчтой орчуулга болж чаддаггүй. Зарим тохиолдолд үгчлэн орчуулснаар хэлцийн утга алдагдах, харин тайлбарлан орчуулснаар өвөрмөц бүтэц нь орхигдож хэлц байдлаа бүрэн алддаг сөрөг талтай.

Ер нь өвөрмөц хэлцийг орчуулах арга олон хүчин зүйлээс шалтгаална. Орчуулах хэлэнд утга дүйцэх өвөрмөц хэлц байх эсэх нь гол асуудал биш юм. Өөрөөр хэлбэл, орчуулах хэлний тухайн найруулгад хэлцийг хэрэглэхэд тохиромжтой эсэх, эх ба орчуулах хэлнүүдийн хэл найруулгын хэм хэмжээ ялгаатай байх, уран яруу хэрэглүүрийг хэрэглэх зарчим харилцан адилгүй байх зэрэг олон хүчин зүйлээс хамаарч хэлцийг орчуулах арга, стратеги өөр өөр байдаг.

Өвөрмөц хэлцийг англи хэлнээс бусад хэл рүү орчуулсан байдлыг ажиглахад дараахь дөрвөн арга түгээмэл тааралддаг билээ.

1. Орчуулгын хэлний утга болон бүтэц ижил, төстэй хэлцээр
Соёл, сэтгэлгээний хувьд нийтлэг шинжтэй, эсвэл төрөл хэлнүүдийн хооронд зарим өвөрмөц хэлцийг энэ аргаар орчуулах тохиолдол их байдаг. Жишээ нь:

Эх: *Things are beginning to cost more and more. It looks like we'll all have **to tighten our belts**.*

Орчуулга: *Юмны үнэ улам өсөөд, бид **бүсээ чангалах** хэрэгтэй болж байх шиг байна.*

Эх: *Our workers are already upset, and you'll just **add fuel to the fire** if you cut their wages.*

Орчуулга: *Ажилчдыг бухимдал ихтэй байхад цалинг хөлсийг нь хасвал **гал дээр тос нэмсэн** хэрэг болно шүү.*

2. Орчуулах хэлний утга ижил, бүтэц өөр хэлцээр

Эх хэлний өвөрмөц хэлцтэй утгын хувьд дүйх боловч тухайн хэлцийг бүрдүүлэгч бусад үг, тэдгээрийн бүтэц нь өөр байх орчуулах хэлний хэлцээр орлуулан орчуулахыг хэлнэ. Ихэнх тохиолдолд буюу соёл, сэтгэлгээний ялгаа бүхий үндэстнүүдийн хэл хооронд өвөрмөц хэлцийг орчуулахад нэлээд тохиромжтой нь энэ арга юм. Жишээ нь:

Эх: *The horses **were neck and neck** as they crossed the finishing line, so the judges have called for a video.*

Орчуулга: *Морьд барианд зуузай холбон орж ирсэн учраас, морины комиссынхон уралдааны бичлэгийг үзэхээр болов.*

3. Тайлбарлан орчуулах

Орчуулах хэлэнд дүйцэх хэлцгүй, эсвэл эх ба орчуулах хэлний найруулга зүйн эрс өөр хэм хэмжээнээс шалтгаалан орчуулах эхэд өвөрмөц хэлцийг хэрэглэхэд тохиромжгүй байх зэргээс хамаарч зарим үед тайлбарлан орчуулах шаардлага тулгардаг. Өвөрмөц хэлцийг энэ аргаар орчуулснаар өвөрмөц далд утга, бүтэц нь үгүй болдог сул талтай. Жишээ нь:

Эх: *If we're **given the green light** by the local council, we'll start building our factory.*

Орчуулга: *Дүүргийн захиргаанаас зөвшөөрөл олговол, бид үйлдвэрээ барьж эхэлмээр байна.*

4. Орчуулалгүй орхих

Орчуулах хэлэнд сайтар тохирох дүйцэлгүй, тайлбарлан орчуулахад амаргүй, аль эсвэл хэлний системийн онцлог, найруулга зүйн шаардлагаар ихэнх тохиолдолд нэг ба хоёр үгээс бүрдсэн өвөрмөц хэлцийг орчуулалгүй орхисон байх нь бий. Жишээ нь:

Эх: *When I bought a pound of nails, the clerk threw in a few extra nails **for good measure**.*

Орчуулга: *Хагас кило хадаас авсан чинь худалдагч нь хэдэн хадаас нэмж өглөө.*

Resume

Idioms are frozen patterns of any languages which allow little or no variation in form, and carry meanings that cannot be revealed from their individual components.

A man's ability of using idioms of a foreign language hardly ever matches that of a native speaker. The majority of translators working into a foreign language cannot hope to achieve the same sensitivity that native speakers seem to have for judging when and how an idiom can be manipulated. This raises issues into the argument that translators should only work into their native language or language of habitual use.

Idioms demand that a translator be not only accurate but highly sensitive to the rhetorical effects of the language. The way in which idioms can be interpreted or translated into another language depends on many factors.

Ашигласан ном

1. Аким Г. Монгол өвөрмөц хэлцийн товч тайлбар толь., 1982, УБ
2. Дашдаваа Д. Орчуулгын зарим асуудал, 1977., УБ
3. Дашдондов Ц. Монгол-Англи өвөрмөц хэлцийн толь., 2012
4. Аким Г. Монгол-Орос өвөрмөц хэлцийн товч толь., 1985, УБ
5. Аким Г. Монгол өвөрмөц хэлцийн товч тайлбар толь., 1982, УБ
6. Мөөмөө С. Ерөнхий хэлний шинжлэл., 1996, УБ
7. Гүрбазар Р. Орчуулгын онол дадлагын үндэс., 1996
8. Лувсанжав Чой. ‘Орос-Монгол өвөрмөц хэллэгийн толь., 1970, УБ
9. Бадамдорж Д. Монгол хэлний үгийн сангийн утга зүй., 2006, УБ
10. <http://www.idiomsphrases.com/> , <http://idioms.thefreedictionary.com/>

ЖУЛИАН ХАУСЫН ЗАГВАРААР ОРЧУУЛГЫН ЧАНАРЫГ ҮНЭЛЭХ НЬ

(С. Эрдэнэ. “Өвгөн шувуу” өгүүллэгийн англи орчуулгын жишээн дээр)

Б.Удвал¹

Товч утга: Орчуулга нь хэлшинжлэлийн онол, хэл зүйн дүрмийн дагуу хийгдэхийн зэрэгцээ, эх зохиолын зохиогчийн санаа, сэтгэл хөдлөл, тухайн бичвэрээр дамжих соёлын утгыг давхар илэрхийлэх үүрэгтэй. Энэхүү орчуулгын дүйцлийг хэрхэн хангаж байгааг үнэлэх арга болон загваруудыг хэл шинжлэлийн олон эрдэмтэд дэвшүүлсэн байдаг. Эдгээрээс германы хэлшинжлэлийн эрдэмтэн, орчуулга зүйч Жулиан Хаусын “Орчуулгын чанарын үнэлгээ”-ний загвараар зохиолч С.Эрдэнийн “Өвгөн шувуу” өгүүллэгийн Англи орчуулгын хэсэгт орчуулгын чанарын үнэлгээ хийж үзлээ. Бид үндэсний соёлын гүн гүнзгий утга агуулга бүхий энэ өгүүллэгийн орчуулгын эхний 5 цогцолборыг сонгож авсан бөгөөд тус өгүүллэгийг 2009 онд МУИС-ийн ГХСС-ийн багш Н.Оюун-Ундраа асан англи хэлнээ хөрвүүлэн “Mongol survey” - сэтгүүлд хэвлүүлсэн юм. Жулиан Хаусын загвараар монгол эхийг англи орчуулгатай нь харьцуулан үнэлгээ хийж, орчуулгын онолд гарч ирж байгаа шинэ чиг хандлагыг танилцуулах зорилготой юм.

Түлхүүр үг: Орчуулгын чанарын үнэлгээ, Хаусын загвар, чөлөөт орчуулга, “Өвгөн шувуу”, Жулиан Хаус

I. Жулиан Хаусын орчуулгын чанарын үнэлгээ

1.1 Орчуулгын чанарыг үнэлэх загварын тухай ерөнхий ойлголт²

Хаусын орчуулгын чанарын үнэлгээний загвар нь хэлний хэрэглээний онол дээр суурилан гарсан загвар юм. (1977, 2nd ed. 1981)

Энэ загварыг эх бичвэр, орчуулга хоёрыг харилцан тохируулах зарчмаар орчуулгад хэлшинжлэл- хэл яриа мөн түүнчлэн соёлын нөхцөл байдлын дамжуулалтыг үнэлэх зорилгоор Халлидейн бүтэц үүргийн онол, прагматикийн зарчим, Прагийн хэлшинжлэлийн сургуулийн судлаачдын гаргасан бүртгэн жагсаах онол, найруулга зүй, хэл-ярианы шинжилгээний (discourse analysis) онолууд дээр үндэслэн зохиожээ.

Энэ загвар нь орчуулгын чанарын гол ойлголт болох дүйцлийг тогтоох зорилготой юм. Орчуулгын дүйцэл гэдэг ойлголт нь урт хугацааны туршид орчуулга судлаачдын дунд маргаантай байсан ойлголт бөгөөд латин хэлнээс гаралтай equivalence гэдэг үг нь англи хэлнээ equal of value буюу “тэнцүү үнэ цэн” гэж орчуулагддаг юм.


¹ МУИС-ийн Завхан сургуулийн багш

² Translation Quality Assessment. Juliane House. 2014. London

Хаус дүйцлийн талаар орчуулга судлаачдын дэвшүүлсэн үзэл санаануудыг судалсны үндсэн дээр дээрх загвараа боловсруулсан бөгөөд энэ загварын гол цөм зорилго нь орчуулга, эх бичвэр хоёрын дүйцлийг тогтоох явдал юм гэжээ.

Тэрээр мөн орчуулга бол нэгт талаасаа эх бичвэр нөгөө талаасаа хүлээн авагчийн харилцааны байдал гэсэн хоёр хязгаарт хашигдаж байдаг гэж үздэг бөгөөд дүйцлийн тухай ойлголтыг нэг хэл соёлоос нөгөө хэл соёлд эх бичвэрийн утга санааг хадгалан дамжуулах үйл ажиллагаатай холбоотой байдаг гэж тодорхойлоод орчуулгын утга санаатай онцгой хамааралтай *утга зүйн байдал (semantic aspect)*, *бодит байдлын байдал (pragmatic aspect)*, *бичвэрийн задлан шинжилгээний байдал (Textual aspect)* зэргийг тодорхойлж орчуулгын дүйцэл ба дүйцлийг үнэлэхэд юу нь чухал болохыг нарийвчлан тайлбарласан байна.

1.2 Эх бичвэрийг орчуулгатай бүтцийн хувьд харьцуулан тохируулах загвар.



Хаус бичвэрийн бүтэц нь хам нөхцөлд суурилсан хэлний бүрэлдэхүүн хэсгүүдийг задлан шинжилснээр тодорхойлогдох боломжтой гэж үзээд хам нөхцөлийн цар хүрээг хэл хэрэглэгчийн цар хүрээ, хэлний хэрэглээний цар хүрээ гэсэн хоёр төрөлд хувааж тодорхойлсон байна.

Хэл хэрэглэгчийн цар хүрээнд газар зүйн байрлал, нийгмийн гарал үүсэл, цаг хугацааны онцлог зэрэг ордог бол хэлний бүрэлдэхүүн хэсгүүд, хэлний нийгэм дэх үүрэг харилцаа, хэлэнд хандах нийгмийн хандлага, орон нутгийн онцлог зэрэг нь хэлний хэрэглээний цар хүрээнд ордог гэжээ.

Хам нөхцөлийн цар хүрээг ашиглан эх бичвэрийн мэдээллийг орчуулгын мэдээлэл болгодог. Дээрх загвараар орчуулгын чанарыг үнэлэхдээ эдгээр мэдээллүүдийн бүтцийг холбон таацуулж байж орчуулгын чанарыг тодорхойлох юм. Хэмжээсүүд нийцэхгүй бол алдаатай гэж үзнэ.

1.3 Орчуулгын хэв шинж

Орчуулгын чанарыг үнэлэх дээрх загварыг боловсруулахдаа Хаус орчуулгыг хэв шинжээр нь хоёр ангилсан.

Чөлөөт орчуулга (Overt translation): Хоёрдох эх хуулбар биш, мөн тодорхой нэг бүлэг, хүмүүст чиглэсэн мэдээллийн чанартай орчуулга биш. Эх бичвэр соёлын хязгаартай. Өөрөөр хэлбэл эх бичвэр тухайн хэлээр ярилцагч орны нийгэм, соёлд хамааралтай. Уншигчид орчуулгын бүтээл уншиж байна гэдгээ мэддэг. Эх бичвэр тухайн нийгмийн соёлын онцлог, эсвэл түүх уламжлалын онцлогтой холбоотой байдаг. Эх бичвэрийн чөлөөт орчуулгыг хоёр төрөлд хувааж болно.

- Түүхэн бичвэрийн орчуулга /уран зохиолын бус/
- Тодорхой цаг хугацаанд хамаарахгүй бичвэрийн орчуулга / уран зохиолын текст/

Эдгээр орчуулга нь хэл хэрэглэгчийн цар хүрээг харуулдаг. / language user dimension/

Орчуулагч энэ тохиолдолд уншигчдыг эх бичвэр, түүнтэй холбоотой соёлд хөглөх үүрэгтэй.

Чөлөөт бус орчуулга (Covert translation): Хоёрдогч эх хувилбар, орчуулж буй хэлний соёлд чиглэсэн, эх бичвэрийн хэлний соёлтой уялдаа холбоогүй. Эх бичвэр орчуулга хоёрын хүлээн авагчид ижил түвшний хүмүүс байдаг. Энэ орчуулга тодорхой бүлгийн хүмүүсийн чиглэсэн байдаг. Соёлын ялгаа байхгүй.

2. 1 Эх бичвэр (Language /text)

С.Эрдэнэ. Өвгөн шувуу (1964), Уб. Богино өгүүллэг (эх бичвэр Монгол; Орчуулга Англи)

1. Жав гуай, нар ханын толгойд тусаж байхад нүдээ нээлээ.
2. Зовхи нь хөх няц болон хавагнаж ухархайдаа хонхойн ширгэсэн гэрэлгүй нүдээр гэрийн доторхийг тойруулан харах гэж
3. ихэд хүндэрсэн толгойгоо арайхийн эргүүлэв.
4. Хянган хамрын самсааны мөгөөрс нэвт гэрэлтэн шанааны нь яс арьсаа цоо татах бий гэмээр ёрдойжээ.
5. Царайны нь өнгө энэ нүгэлт ертөнцөд амьдрах өдөр тоотой хүн гэдгийг илтгэнэ.
6. Яс арьс болсон гараараа орны хөлөөс уясан татуурганаас чангааж байж биеэ хагас эргүүлээд
7. явган ширээн дээрх шаазантай цийдмээр амаа дэвтээв.
8. Тэгээд ханын толгойд туссан нарны гэрлийг хэсэг ширтэв.
9. Гадаа зуны сайхан өдөр,
10. Жав гуай тэнгэрийг тооноор, газрыг үүдээр харах төдий болсоор уджээ.
11. Гэвч ханын толгойд туссан нарны гэрлийн шар толбонд бүхий л газар дэлхийг бас харж болно.
12. Насаараа хөндлөн гулд давхисан тал нутаг, үзэж өнгөрүүлсэн амьдрал нь
13. үүрд нүдээ анихаас нааш яаж балран арилах билээ.
14. Өглөө болгон «Одоо ингээд зовлон дуусах цаг ирээгүй» юу гэж горьдох боловч өдөр хоног өнгөрсөөр л байна.
15. Хүн гэдэг мөн ч бөх голтой юм.
16. Утсан чинээхэн улаан амь гэвч тасарч өгөхгүй нь гайхалтай.
17. Өвчин ойндоо хүрлээ.
18. Жав гуай өнгөрсөн хаврын цагаан хагднаар хадан гэртээ харина гэж бодож байсан боловч бүтсэнгүй.
19. «Би ер нь долоон голтой амьтан юмаа» гэж хүнд ярина.
20. Үхэхийн тухай бодож яваагүй боловч үхэхээс нэг их айхгүй хүн байж.
21. Үүнийгээ ойлгохдоо санаа амарсан
22. бөгөөд элдэв зовлон гаслан болж гиншигнэлгүй зоригтой тайвнаар үхлээ хүлээж байна.
23. Сэтгэлээр машид хатуужин чадахад биеийн шаналал хүртэл намдаад явчихна.
24. «Ийм сайхан өдөр байтал үүдээ битүүлээд гардаг нь юу вэ?» гэж эхнэртээ уур хүрмээр аядсанаа
25. «Жав чи бүү бухимдаад бай» гэж өөртөө тушаав.
26. Зэ жигүүртэй төрсөн маньд чинь
27. Жигтэй сайхан орон байвч
28. Жаргал зовлон алинд ч бол
29. Заяаныхаа хүчээр болдог бус уу

2.2 Орчуулга

Орчуулсан. Н.Оюун-Ундраа /МУИС, ГХСС-ГХСТ/, 2009. “Mongol Survey” сэтгүүлд 2009 онд хэвлэгдсэн.

1. Jav *guai* [title of respect similar to Japanese *san*], as the sunlight was glancing over the top of his ger wall, opened his eyes.
2. To look around the ger through his lightless eyes, deeply sunken into his eye sockets, and with swollen eyelids,
3. barely, he turned his heavy head to the side.
4. The cartilage of his high-bridged nose and his cheekbones stuck out as if piercing through his skin.
5. The color of his face augured ill for the naked fact that his days to live on in this sinful world had been heretofore numbered.
6. On having half shifted and pulled himself up with his mere skin-and-bone hands, using a strap latched to the bedposts,
7. he lightly sipped some *tsiidem* [water with milk mixed in it] from the porcelain bowl on the smallish table next to his bed.
8. Then he gazed for a while at the sunlight hitting the ger wall.
9. It was a pleasant summer day outside.
10. A long time had elapsed since Jav *guai* had stared up at the skies through the smoke hole of his ger or at the ground through its open door.
11. But he could see the whole wide world even from the yellow spot of sunlight hitting the ger wall.
12. The steppe – where he used to gallop the length and the breadth of, during his lifetime and all his life – that he had led.....
13. How he could forget them all until he closed his eyes and fell into the eternal sleep.
14. Morning after morning, he had been hoping against hope that his time had come to put an end to all this agony, but the days were still passing by.
15. What a durable life man had!
16. Just a threadlike life – but with the damndest stiff lingering on against its severance...
17. It had been a whole year to the day since he had gone down with illness.
18. Jav *guai* had been, during the fall of the previous spring's withered grass, thinking to return to the earth, but in vain.
19. "It seems like I have seven lives," he would say to people.
20. Never, in the back of his mind, had he really thought about death, but he seemed not to be afraid of it.
21. Understanding this brought him relief,
22. and he calmly awaited his end with no moaning in grief.
23. By plucking up his spirit, the torture of his physical body seemed like alleviation.
24. "Why on earth did she close the door shut on such a nice day?" he thought to himself, with an irritated tone at his wife,
25. but in a twinkling, bade himself not to get exasperated so impatiently.
26. Oh! As for us born with wings,
27. How stunningly beautiful the homeland is!

28. Yet, for the joys and sorrows of life,
29. We are in the hands of fate, aren't we?

2.3 Англи орчуулгыг Монгол руу буцааж хөрвүүлсэн хэлбэр

The Old Bird [Өвгөн шувуу]

1. Жав гуай [Хүндэтгэлийн нэр Япон хэлний *сан*- тай ижил] нарны гэрэл түүний гэрийн ханын дээд хэсэгт гялалзаж байхад нүдээ нээлээ.
2. Ухархайдаа гүнзгий хонхойж, зовхи нь хавдсан гэрэлгүй нүдээрээ гэрээ тойруулан харах
3. Тэр хүндэрсэн толгойгоо арайхийн хажуу тийш эргүүлэв.
4. Түүний хянган хамрын мөгөөрс бас шанааны яс нь арьсаа цоолох бий гэмээр ёрдойжээ.
5. Үнэнийг хэлэхэд энэ нүгэлт ертөнцөд амьдрах түүний өдрүүд тоологдчихсон өвчтэй гэдгийг түүний царайны өнгө илэрхийлнэ.
6. Яс арьс болсон гараараа орны буланд бэхэлсэн уяаг ашиглан өөрийгөө дээш нь татаж бас хагас шилжүүлэв.
7. Тэр орны хажуугийн жижиг ширээн дээрээс шаазан аягатай цийдэм [ус сүүг хольсон зүйл] хөнгөн амсав.
8. Дараа нь тэр нарны гэрэл ойсон гэрийн ханыг хэсэг зуур ширтэв.
9. Гадаа тааламжтай зуны өдөр байлаа.
10. Жав гуай тэнгэрийг дээшээ гэрийнхээ утааны нүхээр, газрыг түүний онгорхой хаалгаар ширтэх болсноос хойш урт хугацаа улирчээ.
11. Гэвч тэр дэлхийг бүхэлд нь гэрийн хананд ойсон нарны гэрлээс ч харж чадна.
12. Тал нутаг – тэнд тэр бүхий л амьдралынхаа турш хөндлөн гулд чөлөөтэй давхидаг байсан- тэр тэргүүлдэг байсан...
13. Тэр нүдээ аних бас мөнхийн нойронд автах хүртлээ тэр тэд бүгдийг яаж мартаж чадах билээ.
14. Өглөө бүр тэр энэ бүх тарчлаант өвчинд төгсгөл тавихыг хүсэх боловч өдрүүд өнгөрсөөр.
15. Хүн ямар бат бөх амьтай юм бэ!
16. Чухамдаа утас шиг амь – гэвч түүнийг тасрахын эсрэг бүх боломжоороо зууралдан үргэлжилсээр...
17. Тэр өвдсөнөөс өдрөөс хойш бүтэн жил өнгөрчээ.
18. Жав гуай өмнөх хаврын хатсан өвс унах үеэр газар шороо руу буцна гэж бодож байсан гэвч энэ нь дэмий болжээ.
19. “Би долоон амьтай юм шиг санагдаж байна.” Гэж тэр хүмүүст ярина.
20. Тэр өмнө нь хэзээ ч үхлийн тухай бодож байгаагүй гэвч тэр үүнээс айхгүй байгаа бололтой.
21. энэ ойлголт түүнд тайвшрал авчирчээ.
22. Мөн тэр гиншин ёолох уй гашуугүй тайван төгсгөлөө хүлээсэн.

23. Түүний сэтгэл сэргэж биеийн өвчин зовиур намдсан мэт санагдана.
24. “Газар дээр ийм сайхан өдөр байхад тэр яагаад хаалгаа хаасан юм?” гэж дотроо бодож эхнэртээ ундууцах байдалтай болов.
25. Гэвч агшин зуур, тэвчээргүйтэж бухимдахгүй байхыг өөртөө тушаав.
26. Оү! Жигүүртэй төрсөн бидний хувьд!
27. Ямар гайхалтай үзэсгэлэнтэй эх нутаг гэж!
28. Гэсэн хэдий ч амьдралын баяр баясгалан бас уйтгар гунигт!
29. Бид хувь заяаны гарт байдаг, үгүй гэж үү?

3. Эх бичвэр болон Орчуулгын бичвэрт хийсэн орчуулгын чанарын үнэлгээ

3.1 ЗОХИОЛЫН ХҮРЭЭ (FIELD)

Гол агуулгын хувьд орчуулга эх бичвэрээсээ огт зөрөөгүй. Орчуулгын шинжилгээ хийсэн эхний цогцолборуудыг Монголоор уншиж эхлэхэд цаашаа яасан бол энэ өвгөн үхчихгүй байгаа гэсэн сэтгэгдлийг уншигчдын сэтгэлд төрүүлж дараагийн үйл явдал руу хөтөлдөг. Орчуулгын хувилбар ч бас өөр соёлтой уншигчдад тийм сэтгэгдэл төрүүлэхээр зохиолын үйл явдлын уялдаа холбоог сайтар гаргаж өгсөн.(9,10, 11, 12) **A long time had elapsed** since Jav *guai* had stared up at the skies through the smoke hole of his ger or at the ground through its open door. But he could see the whole wide world even from the yellow spot of sunlight hitting the ger wall. **The steppe** – where he used to gallop the length and the breadth of, during his lifetime and all his life – **that he had led**..... How he could forget them all until he closed his eyes and fell into the eternal sleep.

Хүн төрөлхтөн төрсний эцэст үхэх жамтай гэдгийг сайн мэддэг боловч яг энэ ойлголтын талаар тэр бүр нухацтай тунгаан бодох нь ховор байдаг. Өөрөөр хэлбэл өөрөөс нь нэлээд хол байдаг зүйл шиг боддог. Гэхдээ үхэл гэдэг аймаар зүйл биш, бас үхэл тулгарсан үед хүн өөрийгөө захирч ухаантай байх ёстой, мөн өдөр тутмын энгийн зүйлсийн гайхамшигтай үнэ цэнэтэй талыг харуулах нь эх бичвэрийн ерөнхий агуулга юм. Орчуулгад энэ агуулга дүйцэлтэй буусан. (9/9,11/11,18/18, 20/20, 21/21, 22/22, 23/23) [**could see the whole wide world even from the yellow spot** of sunlight hitting the ger wall] [Jav *guai* had been thinking to return to the earth,] [bade himself not to get exasperated so impatiently]

3.2 ЗОХИОГЧИЙН ЗОРЬСОН САНАА (TENOR)

Зохиогчийн газар зүйн болон нийгмийн байдал, цаг хугацаа. /Author's temporal, geographical and social provenance/

Үгийн сангийн хэрэглээний хувьд

1. Монгол хэлний “гуай” гэдэг хүндэтгэлийн үгийн галиглан орчуулж тайлбар хийжээ. Jav *guai* [title of respect similar to Japanese *san*], (1/1) англи хэлний **mister** гэдэг үгээр монгол хэлний “гуай”-г шууд хөрвүүлэхэд учир дутагдалтай ч энэ өгүүллэгийн орчуулга нь яг тодорхой бүлгийн уншигчдад чиглэгдээгүй чөлөөт орчуулга³ тул япон хэлний САН гэдэг хүндэтгэлийн үгээр биш орчуулж буй хэлний **mister** гэдэг үгээр тайлбар хийх нь япон хэл соёл мэдэхгүй хүнд ойлгомжтой байх болов уу.
2. *Хянган хамрын самсааны мөгөөрс нэвт гэрэлтэн шанааны нь яс арьсаа цоо татах бий гэмээр ёрдойжээ. The cartilage of his high-bridge nose and his cheekbones stuck out as if piercing through his skin.*(4/4) “Хянган хамрын самсааны мөгөөрс нэвт гэрэлтэн” гэсэн 2 бүрэлдэхүүнт өгүүлбэрийн өгүүлэхүүний бүлгийг орхиж хамрын ясны мөгөөрс шанааны яс хоёр хоёулаа арьсаа цоо татах шахаж буй мэт орчуулжээ. Эх бичвэрт хамрын мөгөөрс гэрэлтсэн шанааны яс ёрдойсон гэж өгүүлсэн. Хамрын самсаа нь гэрэлтсэн байх нь үхлийн дохио гэж Монголчууд үзэх тохиолдол байдаг. Харин шанааны яс ёрдойх нь үхлийн дохиог шууд илэрхийлдэггүй.
3. Нарны гэрэл тусах – sunlight hitting, sun light glancing (1,8,11/1,8,11) гэж орчуулсан нь дүйцэл муу болсон Hitting, - гэдэг үг /цохих, хүрэх/ Glancing – гэдэг үг /гялтайх, гялалзах/ гэдэг утгыг илүү илэрхийлдэг. Уран зохиолд ихэвчлэн sun shine, sunlit гэж бичсэн байх нь олон тохиолддог.
4. *Биеэ хагас эргүүлээд - On having half shifted himself* (6/6) гэж орчуулсан нь үг буруу сонгосон. Англи хэлний shift гэдэг үг ихэвчлэн ардаа to гэсэн чиглэл заасан угтвар авч шилжих, хөдөлгөх гэсэн утгыг илэрхийлдэг. Эх бичвэрт Жав гуай биеэ өөр тийш нь шилжүүлээгүй хэвтэртээ эргэсэн иймээс turn гэдэг үгийг сонгох хэрэгтэй байсан болов уу
5. *өнгөрсөн хаврын цагаан хагднаар - , during the fall of the previous spring's withered grass, - өнгөрсөн хаврын хамсан өвс унах үеэр, (18/18)* гэж орчуулсан нь дүйцэлгүй болжээ. Хаврын цагаан хагднаар гэдэг нь тал нутгийнхны хувьд хавар болж цас хайлаад дууссан, өнгөрсөн зуны хатаж цайсан хагд өвс цасан доороос ил гарсан хараахан ногоо ургаагүй үеийн цаг хугацааг заадаг./ ... would pass away around the come out of the withered grass after snow melt in last spring/

³Shamnam Shakernia, “ Study of House’s Model of TQA on the Short Story ant its Translated Text” Global Journal Of HSC(G) volume XIV Issue III. 2014

Өгүүлбэр зүйн хэрэглээний хувьд

1. Хэлний дархлаа болон соёлыг хадгалдаг хэлц үг, мөн өөр соёлын уншигч ухаж ойлгоход хэцүү уртын дууны 4 мөртийг(26/26, 27/27, 28/28, 29/29) орчуулсан хэсгээс харахад орчуулагч англи хэлний хэл зүйн дүрмийн өндөр мэдлэгтэй болох нь харагдаж байна. Just a threadlike life – but with the damndest stiff lingering on against its severance...(16/16) энэ орчуулгыг буцааж хөрвүүлэхэд монгол эхтэйгээ тун ойр болж байна. Зохиогч зүгээр нэг *his life hung only on a thin thread but this would not tear...* гэсэн байдлаар өгүүлэхийг зориогүй. Дууны шүлгийн мөрийг утга санааг алдуулалгүйгээр англи шүлгийн хэлбэр болох сүүл холбох аргаар бичсэн нь монгол зохиолч яагаад шувууны тухай огт дурдаагүй байж зохиолоо (Өвгөн шувуу /The Old bird) гэж нэрлэсэн учрыг англи хэлтэнд ойлгоход дөхөм болсон.
2. Цийдмээр амаа чийглэсэн – ийг *he lightly sipped some tsiidem [water with milk mixed in it]* гэж хөрвүүлсэн. *Lightly sipped* –ийг үгчилвэл *хөнгөн амсах* гэнэ. Эх бичвэрийн *амаа дэвтээх* гэснийг *moistened his lips* гэж орчуулж болох ч энэ маш бага шингэн түүний хоолойгоор давсан гэсэн утгыг гаргаж чадахгүй юм.

Бичвэрийн бүтцийн хувьд

Тэнцүү чанарын эхний шаардлага нь орчуулсан бичвэр бүтцийн хувьд тэнцүү байх юм. Тус орчуулгыг төрөл бус хэлний өгүүлбэр зүйн байрлалын онцлогт тохируулан хийсэн байна. Хэдийгээр өгүүлбэр зүй, болон бичвэрийн бүтцийн хувьд ялгаатай боловч эх бичвэр, орчуулсан хувилбар, буцааж хөрвүүлсэн хувилбар гурвыг утгат хэсэг бүрийг задлан үзэхэд *field, tenor, mode* гурван үзүүлэлтэд бичвэр бүтцийн хувьд тэнцүү байсан.

3.3 АРГА БАРИЛ (MODE)

Энэ үзүүлэлтийн хувьд эх бичвэрээсээ зарим үг өгүүлбэр дээр зөрсөн. Эх бичвэр Монгол уран зохиолын найруулгын онцлогийн дагуу ярианы хэл болон бичгийн хэлний хэл найруулгыг чөлөөтэй ашиглан бичсэн. Үүгээрээ өгүүллэгийн дүр тал нутгийн энгийн нэг өвгөний дүрийг тод гаргаж өгсөн. Орчуулгын хувилбарт англи хэлний өдөр тутмын ярианы хэлэнд тэр бүр хэрэглэгддэггүй уран сайхны үг хэллэг зарим газарт хэрэглэсэн.

A long time had elapsed- for a long time (10/10)

to gallop the length and the breadth of,- he had galloped up and down (12/12)

fell into the eternal sleep-he closed his eyes forever (13/13)

but in a twinkling,- but he change his mind quickly (25/25)

ТӨРӨЛ ЖАНР (GENRE)

Ерөнхий зорилго/generic purpose

Туульсын зохиолын төрлийн хамгийн жижиг хэсэг бол богино өгүүллэг. Энэ богино өгүүллэг энгийн хүүрнэх хэлбэрээр соёлын онцлогийг гүнзгий шингээсэн бүтээл юм. Англи орчуулгад тал нутгийнхны аж амьдрал, соёлын онцлогийг эх бичвэрийн ерөнхий зорилгыг алдагдуулалгүй хөрвүүлэн хүргэсэн. Зарим өгүүлбэрт хэрэглэсэн үг хэллэг эх зохиолын энгийн ойлгоход хялбар өнгө аясыг бага зэрэг өөрчилсөн ч өгүүллэгийн гол агуулга болох монгол хүний ертөнцийг үзэх үзэл, амьдралын философийг өөрчлөлгүй хөрвүүлж чадсан. Орчуулгын хувилбар англи хэлтэнд орчуулгын зохиол гэдэг нь тодорхой, тухайн ард түмнийхээ соёлтой нягт холбоотой чөлөөт орчуулга бөгөөд Хаусын тодорхойлсноор тодорхой цаг хугацаанд хамаарахгүй бичвэр юм.

Дүгнэлт

Жулиан Хаусын орчуулгын чанарын үнэлгээний загвараар Араб, Хятад, Солонгос, Герман, Франц Орос зэрэг орны орчуулга судлаачид орчуулгын чанарт үнэлгээ хийсэн байдаг. Энэ загвараар орчуулгын чанар үнэлгээ хийхэд эх бичвэр орчуулга хоёрыг тусгай үзүүлэлтүүдээр утгат хэсэг тус бүрээр нь тулган тохируулж үзэх шаардлагатай бөгөөд эх бичвэрийн утга санаа, соёлын онцлог, зохиогчийн зорьсон санаа хэрхэн дүйцэлтэй буусан эсэхийг нарийвчлан хянах боломжтой загвар юм. Монгол өгүүллэгийг англи орчуулгатай нь тулгаж үзэхдээ орчуулга эх бичвэр хоёрын эхний хэсгийг утгат хэсгүүдээр нь задалж дугаарлаад нэг бүрчлэн тулгаж үзсэн. Дараа нь англи орчуулгыг буцааж монгол хэлэнд хөрвүүлээд загварт өгөгдсөн үзүүлэлтүүдийн дагуу шинжилгээ хийхэд зөрөө маш бага гарсан бөгөөд үзүүлэлт тус бүрд нь дүгнэлт хийсэн. Энэ загвар нь чөлөөт бус (covert translation), эсвэл хүүхдэд зориулсан богино хэмжээний орчуулгад шинжилгээ хийж үнэлгээ өгвөл илүү тохиромжтой болох нь ажлын явцад ажиглагдлаа. Уран зохиолын орчуулгад энэ загвараар шинжилгээ хийхэд хэт урт нуршсан үзүүлэлтүүд нь заримдаа дахин давтагдах тохиолдол гарч байсан тул зарим үзүүлэлтүүдийг орхисон. Уран зохиолын томоохон орчуулгад эх бичвэр орчуулга хоёрыг тохируулахдаа дээрхийн адил утгат хэсэг тус бүрээр нь бус цогцолбороор нь тохируулбал арай хялбар болох болов уу.

Энэ загварын дагуу орчуулга, эх бичвэр хоёрыг тохируулан үзэж, **ЗОХИОЛЫН ХҮРЭЭ (FIELD)**, **ЗОХИОГЧИЙН ЗОРЬСОН САНАА (TENOR)**, **АРГА БАРИЛ (MODE)** эдгээр гол үзүүлэлтүүдээр үнэлгээ хийж орчуулгын чанарыг шалгавал үнэн зөв дүйцэлтэй, хэл найруулга төгс сайн орчуулгын бүтээлүүд гарах боломжтой юм.

***Abstract:** Translation Quality Assessment has become one of the key issues in translation studies. The House's TQA model is best known and more appropriate for the*

literature translation than other models. This paper demonstrates the revised 1997, model of translation quality assessment by displaying an analysis part of an original text and its overt translation. The part of text is a Mongolian masterpiece translated into English. The masterpiece is mainly about essentiality of ordinary Mongolian's personality. It demonstrates the national features and tradition to readers. The analysis provided in the model for translation quality assessment along the levels of language, register and genre makes a textual profile that defines the individual textual function. The purpose of this paper is to investigate how to use scientific models for evaluating literature translations. Following this critical analyze of TQA model, it suggests that a literature translation is as a scientific products and translation must be adequate pragmatically and semantically equivalent one. In order to make grounded statement of this model both the original and the translation text are analyzed at the same level of precision. After that the translation text is then compared with the source text's textual profile.

Ном зүй:

Монгол хэлээр:

Бат-Ирээдүй, Жанцан (2008) “Монгол хэлц үг, хэллэгийн утга хэрэглээ”, Мон-Эдюкэшн Пресс. Уб.,

Я. Цэвэл, (1966) “Монгол хэлний товч тайлбар толь”,

Сүхбаатар.Ц (2003) “Монгол хэлний найруулга зүйн нэр томъёоны тайлбар толь” Уб.,

Англи хэлээр:

Juliane House (2014) “Translation Quality Assessment past and present” London and New York

Claire Kramsch (1998) “**Pocket Oxford dictionary**” Oxford University Press,

Roget's 21st century thesaurus dictionary

МОНГОЛ ХЭЛЭНД ИЛЭРЧ БУЙ НЕОЛОГИЗМ БА ТҮҮНИЙ ОРЧУУЛГЫН АСУУДАЛД

А. Өлзийнаран, Б. Наранчимэг¹

Товч утга: *Техник технологи, харилцаа холбооны дэвшил болон даяарчлал нэмэгдэхийн хэрээр хүмүүсийн харилцааны гол хэрэгсэл болсон хэлэнд өдөр тутам шинэ үг бий болж, тэр хэрээр бидний хэл баяжсаар байна.*

Монгол хэлэнд англи хэлний оролцоо, нөлөө асар их байгаа бөгөөд техник технологи, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжин маш олон тооны шинэ үг, нэр томъёо орж ирж, хүүхэд залуучууд төдийгүй нийтээр түгээмэл хэрэглэж байна.

Тиймээс энэхүү өгүүлээрээ неологизм буюу аливаа хэлэнд үүсч буй шинэ үг хэллэг, тэдгээрийн орчуулга болон монгол хэлэнд хэрхэн илэрч байгаа талаар судлахыг зорьсон билээ.

Түлхүүр үг: *неологизм, хэлний ба хэлний бус хүчин зүйл, үг оноолт*

Неологизм гэж юу вэ?

Хэл оршин тогтнохын тулд тодорхой хэмжээгээр хувьсан өөрчлөгдөж байх шаардлагатай байдаг. Харин хэл хувьсан өөрчлөгдөхөд шинэ үг хамгийн чухал үүргийг гүйцэтгэнэ. “Neologism” буюу “шинэ үг хэллэг”(Англи-Монгол толь, Оксфорд, 2008 он) гэсэн үг нь 18-р зууны үед анх франц хэлнээс орж ирсэн байна.

Неологизмыг “Нийгмийн хөгжлийн үрээр утга зохиолын хэлэнд шинээр хэрэглэж байгаа, цоо шинэ үзэгдэл юмсыг заасан, идэвхгүй нэрийтгэл үг хэллэг” /mn.wikitionary.org/ хэмээн тодорхойлсон байдаг. Энэ төрлийн үг хэллэгийг олон эрдэмтэн судлаач, хэл шинжээчид дараах байдлаар тайлбарласан байдаг.

Үүнд:

- Аливаа хэлэнд хараахан хүлээн зөвшөөрөгдөөгүй шинэ үг хэллэгийг неологизм гэнэ. Үүнийг ерөнхийдөө үгийн шинэхэн хэлбэр гэж ойлгож болох юм.²
- Неологизмын төрлүүд бол шинээр зохион бүтээгдсэн зүйлсийн нэршил юм.³
- Аливаа хэлэнд неологизм бий болох үед коннотацийг нь өөрчлөхөд бэрхшээлтэй байдаг.⁴
- Шинэ үг хэллэг буюу неологизм нь уран зохиолын орчуулга хийдэггүй, мэргэжлийн орчуулагчдын хувьд томоохон сорилт болдог билээ. Техник

¹ МУИС, ШУС, ХУС-ын ИБАСТ-ийн багш нар

² Eric Partridge, *Usage and Abusage: A Guide to Good English*, 1997, p.201.

³ Jeremy Munday, *The Routledge Companion to Translation Studies*, 2009, p. 210.

⁴ Basil Hatim, *Translation: An Advanced Resource Book*, 2004, p. 247.


технологийн салбарт маш олон тооны шинэ бүтээл, үйл явдал, хэвлэл мэдээллийн салбараас шинэ санаа, шинэ хувилбар гарч ирсээр л байна.⁵

Харин Голландын хэл шинжээч М. Жанссен неологизмыг 5 аргаар тодорхойлсон байдаг. Үүнд:

- Сэтгэл зүйн хувьд неологизмийг хэлний нийгэмлэгт цоо шинэ ойлголт хэмээн үзэж болно.
- Толь зүйн хувьд тухайн хэлний толинд хараахан ороогүй үгийг хэлнэ.
- Үгийн хасалтын хувьд урьдчилан тодорхойлсон үгийн хасалтад байхгүй үг.
- Цаг хугацааны онцлог, үе шат, хөгжлийн үе шатны хувьд өмнө нь тухайн хэлэнд илэрч байгаагүй ч одоогийн ярианы хэлэнд ажиглагдаж байгаа ямар ч үгийг хэлнэ.
- Лавлах түүвэр бүтээлийн тодорхойлолтын хувьд өмнөх лавлах түүвэр бүтээлүүдэд илэрч байгаагүй хэдий ч одоогийн ярианы энгийн бичлэгт илэрч байгаа ямар ч үгийг хэлнэ.

Эдгээр тодорхойлолтоос харвал неологизм нь тухайн хэлэнд урьд өмнө илэрч байгаагүй ямар нэгэн лавлах бүтээлүүд болох толь, ном зохиолд тэмдэглэгдэж байгаагүй хэдий ч, одоо энгийн ярианы хэлэнд хэрэглэгдэж байгаа шинэ үг хэллэг юм байна. Тухайн хэлэнд орж ирсэн шинэ үг хэллэг үүсэх гол хүчин зүйл нь хэлний буюу дотоод хүчин зүйл болон хэлний бус буюу гадаад хүчин зүйл юм.

Ямар ч хэлэнд жилдээ 3000 үгс шинээр бүртгэгддэг гэж тодорхойлогдсон байдаг.⁵ Үнэн хэрэгтээ шинэ үг хэллэгүүдийн ихэнх нь мартагдаж, үлдэх эсэх нь тодорхойгүй байдаг. Мөн энэхүү төрлийн үгс богино настай байдаг учир нарийн тоолж бүртгэх боломжгүй байдаг. Аливаа хэл хөгжих тусам шинэ үг хэллэгийн тоо улам өсөх нь тодорхой. Үүгээр ч зогсохгүй мэргэжлийн хүмүүс болон ерөнхий толь бичгээс үүдэн эдгээр үгс илүү түгээмэл хэрэглэгдэх болжээ. Шинэ үг хэллэг нь онцгой хэрэгцээ шаардлагын хариуд бий болдог тул ихэнх нь ердөө ганц утгатай байхын зэрэгцээ сэдвийн хүрээнээс тэс өөр утгаар орчуулагддаг. Гэвч тун удалгүй ихэнхи нь хуучин утгаа алдаж шинэ утгатай болдог байна.



⁵ Peter Newmark, *A Textbook of Translation*, 1988, p.140.

Тухайн хэлэнд илэрсэн шинэ зүйлийг нэрлэх оновчтой үг байхгүй тохиолдолд эх хэлээс нь үг зээлж авч хэлний зайг нөхөж болохоос гадна дагавар, нөхцөл, язгуур, үг хорших аргаар мөн шинэ үг үүсэж болно.

Харин хэлний буюу дотоод хүчин зүйл түүний дотор ялангуяа үг зээлэх аргаар дараах тохиолдолд неологизмыг үүсгэж болно.

- Тухайн харь үгийг авч байгаа хэлэнд тухайн шинэ юмс үзэгдэл, ойлголтыг тэмдэглэх үг буюу дүйцэл (эквивалент) байхгүй тохиолдолд харь үгийг неологизм хэмээн авах хэрэгтэй болно.

Жишээ нь: гамбургер, сэндвич гэх мэт

- Утгын нарийн ялгааг гаргах зорилгоор шинэ үгийг авдаг.

Жишээ нь: Вайрлэсс (вайфай) – утасгүй интернет, нөүтбүүк- зөөврийн компьютер гэх мэт.

- Хэлний хэмнэх зарчимтай холбоотойгоор харь үгийг неологизм хэмээн авдаг.

Жишээ нь:

Мультмедиа- мэдээллийн олон хэрэгсэл ашиглах

Маникьюр- гарын хумс засалч

Пэдикьюр- хөлийн хумс засалч

Хотдог- халуун зайдас хавчуулсан талх

Анплагед - ямар нэгэн дуу өсгөгч ашиглалгүй, дан хөгжмөөр тоглодог тоглолт.

Паб- архи дарсны мухлаг гэх мэт.

Неологизмын зарим төрлүүд болон тэдгээрийн монгол хэлэнд илэрч буй жишээ

Неологизм буюу шинэ үг хэллэг гэдэг нь аливаа хэлэнд өмнө нь илэрч байгаагүй ч техник технологийн дэвшил, даяарчлал зэргээс үүдэн тус хэлээр ярилцагч ард түмний өдөр тутмын хэрэглээ болсон үгс хэмээн ойлгож болох юм.

Орчуулгын онолч, нэрт эрдэмтэн Петр Ньюмарк неологизмыг хэд хэдэн төрлөөр ангилсан байдаг бөгөөд зарим төрлүүд нь монгол хэлэнд хэрхэн илэрч буйг жишээ тайлбартай нь авч үзье.

Шинэ утга агуулах хуучин үгс

Шинэ утга агуулах хуучин үгс нь техник технологийн холбогдолтой үг хэллэг байх нь цөөн. Ихэвчлэн ямар нэгэн үйл явдлын улмаас олон нийтийн дунд цуу яриа болон тархах, эсхүл хэн нэгэн хүн тус үгийг цоо шинэ утгаар хэрэглэж эхлэхэд тэр нь олон нийтийн анхаарлыг татсанаар шинэхэн утга бий болно. Тийм учраас энэ төрлийн үгэнд цор ганц утга байх боломжгүй бөгөөд бичвэрээсээ хамааран утга нь өөрчлөгдөнө.

Жишээлбэл,

- Миний найз одоо фэйсбүүкээр од боллоо доо.

“Од” гэдэг үгийн тухайд монгол болон англи хэлний аль алинд нь тэнгэрийн од гэдэг үндсэн утгаас гадна нэрд гарч, олны танил болох гэсэн шинэ утга агуулах болжээ.

- Би өөрийн твиттэр хуудсан дээрээ энэ асуудлын талаар жиргэсэн байгаа шүү.

Сүүлийн үед Twitter хэмээх олон нийтийн сүлжээг ашигладаг болсноос хойш tweet буюу шувуу жиргэх гэсэн утгаас гадна өөрийн үзэл бодлоо Twitter сүлжээнд оруулах гэдэг утгаар хэрэглэгдэх болсон байна.

Шинээр үг үүсгэх

Шинэ үг гэж огт байхгүй гэсэн таамаглал олон нийтийн дунд түгээмэл байдаг. Бүхий л авиа, авиалбар нь ямар нэгэн утгатай. Ямар нэгэн үгэн дээр дагавар залгах, үсгийг нь өөрчлөх гэх мэт аргаар үүснэ.

Монгол хэлэнд “Selfie” хэмээх нэр томьёо нь “Self portrait” буюу “өөрийн+хөрөг” гэсэн үгнээс үүдэн өөрөг хэмээн хэрэглэгдэх болсон байна.⁶

Товчилсон үг

Үг товчлолт нь зохиомлоор шинэ үг бүтээх нийтлэг төрөл бөгөөд үгийн эхний үсгүүдээр нь хураангуйлдаг. Энэ төрөлд голдуу компьютер, техник технологитой холбоотой үгнүүд нийтлэг байдаг. Мөн энд олон улсын байгууллагын нэр ч хамаарна.

Жишээ дурдвал, CD (compact disc) PC (personal computer) IT (information technology) гэх мэт олон үгнүүдийг нэрлэж болох юм.

Монгол хэлэнд писидэх (компьютер дээр тоглох) Айтигийнхан (мэдээлэл, технологийн албаныхан), ЮНЕСКО-н өвд бүртгүүлэх зэргээр эдгээр үгийг шууд галиглан түгээмэл хэрэглэж байна.

Эпоним

Энэ нь оноосон нэрээс үүссэн үгийг хэлдэг. Хүний нэрнээс үүссэн эпоним үгийг төвөггүй орчуулах боломжтой. Ямар нэгэн эпоним нэр бүхий брэндийн нэрийг орчуулахдаа зайлшгүй тайлбарыг хавсаргах шаардлагатай байдаг. Ихэвчлэн вино, бяслаг, зайдас зэрэг бүтээгдэхүүний нэрээс үүснэ. Хэрэв тэрхүү бүтээгдэхүүн тийм ч алдартай биш бол ерөнхий нэр томьёог хавсарган бичнэ.

Жишээ нь, Германы зохион бүтээгч инженер Р. Дизелийн нэрээр нэрлэсэн шингэн түлшээр ажилладаг дотоод шаталтын хөдөлгүүрийг монголд “дизель хөдөлгүүр” гэж нэрлэж заншсан байна.

Мөн “Canon” хэмээх хувилагч машины нэрээс үүдэн бичиг баримт олон хувь болгож олшруулах үйлдлийг “канондах”, “канондуулах” гэж ярьж хэвшсэн байна.

Харин одоо бидний дунд түгээмэл хэрэглэгддэг хэлний бус салбар дахь хөгжлийн нөлөөгөөр үүссэн неологизмыг авч үзье.

Нийгэм: *шоудах, дискодох, казинодох, ламинатордох, спонсорлох, скочдох, факсдах*

Улс төр: *пиар хийх, лоббидох, рекэтлэх*

Эдийн засаг: *мобайлдах, лизингдэх, индексчлэл*

Техник технологи: *постлох, принтерлэх комментлох, шейрлэх, гүүгэлдэх гэх мэт.*

⁶ Зугаатай хэл шинжлэл групп, 2014

Даяарчлалын маш олон давуу талууд байдаг ч нэгэн томоохон сул тал байдаг нь аливаа хэлэнд шинээр орж ирж буй техник технологи, шинэ нээлт, бүтээгдэхүүний нэршил байдаг. Харин олон нийт энэхүү үгсийг хэрхэн орчуулах тал дээр янз бүрийн санал дэвшүүлдэг. Эдгээр үгсийг заавал орчуулж эх хэлнээ буулгах ёстой гэж үздэг хэсэг бүлэг байхад дэлхий нийтийн нэршлээр нь авч хэрэглэх ёстой гэж үздэг хэсэг бүлэг хүмүүс ч байдаг.

Тухайлбал, ерөнхийлөгч асан Ц. Элбэгдорж 2015 онд УИХ-ын хаврын чуулганы үеэр хэд хэдэн гадаад нэр томъёог монголчлон орчуулах санал гаргаж байсан байна.

- Визийг нэвтрэг
- Рестораныг зоогой
- Кофег боргол
- Шоколадыг боргош
- Айпадыг хавтага
- Компьютерийг цахимбар
- Цементийг гахиур
- Хоббиг ин
- Логог хондого
- Бензинийг гүүгэн гэж дуудаж сурцгаая” гэсэн санал оруулж байсан байна.⁷

Мөн Монгол хэл соёлын хүрээлэнгийн захирал Г. Сүлд-Эрдэнэ үзэхдээ “Манай улсад нэр томъёо, гадаад үгийг орчуулж оноож, хэрхэн хэрэглэх асуудлыг төр засгаас тохоон томилсон “Төрийн хэлний зөвлөл” цэгцлэх ёстой. Чоно борооноор гэгчээр өөрийгөө дөвийлгөсөн хүмүүс шинэ үг хэллэг, нэр томъёог дураараа зохиож ярьж, судлаач эрдэмтэд өөр өөрсдийн хэрэглэж сурсан нэр томъёогоо өөрийн хүрээллийн хүмүүст түгээж буй асуудал газар аваад байгаа. Төрийн хэлний зөвлөл эхлээд гадаад үгийг яаж орчуулах, нэр томъёо боловсруулах зарчмаа тогтоочихоод улиралд шинээр орж ирсэн үг хэллэгийг маш оновчтой судалгаатай, тайлбартайгаар яаж орчуулах вэ гэдгийг хэлэлцэн баталж баймаар байна.” гэсэн санааг дэвшүүлсэн байна.⁸

Судалгааны ажлынхаа хүрээнд монгол хэлэнд шинээр илэрч буй харь үгс, тэдгээрийг хэрхэн орчуулах талаар оюутан залуус ямар ойлголттой байгаа талаар сонирхон оюутнуудаас санал асуулга авахад дийлэнх нь орчуулгын тухайд тухайн үгээсээ хамаарах бөгөөд нэр томъёоны орчуулгын хувьд нийтээр тогтсон дүрэм журам байхгүй нь түвэгтэй байдаг гэдгийг онцолж байлаа.

Дүгнэлт

Бидний өдөр тутмын амьдралд хэлний бөгөөд хэлний бус хүчин зүйлийн нөлөөгөөр шинэ үг хэллэг нэмэгдэж байдаг бөгөөд үүнийг хэл шинжлэлд неологизм гэсэн ойлголтоор илэрхийлдэг.

⁷ Ерөнхийлөгч асан Ц. Элбэгдоржийн УИХ-ын чуулганы хуралдааны үеэр хийсэн мэдэгдлээс. 2015 он

⁸ Г. Сүлд-Эрдэний www.ikon.mn-д өгсөн ярилцлагын хэсгээс. 2014 он

Монгол хэлэнд нийгэм, эдийн засаг, улс төр, техник технологи, ялангуяа хэвлэл мэдээллийн салбарт энэхүү шинэ үг үүсэх үйл явц өргөн дэлгэрч байна.

Сүүлийн үед интернетийн орчинд залуусын дунд англи үг хэллэгийг шууд галиглах болон монгол хэлний үг бүтээх дагавар залгаж шинэ үг хэллэг бий болж байгаа нь түгээмэл ажиглагдаж байна. Харь хэлнээс орж ирж буй шинэ үг хэллэгийг орчуулах тал дээр олон янзын байр суурьтай байдаг. Тухайлбал, олон улсын нэршлээр нь нэрлэх сонирхолтой хүмүүс байхад заавал монголоор орчуулах хүсэлтэй хүмүүс ч байна.

Судалгаагаас харахад цаашид шинэ үг хэллэгийн асуудлыг үүсэн гарч буй нөхцөл шалтгааныг судалж, орчуулах боломжтой үг хэллэгийг орчуулах, хэлний хэмнэх зарчмын дагуу боломжгүй үгнүүдийг нь галиглаж, орчуулахгүй хэвээр нь үлдээж, өөр өөрсдийн ойлголтоор бус нэгдсэн журам бий болгож, нийтээр нэгдсэн нэг ойлголттой болох шаардлагатай нь ажиглагдлаа.

Resume

In our globalized world new words and terms are continually created every day and enter a language due to technological advances.

The influence of English language plays an important role in Mongolian language. Each year, many new words and terms are introduced through the use of technology and media and are widely used by children and youths. This article aims to explore the how neologism or new words are created and their translations are incorporated into the Mongolian language.

Ашигласан материал

англи хэлээр

1. Basil Hatim, *Translation: An Advanced Resource Book*, 2004, pp. 247.
2. Eric Partridge, *Usage and Abusage: A Guide to Good English*, 1997, pp.201.
3. Jeremy Munday, *The Routledge Companion to Translation Studies*, 2009, pp. 210.
4. Lexicology of English, L.Ya. Minaeva, 1881, Moscow
5. Oxford Advanced learner's dictionary, 2012
6. Peter Newmark, *A Textbook of Translation*, 1988, pp.140.
7. Qualification paper in modern English, Umarova, 2012

монгол хэлээр

1. Р. Гүрбазар, “Орчуулгын онол, дадлагын үндэс”, Улаанбаатар, 1996
ахим эх сурвалж
1. <https://www.wikidictionary.com>
2. <https://www.Dictionary.com>
3. <http://ikon.mn/n/c5z>
4. <https://www.fast-index.com>
5. <http://mongolkhel.mn>
6. <http://www.president.mn/content/11548>

МАШИНЫ ОРЧУУЛГЫН ХӨГЖИЛ БА ХЭРЭГЛЭЭ

Ж.Эрдэнэбат¹

Товч утга: Энэхүү өгүүлэлд орчин үед хурдацтай хөгжиж буй машины орчуулга ба компьютерт суурилсан орчуулга, түүний эрэлт хэрэгцээ, машины орчуулгын ажиллах горим, хэрэглээний хэлбэрүүд, хөгжлийн чиг хандлага, хүний орчуулга ба машины орчуулгын онцлог, давуу болон сул тал, орчуулгын сургалтад анхаарах зарим нэг асуудлыг дэвшүүлсэн болно.

Түлхүүр үг: машины орчуулга, компьютерт суурилсан орчуулга, орчуулгын програм хангамж, орчуулгын төрөл зүйл, машины орчуулгын эрэлт хэрэгцээ

Машины орчуулга

Машины орчуулга ба компьютерт суурилсан орчуулга нь хүний орчуулах үйл явцыг хөнгөвчлөхөд чиглэсэн онлайн ба онлайн бус горимын компьютерийн програм хангамжийг ашиглан, орчуулгын ажлыг гүйцэтгэдэг шинэ тутам хөгжиж буй орчуулгын хэлбэр юм.

Хүний тусламжгүйгээр төгс чанартай орчуулга хийх автомат машины орчуулгын систем хараахан бий болоогүй байгаа хэдий ч *Google*, *SYSTRAN*, *Microsoft* зэрэг томоохон компаниуд энэ салбарт ихээхэн хөрөнгө оруулалт хийж, тэр хэмжээгээр машины орчуулга хөгжсөөр байна. Тухайлбал янз бүрийн түвшинд програмчилагдсан 100 гаруй хэлний сантай “*Google Translate*” програмыг өдөр бүр 200 сая гаруй хүн 100 тэрбум орчим үг хэллэгийг орчуулахад хэрэглэж байна¹.

Машины орчуулгаас монгол хэл хоцорсонгүй. Монгол хэлийг “*Google Translate*” програмд оруулах ажилд Монголын тал *Google* корпорацитай идэвхтэй хамтран ажиллаж, 2013 оноос эхлэн монгол хэлийг тус үйлчилгээнд нэвтрүүлсэн байна. Эдүгээ “*Google Translate*” үйлчилгээг ашиглан интернет олон хэлний орчинд үнэ төлбөргүйгээр эх хэл рүүгээ мөн эх хэлнээсээ орчуулга хийх боломж бидэнд хэдийнээ бүрджээ.

“*Google Translate*” нь “*machine learning*” буюу өөрөө өөрийгөө сайжруулах горимын орчуулгын систем юм. Тиймдээ ч их хэмжээний мэдээллийн сан шаарддаг. Програм нь 10 сая ба түүнээс дээш тооны хос өгүүлбэр /sentence pair/ орсон хэлний хувьд орчуулгын чанар тун сайн байгаа бөгөөд үүнд англи, испани, герман, франц зэрэг найман хэлний орчуулгыг дурдаж болно. “*Google Translate*”-ийн монгол хэлний орчуулга чанарын хувьд хангалтгүй байгаа нь мэдээллийн сан бага байгаатай холбоотой. Гэхдээ тогтмол хэрэглэж, алдааг залруулах тутам ‘*machine learning*’

¹ МУИС, ШУС, ХУС-ын ИБАСТ-ийн багш

систем тодорхой алгоритмын дагуу өөрөө суралцаж, мэдээллийн сангаа баяжуулах тул монгол хэлний орчуулга улам бүр төгөлдөржинө гэдэгт итгэлтэй байна.

2016 оны арваннэгдүгээр сард *Google* корпораци “*Google Translate*” програмынхаа орчуулгын чанарыг сайжруулах зорилгоор электрон “оюун ухаан–нерв” горимын системийг боловсруулж, GNMT буюу *Google*-ийн электрон нерв бүхий машины орчуулгыг эхний ээлжинд англи, хятад, франц, герман, япон, солонгос, португал, испани, турк зэрэг найман хэл дээр нэвтрүүлжээ. Эдгээр хэл нь “*Google Translate*” програм ашиглалтын 35% орчим хувийг эзэлж байгаа аж². Удалгүй 2017 оны гуравдугаарт сард дахин орос, хинди, вьетнам гурван хэл дээр нэвтрүүлсэн байна. Мөн энэхүү програм нь дээрх найман хэл дээр өгүүлбэрийн түвшинд орчуулга хийх хэмжээнд боловсронгуй болсноос гадна орчуулгын түүхийг хуримтлуулах болсноор орчуулгын чанар улам бүр боловсронгуй болж, хүний орчуулгаас дутахааргүй түвшинд хүрсэн талаар судлаачид бичиж байна². *Google*-ийн хувьд энэ бүхэн зөвхөн эхлэл ажээ. Тус компани шинэ тутам боловсруулсан програмаа одоогоор зөвхөн дээрх найман хэл дээр ашиглах боломжийг бүрдүүлээд байгаа ч цаашид судалгаагаа гүнзгийрүүлэн “*Google Translate*” програмын бусад хэлний орчуулгад нэвтрүүлэх зорилгоор судалгаа хийж байна.

Мөн 1968 онд байгуулагдсан, машины орчуулгын чиглэлээр дагнасан үйл ажиллагаа явуулдаг *SYSTRAN* компани дүрэмд суурилсан машины орчуулгын програмаа улам бүр төгөлдөржүүлж, 2010 онд дүрэм ба статистик өгөгдөл хосолсон машины орчуулгын програмыг нэвтрүүлж, 130 гаруй хэлээр орчуулгын үйлчилгээ үзүүлж байна. Эдүгээ тус компани дэлхий даяар олон хэл хоорондын харилцааг хөгжүүлэх зорилгоор цэвэр электрон нерв горимын машины орчуулгын (Pure Neural Machine Translation) програмыг мөн боловсруулаад байна.

МУИС цахим орчуулгын хөгжилтэй хөл нийлүүлэн алхаж, англи–монгол онлайн орчуулгын системийг туршилтын журмаар ажиллуулжээ. Уг орчуулгын програм хангамжийн ажиллах горим нь дүрэмд суурилсан машины орчуулгын програмын горимоор орчуулгын бэлтгэл үе, орчуулах үе, үр дүнг нэгтгэх үе гэсэн үндсэн гурван хэсгээс бүрдэл болдог байна⁶. Тодруулбал орчуулгын бэлтгэл үед програм хангамж өгөгдлийг энгийн бичвэрт хөрвүүлж, орчуулах үед хэлзүй, өгүүлбэрзүй, найруулгазүйн олон шатлалт үйлдэл хийдэг бол үр дүнг буцаан нэгтгэснээр орчуулга бэлэн болдог байна.

Машины орчуулгын хөгжилд нөлөөлж буй хүчин зүйл бол орчуулгын өөрчлөгдөн шинэчлэгдэж буй эрэлт хэрэгцээ юм. Жишээ нь хүний орчуулсан, уламжлалт, чанартай орчуулгын эрэлт хэрэгцээнээс гадна чанарын хувьд харьцангуй доогуур, тухайлбал интернет орчинд тодорхой эх материалын ерөнхий утгыг олж авахад илүүтэй анхаарсан хэрэглэгчид олширсоор байна. Үүнээс гадна харилцааны энгийн хэлбэрүүд тухайлбал утас, электрон захидал, *viber*, *wechat* зэрэг онлайн горимын харилцааны програм, олон нийтийн газарт өрнөдөг өдөр тутмын яриа гэх мэт хэрэглээний олон янзын хүчин зүйлсийн улмаас машины орчуулгын эрэлт хэрэгцээ нэмэгдэж, чанарын хувьд улам бүр боловсронгуй болсоор байна. Үүний

нэгэн жишээ бол 2017 оны нэгдүгээр сард танилцуулсан Японы “Logbar” компанийн “ili” хэмээх авсаархан орчуулгын төхөөрөмж юм. Уг төхөөрөмж нь 50,000 үг хэллэгийн сантай бөгөөд интернетгүй орчинд ердөө 0.2 секундийн хурдтайгаар англи, япон, хятад хэлнээ хүний хэлсэн мэдээллийг төвөггүйхэн орчуулдаг байна. Тэр ч бүү хэл хэлний мэдлэг сайтай орчуулагч хүн орчуулгад тохирох оноосон нэршлийг сонгохдоо тайлбар толиноос илүүтэйгээр орчуулгын програм хэрэглэх, эх ноорог орчуулгаа боловсруулахдаа компьютерт суурилсан орчуулгын програм ашиглаж, дараагаар нь хянан тохиолдуулах хэлбэрийн орчуулах явц нэмэгдэж байгаа нь машины орчуулга шинэ түвшинд гарахад ихээхэн түлхэц үзүүлж байна.

Өсөн нэмэгдэж буй машины орчуулгын хэрэглээний дээрх хэлбэрүүдийг Жон Хатчинс **а. утга задлах** (орчуулагчдын орчуулгын програм хангамжийг ашиглаж буй хэлбэр), **б. утга ижилсэх** (эх материалын ерөнхий утгыг тайлахад илүүтэй анхаарсан хэрэглээний хэлбэр), **в. утга сэлгэх** (өдөр тутмын хэрэглээний хэлбэр), **г. мэдээллийн хүртээмж** (интернет, мэдээллийн технологийн түвшин дэх олон хэлний мэдээллийн сан) гэсэн дөрвөн зүйл болгон ангилжээ³.

Түүхэн хөгжил

Автомат орчуулгын системийн түүхийг сөхөж үзвэл компьютерийг зохион бүтээсэн тэртээ 1940 оноос эхэлжээ. Эхэн үедээ толь бичгээс өөрцгүй байсан уг систем 1980-аад оноос шинэ түвшинд хүрсэн цахим хэл шинжлэл болон олон үйлдэлт програм хангамжуудын тусламжтайгаар орчуулгын эхэд үгзүй, өгүүлбэрзүй, цаашлаад утгазүйн нарийвчилсан задаргаа хийх боломжтой болсон байна. Улмаар ижил нэр (*homonym*), утгын оновчтой холбоог тодорхойлох програм хангамжууд нэмэгдэж машины орчуулгыг шинэ түвшинд хүргэжээ.

Машины орчуулгыг эхэн үедээ холбогдох тоног төхөөрөмжийн зардлын улмаас засгийн газар, олон улсын байгууллага, цэргийн анги нэгтгэл ашиглаж байв. Жишээ нь 1970-аад оны үед “Systran” орчуулгын програмыг Оросын цэргийн зориулалттай шинжлэх ухаан, техникийн баримт сэлтийг англи хэлнээ орчуулах зорилгоор АНУ-ын агаарын цэргийн хүчин ашиглаж байв. “Systran” орчуулгын програмын орчуулгын чанарыг зарим тохиолдолд 90%-ийн гүйцэтгэлтэй гарч байсан тухай мэдээлэл байдаг⁴. Харин Европт машины орчуулгыг хамгийн анх ашигласан байгууллага нь Европын Комисс бөгөөд англи хэлнээс франц хэлнээ орчуулга хийх “Systran” орчуулгын програмыг 1976 онд суурилуулжээ. Энэ үеэс “Systran” орчуулгын програмыг орчуулгын зорилгоор ашиглаад зогсохгүй удирдах албан тушаалтнууд гадаад хэлээр хэлэх үг, албан бичгийн эх бэлтгэлдээ ашигладаг болсон байна.

1990-ээд он хүртэл машины орчуулгад ихээхэн хөрөнгө оруулалт хийсэн авч үр дүн муутай байсан бөгөөд машинаар орчуулсан эхийг орчуулагч дахин хянах зэргээр орчуулгын зардал буурахгүй байв. Гэвч машины орчуулгыг пүүс компаниуд зах зээлд нийлүүлэх бараа бүтээгдэхүүнийхээ сурталчилгаа болон техникийн баримт бичгийн орчуулгад түгээмэл хэрэглэх болсноор орчуулгын програм шинэ түвшинд гарах нөхцөл дахин бүрджээ. Учир нь техникийн бараа бүтээгдэхүүнийг дагалдах

гарын авлага болон бусад баримт бичиг нь агуулгын хувьд хэт их, богино хугацаанд олон хэл дээр нэгэн зэрэг орчуулагдахаас гадна бүтээгдэхүүний дараагийн шинэ загвар гарахтай холбоотойгоор цаг хугацаа, хөрөнгө мөнгө хэмнэх шаардлага зүй ёсоор тулгарч байжээ. Эдгээр хүчин зүйлийн улмаас техникийн материалын орчуулга нь хүний хүчин чадлаас давсан асуудал болж, томоохон компаниуд машины орчуулгыг хөгжүүлэхэд үлэмжхэн хөрөнгө оруулалт хийх болсон байна. Машины орчуулгыг амжилттай ашиглаж буй олон жишээнээс дурдвал Шведийн Эриксон корпорац *Logos* орчуулгын програм, АНУ-ын Форд, Женерал Моторс, *Xerox* корпорациуд *Systran* орчуулгын програм хангамжийг тус тус ашиглаж байна. Мөн томоохон компаниуд орчуулгын програм хангамжийг ашиглахдаа бараа бүтээгдэхүүнийхээ онцлогт нийцүүлэн хэлний хэм хэмжээг тохируулах оролдлого хийдэг байна. Тухайлбал *Xerox* корпорацийн бараа бүтээгдэхүүний техникийн баримт бичиг боловсруулах багийнхан *Systran* систем ашиглан орчуулгын эх бэлтгэхдээ олон улсын хэмжээнд зөвшөөрөгдсөн англи хэл-найруулгаар боловсруулах үүрэгтэй ажээ⁵. Тодруулбал өгөгдсөн нэр томъёо болон өгүүлбэрийн бүтцийг ашиглан бичдэг байна. Ингэснээр машины орчуулгын систем хоёрдмол утгаас зайлсхийх боломж бүрдэх бөгөөд нэгэн зэрэг олон хэл дээр, богино хугацаанд орчуулгын хувьд чанартай, техникийн баримт бичиг боловсруулдаг байна. Энэ мэтчилэн “техникийн тусгай хэл, найруулгын” давуу талыг пүүс компаниуд хэдийнээ хүлээн зөвшөөрч, хэрэглээ нь нэмэгджээ.

Машины орчуулгын горим

Ерөнхийдөө машины орчуулгын програм нь нэг хэлний үгийг нөгөө хэлний үгээр орлуулах горимоор ажилладаг. Гэвч хэрэглээний үед зөвхөн үгээр зогсохгүй хэлц, цаашлаад өгүүлбэрийг хоёр хэлнээ хамгийн оновчтой түвшинд тохируулан оноох шаардлага зүй ёсоор урган гардаг тул дан үг оноолтоор чанартай орчуулга гарахгүй нь тодорхой байв. Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд дүрэмд суурилсан, өгөгдөл жишээнд суурилсан, хосолсон зэрэг орчуулгын олон янзын програм туршиж байснаас хэл шинжлэлийн үүднээс хэл тус бүрийн онцлогийг тодорхойлох, өвөрмөц хэлцийг орчуулах, орчуулгын явцад гарах алдааг тусгаарлах зэрэг үйлдлийн систем бүхий статистик болон электрон нерв горимын машины орчуулгын програмыг улам бүр хөгжүүлж байна.

Статистик машины орчуулга нь Канад болон Европын парламентын Канадын Хансард Корус түүвэр буюу англи-франц хэл дээрх баримт бичигт тулгуурлан статистик аргаар орчуулах аргачлал бөгөөд дээр дурдсан хэлнээ төстэй агуулга бүхий эхийг орчуулахад үр дүн сайтай байдаг байна. Гэвч бодит байдал дээр олон хэлнээ иймэрхүү хос хэлний баримт бичиг тохиолдох нь ховор юм. 2005 онд *Google* корпораци орчуулгын програмаа сайжруулах зорилгоор НҮБ-ын баримт бичгээс 200 тэрбум орчим үгийг авч ашигласан байдаг.

Тодорхой даалгавар бүхий алгоритмаас илүүтэйгүүр гүн бүтцэд тулгуурлан өөрөө суралцах электрон нерв горимын машины орчуулга нь сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжиж байна. *Google* корпорацийн орчуулгын програм нь эдүгээ өмнөх

статистик аргаас илүүтэйгээр энэ технологид суурилж байна. Мөн 2017 онд машины орчуулгын салбарт идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг *Kantan MT, Omniscien Technologies*, болон *SDL* зэрэг томоохон компаниуд электрон нерв горимын машины орчуулгын системд шилжиж буйгаа зарласан юм. Электрон нерв горимын машины орчуулгын давуу тал нь орчуулгын эхийг (*source text*) орчуулах хэлний (*target language*) өгүүлбэрзүйн бүтцээр задалж, задалсан өгүүлбэрийн бүтцийг хялбаршуулах, хялбаршуулсан өгүүлбэрийг эх хэлний өгүүлбэрийн бүтэц рүү буцаан хөрвүүлэх, тухайн хэлний ямар нөхцөл, дагавар залгахыг тодорхойлох, өгүүлбэрт илүүц үгийг хассаны үндсэн дээр хоёр хэлний харгалзах утгатай үгсээр орлуулан, эцэст нь сонгогдсон нөхцөл дагаврыг зөв бичгийн дүрмийн дагуу залгаж орчуулгыг дуусгадаг байна. Иймд орчуулгын сургалтад техникийн тусгай хэл, найруулгын нэр томъёо, байнга хэрэглэгддэг хэлзүйн дүрэм, үгсийн сан, өгүүлбэрийн бүтэц, найруулгын онцлог зэргийг анхаарах хэрэгтэй. Нөгөөтэйгүүр энэ чиглэлийн хэл–найруулгын онцлог, нэр томъёо, өгүүлбэрийн бүтцийг сайтар судалж, орчуулгын хичээлийн агуулгыг баяжуулах, оюутны эрдэм шинжилгээний ажлыг энэ чиглэлд хөтлөх нь ирээдүйн сайн орчуулагч, сайн орчуулгын програм хангамж бэлдэхэд үлэмжхэн хувь нэмэртэй болов уу.

Орчуулгын програм хангамж цаг ямагт өмнөх орчуулгын түүхийг хадгалж, тэр хэрээр орчуулгын чанар нь дээшилсээр байна. Орчуулгын програм хангамж нь техникийн орчуулгын үед нэр томъёог оновчтой оноогоод зогсохгүй хэлзүй, найруулгазүйн хувьд оновчтой байхаар програмчилагдаж, орчуулах болон хэвлэх үйл ажиллагааг ч хүртэл нэгэн зэрэг хийдэг болсон байна. Техникийн гарын авлага болон бусад баримт бичгийн агуулга шинэчлэгдэж байдаг хэдий ч дийлэнх хэсэг нь агуулгын хувьд төдийлөн өөрчлөгддөггүй бөгөөд орчуулгын програм санах ойн тусламжтайгаар өмнө нь орчуулж байсан хэсгийн байршлыг тогтоож, түүнийг дахин ашигладаг байна. Гэвч машины орчуулгын системийг боловсруулах нь зардал ихтэйгээс гадна тухайн салбар орчуулах хэл бүр дээр ижил түвшний, хангалттай тооны нэр томъёоны өгөгдлийн сантай болсон байх зэрэг нарийн шаардлагууд бас байдаг.

Сүүлийн үед орчуулгын програм хангамж улам бүр боловсронгуй болж, англи, франц, герман зэрэг тодорхой хэлний хүрээнд хувийн компьютерт зориулсан хувилбарыг ч мөн зах зээлд нийлүүлээд байна. Үүнээс гадна интернет орчинд ашигладаг орчуулгын програмын хувилбар хэдийнээ та бидний хэрэглээ болоод удаж байгаа бөгөөд үүнийг дагаад онлайн орчуулгыг хянах үйлчилгээ явуулдаг бизнесийн компаниуд нэмэгдэж байна.

Дүгнэлт

Хэдийгээр машины орчуулгад шинэ дэвшилт гарсаар байгаа ч бие даасан мэргэжлийн орчуулгын програм бий болох хараахан болоогүй байна. Утга зохиол, хууль эрхзүй гэх мэт хүний орчуулгын ур чадварын үр дүнд бий болох, утгыг нарийвчлан задлах шаардлагатай эх материалын орчуулгын үед хүний орчуулга нэгдүгээрт хямд, хоёрдугаар илүү үр дүнтэй байх тул энэ төрлийн орчуулгын эрэлт

хэрэгцээ байсаар байх болно. Мөн аман орчуулгын салбарт машины орчуулга хүний орчуулгыг гүйцэх болоогүй байна. Дипломат болон бизнес яриа хэлэлцээрийн орчуулгад орчуулагчийг машинаар орлуулах боломж харагдахгүй байна.

Нөгөөтэйгүүр интернет дэх хэмжээлшгүй их цахим эх бичвэрийн орчуулгын хувьд хэдий орчуулгын чанар хангалтгүй ч хурдны хувьд машинтай өрсөлдөх зүйл алга л байна. Машины орчуулга нь хэмжээний хувьд хэт их, үг хэллэг, нэр томъёо, өгүүлбэрийн бүтцийн хувьд нэгэн жигд, дахин давтагдсан шинж чанартай, нэгэн зэрэг олон хэлэнд орчуулах техникийн баримт бичиг, бараа бүтээгдэхүүний гарын авлага зэрэг материалын орчуулгад оновчтой хувилбар байх нь тодорхой байна. Энэ мэтээр хүний болон машины орчуулга өөр өөрийн давуу болон сул талтай.

Бизнес захидал, харилцааны орчуулгад орчуулагч хүний үүрэг чухал хэвээр байх боловч хувийн шинжтэй захидал, харилцаанд машины орчуулгын хэрэглээ улам бүр нэмэгдэх хандлагатай байна. Үүнээс гадна электрон шуудан, вэб хуудас болон компьютерт суурилсан мэдээллийн үйлчилгээний салбарт машины орчуулга цорын ганц боломжит шийдэл нь байх болов уу.

Дүгнэж хэлэхэд машины орчуулгын үр дүнд орчуулгын салбарт шинэ шинэ боломжууд бий болсоор байна. Хэдийгээр машины орчуулга хүний орчуулгын түвшинд хүрэх болоогүй ч цаашид улам бүр боловсронгуй болох нь илэрхий. Нөгөөтэйгүүр сүүлийн үеийн орчуулгын програм муухан орчуулагчаас илүүтэй орчуулаад байгаа бодит байдлыг бид юу юунаас илүүтэй анхаарч, сургалтын хөтөлбөр, хичээлийн агуулга, заах аргазүйгээ шинэчилж байх нь орчуулгын чиглэлээр сургалт, судалгаа явуулж буй хэн бүхний хувьд чухал билээ.

Ашигласан эх сурвалж

1. https://en.wikipedia.org/wiki/Google_Translate#cite_note-GT_Turovsky_2016-2
2. Barak Turovsky, Found in translation: More accurate, fluent sentences in Google Translate, 2016
<https://blog.google/products/translate/found-translation-more-accurate-fluent-sentences-google-translate/>
3. John Hutchins, The development and use of machine translation systems and computer-based translation tools, 1999, Beijing, China
<http://hutchinsweb.me.uk/Beijing-1999.pdf>
4. Wheeler, Peter J. "Systran". In: Machine Translation Today: The State of the Art. Ed. by Margaret King. Edinburgh: Edinburgh University Press, 1987
5. Elliston, J.S.G. (1979) "Computer-aided translation – a business viewpoint." Translating and the Computer: proceedings of a seminar, London, 1978
6. Англи-Монгол орчуулгын онлайн системийн танилцуулга, 2010
<https://www.slideshare.net/jamuh/ss-6005596>

КОМПЬЮТЕР, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИТОЙ ХОЛБООТОЙ ЗАРИМ НЭР ТОМЬЁОНЫ ОРЧУУЛГЫН АСУУДАЛД

Н.Оюунзаяа

Шинжлэх ухаан, нэр томъёоны орчуулга хийх нь энгийн, утга зохиолын орчуулга хийхээс зарим талаар ялгаатай байдаг. Учир нь орчуулагч орчуулгын онолын мэдлэг, гадаад хэл, эх хэлний мэдлэг, түүнийгээ ашиглах чадвараас гадна тухайн салбар шинжлэх ухааны мэдлэгтэй байхыг шаарддаг онцлогтой юм. Шинжлэх ухааны эхийн орчуулагчийн гол зорилго нь аливаа мэдээллийг тов тодорхой, яг таг, нарийн нягт, уран сайхны хэтрүүлэггүй, товч тодорхой байр суурийг баримталсан байх хэрэгтэй. Био-Анагаах ухааны эрдэмтэн Бетани Тиверж (2002) шинжлэх ухааны орчуулга хийхдээ дараах зарчмуудыг баримтлах хэрэгтэй гэж дүгнэжээ. Үүнд:

1. Зорилтот уншигчдад зориулан ажиллах
2. Зохиогчийн хийсэн сонголтыг харгалзан үзэх
3. Ишлэл, ном зүйг зүй зохистой хэрэглэх
4. Тухайн салбар шинжлэх ухааны талаар гүнзгий ойлголттой байх
5. Шинжлэх ухааны бичиглэлийн хэв маяг, төрлийг мэддэг байх
6. Бүтээлч асуулт өөртөө тавьдаг байх
7. Хэвлэлтийн шалгуурыг хангасан байх
8. Сүүлийн үеийн туршлагуудтай танилцсан байх
9. Хийсэн ажлуудаа бусадтай хуваалцаж туршлага солилцох гэсэн байна.

Компьютер, мэдээллийн технологийн салбар асар хурдацтай хөгжиж байгаа өнөө үед энэ шинжлэх ухаантай холбоотой үг хэллэг, ойлголт, нэр томъёог орчуулах ажил орчуулагчдаас ч бас их хурд, цаг үеэсээ хоцрохгүй байхыг шаардаж эхэлжээ. Энэ их хурд нь өөрөө мэргэжлийн орчуулагчид, хэл шинжээчид, хэл бичгийн эрдэмтэд болон тухайн салбар шинжлэх ухааны эрдэмтэд, экспертүүдийн хооронд аливаа нэр томъёог орчуулах уу эс орчуулах уу гэх ойлголтын зөрүүг үүсгэж байна. Мэргэжлийн олонхи орчуулагчид, хэл шинжээчид, хэл бичгийн эрдэмтэд эх хэлээ цэвэр байлгахыг зорьж аль болох нэр томъёог орчуулах, үгийн сангаас дүйцэх үг хэллэгийг олохыг шаарддаг байхад тухайн салбар шинжлэх ухааны эрдэмтэд, экспертүүдийн дийлэнх нь нэр томъёог орчуулах, үгийн сангаас дүйцэх үг хэллэгийг олж нутагшуулах, хэрэглээнд оруулах асуудлыг цаг үрсэн асуудал гэж үзэх хандлагатай ажээ. Тэдний хувьд тухайн сэдвийн агуулга, ойлголт болон зорилтот уншигчид чухал байдаг бол орчуулагчид, хэл шинжээчдийн хувьд нийт олон нийтэд хүртээмжтэй, ойлгомжтой байх талаас ханддаг байна. Асуудлыг уг үүднээс нь харвал шинжлэх ухааны орчуулгыг хэлний эрдэмтэд, орчуулагчид их хийж байна уу, мэргэжлийн салбарынхан их хийж нийтэд түгээж байна уу гэдгээс шалтгаалж нэр томъёоны орчуулгын асуудлууд үүд үүсэж байна.

Компьютер, мэдээллийн технологийн салбарын хувьд ойлголт, ухагдахуун, нэр томъёо, тоног төхөөрөмж, хэрэглээ нь харьцангуй олон нийтэд хүрсэн, хүн бүр хэрэглэдэг, ярьдаг, бичдэг онцлогтой. Тиймээс энэ салбарын нэр томъёоны орчуулга олны анхаарлын төвд оршдог агаад санал шүүмжлэлийн бай болдог. Дээр дурьдсан цаг хугацааны хавчигдмал байдал, технологийн их хурд, ухагдахууны шилжилт нь зарим нэр томъёог орчуулах боломжгүй байдалд оруулж байгааг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй.

Би энэхүү ажлаа Ч.Ганхуягийн “Англи –Монгол толь бичиг” 2010, Ш.Янсанжав, Я.Батмэргэн нарын “Computer Dictionary English –Mongolian” 2007 толь бичгүүд дээр үндэслэн хийлээ. Ерөнхийдөө компьютер, мэдээллийн технологийн нэр томъёог дараах аргуудаар орчуулах хандлага зонхилдог:

1. Авиачилан галиглах (transcription)

Display - дисплэй, algorithm- алгоритм, processor-процессор, file-файл gigabyte-гигабайт, megabyte –мегабайте

Тайлбар: Авиачилан галиглан орчуулах арга нь монгол хэлэнд утгыг нь буулгадаггүй бөгөөд тухайн үгийн дуудлагыг кирил бичгэнд хөрвүүлсэн үг зээлдэх арга юм. Монгол хэлний үгийн баялгийг нэмэгдүүлж байгаа эсэх нь маргаантай боловч хэрэглээнд орж нутагшаад байна.

2. Үсэгчлэн галиглах (transliteration)

Function- функц, chip- чип, бичил схем computer terminal-компьютерийн терминал computer test – компьютерийн тест, computer tomography- компьютер томограф

Virus – вирус, graphic-график, computer system analyst – компьютерийн системийн аналит

Тайлбар: Үсэгчлэн галиглах арга мөн адил монгол хэлэнд утгыг нь буулгадаггүй бөгөөд тухайн үгийн бичиглэлийг кирил бичгэнд хөрвүүлсэн үг зээлдэх арга юм. Монгол хэлний үгийн баялгийг нэмэгдүүлж байгаа эсэх нь маргаантай боловч хэрэглээнд орж нутагшаад байна. Үүний хажуугаар зарим нэр томъёоны орчуулга нь зэрэгцээд хэрэглэгдэж байна. Жишээ нь: Display- дэлгэц, computer – цахим тооцооны машин

3. Нутагшуулах (naturalization)

Technology - технологи, technologist - технологич, technological - технологийн computer – компьютер, компьютержүүлэх, компьютержсэн program – програм, програмжуулалт, програмжсан , програмжлагдсан

Тайлбар: Дээрх хоёр аргаар орж ирсэн үгүүд хэрэв хэрэглээнээс гарахгүй бол нутагших үйл явц руу орно.

4. Шинэ үг зохиох (neologism)

Hardware - техник хангамж, software - програм хангамж, earphone – чихэвч cybernetics - залуур зүй

Тайлбар: Энэ нь хуулбарлан орчуулах аргын дараа орох ихэд шилэгдсэн арга юм. Гэвч шинээр үг зохиох, хуучин үг хэллэгийг шинэ агуулгаар баяжуулан хэрэглээнд оруулах үйл явц нь цаг хугацааны хүчин зүйлээс шалтгаалдаг.

5. Хуулбарлан орчуулах арга (calque)

Back up store – нөөц хадгалуур, closed network – хаалттай сүлжээ, vertical scroll bar - босоо шугам, website - сүлжээ байрлал, error voltage – алдаатай цахилгаан хүчдэл

Хагас хуулбарлах арга (Half calque)

All files – бүх файл, information bit - мэдээллийн бит, microchip - бичил чип

Тайлбар: Хамгийн түгээмэл, хамгийн шилэгдсэн арга бөгөөд учир нь үгийн толгой үгээр шууд буулгаж орчуулсан байдаг тул эргээд нөгөө үгээ англи хэл рүү буулгахад үг оноолт таарах магадлалтай.

6. Тайлбарлан орчуулах арга (explanatory translation)

Clipboard – хуулах зөөх зүйлийг хадгалж, гаргаж тавих зориулалттай түр санах ой

Customize – тохируулга буюу сонголт хийх

Alignment - зэрэгцүүлэх буюу тэгшлэх

Zoom - Хуудсыг хувь өгч өсгөж харах

7. Үүнээс гадна товчилсон үгнүүдийг шууд хэрэглэх хандлагатай байна.

CPU, ERIC, RAM

Аливаа техник технологи хөгжиж үг хэллэг шинэ агуулгаар баяжихын хажуугаар урьд нь хэрэглэж байсан технологитой холбоотой үгс хэрэглээнээс гарч хэрэглэгдэхээ больж байна. Жишээлбэл: floppy disc - уян диск, Pentium –(Лонгманы толинд маш хурдан процессор гэж оржээ), tube – зурагтын ламп аналог систем гэх мэт.



Нөгөө талаар нэр томъёог хэт орчуулах гэж оролдох нь зүй бус, алдаа мадагтай орчуулга руу түлхэх аюултай. Жишээ нь: “cellar” гэх үгийг шуудайны хадгалуур, ceramic metal – төмөржүүлсэн ваар, jack – унтраалга, савхан шонгийн нүх, jack socket - савхан шонгийн хавьтлын нүх гэх мэтээр орчуулжээ.

Дүгнэлт



- Аливаа нэр томъёог аль болох эх хэл дээр орчуулах хэрэгтэй.
- Бүх нэр томъёонд үг оноох нь боломжгүй /өөрөөр хэлбэл хүч хүрэхгүй буюу технологийн хөгжлийн хурдыг гүйцэхгүй/
- Шинэ утга /үг/ зохиох, үүсгэх
- Түүнийгээ нутагшуулах, олныг хамруулах
- Өөр ирээдүйд чиглэсэн хандлагаас харах хэрэгтэй
- Хэл баяжна, соёл харилцан нэвтрэлцэнэ

Ном Зүй

1. Ч. Ганхуяг “Англи –Монгол толь бичиг” 2010, Улаанбаатар, Монгол Улс
2. Ш. Янсанжав, Я. Батмэргэн нар” *Computer Dictionary English –Mongolian*” 2007, Улаанбаатар, Монгол Улс
3. Адъяа.О, Дашидаваа.Д Орчуулгын гарын авлага УБ., 1983 он
4. Аким.Г, Орчуулгын санг уудлахад, 1984 он
5. Аким.Г, Орчуулгын санг уудлахад, 2009 он
6. Гинзбург.Л, Вначале было слово /мастерство перевода/ М.,
7. Гүрбазар.А, Орчуулгын онол, дадлагын үндэс УБ., 1996 он
8. Гэндэндарам.Ж, *Anthology of Mongolian Poetry* УБ., 2007 он
9. Дамдинсүрэн.Ц, *Selected short stories*, 1978 он



ОРЧУУЛГЫН ШИНЖИЛГЭЭ



“УТГЫН ТАЯГ”-ИЙГ ТУЛЖ “ЭРДЭМИЙГ ЦЭНГЭЛ БОЛГОХ”-ЫН ҮҮДИЙГ НЭЭСЭН НЬ

(Күнзийн “Шүүмжлэл өгүүлэл”-ийг М.Чимэдцэеэгийн
дуун хөрвүүлсэн чадлыг толилуулахуй)

Го.Аким¹

Үг, утгыг нээвээс болох буюу
КҮНЗ

Суравч эс сэтгэвээс төөрөлдмүй. Сэтгэвч эс сурваас мунхармуй хэмээжээ. Сурах, сэтгэх хоёрыг утгын нэгэн уяанд зангидсан ч арга билгийн аралд салгасан энэ сургаалыг уншин сэрхийвэй. Арга билиг буюу инь янь! Хятадын эртний гүн ухаанаар *инь* (болдогийн ар) нь сүүдэр, хар, хүйтэн, зориг зэрэг ухагдахууныг илэрхийлнэ. *Янь* (болдогийн өвөр) нь гэрэл, цагаан, халуун, ухаан зэрэг утгыг илтгэнэ. Күнз энэ тухайтад айлдахдаа: “Хаан хүн бошиг зарлигаа жилийн дөрвөн цаг лугаа уялдуулан айлдах хэрэгт болой, чингэхгүй аваас тэнгэрийн таалал ямар болох нь вэ хэмээн хүлээж суухаас өөр аргагүй болмуй...Тийнхүү арга билиг нь жилийн дөрвөн улирлын аясыг зохицуулагч ертөнцийн гол зарчим даруй мөн болой. Тэр ч байтугай гэсгээн цээрлүүлэхийн ёс суртгхууны үр нь цаг улирлын ээлжлэх лугаа холбоотой бөлгөө. Хэрэвзээ тэр нь цагтайгаа таарч байвал тус өгнө, тохирохгүй байваас ус л болно” хэмээжээ. Дуун хөрвүүлэгч, хятадач М. Чимэдцэеэгийн орчуулсан Күнзийн “Шүүмжлэл өгүүлэл” ном чухамхүү энэ арга билгийн аралд уяат бөлгөө. Арал гэдэг салгуу боловч холбоотой биш үү! Энэ тухай үл өгүүлэн өгүүлэхэд, Күнзийн “Шүүмжлэл өгүүлэл”-ийг ерөнхийдөө шүлэглэсэн хүүрнэл (проза в стихах) –ийн төрөлд хамааруулж бүрнээ болох. “Күнз яруу үгээр ярихуйд “Шүлэглэлт ном”, “Засагт ном”-оос унших агаад ёслол үйлдэхүйд мөнөөхөн яруу үгээр илтгэх бөлгөө” гэснийг санагтун. Чингээд Артур Вaleyгийн англи руу орчуулсан нэгэн бадгийг сийрүүлсү:

Tsu-hsia said, a man who
Treats his betters as betters
Wears an air of respect,
Who into serving father and mother
Knows how to put his whole strengtch,
Who in service of his prince will lay down his life,
Who in intercourse with friends is true to his word -

¹ МУ-ын СГЗ, дуун хөрвүүлэгч, доктор

Others may say of him that he still lacks education, but I for my part should certainly call him an educated man.

Тэгвэл Л.Переломовын орос руу орчуулсныг сонирхуулсу:

Цзы Ся сказал:

-Если кто-то в отношениях с женой ценит её моральные качества и не придает большего значения внешности, исчерпывает все свои силы, служа родителям, не щадит своей жизни, служа правителю, правдив в отношениях с друзьями, то хотя о нем и говорят, что он не обладает ученостью, я непременно назову его образованным.

Одоо Чимэдцэегийн орчуулгыг толилуулсу.

Зы Шя² өгүүлрүүн: *Ухаант мэргэнийг хүндлэн, ужид өнгийг олтгойлох, эцэг эхээ тойлохуйд энэ биеэ үл гамнах, эзэн ноёнд шадарлахуйд амь насаа зольж чадах, анд нөхөр лүгээ ханилахуйд ам хэл андуугүй бат, ийм хүмүүн хэдийвээр эрдэм номд гэгээрээгүй боловчиг би бээр түүнийг эрдэмт хүмүүн хэмээн үзмү.*

Уг эх айзамтай гэдэг нь англи орчуулгыг бадагласнаас харагдана. Орос орчуулгад энэ нь онхи байхгүй. Тэгвэл Чимэдцэегийн орчуулгыг бадаглах аваас шүлэг болчихно. Тэрвээр *ухаант мэргэн – ужид өнгө, эцэг эх –энэ бие, эзэн ноён – амь нас, анд нөхөр – ам хэл* гэх зэргээр утгат хэсгүүдийн эхийг авиа ижилсүүлэн өгүүлбэртээ айзам оруулсан байх юм. Өөрөөр хэлбэл толгой холбочихсон хэрэг юм. Ц.Дамдинсүрэн абугай “Монголын үргэлжилсэн үгийн зохиолд шүлэг болохын үүсэл байна. Энэ үүсэл нь аль вэ гэвэл толгой холбох ёс болно” гэж айлджээ. Дамдинсүрэн гуайн айлдсан нь Чимэдцэегийн дуун хөрвүүлгээр нутлагдаж байна гэж хэлэхэд алдас үл болох. Мөн “сайн хүүрнэл зохиолын³ үндсэн шинж аваас амьсгалах лугаа адил амьд бөгөөд айзамтай байхад оршино” гэж Гурмоны⁴ хэлсэнтэй ч дүйж байх шиг.

Чимэдцэегийн орчуулгыг бас нэгэн орчуулгатай харгуулмаар санагдав. Энэ нь Түмэдийн Галсангийн орчуулга болно. Түмэдийн Галсан бол “Монгол үсгийн бүгд тайлбар бичиг”-тээ “Зарим монголчууд малгай өмсмүй, будаа хиймүй гэгч үгийн монгол үгийг хятад үгэнд нийлэмжгүй хэмээн зориуд хэлж, малгай зүүмүй, будаа засмуй хэмээн хэлж, сайхан хэлмүй хэмээсээр харин чухам монголын уг үгээ орхижээ. Утгагүй буруу хэлснээ зөв хэмээн санаж явагчид өөрөө хятад ч бус, монгол ч бус бэсрэг болсноо эс мэдэжүхүй... Үл нийлэгч бүгд үгсийг халж засахыг хүсэх хэрэггүй. Үгээн голж жигшээд аяндаа үгээр үгүйрэхүйд хүрмүй заа” гэж сэтгэл

² Күнзийн шавь. “Хэв дундын ёсон” номыг зохиожээ. Уг ном М.Чимэдцэегийн орчуулгаар монгол уншигчдын хүртээл болсон болно.

³ Проза гэдэг орос, prose гэдэг англи нэр томъёг бид үргэлжилсэн үгийн зохиол гэж гурван үгээр орчуулаад сурчихаж. Миний хувьд хүүрнэл зохиол гэвэл арай товч бөгөөд тод мэт. –Г. А.

⁴ Реми де Гурмон (1858-1915) – Францын зохиолч, уран зохиолын онолч.

түгшин бичиж байсан тэр мэргэн мөн. Саяын дээр ишилсэн өгүүлбэрийг тэрвээр орчуулсан нь, “Зы Шися өгүүлрүүн: *“Сайныг сайшаахуй дагаан өнгө дүр дуртай бээн шилжүүлэх ба эцэг эх юугаан ачлахуй дур хүч бээн гүйцэтгэн чадах ба эзэн иезн үйлчлэхүй дүр бие бээн гээх бээр болгон чадах ба нөхөр хань лугаа нөхөрлөхүй дүр үгс итгэмжтэй болох балбаасу хэдий бээр бичиг эрдмийг эс сурсан ч болов би эрх үгүй үүнийг сурсан хүмүүн хэмээмүй”* гэжээ. Урианханы Чимэдцэеэгийн орчуулга, Түмэдийн Галсангийн орчуулга хоёр утга үнэхээр ижил нь харагдаж байна. Гэхдээ орчуулгын урын хувьд Чимэдцэеэ “шагласан” бол Галсан “хавсан” байна.

Цааш нь Чимэдцэеэгийн орчуулгад байгаа “ужид өнгийг олтгойлох” гэдэг үгийг авъя. Бүсгүй хүний өнгө зүсэд үл шунах гэсэн утга бүхий энэ хэллэгийг англи орчуулгад ор тас орхисон бол оросоор нь болохоор “хэрвээ хэн нэгэн эхнэртэйгээ харьцахдаа түүний ёс суртахууны чанарыг үнэлээд, өнгө зүсийг нь ихэд үл бодох” гэх ухааны юм орчуулжээ. Энэ нь үнэндээ уг эхийн утгыг даан ч гүүрээгүй хэрэг юм. Орчуулагч тийн ойлгоогүйн үнэнээ хүлээхдээ: “Энэ өгүүлбэрийг ойлгоход нэн төвөгтэй...” хэмээжээ. Тэгвэл Галсан *өнгө дүр дуртай бээн шилжүүлэх* гэсэн нь мөнөөхөн утгыг дэндүү сайн ойлгосных гэлтэй. Харин молхи би Чимэдцэеэгийн *ужид* гэсэн үгэнд ялихгүй эргэмлэнэм. Ужид гэдэг нь ужид самуун гэдэгтэй хорших нь элбэг агаад муу утгатайгаар хэлэгддэг. Гэтэл өнгийг ужид гэхээр муу өнгө, муухай өнгө гэсэн утга илэрхийлж болзошгүй. Монгол хэлний **өнгөнд унах, өнгөнд дурлах, өнгөнд тачаах** гэдэг гэдэг үгс лугаа хоршиж байгаа өнгө бол бүсгүй хүний царай зүсний сайхныг заасан утгатай гэж мунхагланам. Харин өнгөнд унаж, өнгөнд тачааж байгаачуул нь л тааруухан утгатай болж сонсогдох мэт. Тэр байтугай өнгө гэдэг үг бүсгүй хүнийг ч шууд заах нь буй. Тухайлбал өнгө мөнгө гэхэд өнгө гэдэг нь царайлаг эмэгтэй хүн гэсэн үг. **Өнгө мөнгөнд шунах** гэхээр бүсгүй хүн, мөнгө төгрөг нь муу бус эдгээрт шунаж байгаа нь л тааруу хэрэг гэсэн утга буй. Иймд эрхэм дүү үүнийг болгоон тунгаах буй заа.

Манай дуун хөрвүүлэгч Күнзийн эгшиглүүлэн өгүүлсэн өвөрмөц найруулгыг орчуулгадаа бүрэн гаргасан гэж хэлэхэд хилс огт үл болох. Тухайлбал:

Сэнтийд залрахуйд алжаалыг умартах, сэдэж гүйцэлдүүлэхэд шударгыг баримтлах... Манай дээдсийн тун ч тунгаагууштай энэ сургаалыг Чимэдцэеэ орчуулахдаа *сэнтийд залрах, сэдэж гүйцэлдүүлэх* хэмээн толгой холбосноос гадна үгийг хоршин монгол найруулгын сондгойруулахгүй зарчмыг чадмаг хэрэглэсэн байна. Ренчин багштан бичихдээ: “Монгол хэлний найруулгазүйд хоршоо үг, хоршсон аливаа үг хэрэглэхдээ өгүүлбэрийн дотор хэд хэд тохиолдвоос сондгойруулахгүйг тун эрхэм болгодог байлаа. Тэр шаардлагыг монгол хэлний яруу сайхан найруулганд тун зохимжтой зүйл гэж үзэх нь зүйтэй бөгөөд хэлний боловсролыг зузаадах бүр, бичгийн боловсролтой хүн эрхэмлэн үзвэл зохих зүйл байнам” гэжээ. Үнэхээр бичгийн боловсролтон хүн бүрийн эрхэмлэвээс зохилтой эл сондгойруулахгүй буюу тэгш хэмийн зарчим өдгөө манай бичээчингүүдийн найруулгад огт байхгүйг цухас онцлоод цааш өгүүлсү.

Жигүүрт шувуу үхэхийн цагт гунганах дуу нь гаслантай, журамт хүмүүн эцэслэхийн цагт хэлэх үг нь уяралтай.

Энд Чимэдцээ орчуулагч толгой холбоод зогсоогүй дотоод холбоцыг ашиглаж, тэр байтугай сүүл холбон орчуулгаа айзамтай болгосон нь харагдана. Энэ нь “Шүлэглэлт ном”-оос ишилсэн зүйл гэх тул шүлэг байх ёстой нь ч дамжиггүй. Тиймээ, Чимэдцээгийн орчуулгыг уншихад түгдрэх, түг яг хийхийн зовлон байхгүй, ганцын төдий ч боргиогүй горхийн усан гялтагнан мэлтрэн урсах шиг л болно. Ийм орчуулгыг уншихад үнэхээрийн урамтай. Тэгвэл Галсангийн орчуулсан нь, *жигүүртэн үхэхээ шахмагц түүний донгодох ч уяралтай болох бөгөөд хүмүүн үхэхээ ойртмогц түүний үгс ч сайн болмуй хэмээжээ.* Энд Чимэдцээгийн орчуулга мөн л урын хувьд мэтгэж чадсан нь илт.

Английг сийрүүлсү.

When bird is about to die, its song touches the heart. When man is about to die, his words are of note. Үүнийг үгчилбээс шувуу үхэх болохдоо дуу нь зүрхэнд хүрдэг. Хүн үхэх болохдоо үг нь зөөлөн аястай болдог гэх маягийн бууна. Энд англи орчуулагч **-t, -te** гэсэн үгсээр сүүл холбосон нь ажиглагдана. Яагаад **-te** гэж байхад сүүл холбосон гэж хэлж байна вэ гэвэл дуудлагад **-e** нь уншигддаггүй. Чингэхлээр англи орчуулагч ч шүлэглэх гэсэн нь тодорхой. Галсангийн ч, Вaleyгийн ч орчуулгаас үзсэн, уг эхэд хүн л байгаа бололтой. Гэтэл Чимэдцээ **журамт** гэсэн үг нэмсэн байна. Учир нь гагц хүн гээд буулгачихад, өгүүлбэр сондгойрох гээд байсан байна. Хоёрт, **журамт** гэсэн тэрхүү үгийг нэмснээр айзам цохилт таараад явчихаж байна. Мөн жигүүрт гэдэгтэй толгой холбоход ч тус болсон байна. Ийнхүү ганц жигүүрт гэдэг үг олон талын ач холбогдолтой байжээ. МГО-д “нэмэх хэрэгтэй нүгүүдийг нэмэн үйлд” гэсэн зарчимд цав хийтэл тохирч байна.

Орос орчуулгыг авч үзсү. Птицы перед смертью жалобно кричат, люди перед смертью о добре говорят /шувуу үхэхийнхээ өмнө гаслантайгаар хашгардаг. Хүн үхэхийн өмнө сайн буяны тухай ярьдаг/ Эдгээрийг нарийвчлан тайлбарлалтгүйгээр Чимэдцээгийн орчуулгатай харьцуулаад үзчихэд чухам ямар байгааг уншигч абугай өлхөн ухах буй заа.

Чигч шударга хүмүүнийг өргөж, цалгар гажуу хүмүүний дээр тавигтүн. Тэгвээс эгэл олон дагаюу. Цалгар гажууг өргөж, чигч шударгын дээр тавиваас эгэл олон эс дагаюу.

Манай эгэл олон цалгар гажууг чигч шударгын дээр тавьчихаад өөрсдөө зовж байгаа өнөө үед тэдний оюуны сүвийг нээгдүүлмээр энэ сургаалын орчуулгад мөн л авианы төстэйг харгалзан толгой холбосныг дурдаад, англи орчуулгыг нь сийрүүлсү.

If you raise up the straight and set them on top of crooked, the commoeners will support you. But if you raise up the crooked and set them oh top of the straight, the commoneners will not support you.

Орос нь гэвэл: Если возвышать прямых и ставить их над кривыми, то народ сам подчинится. Если возвышать кривых и ставить их над прямыми, то народ не подчинится.

Харин эдгээр орчуулгууд хоорондоо бараг үг үгээрээ дүйж байгааг үзэж болно.

Чингэхлээр Чимэдцээгийн орчуулга ямар болж вэ гэдгийг бүрнээ цэгнэж болох талтай. “М.Чимэдцээгийн орчуулгыг нягтлан үзэхүл уг эхийн үгэнд хэт баригдах, эсхүл хэт холдон хөндийрөх хоёр зүйл хэтийдлээс ихэд болгоомжилсон байхын зэрэгцээ онолтой, номтой хүний шийр зааж, “Шүүмжлэл өгүүлэл”-ийн холбогдол бүхий арваад ном, тайлбар сэлтийг зэрэгцүүлэн үзэж, хашир хандсан, эртнийхээ бичгээр байгаа нэг өгүүлбэрийн, нэг үгийн утгыг хятадын эрдэмтэд өр өөрөөр тайлсны хамгийн гол дунджийг олох гэж хичээсэн, зарим тайлбар нь эртнийхээ утгаас гажсан, хэт эдүгээчилсэн зэргийг анзааран олж, уг эхийнх нь язгуур утгыг түшиж, үг оноосон...” гэх буюу “Хэдэн мянганы тэртээ бичигдсэн суут их мэргэний билиг сургаалын зүйлийг хэдийвээр өнөө цагийн уншигч олноо хүргэж байгаа ч гэсэн, наанадаж өнө эртнийх нь өнгө аясыг бага боловч хадгалахын учир...сонгодог бичгийн хэлний үг, найруулгыг зохистой газар нь аль болох хэрэглэхийг хичээсэн...” хэмээн хятад хэлэнд шарласан багш Ц.Базаррагчаа агсан үнэлжээ.

Чимэдцээ өөрөө бичихдээ: “Ийн орчуулахдаа нэг талаар утгын таягийг тулах зарчмыг аль болох барихыг хичээж, нөгөө талаар уг хятад эхээс аль болох холдуулахгүйг бас хичээнгүйлсэн болно” гэж өөрийн дуун хөрвүүлсэн аргыг дурджээ. Тэгвэл утгын таягийг тулсан нэг сонин жишээ гэвэл: *Тэвдэж явахуйд тэвнээр ч болов туслагтун, тэнхээтэй явахуйд тэмээгээр туслаад ч юуны хэрэг гэжээ.* Чухамхүү энэ нь цэвэр монгол цэцэн үг юм. Тэгвэл англи орчуулгыг сөхье.

“A gentleman helps out the necessitous, he does not make the rich richer still” гэсэн байна. Тэгвэл оросоор ямар буй. “благородный муж помогает нуждающимся, но не обогащает богатых”

Хоёр орчуулгын алинд нь ч цэцэн үг алга, энгийн үгээр л буулгасан зүйл байна. Магадгүй, хятад эхэд нь хэлц байсан байж мэдэх ч би гүүрэхгүй, байхгүй байсан ч гэсэн чингэж орчуулж болох бүрнээ талтай. Энэ нь уншигчаа бодох, мөн сэтгэгдэл ойрхон болгох гэсэн зарчимууд бий. Өөрт тохиолдсон нэгэн жишээг далимд дурдсу. Тэртээ өнгөрсөн зууны жараад ондсон. Зөвлөлтийн коммунист намын дарга Л.Брежневийн нэгэн бүгд хурал дээр тавьсан илтгэлийг бид орчуулж билээ. Чингэхэд *молочные реки, кисельные берега* гэсэн нэгэн орос цэцэн үг тааралдсныг бид *тосонд умбаж, торгонд хөлбөрөх* гэж орлуулан орчуулж билээ. Тэгээд уг орчуулгын товхимолыг би гэртээ авчирч, хадам эцэгтээ өгвөл өвгөн түүнийг уншиж байгаад гуяа алгалан “энэ Брежнев дарга мундаг хэлж шүү” гэж байна. Юу? гэж намайг асуувал тосонд умбаж, торгонд хөлбөрөх гэж мөн ч онож

хэлж шүү гэдэг байгаа. Хэрэв *сүүн гол, жимсэн эрэг* гэж орчуулсан бол тэгэж сэтгэл хөдлөх юмгүй, энэ нь юу гэж байгаа юм бол гэж гайхсхийгээд л өнгөрөх байсан байх. Энэ нь юу харуулж байна вэ гэвэл уншигч уншиж байгаа зүйлийнхээ утгын авцалдааг л харахаас бус, орчуулагч яаж орчуулж вэ гэдгийг анзаардаггүй, өөрийн сэтгэлд ойрхон үгийг л сэтгэлээрээ хүлээж авдаг гэдгийг үзүүлж байгаа хэрэг юм. Уг орчуулга үнэхээр уншигчийн сэтгэлд ойртсон байж л дээ. Угтаа орос цэцэн үгийг орос хүн уншаад ямар сэтгэгдэл төрөх вэ, монголоор монгол цэцэн үгийг уншаад яг тийм сэтгэгдэл төрж байна гэсэн үг юм. Сэтгэгдэл ойр болох гэдэг энэ. Зарим онолчид орлуулах аргыг орчуулгыг эхээс нь холдуулах муу талтай хэмээн шүүмжилдэг хэдий ч сэтгэгдэл ойрхон болгохын тухайтад үүнээс шилдэг нь үгүй гэлтэй.

Чимэдцээ орчуулгадаа монгол хэлнийхээ үгсийн сангаас үг шүүрдэн оноохдоо ойролцоо утгатай үгүүдийг чадварлаг сонгосон нь бахдалтай. Өөрөөр хэлбэл нэг үгийг нэг дор хоёр хэрэглэсэн байвал ойролцоо утгат үгийг олж шигтгэж өгсөн, үүнд: **өмхөрсөн** мод, **өгөршсөн** хана, шувуу **үхэх**, хүн **эцэслэх**, эзэн ноёд **шадарлах**, анд нөхөр лүгээ **ханилах** гэх мэт. Гэтэл англи орчуулгад **die**, орос орчуулгад **смерть** гэсэн байх жишээтэй.

Өгүүлэлийнхээ эхэнд арга билгийн тухайтад онцолсон минь учиртай. *Гагцхүү асар дээд мэргэд, адгийн доод тэнэгийг л өөрчилж үл болью* гэх буюу *хүмүүний зан чанар ойр, заншил дадал хол* гэх. Ийнхүү асар мэргэнийг адгийн тэнэгт сөргүүлэх, холыг ойрд харшуулах гээд арга билгийн уяанд зангидсан сургаал “Шүүмжлэл өгүүлэл”-д арвин бөгөөд Чимэдцээ чухамхүү үүнийг онож гаргаснаараа Күнзийн өвөрмөц найруулгын ч судсыг оносон хэрэг мөн болой.

Арван годгор барьж очсон хүнд эрдэм заахаас цааргалаж үзээгүй Күнз мэргэн эрдмийг цэнгэл хэмээн үзэж байжээ. Күнз “эрдэмийг сурсан хойно эрхбиш үргэлжид давтан сурваас цэнгэл бус уу”, “эрдмийг цэнгэл болгогтун” гэх зэргээр чухамхүү цэнгэл хэмээн үздэг эрдмээ эл номдоо шингээснийг Чимэдцээ гавъяат аялгуу сайхан монгол хэлээрээ асар бахдалтайгаар нээн чадаад, хотол олон монголчууддаа эрдмийн цэнгэл эдлүүлэхийг зорьсон тухайтад өгүүлэхүй ийм буюу. Күнз үг, утгыг нээвээс болох буюу гэж цэцэлсэн нь аргагүй л үнэн ажгуу. Үгүй нээрээ, Күнз юу л гэж дэгэс хэлэх билээ дээ!

Эцэст нь Чимэдцээ маань Хятадын уран зохиол орчуулдаг гадаадын дуун хөрвүүлэгч нарт олгодог эрхэм шагналыг хүртсэн нь энгийн хэрэг бус аа! Базаррагчаа гавъяат ч шавьдаа “Орчуулга хэмээх “тамын ажил”-д чөмгөөн дундартал зүтгэсэн хүмүүн хэт нь диваажингийн орноо заларч, мөнхийн хутаг олдог юм гэсэн шүү” гэж захьсан нь ч багш хүний шавиараа бахархсан, авъяасыг нь бахдсан чин сэтгэлийн үг гэдэгт бас эргэлзэх зүйлгүй ажаам.

Ашигласан ном зохиол

1. Күнз. **Шүүмжлэл өгүүлэл**. Хятад хэлнээс орчуулсан Мэнэрэлийн Чимэдцэе. УБ., 2013.
2. Confucius. **The Analects**. Translated by Arthur Waley. Wordworth Editions Limited, 1996.
3. Л.С.Переломов. **Конфуций. Лунь Юй**. Москва. 1998.
4. Б.Ринчен. **Сондгойруулахгүйг эрхэм болгохуй**. Монгол бичгийн хэлний зүй. IV дэвтэр. УБ., 1967. “Марк Твений минь махыг идэж дээ” Эмхэтгэл. УБ., 1991.
5. Ц.Дамдинсүрэн. **Олег цэцний дууллыг орчуулсан минь**. Орчуулах эрдэм. I дэвтэр. УБ., 1972.

МНТ-Д БУЙ ЗАРИМ НАНГИАД ХҮНИЙ НЭРИЙН ФРАНЦ ОРЧУУЛГА

Н. Мөнх¹

Товч утга: Бид МНТ-ыг нэгбүрчлэн шүүж үзээд нийт 455 хүний түүвэрлэсэн. Үүнээс бидний олж чадсанаар 15 нэр нь нангиад хүний нэр байна. Бид эдгээр нэрийг франц хэлнээ хэрхэн орчуулсан байгааг нь орчуулгын ангилал хийхэд: 7 нэрийг үгчилж, 5 нэрийг үсэгчилж, 3 нэрийг франц хэлтэн уншигчдад ойлгомжтой болгох үүднээс тус тус тайлбарлан орчуулсан байна.

Түлхүүр үг: МНТ, франц, орчуулга, хүний нэр, нангиад

“Монголын нууц товчоон” нь дундад эртний монгол хэл, уран зохиол, хэл-соёлыг судлахад нэн чухал байр эзэлдэг. Оноосон нэр судлалын тухайд ч энэ туурвил нь үнэлж баршгүй баримт, эх сурвалж юм. МНТ-ы хүний нэр судлалд гүйцэд сайн судлагдаагүй, маргаантай зүйл их байдаг: нэрийн бичлэг, утга, гарвали, бүр тэр ч байтугай хүний нэрийн тоог өнөөг хүртэл гүйцэд гаргаж, нэг мөр болгож чадаагүй байгаа (430-455). Үүнээс гадна МНТ-ы монгол эхийг хятад үсгээр буулгах, хөрвүүлэх явцад ханз үсгийн дуудлага, бичлэг зэргээс үүдэн нэрийн гарваль нь монгол үг биш мэт болсон нэр нэлээд байдаг гэж эрдэмтэн Н. Жамбалсүрэн үзсэн байдагтай бид санал нэг байна.

Бид МНТ-ы 1994 оны франц орчуулгад тулгуурлан хүний нэр 434-ыг түүвэрлэн бүртгэсэн². Мари-Доминик Эвен, Родика Поп нарын энэ орчуулга ЮНЕСКО-гийн Дорно дахины бүтээлийн цоморлиг гаргах төслийн хүрээнд хийж гүйцэтгэжээ. МНТ-ыг франц хэлнээ орчуулахдаа 1949 оны Поль Пеллио гуайн галиг, 1990 оны Б. Сумъяабаатарын МНТ-ыг үндсэн хэрэглэгдэхүүнээр, Ц. Дамдинсүрэн (1975), Д. Цэрэнсодном (1990), Ш. Гаадамба нарын бүтээлийг нэмэлт хэрэглэгдэхүүнээр ашигласан байна. Энэ нь франц хэлээр гарсан анхны бүрэн орчуулга бөгөөд 851 зүүлт тайлбартай томоохон бүтээл юм. Орчуулагч нар өмнөтгөлд тухайн орчуулгыг эрдэм шинжилгээний бус олон нийтэд зориулсан орчуулгын бүтээл гэж бичсэн байдаг бөгөөд МНТ-ыг орчуулахдаа франц хэлтэн уншигч нарт монголын түүх, соёл, хэл, сэтгэлгээний онцлогийг таниулах үүднээс эхийг чандлан баримталж орчуулсны зэрэгцээ ихэнх оноосон нэрийг (хүний нэр, газар усны нэр, овог аймгийн нэр) И. Де Рахевильц, Н. Поппе, В. Рибакки, Л. Лигети, П. Поуха, Э. Хэниш, А. Мостаэрт нарын судалгаанд тулгуурлан утгачилж, үгчилж орчуулсан байдгаараа бусад орчуулгаас өвөрмөц талтай. Бид уг орчуулгад тулгуурлан МНТ-д буй нангиад хүний нэрийн тоог гаргаж, франц хэлнээ хэрхэн

¹ МУИС, ШУС, ХУС-ын Европ судлалын тэнхимийн багш, доктор

² Н. Мөнх, *Монголын нууц товчооны хүний нэрийн франц орчуулгын судалгаа*, докторын зэрэг горилсон бүтээл, УБ., 2017.

орчуулсан байгаад ажиглалт хийхийг оролдлоо. Бид уг судалгаанд Мари-Доминик Эвен, Родика Поп нарын МНТ-ы франц орчуулга, Ш. Чоймаагийн кирилл хөрвүүлэг, Б. Сумъяабаатарын бүтээл, И. де Рахевильцын латин галиг зэргийг үндсэн хэрэглэгдэхүүн болгон ашигласан.

МНТ-ы франц орчуулгыг шүүж 15 хятад хүний нэр, цол олсон. Эдгээр нэр, цолыг франц хэлнээ дараахи байдлаар орчуулсан байна:

1. **Alaquš Digit Quri-Алахушиу Дигид Хури, Prince Geai-l'Officier** /阿剌^中忽失的吉^中忽^舌里- ā lā hū shī dì kǐ t' (ī) hū rǐ/. (§§182, 190, 202). Судлаачид *Alaquš* –ийг түр. *ala quš* ‘ятга шаазгай’, *digitхури* гэдгийг түр. *tegin*³ + *quri* (цол, хэргэм) хэмээх хоёр үгээс үүссэн цол хэргэм гэж үздэг. Иймээс *Alaquš Digit* –ийг үгчлэн, *Quri*-г франц хэлнээ *l'Officier* ‘офицер, албан тушаалтан’ гэж утгачилан орчуулжээ.
2. **Altan qahan-Алтан хаан, L'Empereur d'Or** /阿^勒壇^中合^中罕- ā l(è) t'án hǎ hān /. (§§ 53, 132-134, 248, 252, 253, 271, 273). Хятаны хааны цол. Энэ цолыг шууд үгчлэн орчуулсан байна.
3. **Aša Gambu-Аша Гамбу, Asa-l'Accompli** /阿沙^中敢不 - ā sō kām pù/. (§§256, 265, 266). Тангадын жанжин. *Aša*-г үсэгчилж /s-ийг тэмдэггүй бичсэн нь төвд бичлэгийг баримталсан байж болох талтай/, *Gambu*-г *Accompli* ‘төгс, төгөлдөр’ гэж орчуулжээ. И. де Рахевильц *aša* /төвд A-za/ *T'u-yü-hun* ургийн нэр, төвд. *gambui* нь *цэргийн дарга, жанжин* хэмээх утгатай гэж тайлбарлажээ. (I de R. vol. II, p. 938). Рашид ад Дин *kambu* (*gambu, gambo*) нь *агуу, их* гэсэн утгатай хэмээн тайлбарлажээ. Иймд энэ нь хүний нэр бус *төрийн том албан тушаалтан* (?) гэсэн хэргэм байж болох талтай. Германы эрдэмтэн Х. Франке (H. Franke): Юань гүрний үеийн олон хятад сурвалжид *Gambu* гэсэн нэр байх бөгөөд *цэргийн дарга, жанжин* гэсэн утгатай хэмээжээ. Иймээс энэ нэрийг *Aša-l'-Officier* гэж орчуулах нь зүйтэй болов уу.
4. **Burqan-Бурхан, Divin; Iluqu Burqan-Илаху Бурхан, Divin-Victorieux**⁴ /亦魯^中忽不^舌兒^中罕-yì luō hū pù ér hān/. (§§249, 250, 256, 265, 267, 268). Энэ нь хүний нэр биш тангадын хааны цол хэргэм юм⁵. *Divin Victorieux* гэдэг нь монголоор *ялгуусан/ялагч бурхан* гэсэн утгатай бөгөөд энэ цол Буддын шашинтай холбоотой байж магад.
5. **Čaqa-Чага, Infante** /察^中合 - ch'á hǎ/. (§249). Тангадын гүнж. *Infante* бол Испани, Португалийн угсаа залгамжлах хунтайж, гүнжийн цол юм. Энэ үгийг хүний нэр бус *Илаху бурхан* гэдгийн нэгэн адил цол хэмээн үзээд орчуулсан бололтой. Алтан товчид *Цагаан* гэж буулгасан, харин И. де Рахевильц монгол хэлний *čaqa* ‘хүүхэд’ гэдэг үгээс үүссэн нэр байж магад хэмээн үзжээ. Алтан товчийг баримталбаас *Blanche* гэж орчуулна. Гэсэн хэдийвээр бид дээрхи орчуулгыг оновчтой болжээ гэж үзэв.

³ түр. *tegin* (<*tegin*), олон тоо *tigit* – “*тайж, ханхүү*”. Судлаач Ц. Баттулга *Эртний түрэгийн гурван цолын тухай*, Монголчуудын зэрэг дэв, УБ., 2009, т. 10-25-г үзнэ үү.

⁴ Хожуу Чингис хаан *Шудрага* буюу *Droit* хэмээх цол олгосон.

⁵ Тухайн үеийн тангадын хааны оны цол нь *Hsiang-tsung*, нэр нь *Li An-ch'üan* байжээ.

6. **Güngjü-Гүнжү, Güngjü** /公主-kūng chu/. (§248). Нэрийг *Güngjü* гэж үсэгчилсэнтэй санал нэг буй. Судлаачид нэрийг *Güngjü* (П.П. т. 100, Кл. т. 184, И. де Ра. т. 177, Т. Дц. т. 189) *Günzü* (Б. Сб. т.734), *Kunju*, (Ко. т. 293) гэж тэмдэглэжээ. МНТ –ы олон орчуулгад *Güngjü*-г нэг бол нэр, нэг бол цол болгон орчуулсан байдгийг хавсралтаас үзэх. Эвен, Поп нарын орчуулгад: ... *il envoya à l'Empereur Cinggis une princesse appelée Güngjü* гэж орчуулсан, *une princesse appelée Güngjü* гэдгийг ‘Güngjü нэртэй гүнж’ гэж орчуулна. Бид: ... *une fille appelée Princesse* (хүний нэр гэж үзвээс), эс бөгөөс ... *sa princesse* (цол гэж үзвээс) гэж орчуулах нь зөв гэж үзлээ.
7. **Gür qan-Гүр хан, Le Roi-Universel**⁶ /古兒合 - kǔ ér hā/. (§198). Энэ нь Хятаны хааны цол. МНТ-оос үзэхэд уг цол нь Төв Азид нилээд дэлгэрсэн цол байжээ (§§141, 150-152, 177). *Gür*-ийг *даян дэлхийн, ертөнцийн* гэдэг утгаар *Universel, qan*-ыг *Le Roi* хэмээн орчуулжээ.
8. **Höbögetür-Хөбөгэтүр, Höbögetür** /豁孛格秃兒 - huō péi ké t'ū ér/. (§251). *Höbögetür* гэж үсэгчилэх. Судлаачид *Höbögätür* (П.П. т. 101), *Höbögetür* (Кл. т.187, И. де Ра. т. 179, Т. Дц. т. 191, Б. Сб. т.743) *Hobeketur* (Ко. т. 294) хэмээн тэмдэглэсэн байна. Японы судлаач Нака Мичиёо энэ нэрийг *Wan-yen Ch'en-ho-sang* жанжны нэр, харин Кливез уг нэрийг Жувэйнигийн дурьдсан *Qamar Neküder* гэдэг нэрийн нэг хувилбар гэж үзсэн байна⁷.
9. **Пе-Илэ, Пе** /亦列 - yì liè/. (§251). И. де Рахевильцын судалгаанд тулгуурлан нэрийг франц хэлнээ *Yeh-lü*⁸ (~ I-la ~ I-lieh) гэж буулгах нь зүйтэй болов уу. Энэ нэрийг *Ilä* (П.П. т.101), *Ile* (Кл. т.186, И. де Ра. т. 179, Т.Дц. т. 191, Б. Сб. т. 743, Ко. т.294) гэж судлаачид үсэгчилсэн байна.
10. **Jeugon-Жэу Гон, Chao-le-Mandarin** /趙官-chào kuān/. (§251). Хятадын Сүн гүрний хаан. Орчуулагчид *Jeugon* буюу *Жэу Гон* гэдэг бол Өмнөд хятадын *Ning-tsung* хааны доромж нэр, овгийн нэр нь *Chao* гэж тайлбарлаж, (Э. П. т. 301:21). *Chao* овогт хятад гэж орчуулжээ.
11. **Ongging čingseng- Онгийн чинсан, Premier Ministre Wan-Yen**. Уг полны тайлбарын тухайд доороос үзнэ үү. Уг цолыг франц хэлтэн уншигчдад дөхөм болгох үүднээс өөрчлөн *ерөнхий сайд Ван Янь* гэж өөрчлөн орчуулсан байна.
12. **Qada-Хада, Qada** ^{/合荅 - hā tā/}. (§§251, 252). Нэрийг үсэгчилсэн байна. Судлаачид *Qada* (П.П. т. 101, Кл. т. 186, И. де Ра. т.179, Т. Дц. т. 191, Б. Сб. т. Ко. т. 294) гэж галигласан байна. Рашид ад Дин *Qadai Rengü* гэж тэмдэглэсэн бөгөөд Бойл, Кливез нар *Qada Sengüm* (= ? Senggüm < нанг. *chiang-chün* ‘жанжин’) гэж тайлбарласан байдаг. Тэд эл нэрийг *Wan-yen* (жанжин) *Ho-ta*⁹

⁶ 150, 177-р зүйлд Хэрэйдийн Ван ханы авга.

141-р зүйлд Жалайрын Жамухын цол.

151, 152, 177-р зүйлд Ван ханы эцгийн цол.

⁷ F. W. Cleaves, *The Secret History of the Mongols*, London, 1982.

⁸ Igor de Rachewiltz, *The secret history of the Mongols, A Mongolian Epic Chronicle of the Thirteenth Century*, Vol. II т. 911: *Ile* гэдэг нэрийг *I-la P'u-a* хэмээх нэр гэдгийг тогтоосон. Гэхдээ *Ile* нь *Yeh-lü* (~ I-la ~ I-lieh) гэдэг хятан нэр байх нь дамжиггүй.

⁹ Чин гүрний жанжин, 1232 онд монголчуудад ялагдаж, олзлогдсон. W. Abramowski, *Die chinesischen Annalen von Ögödei und Güyük-Übersetzung des 2. Kapitels des Yüan-shih*, Zentralasiatische Studien, 1976.

гэж тогтоосон тул *Хада* гэдэг нь *Ho-ta* гэдэг нангиад нэрийн монгол дуудлага ажээ.

13. **Se'üse-Сэгүсэ, Laquais** /薛兀薛-siē wù siē/. (§273). Алтан хаанд өгсөн цол. *Se'üse*-г *зарц* гэсэн утгаар *Laquais* хэмээн үгчлэн орчуулжээ.
14. **Tenggeri-Тэнгэр, Ciel** /騰格^᠑理 t' éng ké rǐ/. (§253). Алтан хааны хүү. *Tenggeri*-г мо. тэнгэр хэмээн үзэж *Ciel* гэж үгчлэн буулгасан байна. Энэ нэр нь Т'ieh-ko 帖哥¹⁰ хэмээх нангиад нэрийн монголжсон дуудлага бөгөөд *тэнгэр* гэсэн утгагүй.
15. **Vuqanu-Фүхану, Fuqanu** /夫^᠑合訥 -fū hā nè/. (§ 253). Нэрийг галигласан бөгөөд Зүрчидийн цэргийн энэ жанжны нэр *P'u-hsien Wan-ni* ажээ. (Э. П. т. 302:31). Нэрийг *Vuqanu* (П.П. т. 102, И. де Ра. т. 181), *Wuqanu* (Кл. т.189), *Fuqanu* (Т.Дц. т. 193), *Yuqanu* (Б. Сб. т. 752), *Fuqano* (Ко. т. 295) гэж үсэгчилсэн байна.

Дээрхи түүвэрлэсэн жишээнээс үзэхэд XIII зуунд монголчууд нангиад нэрийг нэг бол монголчилж дууддаг эс бөгөөс дуудлага төстэй монгол үг, нэрээр (Илэ, Хада, Тэнгэр) орлуулдаг байжээ. Энэ нь таамаг төдий бөгөөд цаашид дундад эртний үеийн бусад баримт, сударт тулгуурлан улам гүнзгийрүүлэн судлах нь зүйтэй байна. Мөн хятад хүмүүсийг нэрээр нь бус цол, албан тушаалаар нь дуудах нь элбэг байжээ (Алтан хаан, Бурхан, Гүнж, Сэгүсэ г.м.).

Франц орчуулгын тухайд гэвээс бид МНТ-д 15 нангиад нэр, цол түүвэрлэснээс бөгөөд 7 нэрийг үгчилж, 5 нэрийг үсэгчилж, 3 нэрийг франц хэлтэн уншигчдад ойлгомжтой болгох үүднээс тайлбарлан орчуулсан байна.

Резюме

Мы насчитали в Сокровенном сказании монголов 455 антропонима. В данной летописи мы нашли 15 китайских антропонима из которых 7 были дословно переведены на французский язык, 5 имён были переведены на французский методом транслитерации, а 3 имени были изменены при переводе для того чтобы франкоязычный читатель смог правильно их воспринять.

НОМЗҮЙ

Кирилл үсгээр:

1. Алтанзаяа Л., 2009. *Монголчуудын зэрэг дэв*, ЭШХИЭ, УБ.
2. АН СССР, 1969. *Древнетюркский словарь*, Ленинград.
3. Гаадамба Ш., 1990. *Монголын нууц товчооны судлалын зарим асуудал*, Улсын хэвлэлийн газар, УБ.
4. Ганшина К. А., 2002, *Русско-французский, французско-русский словарь*, Издательство “Астрель”, Москва.
5. Дамдинсүрэн Ц., 1976. *Монголын нууц товчоо*, УХК, УБ.
6. Дариймаа А., 2008. *Монгол хүний нэрийн толь*, УБ.

¹⁰ Монголд барьцаанд ирсэн Хятадын Алтан хааны хүү.

7. Дашцэдэн Т., 2009. *Монголын нууц товчоон -ы галиг*, Битпресс ХХК, УБ.
8. Козин С. А., 1941. *Сокровенное сказание, Монгольская хроника 1240 г. под названием Mongγol-un Niγuᠰa Tobᠰiγan, Юань чао би ши, Монгольский обыденный изборник*, том I, Изд-во АН СССР, Москва-Ленинград.
9. Лувсанданзан 1990. *Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан Алтан товч хэмээх оршвой*, УБ.
10. Лувсандорж Ж., 2014. *Монголын нууц товчоон* (Монгол улсын Нууц түүх), “Бэмби сан” ХХК, УБ.
11. Лувсандэндэв А., 1957. *Монгольско-русский словарь*, Гос. изд-во иностр. и нац. словарей.
12. Намндорж О., 1996. *Түүхт нэрсийн лавлах “Монголын нууц товчоо”*, УБ.
13. Өлзийсүрэн Б., 2005. *“МНТ”: хүний нэрийн толь*, УБ.
14. Сумъяабаатар Ц., 1990. *Монголын нууц товчооны үсгийн галиг*, УБ.
15. Цэрэнсодном Д., 2000. *Монголын Нууц товчоо*, эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар, Мөнхийн үсэг, УБ.
16. Чоймаа Ш., 2011. *Монголын нууц товчоо*, Эртний үг хэллэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрвүүлэг, Мөнхийн үсэг ХХК, УБ.

Латин үсгээр:

1. Bese L., 1978. *Some Turkic Personal Names in the Secret history of the Mongols*, Acta orientalia Hungarica, Vol. 32, т. 352-359.
-1974. *Sur les anciens noms de personne mongols*, traduction de R. Hamayon, Etudes mongoles, 5, pp. 91-96.
2. de Rachewiltz I., 2004. *The Secret History of the Mongols: A Mongolian Epic Chronicle of the Thirteenth Century*, Brill Leiden-Boston, Vol. I, II.
-1972. *Index to the Secret history of the Mongols*, Indiana University Publications.
3. Marie-Dominique Even et Rodica Pop, 1994. *Histoire secrète des Mongols*, Connaissance de l’Orient, collection UNESCO d’œuvres représentatives, Gallimard, Paris.
4. Mostaert A., 1953. *Quelques problèmes phonétiques dans la transcription en caractères chinois du texte mongol du Iuen tch’ao pi cheu*.
5. - 1953. *Sur quelques passages de l’Histoire secrète des Mongols*, Harvard-Yenching Institute, Cambridge, Massachusetts.
6. Pelliot P., 1949. *Histoire secrète des Mongols*, restitution du texte mongol et traduction française des chapitres I à VI, Librairie d’Amérique et d’Orient, Adrien-Maisonneuve, Paris.
7. Poppe N., 1975. *On Some Proper Names in the Secret History*, Ural-Altaische jahrbücher, Band 47, Wiesbaden, ss. 161-167

МОНГОЛ, ГЕРМАН ХЭЛНИЙ АХУЙ, СОЁЛЫН ХОЛБОГДОЛТОЙ ДҮЙЦЭЛГҮЙ ҮГ, ХЭЛЦ ҮГИЙН ОРЧУУЛГА

А.Цэрэнчулуун¹

Товч утга: *Аль ч хэлэнд тухайн ард түмний амьдрал, ахуй, соёлын онцлог, өвөрмөц сэтгэхүйтэй холбоотой өөр хэлэнд үгчлэн буулгах боломжгүй, дүйцэлгүй үгс, өвөрмөц хэлц байх бөгөөд тэдгээрийг ихэнх тохиолд галигчлан буулгаад зүүлт хийн тайлбарлах, эсвэл илэрхийлэл нь өөр боловч утга дүйх үг, хэлцээр төлөөлүүлэх, эсвэл төстэй хэллэгээр орлуулах аргыг хэрэглэдэг байна.*

Энд монгол герман, хэлний дүйцэлгүй үг, өвөрмөц хэлцийн зарим нэгийг орчуулахыг хичээв. Монгол хэлний дүйцэлгүй үг, өвөрмөц хэлцийг хүснэгтэнд оруулан нэгдүгээр багананд бичээд толь бичгээс утгыг нягтлан хоёрдугаар багананд тодруулаад гуравдугаар багананд герман хэлээр орчуулан бичлээ.

Герман хэлний дүйцэлгүй үгийг бичээд ард нь дугуй хаалтан дотор үгчлэн орчуулж тайлбарлаад эцэст оноосон үг буюу монгол дүйцэл-ийг бичих журмаар тайлбарлав.

Дүйцэлгүй үг:

Тухайн улс, үндэстний ахуй амьдрал, шашин шүтлэг, түүх, хэл соёл, сэтгэхүйн өвөрмөц байдлыг тусгасан үг, өвөрмөц хэлц нь зөвхөн тухайн хэлээр илэрхийлэхээс биш өөр хэлэнд шууд буулгах орчуулах боломжгүй тул тайлбарлах буюу дүйцүүлэн буулгах аргыг хэрэглэх болой. Дүйцэлгүй үгийг орчуулахад хоёр шатаар ажиллана, нэгт зөв ойлгох, хоёрт хэрхэн орчуулж уншигчид хүргэх юм.

Түлхүүр үгс:

Монгол хэлний гадаад хэлэнд үл орчуулагдах зарим үгс:

сум, дээл, наадам, ааруул, баг, айраг, агент, тэмээний хом, дээс, бүс, дэгтий, "хуймаг", "пэлдэн шиг эрхэмлэн хадгалах", "Мүнхагийн ухаан үдээс хойш", "Санаа сохор бол нүд сохор"

Герман хэлний зарим дүйцэлгүй үг, өвөрмөц хэлц үгс:

verschlimmbessern (дордуулан засах), Vorfreude (угтан баярлах), Fremdschämen (бусдын өмнөөс ичих), Fernweh (харийг санагалзах), Verabredet (болзсон), Fingerspitzengefühl (хурууны өндөгний мэдрэмж), Brückentag (Гүүр өдөр), Viele Wege führen nach Rom (Олон зам Ром хүргэдэг) Das geht auf keine Kuhhaut (энэ ямар ч үхрийн ширэн дээр багтахгүй)

¹ Орчуулагч, судлаач

Монгол үг, хэлц үг Я.Цэвэлийн монгол хэлний товч тайлбар толь -ноос
нягталбал: Тайлбар,

Герман орчуулга

ааруул - Хатаасан аарц, ааруул тавих, хорхой ааруул Gepresster und
getrockneter Quark.

агент - Явуулын худалдаачин

аймаг - Засаг захиргааны том нэгж, Bezirk

баг - Орон нутгийн засаг захиргааны анхан шатны нэгж, биеийн тамирын
тэмцээний нэг тал, Ein Bag war schon unter den Qing-Kaisern eine Verwaltungseinheit
unterhalb des Somons

буйл - Nasenpflock

бүс - Гадуур хувцасны бэлхүүс, бүсэлхийгээр ороож бэхлэх уях урт
нэхмэлийн зүйл буюу сур Scharfe, Gürtel aus Leder für den Deel(Mantel)

дэгтий - Хүйтэнд гутлын гадуур өмсөх үл, зулаг, түрий, уяанаас бүрдэх мал
амьтны арьсаар хийсэн нэгэн зүйл гутал; гутлын гадуур өмсөх арьсан бойтог:
Überstiefel aus Pelz gegen den strengen Winter

дээл - Гадуур өмсөх энгэр зах бүхий урт хувцас, зуны дээл, өвлийн дээл
Deel (дээл) Langer Mantel der Mongolen. Heutzutage wird einfach Deel gesagt. Es
gibt den Terleg(тэрлэг) ohne Fellfutteransatz (ohne Futter, mit dünnen Futter, wattiert)
und Deel (Wildedermantel, Lammfellmantel, Herbstfellmantel und Winterpelzmantel)

дээс - Үс, хялгас, олс, хийм зэргээр томж хийсэн оосор Eine gedrehte Seile
aus Kamelhaare oder Rossmähnen oder Yakhaare

Мунхагийн ухаан үдээс хойш die Besinnung eines Dummen kommt erst am Nachmittag

Наадам - Олноороо хийж баясах цэнгэл зугаа, эрийн гурван наадам
Sommerfest in der Mongolei. Eigentlich „Die drei Spiele der Männer
(Bogenschießen, Pferderennen und Ringen)“

Пэлдэн - Ein Augenheilmittel gegen Grauer Starr

пэлдэн шиг эрхэмлэн хадгалах “gut aufbewahren, wie Pelden”

Санаа сохор бол нүд сохор was man nicht im Kopf hat, sieht man auch nicht

сум - Verwaltungseinteilung eines Aimaks

Тэмээний хом - Der Khom ist eine Vorrichtung aus Filz, Kamelhaarseilen und aus
Holzstangen. Sie schützt den Rücken und die Flanken des Kamelkörpers vor Scheuern,
Reiben und Verletzungen durch die Traglasten. Den Khom richtig anzulegen ist das A und
O der Karawanenführer.

хуймар - Aus gesüßtem Teig in Butter gerösteter Teigkuchen Dem deutschen
Eierkuchen ähnlicher Teigkuchen.

эрүүний шөл Kiefersuppe Gardinenpredigt

Герман хэлний дүйцэлгүй үг, өвөрмөц хэлцийг орчуулахдаа дугуй хаалтан
дотор үгчлэн орчуулж тайлбарлаад эцэст оноосон үг буюу монгол дүйцэл- ийг бичих
журмыг баримтлав.

Зөвхөн герман хэлэнд байдаг үгс:

1. Vorfreude (үгтан баярлах)

Ямар нэгэн зүйлд баярлах гэдэг үг бүх хэлэнд байх боловч болох зүйлд урдаас баярлахыг оноож хэлсэн "үгтан баярлах" (Vorfreude) хэмээх гоё үг зөвхөн герман хэлэнд байдаг ажээ. Монголчууд "болно гэж баярлах" гэнэ.

2. Schnapsidee (сархад санаа)

Их хэмжээний нанчид хүртсэн хүнээс л гарч болох жинхэнэ солиотой санааг илэрхийлсэн "сархад санаа" гэсэн үг герман хэлэнд л байдаг байна. Хэн нэг хүн санаж бодолгүйгээр тэнэг санаа гарвал түүнийг ч бас "сархад санаа" гэх болой.

3. Fremdschämen (бусдын өмнөөс ичих)

Өөрөө ч мэдэлгүй бусдын өмнө хөөрхийлөлтэй загнаж байгаа хүнийг хараад хөндлөнгөөс нүүр улайхыг германчууд бусдын өмнөөс ичих (Fremdschämen) гэнэ. Монгол хэлэнд ч бас "хөндлөнгөөс ичиж үхэх шахах" гэсэн үг байдаг билээ.

5. Fernweh (харийг санагалзах)

"Нутгаа санах/гэрээ санах" гэдэг үг ихэнх хэлэнд байдаг түгээмэл үг. Гэтэл герман хэлэнд яг эсрэг санааг илэрхийлсэн "харийг санагалзах" (Fernweh) гэдэг үг байдаг.

Харийг санах гэдэг нь шууд л юмаа баглаж аваад гадаадын аль нэг улсыг зорих хүслийг хэлнэ. Харь орны хүн ардтай танилцаж, соёлыг гайхан, магадгүй аж амьдарлаа дээшлүүлэх, аз жаргалын эрэлд гарахын хүслэнг "харийг санагалзах" гэх болой. Харин англи хэлэнд "таваг нь загатнасан"(itchy feet) гэсэн ойролцоо утгатай үг байдаг бол үргэлж тэнэж, хэсэж явах дон шүгэлсэн хүнийг ч бас монголчууд "тэнүүчлэх дон шүглэсэн хүн", "үл нь загатнасан" гэнэ биз.

5. Abendbrot (оройн талх)

"Оройн талх" гэдэг үг орой иддэг талхыг хэлмээр. Гэхдээ германчууд өдрийн төгсгөлд цуг сууж иддэг хоолыг "оройн талх" гэдэг. Энэ нь оройдоо хөнгөн шиг талх хиам, бяслаг иддэгээс гаралтай биз. Тэгээд ч үдэд гол хоолоо иддэг тул оройдоо бага хоол иддэг билээ. Монголчуудын өглөөний цай гэдэг маань зөвхөн цай уух биш бас бага зэрэг юм идэж халуун цай уухыг хэлдэг билээ. Тийм учраас германчуудын оройн талхыг монголчууд бол "оройн цай" гэнэ байх.

6. verschlimmbessern (дордуулан засах)

Ямар нэг зүйлийг сайжруулах гээд бүр дордуулж орхихыг германчууд "дордуулан засах" гэнэ. Улам сайжруулах гэж оролдох бүр муутгаж орхих явдал хааяа гардаг билээ. Монголоор бол "нуухыг авах гээд нүдийг нь сохлох", "долоо дордуулах" гэдэг хэлцтэй утга нэгэн ажээ.

7. Kummerspeck (шаналгааны харвин)

Хайр сэтгэл, ажил, амьдралын бүтэлгүйтэл, эсвэл бусад сэтгэл хөөрлийн улмаас их хэмжээний амттан: чихэр, шоколад, шарсан хуурсан зүйл: гамбирцаг, чипс, тахиа зэрэг идэх аваас гэдсээрээ өөхөлж эхэлнэ. Үүнийг германчууд "шаналгааны харвин" гэх болой. Монголчууд бол "бузрын тарга" гэнэ байх.

8. Verabredet (болзсон)

Германчууд цаг нарийн баримталдгаараа дэлхий дахинд алдартай. Тэд цагийг яаж баримталдаг юм бэ? Болздог юм. Тиймээс ч "болзсон юм шиг" уулзах гэсэн хэлц үг ч герман хэлэнд байдаг. Монголчууд эсрэгээрээ хол юманд явахдаа нарийн цаг болзохоос цээрлэдэг нь байгаль, цаг уурын эрхшээлд байдаг нүүдлийн соёлтой ард түмний болгоомжлолтой холбоотой байж болох билээ. Энэ бол тухайн хоёр ард түмний ахуй амьдралаас үүдэлтэй соёлын ялгаа юм. Харин монголчуудын дунд өвөг дээдэс эртнээс нааш баримталж ирсэн "за гэвэл ёогүй" гэдэг үг байдаг. Амалсан зүйлээ заавал биелүүлдэг бичигдээгүй хуультай улс билээ. Монголчууд нэг зүйл дээр цагийг яс барьдаг гэнэ. Энэ нь "бүүз жигнэхэд" гэнэ.

9. Scheinheilig (гэмгүй царайлсан)

Хүн бүхэн л гэмгүй царайлсан хүнтэй хаа нэгтэй, хэзээ нэгэн цагт тааралдсан байж таараа. Ийм хүн нүүрэн дээрээ томоотой, тохитой, эелдэг ааштай харагдах боловч, дотроо зальжин байдаг. Ийм хүнийг монголчууд "хонины арьс нөмөрсөн чоно" гэнэ.

10. Torschlusspanik (хаалга хаагдана гэж сандрах)

Хаалга хаагдана гэж сандран мэгдэх гэдэг нь дундад зууны үед харуй бүрий болоход хотын хаалгыг хаачихдаг байсан үед оройтож ирсэн хүмүүс хотын гадаа, араатан амьтан, хулгайч дээрэмчдийн аюул занал дор хоноглоход хүрдэг байсан үеэс гаралтай ажээ. Амьдралд таарч тохирох "хань ижилгүй үлдэх бий хэмээх сандрал"-ыг хотын хаалга хаахтай зүйрлэсэн хошин хэллэг. 30 эргэм насны хүн таарч тохирох ханиа олохгүй гон бие, гозон толгой болж үлдэх бий хэмээн сандарч эхэлдэг билээ. Аз жаргалтай хосуудын дунд ганцаараа үлдэхээс эмээх зовнил. Хэзээ нэгэн цагт боломжит цаг хугацаа хашааны хаалга шиг хаагдаж орхиход гадаа үлдчихээд хашааны модноос үгзчин ганцаараа зогсох вий гэсэн мэгдэл юм. Монголчууд бол "гон бие, гозон толгой болж үлдэхээс айх" гэнэ.

11. Fingerspitzengefühl (хурууны өндөгний мэдрэмж)

Бусдын хэрэг явдалд туйлаас болгоомжтой хандахыг герман хэлэнд "хурууны өндөгний мэдрэмж" (Fingerspitzengefühl) гэдэг. Хэрэг дээрээ тулахаар тийм нарийн мэдрэмж гаргаж чадах хүн тун цөөхөн ажгуу. Монголчууд бол "торгон мэдрэмж" гэнэ байх.

12. Brückentag (Гүүр өдөр)

"Гүүр өдөр" гэдэг нь германчуудын дуртай үг бөгөөд энэ нь баярын буюу гарагийн төгсгөлийн өмнөх өдрийг хэлдэг байна. Сүүлчийн ажлын өдөр гэсэн үг. Ихэнх хүмүүс энэ өдрөөс эхэлж амралтаа авах сонирхолтой байдаг байна. Ингэснээр гэр бүлтэйгээ хамт нэг өдрийг ч гэсэн илүү өнгөрөөх, гадаадад явж "харийг санагалзах" хүсэл тэмүүллээ биелүүлэх боломж гардаг байна. Монголчууд бол ажил амралтын "завсрын өдөр" гэнэ.

13. Geborgenheit (хамгаалалд байх)

Хамгаалал гэдэг нь тааллаараа, санаа амар, баттай загнах нөхцөл байдлыг хэлнэ. Энэ нь найдвартай байдлаас хавьгүй өргөн дэлгэр утгатай ажээ. Манайхан бол "ар тал сайтай" гэнэ байх.

Янз бүрийн гаралтай орчуулах боломжгүй буюу орчуулахад бэрхтэй эртний болон шинээр үүссэн герман үгс:

14. Dunkelziffer (харанхуй тоо)

"Харанхуй тоо" гэдэг нь хар өнгөөр бичсэн тоог биш, харин их бага хэмжээ нь эс мэдэгдэх "нуугдмал тоог" хэлнэ. Энэ нь голдуу аливаа гэмт хэргийн жинхэнэ уршиг нь хэлж таамаглаж байснаасаа хавьгүй их гарахыг хэлнэ. Жинхэнэ (харанхуй тоо)тоо нь мэдэгдэж таамаглаж байснаасаа хавьгүй их байх жишээтэй. Манайхан ч бас "харанхуй тоо" гэнэ байх.

15. Vausparen (байшинд хуримтлуулах)

Германчууд зөвхөн ажилсаг, цаг баримталдаг гэдгээрээ алдартай бус, бас аливч хямгач гэдгээрээ нэртэй. Өөрийн гэсэн орон гэртэй болохын тулд хурааж хуримтлуулахыг "байшинд хуримтлуулах" гэнэ. Эцсийн эцэст хуримтлуулсан мөнгөөрөө дөрвөн ханаттай болох явдал тул тун нарийн сахилга баттай хуримтлуулж гардаг байна. Манайхан бол "толгой хоргодох оронтой болоход тоотой хэдээ хуримтлуулах" гэнэ.

16. Dornröschenschlaf (сарнайхан дотор нойрсох)

Хэн нэгэн "сарнайхан дунд нойрсох" аваас юу ч хийж, бүтээхгүй, ямар нэгэн ахилт дэвшилт ч гарахгүй. Бас чухал албан хаагч, тухайлбал засаг захиргааны удирдах хүмүүс сарнайхан дунд нойрсож гарах явдал гардаг. Тийм тохиолдолд тэдгээр хүмүүсийг үлгэрт гардаг шиг 100 жилээр нойрсохгүй л байгаасай гэж зөвхөн найдах билээ. Манайхан бол "алхайж суух" гэнэ.

17. Geschmacksverirrung(мэдрэмж нь бүдилсан)

Хоорондоо огт зохицохгүй ижил буруу хувцсыг хольж хутган өмсдөг хүнийг "мэдрэмж нь бүдилсан" хүн гэдэг байна. Энэ хэлцийг юм сонгож, тохируулж

чаддаггүй хүн дээр хэрэглэнэ. Энэ хэллэгийг өмсөх хувцаснаас гадна найз нөхрөө сонгоход ч хамаатуулан хэрэглэдэг байна. Манайхан бол "сонгож чаддаггүй" хүн гэнэ.

18. Sturmfrei (шуургагүй)

Хэрэв хэн нэгэн хүүхдийн аав ээж хоёр эзгүй бол гэртээ ганцаараа үлдэх юм бол англиар "наргих цаг"(party time) боллоо эсвэл "гэртээ ганцаараа"(home alone) гэнэ. Энэ бүхнийг шуургагүй үе гэж тодруулж болох бөгөөд энэ нь "муур үгүй бол хулгана дураараа дургина"(When the cat's away, the mice will play) гэдэг зүйр цэцэн үгтэй дүйцэх болой. Манайхан бол "дураараа дургих цаг" гэнэ байх.

19. Ohrwurm (чихний өт)

"Чихний өт" гэдэг нь ямар нэгэн чихэнд ордог хорхой биш, харин ямар нэгэн дуу чихэнд хоногшоод, өөрийн эрхгүй тэр дууг аялж явахад хүрэхийг хэлнэ. Өөрөөр хэлбэл "Чихэнд хоногшсон аялгуу" гэсэн үг.

20. Erbsenzähler (вандуй тоологч)

Тун нарийн хүнийг германчууд "вандуй тоологч" гэдэг. Манайхан бол тун нарийн харамч хүнийг "гарынх нь салаагаар юм гоочихгүй", "хорголоо тоолсон амьтан" гэнэ.

21. Dreikäsehoch (гурван бяслаг шиг өндөр)

Гурван бяслаг давхарласан шиг өндөр гэдэг нь хүүхдийн өндөр намыг хэлсэн үг ажээ. Бяслагийг том дугуйгаар шахан хийдэг байсан одоо ч хэвээрээ. Тэгээд хариугүй жаахан аяганы мэлхий ширээнд хүрэхтэй үгүйтэй хүүхдийг "гурван давхар бяслагны дайтай" гэнэ. Манайхаар бол "тохойн чинээхэн" гэнэ.

22. Wanderlust (сэлгүүцэх дур хүслэн)

Аялалд гарах туйлын хүслэн, орон гэрийн тааламжтай байдлыг орхин, аяллын паспортон дээрх тамгыг олшруулан шинэ танилуудтай болж, шинэ хот тосгон үзэж, өөр соёлтой танилцахын хүслэн болохыг хэлнэ. Манайхаар бол "таваг нь загтанасан" хүн гэх биз ээ.

23. Pantoffelheld (үглааш баатар)

Найз нарынхаа дунд ханхар, сүр бараатай байвч, эхнэрийн өмнө хайлсан тугалга шиг болдог эрийг германчууд "Pantoffelheld" (үглааш баатар) гэгцээдэг. Нөхөр өрх гэрийн "тэргүүн"(Korf), харин эхнэр хүн "хүзүү"(Genick) нь гэдэг. Хүзүү хүссэн зүгтээ толгойг эргүүлж чадна гэдэг дээ. Манайхан бол ийм хүнийг анд нөхдийнхөө дунд эр бар шиг, авгайнхаа дэргэд эрх хав шиг өөрөөр хэлбэл "эхнэрийнхээ харцаар" гэнэ.

24. Zugzwang (нүүх албадлага)

"Нүүх албадлага" (Zugzwang) гэдэг үг шатрын тоглоомонд ноёноо зайлшгүй нүүхэд хүрэх гэдгээс гаралтай аж. Харин одоо энэ үг шилжсэн утгаараа ямар нэгэн шийдэл гаргахад хүрэхийг хэлнэ. Манайхнаар бол "шахаанд орох" гэсэн үг.

Орчуулахад анхаарууштай герман хэлний өвөрмөц хэлц

Rom wurde nicht an einem Tag erbaut (Ром хотыг ганц өдөр бүтээн босгоогүй)

"Ромыг ганц өдөр бүтээн босгоогүй". Энэ өвөрмөц хэлц утга нь их зүйлийг бүтээхэд цаг хугацаа шаардлагатай гэсэн санаа. Гэхдээ Ром гэдгийг Улаанбаатар хэмээн дүйцүүлж болдоггүй байна. "Ромыг ганц өдөр бүтээн босгоогүй" гэж бичээд тайлбарт зүүлт хийвэл зохимой. Ихийг бүтээхэд хугацаа хэрэгтэй гэсэн үг.

Viele Wege führen nach Rom (Олон зам Ром хүргэдэг)

"Олон зам Ром хүргэдэг". Зам болгон Ром хүрдэг гэсэн санаа биш, харин алив суудлыг шийдэх "олон арга зам буй" гэсэн санааг илэрхийлэх ажээ.

Was Hänschen nicht lernt, lernt Hans nimmer mehr (Хэнсхэний сураагүйг Ханс хэзээ ч сурахгүй)

"Was Hänschen nicht lernt, lernt Hans nimmer mehr" (Хэнсхэний сураагүйг Ханс хэзээ ч сурахгүй) гэж үгчлэн орчуулаад улмаар "Хэнсхэн гэдэг ухаантан сураагүй юмыг тэнэг Ханс бүр ч сурахгүй" хэмээн герман хэл соёл мэдэхгүй хүн үхан ойлгож болох талтай. Харин герман хэл соёл мэддэг хүн бол Хансыг багад нь Хэнсхэн гэдгийг мэдэх тул "өсөхдөө сураагүйг өтлөхдөө бүр ч сурахгүй" хэмээн дүйцүүлэн буулгах биз ээ. Харин төрөл хэлэнд бол ижил төрлийн хэлц байх ажээ. Тухайлбал орос хэлэнд "Чему Ванька не учился, того Иван Иванович не будет знать" гэж байх бөгөөд энэ нь орос хэл, соёл мэдэх хүний хувьд ойлгомжтой тул герман хэлнээс орос хэлнээ үгчлэн орчуулж болох боловч харин төрөл бус өөр соёлтой монгол хэлэнд утгачлан "өсөхдөө сураагүйг өтлөхдөө сурахгүй" гэж буулгаж болох мэт санагдана.

Bis in die Puppen(Хүүхэлдэйнүүд хүртэл...)

"Хүүхэлдэйнүүд хүртэл" хэмээн үгчлэн орчуулагдана. Энэхүү өвөрмөц хэлцийн гарал үүслийг мөшгөх аваас Берлингийн амьтны хүрээлэнгийн голд нь баримлууд байсан бөгөөд тэдгээрийг Берлинчүүд "хүүхэлдэйнүүд" хэмээн нэрлэдэг байжээ. Тэгээд амьтны хүрээлэнгийн голд байсан "хүүхэлдэйнүүд" хүртэл явахад их оройтдог тул хүүхэлдэйнүүд хүртэл битгий яваарай гэдэг байсан байна. Энэ өвөрмөц хэлцийн орчин цагийн утга: "оройтож болохгүй".

Blau machen(Хөх болгох)

"Blau machen" гэдэг үгийг "Хөх болгох" хэмээн үгчлэн орчуулна. Дээр үед ноосон эдлэлийг будганд оруулаад нэгдэх өдөр гадаа тавьж хатаахад хөх болдог байжээ. Тэр үеийн ноосон эдлэлийн будаг хатахлаараа хөх өнгөтэй болдог байсан байна. Ажилчид нь будаг хатаж хөх болох нэг өдөр нь амардаг байжээ. Тэр үеэс эхлэн ажлаа дураараа таслахыг хөх болгох гэх болжээ. Энэхүү өвөрмөц хэлц үгийн орчин үеийн утга "ажил таслах, хичээл пяхах" болой.

Damoklesschwert (Дамоклесийн илд)

Домогт гардгаар Сиракус гэдэг хаан, Дамоклес хэмээх зарцтай байжээ. Хаан нь зарцаа ертөнцийн хамгийн аз жаргалтай хүн хэмээн магтаад хаан ширээндээ нэг өдөр суулгаж гэнэ. Харин хаан ширээнд суулгахын өмнө нэгэн хүнд гэгчийн илдийг адууны сүүлний ганц хялгасаар оосорлон суудал дээр нь зүүжээ.

Хэзээ хялгас тасран илд толгой дээр нь унахыг хэн ч тааварлаж эс мэднэ. Сиракус аз жаргал удаан үргэлжилдэггүй, алхам тутамд золгүй явдал отоож байдаг гэдгийг мэдүүлэх гэсэн гэдэг. Эдүгээ ч гэсэн хэн нэгний толгой дээр Дамоклесийн илд савлаж байдаг ажгуу.

Энэ өвөрмөц хэлцийн орчин үеийн утга нь "аюул заналхийлэл" болой.

Das geht auf keine Kuhhaut (энэ ямар ч үхрийн ширэн дээр багтахгүй)

Европод цаас гарахын өмнө фергамент хэмээх тугалын адсага, ямааны турсгаар хийсэн илгэн самбар дээр юм бичдэг байжээ. Нэг хүний насан туршдаа үйлдсэн нүглийг чөтгөр нэг фергамент дээр бичдэг хэмээх итгэл үнэмшлээс гаралтай өвөрмөц хэлц үүдэн гарчээ. Энэхүү өвөрмөц хэлцийн орчин үеийн утга нь "хэрээс хэтэрсэн, хүлцэшгүй юм" болой.

Das ist Jacke wie Hose(энэ ч хүрэм өмд шиг адилхан)

"Хүрэм, өмд хоёр андуурмааргүй ялгаатай ч хийж байгаа хүний хувьд бол нилээд зүйл нь төстэй, нэг нь хоёр шуумагтай бол, нөгөө нь хоёр ханцуйтай, хоёулаа адилхан материал ордог ажээ. Алийг нь ч хийсэн адилхан матераиал орно, бас адилхан цаг хугацаа зарцуулна гэсэн утгатай. Энэ өвөрмөц хэлцийн орчин үеийн утга: "адилдаа адил, годилдоо годил".

Das ist mir Schnuppe! (энэ бол дэнгийн бадам)

Дэнгийн голын бадам их ч бай, бага ч бай хүнд хүртээлгүй зүйл болой. Энэ хэлцийн орчин цагийн утга: хүртээлгүй юм. Энэ нь монголын "надад хамаагүй, хаданд чимээгүй" гэдэг хэллэгтэй дүйх болой.

Die Kirche im Dorf lassen(Сүмээ тосгонд орхих)

Катологийн шашинтнууд эхлээд нэг сүм бариад түүнийгээ тойруулан айл орон сууцаа барина. Оршин суугчид олширч тосгон нь хаяа тэлэн зэргэлдээ тосгонтой

нийлнэ. Шүтлэгтнүүд сүмээ тойрон мөргөл үйлддэг байснаа багтахаа болиод тосгоноо тойрон гороолоно. Заримдаа зэргэлдээ тосгоныхоо хаягаар явна. Үүнд тэр тосгоныхон дургүйцэн эд "сүмээ тосгондоо орхих хэрэгтэй" гэсэн егөөдөл гарчээ.

Орчин үеийн утга нь: "хэтрүүлэх хэрэггүй, хэр хэмжээндээ байх" ажээ. Өөрөөр хэлбэл манайхны "араамандаа жайжигнах" -тай дүйцэх юм.

Die Löffel spitzen (халбагаа үзүүрлэх)

Анчдын өвөрмөц хэллэгээс гаралтай бөгөөд туулайн чихийг халбага гэх болой. Тэгээд туулай чихээ босгон чимээ чагнахыг die Löffel spitzen (халбагаа үзүүрлэх) гэнэ. Харин битүү туурайтан адуу, тахь, хулан болон гөрөөс нь цөм чихээ хөдөлгөдгөөр өвөрмөц бөгөөд тэдний чихийг "Lauscher" гэнэ. Герман хэлэнд чихийг ерөнхийд нь "Ohr" (чих) гэдэг билээ. Монгол хэлнээ: "чихээ соотойлгох" гэнэ.

Durch die Lappen gehen(алчуурнууд дундуур явах)

Дээр үед германчууд ан амьтныг нохойгоор хөөлгөн алчуур зүүсэн мухар руу хөөн оруулж агнадаг байжээ. Ийнхүү шахаанд орон тэр ан амьтад барьдаг атал зарим нэг ан амьтан алчуур зүүсэн газраар ороод гарч оддог байжээ. Ийнхүү "алчуур дундуур явах" гэдэг өвөрмөц хэлц үг буй болсон бөгөөд одоогийн утга нь "арилж одох" бөгөөд энэ нь манайхны "харах бараа, хайх мөргүй алга болох" гэдэг өвөрмөц хэлцээр дүйлгэн буулгаж болох ажээ.

Eulen nach Athen tragen(ууль Атина руу аваачих)

Ууль шувууг герегчүүд цэцэн мэргэн ухааны билэг тэмдэг гэж үзнэ. Тэгээд Афен хотыг цэцэн мэргэний хот гэдэг байна. Тийм ч учраас Афен хот баримал, цутгамал, зормол уулины дүрсээр дүүрэн байжээ. Тэгээд л Афен руу ууль шувуу аваачих гэдэг нь илүүц юм хийх гэсэн утгатай. Тухайлбал манайхаар бол Булганы сайхан руу айраг аваачих, Хонгорын элс рүү элс аваачих, германы Мюнхен рүү шар айраг зөөхтэй нэгэн адил аж. Энэ хэлцийн одоогийн утга нь "илүүц юм хийх" бөгөөд "хотонд хоргол зарах" хэмээн буулгаж болмоор ажээ.

Хэл бичгийн ухааны нэрт эрдэмтэн Д.Дашдаваа үндэсний онцлог бүхий үгийг хэрхэн орчуулах тухай бичихдээ:

- галигчлан буюу транскрипци хийх,
- хуулбарлан буулгах буюу кальки(үгчлэн буулгах)
- тайлбарлан орчуулах,
- орчуулгад зүүлт тайлбар хэрэглэх аргыг түгээмэл хэрэглэнэ гэжээ.

Ц.БАЗАРРАГЧААГИЙН ОРЧУУЛГЫН УРНААР НАЙРУУЛАХУЙН ЭРДЭМ

М. Чимэдцэеэ¹

*Эгэл жирийн нь эрхэм тансагаас давбаас
болхи толхи больюу.*

*Эрхэм тансаг нь эгэл жирийнээс давбаас
хоосон хуудам больюу.*

*Эрхэм тансаг хийгээд эгэл жирийн нь эн тэгширвээс сая
эрдэмт сайд больюу.*

“Шүүмжлэл өгүүлэл” номоос

Товч утга: МУСГЗ, МЗЭ-ийн Д.Нацагдоржийн нэрэмжит шагналт, МОЭ-ийн “Дуун хөрвүүлэгч” шагналт, доктор, профессор Цэдэвдоржийн Базаррагчаа бол Монголын нангиад хэлний орчуулгын өргөө их гэрийн хойморт дээгүүр залрах хувьтай их дуун хөрвүүлэгч мөн. Ц.Базаррагчаа эртний хятадын сонгодог яруу дууллын охь дээж болсон “Шүлэглэлт ном”-оос эхлэн, Тан улсын найрагч Ли Бай, Дү Фү, Ван Вэйн шүлгүүд, Хятадын шинэ үеийн утга зохиолын үндэслэгч, их бичгийн хүн Лү Шюнь (Лу Синь)-ий шилдэг зохиол бүтээл, Өвөрмонголын нэрт зохиолч Малчинхүү, Тайваний нэрт зохиолч Ши Мөрөний уран нийтлэлүүд зэрэг өдий төдий зохиол бүтээлийг багтаасан орчуулгын үлэмж арвин өвийг үлдээсэн нэрт орчуулагч юм.

Түлхүүр үг: Орчуулгын уран зохиол, Тан улсын яруу найраг, Ли Бай, Дү Фү, соёлын орчуулга

Монголын уран зохиолын далай их өв сангийн нэг чухал бүрэлдэхүүн хэсэг нь орчуулгын уран зохиол билээ. Тэрхүү орчуулгын өв сангийн оmtгойлж үл болох нэг чухал хэсэг нь нангиадын уран зохиолын монгол орчуулга юм.

Хятад орон нэн эртний түүх соёлтой, утга соёлын яндашгүй баян өв сантай, тэрхүү сан хөмрөг нь олон мянганы уламжлалтай, үлэмж баян тансаг бөлгөө.

Аугаа их эрдэмтэн, билгүүн номч Бямбын Ринчен “Бид түмэн түмэн улсын нэрт эрдэмтэн мэргэдийн гайхамшиг шинжлэлийн ойллого, дөрвөн зүгийн эрт өдгөөгийн бичгийн утгач нарын зохиосон сэтгэлийг булаах мэт яруу сайхан найруулалт бичгийг бахдан үзэцгээж, эрдмээр хүмүүжин, соёлоор цэнгэлдэхүйд их төлөв орчуулан хөрвүүлснийг үзнэм бус уу” хэмээн яруу сайхан өгүүлсэн байдаг. Тэрхүү “эрдмээр хүмүүжин, соёлоор цэнгэлдэх” их үйл хэрэгт энэхэн нэгэн бие, эрдэм ухаан, авьяас билгээ харамгүй зориулж ирсэн Монголын номч мэргэн, эрдэм төгс олон дуун хөрвүүлэгч гүүш нарын нэг бол миний номын багш, нэрт дуун хөрвүүлэгч Цэдэвдоржийн Базаррагчаа мөнөөс мөн билээ.

Энд би нэгэн бяцхан дурсамж өгүүлье гэж бодлоо. Миний бие МУИС-ийн монгол хэл уран зохиолын ангийн оюутан байсан цаг. Биднийг сурч байх тэр үед 3-р

¹ МУСГЗ, МУИС, ШУС, ХУС, Ази судлалын дэд профессор, доктор

ангиас нь багшийн үндсэн анги, монгол бичгийн анги, хятад хэлний, япон хэлний гэж хувааж мэргэшүүлж эхэлсэн юм. Би 2-р ангиа төгсөөд зун нь нутаг явж, намар нэлээд оройтож, хичээлээс хоцорч ирсэн юм. Угаасаа алс баруун хязгаарын хүн, газар хол, онгоцноос өөр унаа байхгүй, онгоцны тийз олдохгүй хүлээсээр тийнхүү оройтсон хэрэг. Намайг ирэхэд бүх хүүхдийг анги ангид нь нэгэнт хуваагаад дууссан байлаа. Би уг нь монгол бичгийн ангид орох санаатай, тэгээд декан дээр орлоо. ХБФ-ын декан агуу их эрдэмтэн Чой. Лувсанжав багштан байсан юм. Тэгээд учир байдлаа хэлж, монгол бичгийн ангид орох санаатайгаа хэлсэнд, Лу багш “Чи яасан их хичээл тасалдаг хүн бэ? Бүх ангийг хуваагаад дууссан” гээд ширээн дээрээсээ нэг далавгар цаас авч, “Хэний хэн билээ? хэмээн асууж, гүйлгэн харснаа “Чи ер нь хятад хэлний ангид ор” гэв. Тэр үед Монгол-хятад хоёр улсын харилцаа мөсөн цэвдэг байсан цаг. 1976 он шүү дээ. Тэр үед надад Хятадын тухай ямар ч ойлголт, мэдлэг байхгүй.

Тэгтэл Деканы өрөөнд сууж байсан тачирхан бужгар үстэй, дунд насны бор хүн босож ирээд нөгөө цаасыг харснаа “Энэ нөхрийг ерөөсөө хятад хэлний ангид авъя” гэлээ. Тэр хүн миний номын багш, манай хятад хэлний салбарын хэдэн үеийнхний багш, өнөөдөр хятад хэлний орчуулагч хэмээн өргөмжлөгдөж буй олон хүнийг өөрөө үлгэрлэн дагуулж, зам мөрийг нь зааж хөтлөн, эрдэм ухаанаа харамгүй хүртээсэн ачтан Базараа багш маань байсан юм. Өчүүхэн миний цаашдын хувь заяа, өнөөдрийн миний амьдралын зам мөр тийнхүү хэдхэн хормын дотор шийдэгдэж, цагийг эзэлсэн их номч эрдэмтэн Лу багш, Лу багшийн шавь Базараа багшаас номын авшиг хүртэх их хувь тохиосон тэрхүү сайхан учралыг багшийнхаа 80 насны сүүдэр гийсэн энэ өдөр эргэн дурсахуйд сэтгэл уярч байна.

МУСГЗ, МЗЭ-ийн Д.Нацагдоржийн нэрэмжит шагналт, МОЭ-ийн “Дуун хөрвүүлэгч” шагналт, доктор, профессор Цэдэвдоржийн Базаррагчаа бол Монголын нангиад хэлний орчуулгын өргөө их гэрийн хойморт дээгүүр залрах хувьтай их дуун хөрвүүлэгч мөн.

Багштан эртний хятадын сонгодог яруу дууллын охь дээж болсон “Шүлэглэлт ном”-оос эхлэн, эртний хятадын романтик буюу бадрангуй хүслэнгийн их дууч Чү Юаний уянгын найргаар дамжин, “Хятадын яруу найргийн алтан үе” хэмээн нэрлэгддэг Тан улсын үеийн тэнгэрлэг их найрагч Ли Бай, Дү Фү, Ван Вэй нарын шүлэг найргаар үргэлжлэн, хятадын шинэ болон шинэхэн үеийн уран зохиолын гол төлөөлөл болох 51 найрагчийн 100 гаруй шүлэг найраг, түүнчлэн Тайваньд аж төрдөг нэрт монгол зохиолч Раашдондогийн Ши Мөрөнийн шүлгийн дээж зэргийг багтаасан яруу найргийн орчуулгын баялаг өвийг, Хятадын шинэ үеийн утга зохиолын үндэслэгч, их бичгийн хүн Лү Шүнь (Лу Синь)-ий шилдэг зохиол бүтээлээс эхлэн, хятадын нэрт зохиолч Фэнь Жицай, Өвөрмонголын нэрт зохиолч Малчинхүү зэрэг зохиолчдын бүтээлээр үргэлжлэн, дээр өгүүлсэн Ши Мөрөний уран нийтлэлүүд, түүнчлэн нэрт зохиолч Зан Чэнжи-гийн “Хилэн хар ажнай” тууж зэрэг өдий төдий зохиол бүтээлийг багтаасан үргэлжилсэн үгийн зохиолын орчуулгын үлэмж арвин өвийг та бидэнд тус тус үлдээсэн байна.

Багштан молхи шавь миний биеийг шахаж шахамдуулан байж, хамтран орчуулж хэвлүүлсэн “Алс холын цагаан суварга”, “Хамгийн сүүлд хагдран унадаг навч” хэмээх хятадын хүүхдийн зохиолчдын бүтээл хоёр боть ном мөнхүү багшийн орчуулгын өв санд зүй ёсоор багтана.

Эртний хятадын их сэтгэгч Күнз ард түмний дунд түгэн тархсан 3000 шүлэг найргаас шилж сонгон, хураан цуглуулж, ариутган шүүж, эмхлэн цэгцэлж, 305 шүлэг бүхий уянгын болон магтаалын яруу найргийн эмхэтгэл “Шүлэглэлт ном”-ыг бүтээсэн гэдэг.

“Шүлэглэлт ном”-ын дотор багтсан шүлэг найраг, яруу дуулал нь цаг хугацааны хувьд НОТ-ын өмнөх XI-VI зууны үед хамаарагдана. Энэ утгаараа “Шүлэглэлт ном” бол эртний нангиад орны бүхэл бүтэн үеийн дүр төрхийг тусгасан уран зохиолын хосгүй гайхамшигт дурсгал юм. “Шүлэглэлт ном”-ыг дэлхийн олон улс оронд аль эртнээс дуун хөрвүүлэн орчуулж ирсэн байх агаад Орос улсад л гэхэд 1852 онд “Москвагийн хүн” сэтгүүлийн нэгдүгээрт “Шүлэглэлт ном”-ын шүлгүүдээс шилж, орчуулснаа “Күнзийн шүлэг” нэртэй хэвлэж байжээ.

Ц. Базаррагчаа багштан Монголд анх удаа “Шүлэглэлт ном”-ын сор дээж 70 шүлэг дууллыг дуун хөрвүүлэн орчуулж, 1999 онд “Шүлэглэлт ном” хэмээх бэсрэг ном хэвлүүлснээр тэрхүү сонгодог бүтээлийн шилдэг шүлэг дууллыг эх монгол хэлээрээ амтархан үзэхийн хувь бүрэлдэж, уншигч судлаачдын “оюуны цөгцөнд найргийн шар тос нэмсэн” буянтай үйл болсон юм.

“Шүлэглэлт ном” гээд нэрий нь аль хэдийнээ орчуулан, бичиг зохиолд олонтаа тэмдэглэсэн атал, уг номыг өдий болтол монголчлон орчуулаагүйн хамаг учир нь нэгд, “Шүлэглэлт ном” эртнийхээ бичгээр байгаа, хоёрт, шүлэг орчуулах нь хүүрнэл зохиолыг бодвол нэн нарийн хууль зүйтэй, манай эртний мэргэдийн орчуулгын онол зарчим нэн хатуу байсантай холбоотой болов уу” [2. 5] хэмээн багштан тэмдэглэжээ.

Хятадын аман зохиолд зан үйлийн яруу найраг чухал байрыг эзлэх агаад ийм зан үйлд холбогдох олон дуу “Шүлэглэлт ном”-д уламжилж иржээ. Ийм нэгэн шүлгийг монгол хэлнээ хэрхэн орчуулсныг жишээ болгон авч үзье:

Тэргүүлэгч цэцэг зулгарахуй

(Жао нутгийн дуу)

Тэргүүлэгч цэцэг сэм сэмхэн зулгарч эхэлмүй

Тэсч талаас илүүгүй нь зулгараагүй байнам

Тэргүүлэгч цэцэг сэм сэмхэн зулгарч эхэлмүй

Тэн хагасаас илүү нь одоохондоо зулгараадүй

Өлзий төгс өдрийн сайныг алдчих вий гэж

Ураглахыг хүссэн хархүү минь учирлах боллоо.

Тэргүүлэгч цэцэг сэм сэмхэн зулгарсаар байнамүй

Тэртэй тэргүй гуравны нэг нь үлдсэн баймүй

Өнөөдрөөс хойш ахиад хүлээж чадашгүйн гэж
Ураглахыг хүссэн хархүү минь учирлах боллоо.

Тэргүүлэгч цэцэг сэм сэмхэн зулгарсаар байнамуй
Тэвэр тэврээр болц нь ханасан жимсий нь түүнэмүй
Тэгэхээр одоо нэг ам нээх болсон биш үү гэж гуйнамуй. [2. 38]

Нэгэн гоо бүсгүй ураглахыг гуйн ирэх идэр залуу хоёрын хайр сэтгэлийн өрнөлийг тэргүүлэгч цэцэг хагдарч зулгарах, үр жимс нь боловсрох цаг хугацааны учир шалтгааны холбоонд оруулан шүлэглэснийг ийнхүү урнаар найруулахуйн ид хавийг илтгэн дуун хөрвүүлжээ. Энд монгол шүлгийн онцлогийг харгалзан, толгой холбох зорилгоор чимэг үг оруулан, шүлгийн аяс айзмыг жигдрүүлэх, сэтгэл хөдлөлийн чадлыг нь нэмэгдүүлэхийн тулд холбоо хоршоо үг хэрэглэх, үг давтах зэргээр үгсийн сангийн болон хэл зүйн хувиргалыг чадамгай хийснээр уран яруу, утга төгөлдөр орчуулга болж чаджээ.

Зэрэг хэргэмээ алдаж, мөхөж доройтсон нэгэн эрхтэн урд өмнө сайн сайхан явснаа гашуудан дурсаж буй гунил дууг хэрхэн монголчлон орчуулсныг шинжин үзвээс монголын шүлэг орчуулах эрдэм ухаан, урнаар найруулахуйн ур чадварыг хэрхэн илтгэн дуун хөрвүүлснийг бэлхнээ харж болно.

Хятад эх:

权輿
於! 我乎, 夏屋渠渠,
今也每食无馀.
于嗟乎! 不承权輿.
於! 我乎, 每食四簋,
今也每食不饱.
于嗟乎! 不承权輿. [4.174]

Хятад эхийг уг шүлгийн журмыг эвдэлгүйгээр үгчлэн орчуулбал:

Анхандаа

Ай! Би чинь, Асар минь өндөр их байв,
Харин өнөө хоол унд ч үгүй хоосон.
Гаслантайя! Анх байсан бүгд алга болов.
Ай! Би чинь, Амтат хоол аяга дүүрэн байв,
Харин өнөө ходоод хонхолзон өлөн.
Гаслантайя! Анх байсан бүгд алга болов.

Өвөрлөгч нутгийн дуун хөрвүүлэгч Дэлгэрсаны орчуулга:

Анхны дор (Чин газрын дуу)

Аяа хоохой! Ер нь би
Асар тагт дор сууж байсан бөлгөө,
Амуу будаа одоо нэгэнт тасарвай.
Ай халаг!
Анхны дор адилтгаваас өсөд зөрмүй.
Аяа хоохой! Ер нь би
Амтат идээнээр ширээ дүүрэн бөлгөө,
Арга алдартал одоо гэдэс өлсмүй.
Ай халаг!
Анхны дор адилтгаваас өсөд зөрмүй. [3.143]

Ц.Базаррагчаагийн орчуулга:

Түшмэдийн гуниглал (Чин нутгийн дуу)

Аяа! Би гэдэг
Асрын өндөрт аагиж явлаа.
Аяа! Гэтэл өнөөдрийн өдөр
Атгахан будаагүй өлөн.
Аяа! Хоохой!
Аагиж аахилж явсантай минь
Адилшаах юм огтхон ч алга даа.
Ээ-ээ! Хөөрхий!
Идээ будаанд бялуурч
Илийрч, бас халуурч явлаа.
Ээ-ээ! Тэгтэл өнөөдөр!
Идэх уухаар дутаж гуцаж
Өлбөрч, бас өрвөлзөж явна аа.
Ээ-ээ! Хоохой!
Илийрч бялуурч явсантай минь
Ижилсээх юм юу ч алга аа! [2. 41]

Юуны өмнө шүлгийн гарчгийг хэрхэн орчуулсныг үзвэл, өвөрлөгч эрдэмтэн Дэлгэрсан хятад орчуулгын онолын гол зарчим “шинь” (信) буюу “эх зохиолын үг утгасыг хатуу мөрдөн оноох” жаяг зарчмын дагуу, “Анхны дор” хэмээн орчуулсан бол, Ц.Базаррагчаа багштан шүлгийн нэвтрэн гарах хам утгаас нь ургуулан, “Түшмэдийн гуниглал” гэж өөр шинэ нэр үүсгэн орчуулжээ.

Тийнхүү зохиолын нэвтрэн гарч буй хам сэдэв, хам утгы нь түшин чөлөөтэй утгачлан, өөр шинэ нэр оноон орчуулдаг нь монгол орчуулгад эртнээс хэрэглэсээр ирсэн уламжлал, арга зарчмын нэг юм. “Шүй ху жуань”(水浒传) хэмээх хятадын алдарт зохиолын нэрийг монголоор “Усан булгамалын бичиг”, “Толын тохой”, “Мөрний хариг” гэх зэргээр янз бүрээр оноон нэрлэсэн байдаг. Гэвч энэ зохиол Монголд “Сүн улсын хүйтэн уулын бичиг” хэмээх нэрээр алдаршсан билээ.

Монголын эрдэмт гүүш нар уг номын нэрийг тийнхүү өөрөөр орчуулсан нь мэдэхгүйдээ буюу санамсаргүй гарсан мадаг яавч биш. Зохиолд эргэн тойрон усаар хүрээлэгдсэн Лянь шань буюу Лянь уулнаа нэг зуун найман зоригт эрс “тэнгэрийн хувь зохиолоор барилдаж, төрсөн нутаг ус өөр боловч, нэгэн эхийн хөвгүүд, элэг зүрхний зузаан янаг ах дүү болж, жаргах зовохыг хамт эдлэн” буй гайхам үйл явдлыг уран яруу дүрслэн өгүүлсэн зохиолыг нэвт гарч буй агуулгын хүрээнд нь авч үзэн, мөнхүү монгол орчуулгын уламжлалыг даган монгол ахуйд идээшүүлэн, усанд бус ууланд болж буй хэрэг явдал тул уулын нэрний ижил дуудлагыг нь зээлдэн зориуд “хүйтэн уулын” хэмээн нэрлэсэн бол уу. Бас уг эх зохиолын нэрнээ байхгүй ч гэсэн зохиолын үйл явдал Сүн улсын үед болж байгаа учраас уншигчдад илүү ойлгомжтой, сонирхолтой болгохын үүднээс “Сүн улсын” гэж зориуд тодотгосон байдаг.

Тайваний нэрт зохиолч, яруу найрагч Ши Мөрөн Монголын их бичгийн утгач Жамцын Бадраа асан анддаа өргөн барьсан магтаал дууг Ц.Базаррагчаа багштан дуун хөрвүүлэхдээ “Алсран одох нь үгүй” хэмээн мөнхүү шинэ нэр оноон орчуулжээ.

Алсран одох нь үгүй

(Ж.Бадраа анд нөхөртөө өргөн барьсан магтаал дуу)

...Өндөр дээдсий минь зүрхээр дамжин дуурьссан дуу
Өнөд үр хойчисынх нь цээжинд хадаатай гэсээн чи
Тиймээ, дотно анд минь ээ, бид мартаагүй ээ
Аялгуу дуу маань дундраагүй цагт, дуусаагүй цагт
Ая эгшгий чинь сонсоно оо, сонссон шүү дээ...

Чин найрсуу анд минь ээ, сонсон таалж ажааму
Чиний л учир дуурсах дуу, чиний л тул мөнхрөх дуу
Чээжин дотроос аль алин нь алсран одох нь үгүй ээ...[5.13]

Багштан уг шүлгийг дуун хөрвүүлэхдээ, энэ хоёр эрхэм хүмүүнтэй уулзаж учирч явсан хүний хувьд, андын агуу их нөхөрлөлийг нь мэдэх хүний хувьд шүлгийн гүн чанадад элэг зүрхээрээ уусан шингэж, сэтгэлийн хүчит давалгаан дунд уяран хайлан байж, онгод юугаан хөглөн байж орчуулсан нь мэдрэгддэг юмаа. Ийм орчуулгын чухамдаа “увдис чацуу орчуулга” хэмээн нэрлэдэг бөлгөө.

Дээр өгүүлсэн “Түшмэдийн гуниглал” шүлэгт яруу дуудал, яруу асуулт, яруу хандал зэргийг өргөн хэрэглэн сэтгэлийн уярал, догдлол, гуниг шаналлыг хүчтэй илэрхийлснийг Ц.Базаррагчаа багштан “Аяа! Би гэдэг”, “Аяа хоохой!”, “Ээ-ээ! хөөрхий!”, “Ээ-ээ хоохой!” гэхчлэн уран дуудал, уран хандлыг чадмаг хэрэглэн орчуулснаар хятад шүлгийн журмыг төдий л эвдсэнгүй, харин санааг нь улам хурцлан, үзэхүйд нүднээ тод тунгалаг, сонсохуйд чихнээ яруу тунгалаг шүлэг болжухуй.

Нөгөөтэйгүүр Ц.Базаррагчаа багштан эх шүлгийн нийт үг үсэг, хэлбэр журмыг төдий л хатуу мөрдөлгүй, шинэ үг илэрхийлэл, хоршоо холбоо үг нэмэн шүлгийн сэтгэл хөдөлгөх чадлы нь илтгэхийг илүүтэй анхаарсан нь ажиглагдана. Тухайлбал, “аагиж аахилж”, “илийрч халуурч”, “өлбөрч өрвөлзөж” гэхчлэн холбоо хоршоо үг хэрэглэж, “Аяа”, “Ээ-ээ” гэсэн яруу дуудлыг шинээр нэмэн, толгой холбож, мөрийн хэмжээг тэгшитгэсэн байна. Энэ бол монгол шүлгийн орчуулгын нэгэн чухал уламжлал зарчим билээ.

Академич Ц.Дамдинсүрэн “...Шүлгийг орчуулах гэгч үг утгыг орчуулах төдий биш, түүний найруулгын хэв журам ба уран хэл, сэтгэлийг хөдөлгөх чадлыг бүрнээ орчуулах хэрэгтэй. ...Мөн тэрчлэн нэг үгийг ямагт нэг үгээр орчуулахад их л бэрхтэй, хэд хэдэн үгийг хэрэглэх ба зарим үгийг ондоо үгээр орчуулах ч учир гарна. Гагцхүү утгыг алдахгүйг хичээх хэрэгтэй. Нэг талаас үгийг хэтэрхий баримталбал утгыг алдана. Бас нөгөө талаас үгийг хайхрахгүй ахул уг эхээс хэтэрхий холдож орчуулга гэж таньшгүй болно” [1. 282] хэмээн орчуулагч дуун хөрвүүлэгчийн мөрдвөл зохих зарчмыг дурдсан байдаг билээ.

“Монгол шүлгийн мөр нь урт болбол уншихад нуршилтай болох мэт тул эрхбиш богино мөртэй шүлгээр орчуулах” [1.288] чухал байдаг. Академич Ц.Дамдинсүрэн А.С.Пушкиний “Олег цэцний дуулал”-ыг орчуулахдаа хөнгөн амархан шүлэг болгохын тул мөрийг богино болгох, нөгөө талаар утгыг бүрэн бүтэн орчуулахын тул мөрийг урт болгох, ...энэ хоёр зүйлийн үүргийг гүйцэтгэхийн тул нэг мөрийг хоёр мөр болгож орчуулсан [1. 289] туршлагаа өгүүлсэн байдаг. Тэрбээр монгол ардын аман зохиолын дууны шүлэг ихэнхдээ гурван үгт шүлэг байдгийг бас дурдсан билээ.

Ц.Базаррагчаа багштан дээрх шүлгийг монголчлохдоо хятад эхийн арван мөрийг арван зургаа болгон мөрийн тоог нэмж, харин мөр тус бүрийн үгийг гурваас дөрвөн үгэнд багтаан орчуулжээ. Тийнхүү мөр богино, шүлэг хөнгөн болж, ардын аман зохиолд илүү ойртон, унших сонсохуйд яруу сонсголонтой болсон байна. Ингэж орчуулснаар хятад шүлгийн журам төдийлөн эвдэрсэнгүй, үүнийг мөн найман мөр шүлэг болгон уншихад харшлах зүйлгүй байна. Тийнхүү хувиргаж үзвэл:

Аяа! Би гэдэг, Асрын өндөрт аагиж явлаа.

Аяа! Гэтэл өнөөдрийн өдөр, атгахан будаагүй өлөн.

Аяа! Хоохой! Аагиж аахилж явсантай минь

Адилшаах юм огтхон ч алга даа...

Шүлэг орчуулах нь амар хялбар зүйл биш ээ. Тэр тусмаа олон зууны тэртээ зохиогдож ам дамжин уламжилж, боловсорч ирсэн ардын аман зохиолын сонгодог шүлэг дууллыг дуун хөрвүүлэх нь орчуулагчаас чухамдаа “сайтар тохиолдуулах”, “урнаар найруулахуйн” нарийн ур ухаан, эрдэм чадвар шаарддаг болой.

Ц.Базаррагчаа багштаны “Шүлэглэлт ном”-ын орчуулгаас үзэхэд, уг хятад эхээс нь хазайлгүйгээр, бас үг үсэгчлэн мөрдөлгүйгээр, уран сайхнаар шүлэглэн, шүлгийн яруу санаа, уран дүрслэлийг бүрнээ илтгэхийн хичээхийн хамт, монгол

орчуулгын уламжлал, зарчимд бүтээлчээр нийцүүлэн, “монгол хэлний шүлэг зохиох хамаг чадлыг бүрнээр хэрэглэж орчуулахыг” ихэд чухалчилсан нь харагддаг юм.

XX зууны сүүлийн хагаст хятад хэлнээс монгол хэлнээ орчуулсан хятадын уран зохиолын зүйлийн дотор Тан улсын (618-906 он) яруу найргийн орчуулга чухал байрыг эзэлдэг. Монголын түмэн зүтгэлт дуун хөрвүүлэгчид Тан улсын яруу найргаас тийнхүү зориуд шилж сонгон орчуулдаг нь ер санамсаргүй хэрэг биш ажгуу. Учир юун хэмээвээс Хятадын уран зохиолын түүхнээ Тан улсын үе онцгой чухал байрыг эзлэх агаад энэ үеийг “Хятадын яруу найргийн алтан үе” хэмээн нэрлэдэг билээ. Оросын нэрт эрдэмтэн академич Н.И.Конрад энэ үеийг Европын сэргэн мандлын үетэй утга чанар нэг хэмээн адилтган дүгнэсэн байдаг.

Тан улсын үеийн 2300 гаруй шүлэгчийн 50000 орчим шүлэг найргийг багтаасан “Тан улсын бүрэн шүлэг” хэмээх түүвэр бидний үед уламжлан иржээ. Тан улсын яруу найргийн хөгжлийн үе шатыг түрүү үе (618-712 он), бадралын үе (713-765 он), дунд үе (766-826 он), хожуу үе (827-907 он) гэж дөрөв хуваан үздэг. Түүний дотор яруу найргийн бадралын үед (713-765 он) хятадын сонгодог яруу найргийн тэнгэрт мөнхөрсөн дөрвөн их найрагч төрөн гарсан нь Ли Бай, Дү Фү, Ван Вэй, Мэн Хао Рань нар юм. Тэдний шүлэг найргаас Монголын нэртэй яруу найрагч, дуун хөрвүүлэгчид шилж сонгон, тансаг сайхан монгол хэлээр дуун хөрвүүлэн орчуулснаар, монголын уншигчид тэрхүү сод шүлэгчдийн яруу найргаас эх хэлээрээ шимтэн уншиж, хятадын сонгодог яруу найргийн охь дээжистэй танилцсан билээ.

“Тэнгэрийн иргэн-Тэнгэрлэг найрагч “хэмээн нэрлэгддэг Ли Бай (701-762 он)-н тансаг сайхан шүлэг найргаас 35 шүлгийг нь сонгон, Монголын нэрт яруу найрагч Б.Явуухулан, нэрт яруу найрагч, орчуулагч Ч.Чимид нар орос хэлнээс монгол хэлнээ дуун хөрвүүлэн, 1960 онд “Шүлгүүд” хэмээх бэсрэг ном хэвлүүлсэн нь эдүгээ уран сайхны орчуулгын үнэтэй өв болсоор байна.

Дорнын их найрагч Б.Явуухулангийн “...их найрагчийн уран бүтээлийг эх хэл дээр нь буюу ядаж нэг удаа орчуулагдсан хэл дээр уншвал улам ч амттай” [6.18] хэмээсэн ерөөл хүслийг энэ зууны 80-90-ээд оны дундуур Ц.Базаррагчаа багштан болон шавь нар нь гүйцэлдүүлсэн билээ. Бүрэн бус тоогоор, Багштан Ли Бай, Дү Фү, Ван Вэй нарын 20 гаруй шүлэг найргийг монгол хэлнээ хятад эхээс нь дуун хөрвүүлжээ.

Дэлхий дахинаа ихэд алдаршсан “Намуун шөнийн бодол” хэмээх гайхамшигт шүлгийг хэрхэн орчуулсныг үзье. Дашрамд дурдахад, энэхүү алдарт шүлэг 2015 онд “Дэлхийн яруу найргийн өдөр”-ийг тохиолдуулан НҮБ-аас гаргасан цуврал марк дээр хятад, англи хэлээр мөнхөрсөн түүхтэй юм.

Уг шүлгийн хятад эх нь: 静夜思
床前明月光,
疑是地上霜。
举头望明月,
低头思故乡。

Орос орчуулга нь:

Думы тихой ночью

У самой моей постели
Легла от луны дорожка.
А может быть, это иней?—
Я сам хорошо не знаю.
Я голову поднимаю---
Гляжу на луну в окошко,
Я голову опускаю
И родину вспоминаю.

Яруу найрагч Б.Явуухулан, Ч.Чимид нарын орчуулга:

Намуун шөнийн бодол

Орны минь дэргэд жим мөр шиг
Сарны туяа тусав.
Орой намрын хяруу ч юм уу
Ёстой бүү мэд.
Тэргүүнээ би дээш нь өргөж
Гэгээвчээр сарыг ширтлээ.
Тэгмэгцээ доош нь гудайлгаж
Эх нутгаа саналаа.

Ц.Базаррагчаа багштан хятад хэлнээс орчуулсан нь:

Намуун шөнийн бодол

Орны минь өмнө унасан сарны гэрэл
Орой намрын хяруу мэт цавцайна.
Толгой өндийн сарыг ажиглахуйяа
Тонгойж гудайн эх нутгаан санагалзвай.

Б.Явуухулан, Ч.Чимид нар орос эхийг барин дам орчуулахдаа, “хятадаас орост, оросоос монгол хэлэнд дамжсаныг зүйрлэвэл, хятад торгыг усанд хоёр дахин дүрж гаргасантай төс нэгэн буй” хэмээн өөрсдийн орчуулгыг ихэд голон буйгаа тэмдэглэсэн нь буй.

Ц.Базаррагчаа багштан уг шүлгийг хятад хэлнээс хөрвүүлэхдээ, хятад шүлгийн журмыг огт эвдэлгүйгээр, дөрвөн шад болгон, монгол ахуйд ойртуулан, яруу сайхан орчуулсан байдаг. Тухайлбал, шүлгийн хятад эхийг үзвээс “хяруу” гэж байхаас бус “орой намрын” гэсэн үг хэллэг байхгүй. Гэтэл хяруу орой намар буудаг жамтай билээ. Ц.Базаррагчаа багштан “Орой намрын хяруу” хэмээн оноон, монгол шүлгийн журмаар толгой холбон орчуулсан нь монгол хүн уншиж, сэтгэл хөдлөн, таашаал авахад улам хүч нэмсэн яруу найруулга болжээ. Үүнийг уг шүлгийн сэтгэл хөдөлгөх чадлы нь илтгэх, эх нутагаа санасан хүний сэтгэлийн хөнгөн гунигийг илүү

тод хүчтэй илэрхийлэх, шүлгийн яруу сайхныг бүрнээ илтгэн, монгол уншигчийн сэтгэл зүйд улам ойртуулах зорилгоор хийсэн уран сайхны найруулгын нэг жишээ гэж хэлж болох буйзаа.

Өөр нэгэн шүлгийн орчуулгыг авч үзье.

Уг шүлгийн хятад эх нь:

望庐山瀑布
日照香炉生紫烟
遥看瀑布挂前川。
飞流直下三千尺
疑是银河落九天。

Орос орчуулга нь:

Смотрю на водопад в горах Лушань

За сизой дымкою вдали
Горит закат,
Гляжу на горные хребты,
На водопад.
Летит он с облачных высот
Сквозь горный лес –
И кажется, то Млечный Путь
Упал с небес.

(Переводы А. Гитовича)

Яруу найрагч Ч.Чимид орос хэлнээс орчуулсан нь:

Лушань уулан дахь хүрхрээг харахад

Алсын буурал униарын тэртээ
Улбар туяа татав.
Арсгар уулыг би ширтэж
Урт хүрхрээг сонирхов.
Үүлэрхэг өндрөөс буусан хүрхрээ
Уулын хөвчийг зүсчээ.
Үзтэл, тэнгэрийн зүйдэл дорогшоо
Унасан юм шиг сунажээ.

Ц.Базаррагчаа багштан хятад хэлнээс орчуулсан нь:

Лу уулын хүрхрээг ажиглахуйяа

Хүлс хадыг наран ээхүйеэ, манан суунаг татаж
Хүрхрээн усан гурван мянган тохой өндрөөс
Гол руу, шаагин шуугин, цэнхэртэн буухуй нь
Газар руу, тэнгэрийн заадал тэр чигээрээ унах мэт ээ

Эхний орчуулгад мөн орос орчуулгын шүлгийн журмыг баримтлан, найман шад болгон орчуулжээ. Уг шүлгийн эх зохиол нь тус бүр долоон ханз үсгээс бүтсэн дөрвөн шад шүлэг байна. Ц.Базаррагчаа багштан орчуулахдаа хятад шүлгийн журмыг хэвээр хадгалан, зэрэгцүүлэн толгой холбон шүлэглэжээ.

Орчуулах, дуун хөрвүүлэх хэрэгт тохиолддог хамгийн адармаатай, бас маргаантай нэг зүйл бол үндэстэн угсаатан хоорондын өөр өөр соёл, түүний ялгаа зөрөөг хэрхэн зөв нээж илэрхийлэх, дамжуулах асуудал юм. Нэгэн соёлын дотор орших ер энгийн зүйлийг өөр нэгэн соёлд ихээхэн хүч ухаан зарж тайлбарлах, дамжуулах явдал орчуулах, дуун хөрвүүлэх хэрэгт алхам тутам тааралддаг. Өөрөөр хэлбэл, тухайн үндэстэн угсаатны соёлын ухагдахууныг орчуулж дамжуулахдаа уншигч хүнд ойлгомжтой байхыг чухалчлах уу, эс бөгөөс эх бичвэрт үнэнч байхыг чухалчлах уу гэсэн асуулт зүй ёсоор урган гардаг. Эдүгээ аливаа нэг үндэстэн угсаатны соёлын ялгаа зөрөөг дамжуулж илэрхийлэхдээ орчуулгын нэгэнт тогтож хэвшсэн хэв загвар хийгээд уламжлалт орчуулгын арга ухааныг хатуу баримтлан, утга санаа дүйх үг хэллэгээр шууд дүйлгэн орлуулах бус, харин тухайн соёлын учир холбогдол, гарвал түүх, ялгаа зөрөө, өвөрмөц онцлог зэргийг тал талаас нь тунгаан нягталж, оновчтой илэрхийлэх явдлыг чухалчлах болж байна. Үүнийг судалдаг ухааныг соёлын орчуулга судлал хэмээн нэрлэж байна. Соёлын орчуулга судлалын үндсэн арга зарчим, стратеги нь “идээшүүлэх” (domestication, доместикац 归化) ба “ондоошуулах” (foreignization, форенизация, 异化) юм. Өөрийн үндэснийхээ соёлыг гол цөм болгон, эх бичвэр дэх харь үнэлэмжийг орчуулж буй хэлнийхээ соёлд шингээн, өөрийн хөрснөө нутагшуулж идээшүүлэх үү?, эсбөгөөс эх бичвэрийг гол цөм болгон, эх бичвэрт буй хэл, соёлын ялгаа зөрөөг хэвээр хадгалан, харь соёлыг таниулж, ондоошуулах уу гэсэн сонголт дуун хөрвүүлэгчийн өмнө тулгардаг. Базаррагчаа багштаны дээр дурдсан шүлгийн орчуулгыг энэ үүднээс шинжвээс, идээшүүлж, ондоошуулсан тодорхой жишээг олж харж болно.

Монгол хэлний “Тэнгэрийн заадас”, “Тэнгэрийн оёдол” хэмээх ухагдахууныг өрнө дахинд орос, англи хэлнээ “Сүүн зам” (“Млечный Путь”, “Milky Way”) хэмээн нэрлэдэг, дорно дахинд хятад хэлнээ “Тэнгэрийн гол”, “Мөнгөн гол” (“天河”, “银河”) хэмээн нэрлэдэг. Тийнхүү өөр өөрөөр нэрлэдэг нь тухайн үндэстэн угсаатны ертөнцийг үзэх үзэл, таньсан танилт, үнэлэмж, үндэстний соёлын ялгаа зөрөөг илтгэх агаад тэрхүү ялгааг тус тусынх нь домог түүхээс нь тодорхой мэдэж болдог.

Тийнхүү орос хэлний **“сүүн зам”**, хятад хэлний **“мөнгөн гол”**-ыг монгол хэлний утга тохирох үгээр дүйлгэн, **“тэнгэрийн заадал”** хэмээн утгачлан дуун хөрвүүлсэн нь уламжлалт орчуулгын аргын үүднээс үзэхүл **“мэдэхүйеэ хялбар”** байх жаяг зарчимд нийцэж, **“идэшүүлэхийн”** жишээ болж байна.

Орос хэлнээс орчуулсан орчуулгад **“гурван мянган тохой”** гэсэн хэллэгийг **“урт”** гэсэн нэг л үгээр орчуулжээ. Хятадаас оросоор орчуулсныг үзвэл энэ үг бас алга байна. Магадгүй орос уншигч **“тохой”** гэсэн дорно дахины уртын хэмжээний ухагдахууныг ойлгоход бэрхтэй тул тийнхүү дөхөмчлөн орчуулсан байж болох. Тэгвэл хятад хэлнээс дуун хөрвүүлсэн орчуулгад уг хэллэгийг шууд үгчлэн **“гурван мянган тохой өндөр”** хэмээн буулгасан нь нэг талаар монгол ахуйд шууд буун, уншиж сонсоход илүү яруу сайхан найруулга болж, нөгөө талаар тухайн үндэстний соёлыг хэвээр хадгалан, уламжлалт орчуулгын **“утга төгс”** байх жаяг зарчимд нийцэж **“ондоошуулах”**-ын жишээ болж чадсан байна.

Аугаа их эрдэмтэн, академич Бямбын Ринчен **“...өөрийнхөө өв соёлын талаар их нямбайлж, цаад орчуулах редакторлах гэж байгаа зохиолын холбогдолтой өв соёлын зүйлийн учры нь олж мэдэхгүй бол, муугаа үзүүлж, муухайгаа дуудуулахаас гадна уг зохиолын утгыг гажуудуулахад хүрдэг юм байна гэдгийг бодууштай байна”** [7.123] хэмээн өгүүлсэн байдаг билээ.

Дээр өгүүлсэн хоёр жишээг монгол орчуулгын нэгэн уламжлал, онол зарчимтай холбон ойлгож болох юм. Доктор, профессор Л.Хүрэлбаатар агсан утгачлах үгчлэх хоёрыг хэт туйлшруулах бус, **“...чухамхүү “цаг үеийг нь олохын эрхээр” гэдэг орчуулгын гол онолын дагуу, дууг (үгийг) ямарчлан байсан ёсоор нь орчуулах зохистой газар дууг хатуу баримталж нэрэнд зүүх ба дууг заримдаа утгачлах зохистой газар утгыг хатуу барьж нэрэнд зүүхийн үүднээс, тухайн орчуулгын бүтээлийн ямар агуулгатайгаас, хэнд юунд хандсан хэрэгцээ зориулалтаас шалтгаалан, харилцан их өөр өөр байж болохыг”** [8.134] бүтээлдээ тэмдэглэсэн билээ. Орчуулагч **“Гурван мянган тохой”** гэснийг **“өндөр”**, **“урт”** гэхчлэн орчуулсангүй, монгол хүний сэтгэлд буух талыг нь бодолцон шууд үгчлэн орчуулсан нь **“дууг ямарчлан байсан ёсоор нь орчуулах зохистой газар дууг хатуу баримтлан нэрэнд зүүсэн”**, харин **“хяруу”** гэснийг монгол ахуйд илүү ойртуулан, санааг нь хурц тод, яруу сонсголонтой болгохын үүднээс **“орой намрын хяруу”** гэж шинэ үг үүсгэн орчуулсан нь **“дууг заримдаа утгачлах зохистой газар утгыг хатуу барьж нэрэнд зүүсэн”** жишээ хэмээн холбон ойлгож болох буй заа.

Тиймээс ч энд өгүүлсэн жишээ бол орчуулгад ганц нэг үг хэллэг нэмэх, хасахтай холбоотой төдий хэрэг бус, эцсийн бүлэгтээ монголын уран сайхны орчуулгын уламжлал, арга зарчим тасралтгүй хөгжин боловсорч, тэр нь шинэ нөхцөлд шинэ хэлбэрээр илрэн тодорч байдгийн нэг жишээ гэж үзвээс зохилтой.

Монгол Улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, нэрт эрдэмтэн, зохиолч, яруу найрагч С.Дулам багштан **“Сэргэн мандлын яруу найрагт бадрангуйн хүслэнгийн (романтизм) дууллыг Ли Бай анх авчирсан бол, аж амьдралын дүр зургийг (реализм) Дү Фү анх бүтээсэн”** хэмээн тэмдэглэсэн байдаг. Тэгвэл сод

найрагч Ван Вэй хятадын яруу найргийн тэнгэрт “Үзэмж төгс байгалийн их дууч”, “Уул ус ургамал цэцэгсийн дууч” хэмээн нэрлэгддэг.

Базаррагчаа багштан Дү Фү, Ван Вэй нарын олон гайхамшигт шүлгийг монголчлон дуун хөрвүүлсэн билээ. Тэдгээрийн нэг нь Дү Фүгийн **“Хаврын шөнийн баяслын хур”** хэмээх шүлэг юм.

Баяслын хур, цаг юугаан олж орохуйн цагт
Бодис болгон, хавартаа шимийг хүртмүй.
Салхин аясаар, шөнө дөл рүү уусан живэх
Сав шим ертөнц, огтхон ч анир чимээгүй
Хээрийн жим, үүлэн хоёр хав харанхуй
Хөлөг онгоцны өнчин гэрэл л тов тодхон...

Монгол сонгодог бичгийн хэлний яруу найруулгаар нүдэнд ургаж, сэтгэлд шингэтэл зураглан дуун хөрвүүлсэн нь энэ юм.

Ван Вэй шүлгийн яруу тансаг нь уян налархай хийгээд утгын гүн чанадад оршдог хэмээн үздэг. Энэ нь буддын шашны дияан бясалгалын ёсны бодь мөрийг танин ухаарах хэмээх ойлголттой дүйдэг байна. Дияан бясалгалын ёсонд хоосон чанарын дээд хүслэнд хүрэхийн төлөөнөө уул аглагийн газар хүсэл сэтгэлийг тэвчин сууж, байгалийн үзэсгэлэн төгсийг бие сэтгэлээрээ мэдрэн, мөнх орших сансар огторгуйн уг чанарыг ухаарч, номын ёсонд гэгээрэх агаад энэ нь шүлэг найрагт тусахдаа ер бусын өвөрмөц яруу сайхныг цогцлоодог ажээ. **“Хулсан шугуйн гэрт”** хэмээх шүлгийн орчуулгыг үзвэл:

Хулсан шугуйн аглагт гав ганцаар суун
Хуур цуур татан уйтгарлан гэнгэнэнэм.
Ногоон шугуйнаа суугч тэр эрийг хэн мэднэм
Гэгээн саран айлсан ирж гийгүүлнэм.

Зэрвэсхэн сонсохуйд өвөрмөц содон зүйл үгүй мэт эгэл ерөмдөг энэхүү дөрөвт шүлэг олон үеийн туршид хүмүүний сэтгэлийг хөвсөлзүүлэн татаж ирсний гайхамшиг нь хүн байгалийн амин холбоо, хүмүүний сэтгэлийн дээд хүслэнг шигтгэж зурагласанд оршдог хэмээн үздэг. Зогсонги, хөдлөнги хоёрыг онолдуулан, зогсонгийн дунд хөдлөнги оршиж, нам сэлүүний дунд эгшиг дуун уянгалсан уран яруу дүр дүрслэл хэмээдэг.

“Уулсын нутгийн намар оройн бороо” хэмээх шүлгийн орчуулгыг үзвэл:

Ажин түжин уулнаа орсон бороо онгойсон хойно амой
Агаар сэрүүн, тунгалаг ану намар оройн цаг амой
Гэгээн саран нарсан ойн намиан завсраар гийгүүлнэмү
Цэгээн булаг уулын чулуу дамжин харьгин харьгилнаму

“Шүлгийн дундаас зураг тодорч, зургийн дундаас шүлэг эгшиглэдэг” нь Ван Вэйн шүлэг найргийн гол гайхамшиг гэдэг. Шүлгийн гүн сэтгэлгээ, зургийн уран санаа, хөгжмийн айзам эгшиг хослон дуурсаж, харилцан уусч, хүмүүний сэтгэл санаа, зан ааль, төрх байдал, хүсэл эрмэлзэл, орь хүслэн бүхэн багтаж, тийнхүү шүлгийн сэтгэлгээ, зургийн санаа, яруу уянга хэм тэгширснээр сая “шүлгийн дундаас зураг тодорч, зургийн дундаас шүлэг эгшиглэсэн” бүтээл төрдөг ажгуу. Багштан Дү Фү, Ван Вэй нарын шүлэг найргаас монголчлон орчуулахдаа “шүлгийн дундаас зураг тодорч”, “зургийн дундаас шүлэг эгшиглэдэг” тэрхүү онцлогийг нь ихэд чухалчлан, монгол хэлний яруу найруулгын олон боломжийг чөлөөтэй хэрэглэн дуун хөрвүүлснээр шүлгийн сэтгэлгээ, зургийн санаа, сэтгэлийн уянга бүхэн өвч цогцолж, чухамдаа “хүмүүний сэтгэлийг хөвсөлзүүлэн” долгиусулсан орчуулга болсон байдаг.

Багштаны зөвхөн яруу найргийн зохиолын орчуулгын тухайт цухас өгүүлэхүйд ийм буюу. Үүнээс гадна үргэлжилсэн үгийн буюу хүүрнэл зохиолын орчуулгын баялаг өв судлах шинжлэх эзнээ хүлээн буй.

Эдүгээ Ц.Базаррагчаагийн орчуулгын дэг сургууль нэгэнт бүрдэн тогтож, олон шавь нар нь үйл хэргийг нь залгамжлан хөгжүүлж байна. Багштан болбоос сүүн цагаан мөртэй, шударгуу шулуун зантай, шавийн төлөө халуун сэтгэлтэй хүн байлаа. МУСГЗ Цэрэнгийн Сүрэнжав, МУСГЗ Ядмаагийн Ганбаатар, нэртэй дуун хөрвүүлэгч Доржсүрэнгийн Болдбаатар гэхчлэн Монголын нангиад хэлний орчуулгын хүрээлэнд “дээгүүр суудалтай, дээж амсах хувьтай” олон шилдэг дуун хөрвүүлэгчийг төрүүлж, гараас нь хөтлөн, хөлийг нь дөрөөнд хүргэсэн ачтан юм.

Багштан болбоос чухамхүү өөрөө дуун хөрвүүлэн шүлэглэсэнчлэн “Чиний л учир дуурсах дуу, чиний л тул мөнхрөх дуу”-гаараа “Чээжин дотроос алсран одох нь үгүй” нэртэй бичгийн утгач мөнөөс мөн билээ.

Ном зүй

1. Дамдинсүрэн.Ц. Бүрэн зохиол. Гутгаар дэвтэр. Оршил тайлбар сэлт ном зүй үйлдэж хэвлэлд бэлтгэсэн Цэдэв.Д. УБ., 2001.
2. Шүлэглэлт ном. Орчуулсан Базаррагчаа.Ц. УБ., 1999.
3. Шүлэглэлт номын сонгомол орчуулга. Дэлгэрсан орчуулав. Үндэстний хэвлэлийн хороо. 1985.
4. Шүлэглэлт ном. 诗经. Тайюань. 2003
5. Ши-Мөрөн.Р “Цагаан хэрэмний чанад нутгийн дуу” Орчуулсан Ц.Базаррагчаа УБ., 2006
6. Явуухулан.Б, Чимид.Ч. Ли Бо. Шүлгүүд. УБ., 1960.
7. Ринчин.Б “Марк Твений минь махы нь идэж дээ...!” УБ., 1991
8. Хүрэлбаатар.Л “Судар шастирын билиг” УБ., 2002

Ф.Х.БӨРНЭТИЙН “НУУЦ ЦЭЦЭРЛЭГ” ЗОХИОЛЫН МОНГОЛ ОРЧУУЛГАД ХИЙСЭН АЖИГЛАЛТ

М.Нарангэрэл¹

Товч утга: Орчуулгын уран зохиолын ном олноор хэвлэгдэн гарч, дэлхийн алдартай шилдэг бүтээлүүдийг эх хэлээрээ унших таатай нөхцөл бүрдэж байна. Харь хэлнээс орчуулсан ном зохиолууд нь зарим талаараа орчуулгын алдаа мадагтай, уран дүрслэл багатай, эх зохиолынхоо санааг дутуу дулимаг, эндүү ташаа буулгасан нь энэ асуудалд анхаарал хандуулах цаг болсныг харуулж байна.

Түлхүүр үгс: Орчуулгын алдаа, харьцуулсан судалгаа, уран зохиолын орчуулга, чөлөөт орчуулга, найруулгын алдаа, утгын алдаа,


Уран зохиолын орчуулга бол тухайн улс үндэстний хэл, түүх соёл, зан заншил, уламжлал, амьдралын хэв маяг, сэтгэлгээний онцлог зэргийг танин мэдэх гүүр болдог. Монголын уран зохиолд гадаадын уран зохиолын орчуулгын бүтээл нэлээд байр суурийг эзэлдэг бөгөөд монголын үе үеийн орчуулагчид дэлхийн сор болсон зохиол бүтээлийг орчуулан монголын уншигч олонд хүргэсээр ирсэн. Сүүлийн жилүүдэд гадаад хэл суралцагчдын тоо нэмэгдэхийн хэрээр дэлхийн бусад үндэстний зохиол бүтээлийг эх хэлнээс нь орчуулах явдал эрчимтэй өрнөж байна. Үүний дотор англи хэлнээс орчуулсан хүүхдийн уран зохиолын тоо багагүй хувийг эзэлдэг.

Хүүхдийн уран зохиолын талаар судалгаа, эрдэм шинжилгээний бүтээл, танин мэдэхүйн гарын авлага, толь нэлээд байгаа боловч орчуулгын бүтээлийг хянан хэвлэх, хэрхэн орчуулсныг харьцуулан судлах, дүн шинжилгээ хийх ажил тун хомс байгаа нь хэл шинжлэлийн хийгээд уран зохиолын орчуулгын онол, практикийн нэг чухал асуудал болж байгаа юм.

Орчуулгын нэрт онолч, Америкийн нэрт эрдэмтэн Южин Найдагийн тодорхойлсноор “Орчуулга гэдэг нь эх хэлээр /source-language/ буй утга агуулгыг /message/ хүлээн авагч хэлээр /receptor language/ буюу зорилтот хэлээр /target language/ илэрхийлж, эн тэргүүнд утгын /meaning/, удаад нь хэв маягийн /style/ хувьд адил тэнцүү байхыг хэлнэ.” гэжээ. (Nida, E., and Taber, C., 1969:16) Түүнийхээр эх хэлээр буй утга агуулга нь 1) задлан шинжлэх, 2) дамжуулах, 3) дахин бүтэцжих гэсэн гурван үе шатыг дамжиж байж зорилтот хэлээр /target language or receptor language/ илэрхийлэгддэг. Өөрөөр хэлбэл, эх хэлээрх утга агуулга нь орчуулагч хэмээх гуравдагч биеэр дамжин дээрх гурван үе шатыг

¹ МУИС, ШУС, ХУС-ын магистрант

дамжсаны үр дүнд зорилтот хэл рүү орчуулагдаж буй хэрэг юм. Иймд эцсийн бүтээгдэхүүн орчуулагчаас буюу түүний мэргэжлийн ур чадвар, арга барил, эх болон зорилтод хэлний мэдлэгийн түвшин, оюуны цар хүрээ гэх зэргээс шууд хамааралтай болж байна. Нөгөө талаар орчуулгын чанарын асуудал мөн эндээс л үүдэн гарна.



Эртнээс нааш 1) чөлөөт орчуулгын, 2) үгчлэх, 3) төгс орчуулах гэсэн гурван арга голчлон ноёрхож ирсэн байдаг талаар эрдэмтэн Д.Дашдаваа агсан бүтээлдээ дурдсан байдаг. Тэрбээр чөлөөт орчуулгын аргыг хэрэглэдэг орчуулагчдыг өөрийн дураар зохиолчийн санааг засах, шаардлагагүй газар үг өгүүлбэр нэмэх, чухал боловч орчуулахад бэрхшээлтэй хэсгийг хасах зэргээр дур зоргоор орчуулж буй талаар тэмдэглэжээ. Мөн зарим орчуулагч чөлөөт орчуулгын аргаас зайлсхийхдээ үгчилсэн орчуулга руу хальтран орж буй талаар ч хөндсөн байна. Бүтээлч сэтгэхүй үгүй орчуулагч харь хэлний үг хэллэгийг үг үсэгчлэн буулгаж, хар муйхраар эх сэдвийг эх хэлнээ дамжуулах буюу нэг хэлний хэлзүй, үгсийн сан, найруулга зүйн онцлогийг эс анхаарч нөгөө хэлний зүй тогтол, бүтэц өгүүлбэрийг сохроор дагаж мөрдсөний уршгаар гарсан орчуулгыг үгчилсэн буюу махчилсан орчуулга гэдэг. Харин төгс үнэн зөв орчуулга нь зохиогчийн бодол санааг аль болохуйцаар уншигчдад ойлгомжтой хэлбэрээр бүрэн гүйцэд гаргаж, уг зохиолын найруулгын өнгө аясыг зөв буулгахад оршдог. Уран зохиолын орчуулгын тухайд өөр хоорондоо нягт уялдаа холбоо бүхий хоёр ухагдахууныг тэмдэглэдэг. Үүнд:

1. Нэг хэлнээ байгаа зохиол бүтээлийг өөр хэлнээ хөрвүүлж гаргаж буй бүтээлч үйл явц
2. Энэхүү үйл явцын үр дүн болох орчуулга хэмээсэн байдаг. (Д.Дашдаваа 2010:86)

Түүний хэлснээс харахад бүтээлч гэдэг үг маш чухал санааг гаргаж байгаа санагдана. Чөлөөт орчуулга, үгчилсэн орчуулгыг бүтээлч сэтгэхүй төгс орчуулгад хөтлөх санаа буй.

19-р зууны Америкийн хүүхдийн сонгодог уран зохиолын нэрт төлөөлөгч Франсис Ходсон Бөрнэтийн “Нууц цэцэрлэг” хэмээх бүтээл нь хүүхэд багачууд төдийгүй насанд хүрэгсэд ч шимтэн уншдаг номын нэг юм. Франсис Бөрнэт нь 1849 онд Английн Манчестерт төрсөн бөгөөд 16 настай байхад эцэг нь нас барснаар гэр бүлээрээ Америк руу нүүсэн байна. Тун удалгүй эх нь нас барж, дөрвөн дүүтэйгээ хоцорсон байна. Тэрбээр бага наснаасаа урлаг, утга зохиолд дуртай нэгэн байсан тул

зохиол бичиж ахуй амьдралаа залгуулах болсон байна. "Фаунтлерийн бяцхан эзэнтэн" /1886/, "Бяцхан гүнж" /1905/, "Нууц цэцэрлэг" /1911/ зохиол бүтээлүүд нь Франсис Бөрнэтэд алдар нэрийг авчирчээ.

1911 онд бүрэн эхээрээ хэвлэгдсэн "Нууц цэцэрлэг" зохиол нь эцэг эхийн анхаарал халамж дутсан, бие бялдрын хөгжил дорой, хүмүүжлийн доголдолтой чинээлэг айлын хүүхдүүд жирийн айлын үе тэнгийн хүүхэдтэй нөхөрлөж, байгаль дэлхийдээ ойртон, бусдын халамж анхаарлыг хүртэж, зөв хүмүүжин төлөвшиж буйг өгүүлдэг сургамжит бүтээл юм.

Эцэг эхээ өвчнөөр алдсан Мэри Леннокс Йоркширт авга ахындаа амьдрахаар ирээд тэр газар нь ид шидээр дүүрэн болохыг мэдсэнээр зохиол эхэлнэ. Түүний авга ах нь зуу гаруй өрөөтэй том байшингаасаа гардаггүй нэгэн. Шөнийн цагаар урт хонгилуудын нэгээс гарах уйлах чимээг охин сонсдог байлаа. Мэригийн эдлэнгийн том цэцэрлэгт тоглож яваад өндөр хашлага бүхий цоожтой нууц цэцэрлэгийг олно. Нэгэн өдөр санамсаргүй таарсан хоёр найзынхаа тусламжтайгаар тэрхүү нууц цэцэрлэг рүү орох замыг нээнэ. Цэцэрлэг тэр чигээрээ хатаж хагдарсан байгаа болов уу? Мэри цэцэрлэгийг амилуулж чадах болов уу?

Эл бүтээлийг зохиолч, яруу найрагч, орчуулагч Д.Оюунчимэг 2016 онд монгол хэлнээ бүрэн эхээр нь орчуулж олны хүртээл болгожээ.

Энэ өгүүлэлдээ “Нууц цэцэрлэг” зохиолын англи хэлээрх эхийн эхний хоёр бүлгийг монгол орчуулгатай нь харгуулан утгын болоод найруулгын алдааг шүүн гаргахыг зорилоо.

The young **English governess who came to teach her** to read and write disliked her so much that **she gave up her place in three months**, and when other governesses came to try to fill it they always went away in a shorter time than the first one. (Burnett, F.H., 1911:2)

1. **Эцэг эх нь зориуд Англиас авчирсан залуухан хүмүүжүүлэгч хүүхэн гурван сарын дараа ажлаасаа халагдав.** Бусад гэрийн багш нар түүнээс ч богино хугацаанд тооцоо хийхийг шаарджээ. (Д.Оюунчимэг 2016:11)

Эхэд өгүүлснээр гэрийн багш эмэгтэйг Англи улсаас авчраагүй, хэн нэгэн ажлаас нь халаагүй, тооцоо хийхийг шаардаагүй. Харин гэрийн багш нь охины байр байдлыг огт хүлээн зөвшөөрч чадахгүй байсан учир гурван сар ч бололгүй өөрөө явсан байна. Бусад багш нь ч бараг зугтсан гэсэн утгатай байна. Иймд энэ өгүүлбэрийг утгын алдаатай өгүүлбэр гэж үзлээ.

“Мэриг уншиж, бичүүлж сургахаар ирсэн гэрийн багш англи эмэгтэй аргаашаа баран 3 сар ч хүрэлгүй яваад өгчээ. Түүний оронд ирсэн гэрийн багш нар ч төд удалгүй орхин явцгаав” гэсэн хувилбараар орчуулах саналтай байна.

2. One frightfully hot morning, when she was about nine years old, she **awakened feeling very cross**, and she became crosser still when she saw that the servant who stood by her bedside was not her Ayah. (Burnett, F.H., 1911:2)

Тийнхүү өдөр хоногууд үргэлжилсээр Мэри нэг өглөө **сэтгэл санааны аймшигт байдлыг мэдэрсээр сэргэж ирлээ**. Халуун гэж жигтэйхэн байх аж. Охины хуучин асрагч Айягийн оронд огт танихгүй эмэгтэй ирэв. (Д.Оюунчимэг 2016:11)

Энэ өгүүлбэрийн *'awake'* гэсэн үйл үг нь *'сэрэх, сэргэх'* гэсэн утгатай бөгөөд монгол хэлэнд *'сэрж ирэх'* гэж огт ярьдаггүй. Мөн *'feel very cross'* хэлцийг *'сэтгэл санааны аймшигт байдлыг мэдэрсээр'* гэж орчуулахын оронд *'уцаарлангуй'* гэвэл утгын болоод найруулгын хувьд оновчтой болох болов уу.

“Аймшигтай халуун нэгэн өглөө **уцаарлангуй сэрсэн** есөн настай охин орныхоо дэргэд Аяагаас нь огт өөр зарц зогсож буйг хараад улам ихээр уурлав” хэмээн орчуулбал дээр гэж үзлээ.

3. Nothing was done in its regular order and several of the **native servants** seemed missing, **while those whom Mary saw slunk or hurried about with ashy and scared faces**. (Burnett, F.H., 1911:3)

Хуучин ёс журам, **танил зарц** нар нь аль нэг тийш арилсан мэт. **Үл таних зарц** нар ямар нэгэн **юмнаас айх мэт булангаас буланд бөөгнөрөн зогсох нь нэн хачирхалтай**. (Д.Оюунчимэг 2016:11)

Эхэд танил, үл таних зарц нарын тухай, буланд бөөгнөрөн зогсож байгаа, тэр байр байдал нь хачирхалтай байгаа талаар огт дурдаагүй. Орчуулагч эхэд буй *'native'* үгийг *'танил'* гэж орчуулсан нь алдаатай агаад энд нутгийн, өмнө нь ажиллаж байсан энэтхэг зарц нарын тухай өгүүлж байна. *'those whom Mary saw'* гэснийг *'үл таних'*, мөн *'slunk', 'hurried'* гэсэн тэмдэг нэрийг *'айх мэт, буланд бөөгнөрөх'* гэсэн нь эндүү ташаа буужээ. Иймд уг өгүүлбэрийг дараах байдлаар орчуулах саналтай байна.

“Байдал нэг л биш болсон агаад **хуучин** зарц нараас ихэнх нь харагдахгүй, байгаа хэд нь цөм айж, зэвхий даасан царайтай, гэтсэн эсвэл сандарсан байхыг Мэри олж харав.”

4. She always did this when she had a chance to see her, because the Mem Sahib – Mary used to call her that oftener than anything else – was such a tall, slim, pretty person and wore such lovely clothes. (Burnett, F.H., 1911:4)

Мэри ээжтэйгээ маш ховорхон уулздаг учраас түүнийг **бусад зарц нарын адил** Мэмсахиб хэмээн нэрлэнэ. Энэ өндөр гоолиг үзэсгэлэнтэй эмэгтэй охиныхоо **бахархал болдог** билээ. Мэмсахиб цаг ямагт гайхалтай хувцаслана. (Д.Оюунчимэг 2016:11)

Эхэд *'ээжтэйгээ ховорхон уулздаг', 'бусад зарц нарын адил', 'охиныхоо бахархал болдог'* гэж огт гараагүй. Орчуулагч *'харах бүрийдээ ширтэх'* гэхийг *'охиныхоо бахархал болдог'* гэж буулгасан нь тохиромжгүй. Учир нь англи эхэд буй *'эхийгээ харах бүрийдээ ширтдэг'* гэж буй нь хүний гадаад гоо үзэмжид татагдсан санаа болохоос бахархаж буй хэрэг биш гэж үзлээ. Нэмж хэлэхэд, энэтхэг зарц нар *'гэрлэсэн, цагаан арьст язгууртан эмэгтэй'*-г *'the Mem Sahib'* хэмээн хүндэтгэн дууддаг байна.

“Ээжийгээ Мэмсахиб гэж ихэнхдээ дууддаг Мэри түүний өндөр, гуалиг, үзэсгэлэн төгөлдөр, гайхалтай сайхан хувцастай төрхийг харах боломж олдох бүртээ бишрэн хардаг байлаа.” гэж орчуулбал дээр санагдлаа.

5. Before the next day three other servants were dead (Burnett, F.H., 1911:5)

Өдөр дунд болоход дахин гурван зарц өөд болжээ. (Д.Оюунчимэг 2016:12)

Эхэд өдөр дунд гэсэн санаа гараагүй. “*Before the next day*” гэдэг нь дараагийн өдөр болохоос өмнө буюу шөнийн 00:00 цагаас өмнөх цагийг заана. Өөрөөр хэлбэл цаг заасан үгийг ташаа орчуулгаас үүдэн утгын зөрөө гарсан байна. Дээрх өгүүлбэрийг дараах байдлаар буулгавал утга нь зөв гарна.

“Шөнө дунд гэхэд дахиад гурван зарц нас барав.”

6. “That pretty, pretty woman! I suppose the child too. I heard there was a child, though no one ever saw her.”

Энэ ямар сайхан хатагтай вэ! Хүүхэд нь мэдээж бас үхсэн биз. Эднийх хүүхэдтэй гэж та сонсож байсан уу, Барни? гэх эрэгтэй хүний дуу гарлаа. (Д.Оюунчимэг 2016:13)

Эхэд буй “*That pretty, pretty woman!*” өгүүлбэрт нас барсан сайхан эмэгтэйн хойноос харамсан халаглаж буй өнгө аясыг илэрхийлж байхад монгол орчуулгад гоо сайхныг нь бахдаж байгаагаар буулган өнгө аясыг өөрчилжээ. Дараагийн өгүүлбэрт “*I heard*” буюу “*би сонссон*” гэсэн хүүрнэх өгүүлбэрийг “*Та сонсож байсан уу?*” гэсэн асуух хэлбэрээр буулгасан нь тодорхой хэмжээнд утгын зөрүүтэй болжээ. Иймд дараах байдлаар орчуулах саналтай байна.

“Хайран сайхан эмэгтэй, хүүхэд нь ч бас өнгөрсөн байх даа. Эднийх хүүхэдтэй байсан гэж би сонсож байсан гэхдээ хэн ч харж байгаагүй.”

7. Mistress Mary, quite contrary

How does your garden grow?

With silver bells, and cockle shells,

And marigolds in a row. (Burnett, F.H., 1911:11)

Чөмгөрийн Зулзага–Мэри,

Чиний цэцэрлэгт юу ургах бол!

Хонх, дун, эмгэн хумс

Харин дотроо мэлхийтэй. (Д.Оюунчимэг 2016:15)

Энэхүү английн бүүвэйн нь шашны болон түүхэн ач холбогдлоороо өөр өөрөөр тайлбарлагддаг бөгөөд утгачлан орчуулах боломжгүй. Шүлэгт дурдагдах Мэри зохиолын гол дүрийн баатрын нэртэй ижил, зөрүүд дураараа зантай учир зохиолч энэ нэрийг өгсөн байх магадлалтай. “Нууц цэцэрлэг” зохиол нь хүүхдэд зориулсан бүтээл тул эл дөрвөн мөргийг аливаа далд утга санаагүй, шууд утгаар нь оруулсан гэж үзвэл эхний мөргийн “*Mistress Mary, quite contrary*” гэдгийг орчуулагч “*Чөмгөрийн Зулзага*” гэж буулгасан нь адтай, сэргэлэн эсвэл сөрөг үнэлэмжтэй ойлгогдож байна. Зохиолын баатар Мэри бол зөрүүд, дураараа, захирангуй охин болохоос адтай сэргэлэн, хорон муу санаатай хүүхэд огт биш тул “*Чөмгөрийн Зулзага*” гэж орчуулах нь уншигчдад эргэлзээ төрүүлэхээр байна.

Гурав дахь мөрийн “bells”, “shell” гэсэн үгийг орчуулагч “хонх”, “дун” гэж орчуулжээ. Эдгээр үгс нь хоорондоо харилцан хамааралгүй агаад цэцэрлэгт цэцэгс байхаас хонхнууд байх боломжгүй. Түүнчлэн “shell” нь “дун” бус “хясаа” юм. Харин “silver bells”, “cockle shell” –ийг чөлөөт бус холбоо үг гэж үзэж хамтад нь цахим хайлтын системээс үзвэл аль аль нь цэцгийн нэр байна. Зургаар хайсан илэрцэд “silver bells” нь цагаан өнгийн хонх шиг цэцэгтэй модлог ургамал, “cockle shell” нь мөн адил хонх шиг хэлбэртэй, нил ягаан өнгийн цэцэгт ургамал байгаа бөгөөд нэгэнтээ цэцэрлэгийн тухай өгүүлж буй дөрвөн мөрт тул уншигчдад ойлгомжтой байх үүднээс цагаан, нил ягаан өнгийн хонхон цэцэгс гэж орчуулах саналтай байна.

Сүүлийн мөрөнд ‘Marigold’-ыг “Бяцхан хумсхан” гэсэн бөгөөд “Эмгэн хумс” гэж ойлгон орчуулсан гэж үзвэл ургамлыг амьтан болгосон болж таарна. (эмгэн хумс-амьтан <https://www.mongoltoli.mn>) Орчуулгад буй “Мэлхий” нь хаанаас гарч ирсэн нь тодорхойгүй бөгөөд хонх, дун, эмгэн хумс дотор мэлхий орсон байх боломжгүй юм.

“Мэри авхай минь
Цагаан, нил ягаан хонхон цэцэгс
Хумсхан цэцэгс зэрэгцэнхэн
Танай цэцэрлэгт ургаа юу даа?”

8.and her mother had been a great beauty who cared only to go to parties and amuse herself with gay people. (Burnett, F.H.,1911:1)

Харин эх нь нөхөр охин хоёроосоо эрс өөр, эрүүл мэнд, гоо үзэсгэлэнгээрээ олны дунд алдартай нэгэн байжээ.

Хэрэв сонирхолтой хөгжилтэй хүмүүсийн хүрээлэлд байдаггүй сэн бол Энэтхэгт нэг ч өдөр тэсэж чадахгүй сэн гэж тэр хааяа хэлнэ. (Д.Оюунчимэг 2016:10)

Энэ өгүүлбэрийг монгол хэлнээ найруулгын хувьд өөрчлөх саналтай байна.

“...эх нь гоо үзэсгэлэн төгөлдөр эмэгтэй байсан бөгөөд гагцхүү үдэшлэгт явж, хөгжилтэй хүмүүстэй хамт цагаа өнгөрөөхийг боддог нэгэн байв.”

9. She had a little thin face and a little thin body, thin light hair and a sour expression. (Burnett, F.H.,1911:1)

Арав гаруй насны, **хорсол тодорсон туранхай нүүртэй, шаргал арьстай** тийм охиныг Мисселтуэйтэд хэн ч өмнө нь хараагүй байв. (Д.Оюунчимэг 2016:10)

Энэ өгүүлбэрийн хувьд “шаргал арьстай” гэсэн дүрслэлийг нэмсэн, “a little thin body”, “thin light hair” зэргийг орчуулаагүй орхигдуулсан, “a little thin face”-ыг “туранхай нүүртэй”, “sour expression”-ыг “хорсол тодорсон” гэж буулгасан нь үг оноолтын хувьд учир дутагдалтай тааруухан болсон гэж үзэж дараах байдлаар өөрчлөв.

“Тэрбээр жижигхэн шөвгөр нүүртэй, шингэвтэр цайвар үстэй, тунна муутай, ууртай байрын охин байв.” гэж орчуулах саналтай байна.

10. She is such a plain child, Mrs.Crawford said pityingly afterward. "And her mother was such a pretty creature. (Burnett, F.H.,1911:13)

Ээж нь тийм үзэсгэлэнтэй сайхан бүсгүй байсан ч энэ охин **ердөө л тэнэг амьтан** юм. (Д.Оюунчимэг 2016:16)

Энэ өгүүлбэрийн хувьд “*She is such a plain child*” гэдгийг “*тэнэг амьтан*” гэж буулгажээ. “*Plain*” гэдэг нь “*not beautiful or attractive*” буюу “*үзэсгэлэнтэй бус, энгийн*” гэсэн утгатай. Харин орчуулгад ээж нь үзэсгэлэнтэй байхад хүүхэд нь тэнэг байна гэсэн санаа гарч байна. Өөрөөр хэлбэл, үзэсгэлэнтэй хүн ухаантай, царай муутай бол тэнэг болж таарлаа. Монгол хэлнээ “Царайны сайхнаар цай сүлэхгүй” гэсэн хэлц байдгаас үзвэл манайд лав царай, ухаан хоёрыг холбон тайлбарладаг ёс байхгүй. Үг буруу сонгосон энэ алдаа нь хүүхдийн зохиолд гарч байгаа гэдэг утгаараа буруу үлгэр дууриал үзүүлэх тул анхаарууштай.

“Яасан ч царай муутай хүүхэд вэ дээ. Гэтэл эх нь ямар сайхан амьтан байлаа.” хэмээн хатагтай Крофорд харамсангүй өнгөөр хэлэв.

Дүгнэлт

“Нууц цэцэрлэг” зохиолын монгол орчуулга нь утга зүйн хийгээд найруулга зүйн талаасаа зарим талаараа оновчтой бус байгаа нь эхний хоёр бүлэгт хийсэн ажиглалтаас түүвэрлэн авсан цөөн жишээнээс тодорхой харагдаж байна. Үг, өгүүлбэр, утга санаа нэмсэн, орчуулахад бэрхтэй санааг орхисон, үг оноолт оновчгүй болсон зэргээс үүдэн орчуулгын бүтээл эх зохиолоосоо зөрүүтэй болжээ. Мөн эх нь гол төлөв нийлмэл өгүүлбэрээс бүтсэн байхад монгол орчуулга дан өгүүлбэрээр илэрхийлсэн байгаа нь уншигчдад хялбар болгохыг зорьсон байх талтай. Харамсалтай нь эхийн хэл найруулга монгол хэлнээ сайн бууж чадаагүй байна. Эдгээрээс дүгнэвэл “Нууц цэцэрлэг” зохиолыг чөлөөт орчуулгын аргаар хийсэн нь тодорхой харагдаж байгаа бөгөөд эх зохиолын өнгө аяс, уран яруу илэрхийлэл, амт шимт нь орчуулгын бүтээлд дутагдалтай байгаа нь зарим талаар ажиглагдлаа.

SUMMARY

This paper deals with some semantic and stylistic errors in the Mongolian translation of a children's classic “Secret Garden” by Frances Hodgson Burnett and offers other version of translations to each. By comparing it, translation errors are caused by misunderstanding of the translation content of the ST, by not rendering the meaning of the ST accurately, by factual mistakes, terminological and stylistic flaws, and by different kinds of interferences between St and TT.

НОМ ЗҮЙ

1. Nida, E., and Taber, C., (1969) “The Theory and Practice of Translation” Leiden: E.J.Brill
2. Д.Дашдаваа (2010) “Орчуулгын найруулга зүйн үндэс, бүтэц-утга зүйн үндэс”, Улаанбаатар
3. Д.Оюунчимэг (2016) “Нууц цэцэрлэг”, Улаанбаатар
4. Burnett, F. H (1911) “The Secret Garden”, Нью-Йорк
<http://www.read.gov/books/pageturner/2002juv21580/#page/24/mode/2up>
<https://www.britannica.com/plant/silver-bells>
<http://www.bolor-toli.com/>
<https://en.oxforddictionaries.com/>

ОРЧУУЛГЫН ОНОЛ, ДАДЛАГА ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛ

(Герман хэл, судлал мэргэжлээр бакалаврын зэрэг олгох
сургалтын хөтөлбөрийн жишээгээр)

Ж.Ариун¹

Товч агуулга: Бакалаврын сургалтын хүрээнд орчуулгын онол, дадлага олгох хичээлийн хөтөлбөрийг 2000 оноос хойш өнөөг хүртэл тасралтгүй шинэчлэн боловсруулж буйн зэрэгцээ зах зээлийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан орчуулгын дадлага хичээлийн нэришл хийгээд агуулга өөрчлөгдсөөр байна. Сүүлийн жилүүдэд хэрэгжсэн зарим нэгэн төслийн хүрээнд орчуулах, хэлмэрчлэх загварын нарийвчилсан тодорхойлолт, орчуулгын хичээлийн загвар сурах бичиг зэргийг боловсруулан сургалтад нэвтрүүлээд байна.

Түлхүүр үг: “Герман хэл, судлал” мэргэжлийн хөтөлбөр дэх орчуулгын дадлага хичээлийн багц цаг, хичээлийн төрөл, орчуулгын дадлага хичээлийн агуулга, стандарт, загвар сурах бичиг

Герман хэл, судлал мэргэжил олгох сургалтын хүрээнд орчуулгын онол болон дадлагын хичээлийн хөтөлбөрийг 2000 оноос өнөө цагийг хүртэл 2000 он, 2002 он, 2005 он, 2008 он, 2012 он, 2015² онд нийт 6 удаа шинэчлэн боловсруулсны сацуу “Орчуулгазүй” мэргэжлийн хамтлаг үүсгэн байгуулагдаж үйл ажиллагаагаа тогтвортой явуулж байна. Өгүүллийн хүрээнд орчуулгын дадлага олгох хичээлийн хөтөлбөрийн талаар илүү дэлгэрэнгүй авч үзлээ.

Орчуулгын онолын хичээл 2005 оны байдлаар мэргэжлийн суурь мэдлэг олгох хичээлийн хүрээнд 1.59%-ийг эзэлж байсан өмнөх жилүүдтэй харьцуулахад сургалтын төлөвлөгөөний сүүлчийн хувилбарын дагуу 1 ББЦ-аар нэмэгдэж 3ББЦ болсон байна. Уг хичээлийг сургалтын III, IV улиралд сонгон үзэх боломжит хэлбэрээр сургалтын нэгдсэн систем СИСИ-д байршуулжээ.

Орчуулгын онолын хичээлийн хөтөлбөрийн агуулгыг мэргэжлийн хамтлаг хийгээд МУИС-ийн хөтөлбөрийн дэд болон ерөнхий хорооны хурлаар тус тус хэлэлцэн баталсны дагуу сургалтанд мөрдөж байна. Хөтөлбөрийг тодорхой үе шатаар давхар нягтлан хэлэлцдэг болсон нь чанарын шалгуур үзүүлэлтэд эергээр нөлөөлөх хүчин зүйл юм. МУИС хичээлийн хөтөлбөр боловсруулах нэгдсэн загварыг хэрэгжүүлж цахим хэлбэрээр байршуулах болсон нь төрийн үйлчилгээ

¹ МУИС, ШУС, ХУС, Европ судлалын тэнхимийн профессор, доктор

² “Герман хэл, судлал” мэргэжлийн сургалтын төлөвлөгөө, 2000-2015 он

үзүүлдэг байгууллагын үйл ажиллагааны хувьд нээлттэй ил тод байдлыг илэрхийлэх давуу тал болно.

Орчуулгын дадал олгох хичээл 2008 он хүртэл герман-монгол орчуулга 9 ББЦ, монгол-герман орчуулга 6 ББЦ нийт 15 ББЦ дадлагын хичээл (мэргэжлийн суурь мэдлэг олгох хичээлийн хүрээнд 11.11% : 7.14% харьцаатай) байсныг сүүлийн жилүүдэд зах зээлийн эрэлт хэрэгцээ болон хөтөлбөрийн шинэчлэлийн шаардлагаар мэргэшүүлэх хичээлийн төрөлд хамруулан найруулгын төрөл зүйлээр ангилжээ.

Гэвч сургалтыг 10 ББЦ болгон бууруулсан үзүүлэлттэй байна (2013 оны мэргэжлийн өөрийн үнэлгээний тайлангийн дагуу). Үүнээс герман хэлний нийгэм, улс төрийн орчуулга 4 ББЦ, бизнесийн герман хэлний орчуулга 2 ББЦ, герман хэлний эрхзүйн орчуулга 2 ББЦ, герман уран зохиолын орчуулга 2 ББЦ байна. ББЦ-ийг бууруулах болсон шалтгаан нь хөтөлбөрт хэл судлалын талыг гүнзгийрүүлэн системчилж үгзүй, өгүүлбэрзүйн хичээлүүдийг шинээр оруулан хэлзүйг авиазүй, үгзүй, өгүүлбэрзүй зэргээр түвшнээр хуваарилан судлуулах зорилготой холбоотой.

Орчуулах техникийн хувьд аман болон бичгийн гээд герман хэлнээс хэлмэрчлэхүй мөн 2 ББЦ байна. 2012 онд батлагдсан сургалтын хөтөлбөрт орчуулгын дадлага олгох хичээл зайлшгүй сонгон судлах хичээлийн хүрээнд нийт 10 ББЦ-ийн багтаамжтай тусгагдсан байна. Найруулгын төрлөөр нь үзвэл дээр нэрлэснээс эрхзүйн орчуулга хичээл хасагджээ. Тухайн хичээлийг заах улирал нь нийгэм, улс төрийн орчуулга, албан бичгийн орчуулгын тухайд V, VI улиралд, албан бичгийн орчуулга, уран зохиолын орчуулга VII, VIII улиралд ноогдсон байна.

“Монголын их, дээд сургуулиудад гадаад хэлний мэргэжлийн ангиудад бакалаврын сургалт явуулах сургалтын агуулга, үндэсний загвар, хөтөлбөрийг боловсруулах үндэс” эрдэм шинжилгээний төслийг МУИС-ийн Хөгжлийн сангийн захиалга, санхүүжилтээр 2009-2011 онд гүйцэтгэсэн бөгөөд уг төслийг МУ-ын гавъяат багш, профессор Э.Равдан удирдан Ц.Доржсүрэн, С.Долгор, М.Одонтуяа, Ч.Сэлэнгэмөрөн нар хамтран гүйцэтгэсэн билээ. Энэхүү төслийн хүрээнд “Европын олон хэлний суурь хөтөлбөр: Сурах, сургах, үнэлэх” орчуулгын бүтээл гарсан. Төслийн хүрээнд багш М.Одонтуяа герман хэлнээс хэлмэрчлэх чадварын тодорхойлолт, герман хэлнээс хэлмэрчлэх чадварын жишээгээр нарийвчилсан тодорхойлолт, бусад хэлнээс хэлмэрчлэх чадварын тодорхойлолт, бусад хэлнээс герман хэл рүү хэлмэрчлэх чадварын жишээ бүхий нарийвчилсан тодорхойлолт, герман хэл болон өөр бусад хэл хооронд хэлмэрчлэх чадварын олон улсын тодорхойлолт, герман хэл болон өөр бусад хэл хооронд хэлмэрчлэх чадварын жишээ бүхий нарийвчилсан тодорхойлолт, герман хэлнээс бичгээр орчуулах чадварын олон улсын тодорхойлолт, герман хэлнээс бичгээр орчуулах чадварын жишээ бүхий нарийвчилсан тодорхойлолт, бусад хэлнээс бичгээр орчуулах чадварын олон улсын тодорхойлолт, бусад хэлнээс бичгээр орчуулах чадварын жишээ бүхий нарийвчилсан тодорхойлолт зэрэг 22 стандарт³ орчуулсан байна.

³ “Герман хэл, судлал” мэргэжлийн сургалтын төлөвлөгөө, 2000-2015 он

ГХСС-ийн төсөл, гэрээт ажил хэрэгжүүлэх журамд үндэслэн ГХСС-ийн Эрдмийн Зөвлөлийн 2011 оны 12 сарын сарын 23-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу олон улсын сургалтын агуулгын стандартад нийцүүлсэн сургалт явуулахад шаардлагатай сурах бичиг, гарын авлага боловсруулах зорилтын хүрээнд “Орчуулгын хичээлийн загвар сурах бичиг зохиох” сэдэвт төслийг 2012 оны 01-р сарын 01-ний өдрөөс 1 жилийн хугацаатай хийж гүйцэтгэсэн. Төслийн удирдагчаар хятад судлалын тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D) В.Батмаа, төслийн гүйцэтгэгчээр Хятад судлалын тэнхимийн дэд профессор, доктор (Ph.D) М.Чимэдцэеэ, Слав судлалын тэнхимийн профессор, доктор (Ph.D) Ш.Туяа, Их Британи, Америк Судлалын тэнхимийн багш, докторант Ж.Эрдэнэбат, Герман Судлалын тэнхимийн эрхлэгч, докторант М.Одонтуяа, Япон Судлалын тэнхимийн багш, доктор (Ph.D) Д.Майсүлд, Франц-Роман Судлалын тэнхимийн багш, докторант Б.Пүрэвсүрэн, Солонгос Судлалын тэнхимийн багш, докторант Б.Дулмаа, Слав Судлалын тэнхимийн багш, доктор (Ph.D) Д. Энхжаргал, Түрэг Судлалын тэнхимийн багш, доктор (Ph.D) Ц.Баттулга⁴ ажилласан байна. Энэ явцад бакалаврын түвшингийн орчуулгын хичээлийн агуулгыг стандартчилж, агуулгын хүрээнд зайлшгүй эзэмших үгийн санг тодорхойлж, олон хэлний орчуулгын хичээлийн агуулгын болон заах аргазүйн жишиг тогтоож, хичээл хоорондын уялдааг хангах, оюутны бие даан ажиллах сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах, бие даан суралцах бодит нөхцөлөөр хангахыг зорьсон хэмээжээ.

Төслийн багийн хэлэлцүүлгийн дүнд 3 дугаар түвшингийн оюутнуудын хэлний мэдлэгийн түвшинд үндэслэн, орчуулгын дадал олгох анхны хичээл болохын хувьд нийгмийн олон салбарыг хамарсан сэдэвтэй сонин, хэвлэл мэдээллийг гадаад болон эх хэлээрээ уншиж ойлгон, хөрвүүлэх анхан шатны дадал, чадварыг эзэмшүүлэх, олон эх бичвэртэй ажиллаж, уншиж ойлгох болон хөрвүүлэх олон тооны дасгалыг хийж бие даан суралцах нөхцөлөөр хангах зорилгоор орчуулгын хичээлийн агуулгыг боловсруулжээ.

Сэдвийн хүрээнд нэгж хичээлийг:

1. Сэдэвтэй холбоотой эзэмшвэл зохих тулгуур үг хэллэг
2. Орчуулгын өмнөх дасгалууд (үгийн болон өгүүлбэрзүйн түвшинд)
3. Гадаад хэлнээс эх хэлнээ орчуулах бичвэр
4. Эх хэлнээс гадаад хэлээр орчуулах бичвэр
5. Орчуулгын дараах дасгалууд (орчуулах эхэд гарсан үг, хэллэг, бүтэц, найруулга зэргийг бататгах, өөр хувилбаруудыг эзэмших зорилготой)
6. Бие даан орчуулах бичвэрүүд (гадаад хэлнээс эхээр болон эх хэлнээс гадаад хэлээр хөрвүүлэх)
7. Нэмэлт бичвэрүүд болон нэмэлт үг хэллэг гэсэн бүтцээр⁵ боловсруулсан байна.

Тухайн хэлний хэлзүй, үгийн сан болон найруулгазүйн онцлогоос шалтгаалж орчуулгын олон хэлбэрийн дасгалтай, оюутан бие даан гүйцэтгэх арвин өгөгдөхүүн

⁴ “Орчуулгын хичээлийн загвар сурах бичиг зохиох”, ГХСС-ийн төслийн ажлын тайлан, УБ., 2013 он

⁵ “Орчуулгын хичээлийн загвар сурах бичиг зохиох”, ГХСС-ийн төслийн ажлын тайлан, УБ., 2013 он

боловсруулсан нь энэ сурах бичгийн онцлог болно. Тус сурах бичгийг 2013-2014 оны хичээлийн жилийн намрын улирлаас орчуулгын хичээлийн сургалтанд хэрэглэж байна. Орчуулгын хичээлийн загвар сурах бичгийг PDF хэлбэрээр МУИС-ийн ОСW-д байршуулсан байна.

Дүгнэлт

- Орчуулгын дадлага олгох хичээл агуулгын хувьд өнөөгийн шаардлагад нийцэхүйц нарийн ялгавартай, тодорхой заагтай, давхардалгүй болж шинэчлэгдсэн,
- Орчуулах, хэлмэрчлэх чадварын нарийвчилсан тодорхойлолт бий болсон,
- Орчуулгазүйн мэргэжлийн хамтлаг байгуулагдан байнгын үйл ажиллагаа явуулж буй,
- Баримт бичгүүд болон хичээлийн зарим нэгэн цахим хэрэглэгдэхүүн багш, суралцагч нарт нээлттэй байдаг зэрэг олон эерэг талтай болжээ.

Цаашид найруулгын төрлөөр нь нэрлэсэн хичээлүүдийн нэрийг зөв ойлгомжтой томъёолж хэвших; сурах бичиг зохиох, цахим хэлбэрээр байршуулах ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулах; МУ-ын БСШУ-ны сайдын 2014 оны 03 сарын 13-ны өдрийн А/78 дугаарын Мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэн батлах тухай тушаалын дагуу “Герман хэлний орчуулга” мэргэжлийн хөтөлбөрийг яаралтай боловсруулан батлуулах; энэ чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх; германы уран зохиолын орчуулга хичээлийг шинэ түвшинд гаргаж герман эх хэлнээс нь төрөлх монгол хэл рүү шууд орчуулсан зохиолын шинэ үеийг гаргаж ирэх нөр их ажлын гарааг эхлүүлэх шаардлага бий.

Номзүй

1. Гадаад хэлний сургалтын агуулгын зөвлөмж, МУИС, УБ., 2016 он
2. “Герман хэл, судлал” мэргэжлийн хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлэх өөрийн үнэлгээний тайлан, МУИС, ГХСС, Герман судлалын тэнхим, УБ., 2012 он
3. “Герман хэл, судлал” мэргэжлийн сургалтын төлөвлөгөө, 2000-2015 он
4. Европын олон хэлний суурь хөтөлбөр: Сурах, сургах, үнэлэх, МУИС, ГХСС, УБ., 2012 он
5. Монголын их, дээд сургуулиудын гадаад хэлний мэргэжлийн ангиудад бакалаврын сургалт явуулах сургалтын агуулга, үндэсний загвар, хөтөлбөрийг боловсруулах үндэс, Эрдэм шинжилгээний төслийн ажлын тайлан, УБ., 2011 он
6. Орчуулгын онол хичээлийн хөтөлбөр, МУИС, ШУС, УБ., 2014 он
7. “Орчуулгын хичээлийн загвар сурах бичиг зохиох”, ГХСС-ийн төслийн ажлын тайлан, УБ., 2013 он

Abstract

Since 2000 as part of bachelor program development, translation theory and practice syllabus has been renewed many times and its content and title has been modified to meet the market demand.

Detailed definition for translation and interpretation models, and pilot textbooks for translation classes have been provided and introduced into the study as results of the projects implemented in recent years.

ТОМАС МАЙН РИДИЙН “МОРЬ УНАСАН ТОЛГОЙГҮЙ ХҮН” ЗОХИОЛЫН ОРЧУУЛГАД НАЙРУУЛГАЗҮЙН ҮҮДНЭЭС АЖИГЛАЛТ ХИЙХ НЬ

Б.Энхтүшиг¹

Abstract: *The main purpose of our research work is to analyze whether modern translated literary works meet the requirements of the quality of good translation works and to offer our suggestions to some failings in them, rather than judging someone's work. We believe that this research work will be useful to students and researchers who are interested in further research in this field.*

Key words: *Stylistics, literary stylistics, stylistic errors in the novel*

Удиртгал

Найруулга зүй: Хэлний олон зүйл нэгжийг хэрэглэх, тухайн харилцааны зорилго нөхцөлтэй уялдуулах, өөрийн бодол сэтгэлийг бусдад зөв ойлгуулах, бичгийн хэлээр зөв бичиж, туурвих, арга хэрэглүүрийг судалдаг ухаан. Эртний Энэтхэг, Ромд найруулга гэдэг нь зөв ярих, зөв бичих гэж тодорхойлж байсан. Энэ тодорхойлолт өнөөг хүртэл үнэ цэн, агуулгаа алдаагүй.

Найруулгыг нийт ард түмний хэл, тухайн хэлээр хэлэлцэж буй бүх хүмүүсийн бичиг зохиолын, аман ярианы хэл гэж үздэг. Найруулга зөв байх нь нэг үсэг авианаас эхлээд бүтэн өгүүлбэр, бүх эх текст зэрэг бүхий л зүйлд хамаардаг.

Найруулга зүйн шаардлага: “Найруулга зүйн үндсэн шаардлага, хэл найруулгын дүрэм горимыг зөрчсөний үр дагаврыг найруулгын алдаа гэнэ. Найруулга зүйн шинжлэх ухаан нь санаа бодлоо илэрхийлэхдээ тохируулан хэлний аль нэг хэрэглүүрийг төгс төгөлдөр сонгон найруулж чадсан эсэхийг тодруулан судалдаг” гэж найруулга зүйч, доктор **Д. Отгонсүрэн** тодорхойлжээ. Тиймээс найруулгын алдаа гэх ойлголттой танилцахаас өмнө найруулгын шаардлагын талаар товч дурдах ёстой. Найруулгын шаардлагыг эрдэмтэд доорхи байдлаар авч үзжээ.

Францын эрдэмтэн, найруулга зүйч **Р. Жеоржин** “Найруулгын нууцууд” номдоо, “Найруулах эрдмийн гол сүнс нь үг сонголт мөн. Найруулж сурахад эзэмшвэл зохих хамгийн чухал чанарууд бол: -өгүүлж байгаа зүйл тодорхой; -үг хэллэг оновчтой; -үгийн баялаг арвин; -нуршсан зүйлгүй товч; -өөрийн гэсэн арга барилтай; -уншигчдад нэгэн цогц ойлголт өгөх; -чамирхсан зүйлгүй, энгийн байх... эдгээр шиг санагдана” гэжээ. /Ц. Сүхбаатар, 2012:53/

Найруулга зүйч, доктор профессор **Ц. Сүхбаатарын** үзсэнээр: 1. ойлгомжтой 2. сонирхолтой 3. яруу сонсголонтой 4. гоо зүйн хэм хэмжээг харгалзан үзсэн байх;

¹ Гадаад хэлний орчуулга зүйн магистрант, МУИС, ШУС, ХУС

Эрдэмтэн Ч. Чойсамба бичвэрт тавигдах үндсэн шаардлага бол 1. тодорхой ойлгомжтой 2. сонирхолтой 3. аль болох хураангуй 4. үг сонголт сайтай 5. гоо зүйн хэм хэмжээнд тохирсон 6. учир зүйд нийцэхүйц байх ёстой хэмээжээ.

Найруулгын алдаа: МУИС-ийн багш **Ч. Чойсамба**, “Найруулгын алдаа гэдэг нь тухайн эх бичвэрийг уншигч хүлээн авч ойлгоход ямар нэг хэмжээгээр хүндрэл учруулж, эргэлзээ гайхал төрүүлж, унших явцыг алдагдуулж, уншигчийн анхаарлыг сарниулж, огт өөр юманд хандуулж буй дотоод зөрчил бүхий нэг эсвэл хэд хэдэн үгийг хэлнэ” гээд дараах хэлбэрээр ангилжээ. Үүнд : 1. тэмдэгтийн алдаа 2. давталтын алдаа 3. хэлзүйн алдаа 4. гоозүйн алдаа 5. учирзүйн алдаа 6. утга ялгах үүрэгтэй үг орхих алдаа 7. үг буруу сонгох алдаа 8. үг буруу байрлуулах алдаа 9. баримтын алдаа 10. гарчиг эх бичвэр зөрчилдсөн алдаа; / Ч. Чойсамба, Сонины хэл найруулга, УБ, 2000:21/

Доктор, профессор **Ц. Сүхбаатар** найруулгын алдааг ерөнхийд нь найруулгын болоод найруулгын бус гэж ангилаад: Найруулгын бус алдаанд – баримтын алдаа, учирзүйн алдаа, хэлзүйн алдаа, гоозүйн алдааг оруулжээ. Харин найруулгын алдаанд үг сонгохтой холбогдуулан – үг буруу сонгох, үг илүүдэх, үг дутаах, үгийн өнгө аясыг гажуудуулсан, дүрслэх буюу яруу хэрэглүүр оновчгүй сонгосон, үг нуршин давтсан гэх зэрэг алдаануудыг авч үзжээ. / Ц. Сүхбаатар, 2012:224-241/

МУИС-ийн багш, эрдэмтэн **М. Базаррагчаа**, “Найруулбар нь хэрэг явдлын тухай оновчтой, энгийн, уран, цэгцтэй өгүүлбэл зохино” гээд “Хэлний нэгжийн утгыг эс үнэлбэл түүнийг сонгон найруулах чадвар мөхөс болоход хүрдэг ажээ. Үг тэргүүтнийг сонгон найруулах нь авах гээхийн ухаан болно. Гээхийг гээж эс чадвал найруулгын алдаа болдог байна” гээд дараах найруулгын алдаанууд байна гэж үзсэн юм. 1. Зөв оновчтой байх ончийг хангаагүй-буруу дутуу 2. Эмх цэгцтэй байх ончийг хангаагүй-нуршуу 3. Уран яруу байхын ончийг хангаагүй-болхи гажуу 4. Энгийн ойлгомжтой байхын ончийг хангаагүй-тодорхой бус, зохисгүй;

Эрдэмтэн **Ш. Барайшир** найруулга зүйн алдааг 1. Үгийг буруу сонгосноос утга гажуудуулах 2. Хар ярианы буруу хэвшсэн үг хэллэгийг утга зохиолын хэлний боловсронгуй найруулгад хутган оруулах 3. Тохиромжтой үг хэллэг байсаар байтал огт шаардлагагүй газар гадаад үг хэллэгийг хэрэглэх 4. Хэрэггүй буюу илүү үг нуршин бичих 5. Тогтсон нэр томъёо, үг хэллэгийг дур зоргоор өөрчлөх 6. Өгүүлбэрийн гишүүдийн тогтолцоог алдагдуулах; /Ц. Сүхбаатар, Хэл соёлын тулгамдсан асуудлууд, Найруулгад эрхэмлэх зүйл, УБ, 2002:5/

Найруулгын төрөл: Шинжлэх ухаанд найруулгын төрлийн тухай ойлголт хөгжлийн тодорхой үе шатыг дамжиж ирсэн. Эртний Ром, Энэтхэг, Грек зэрэг орнууд 17-р зууны үеэс эхлэн найруулгын төрлийг хуваах оролдлого хийж байсан бол Орост 18-р зууны үед Оросын найруулга зүйч, зохиолч М.В.Ломоносов найруулгыг дээд, доод, дунд хувааж эхэлсэн. /Ц. Сүхбаатар, 2012:363/ Монголд найруулга зүй харьцангуй хожим 18-р зууны сүүл үед үүссэн залуу шинжлэх ухаан юм. Монголын эрдэмтэд Б.Ренчин, Ц.Дамдинсүрэн, Я.Цэвэл, Ц.Сүхбаатар,

Б.Отгонсүрэн, Ш.Гаадамба, Ц.Баярсүрэн нар найруулга болоод найруулгын төрлийн талаар олон шинэ санаа, үзэл баримтлалыг дэвшүүлсэн. Өнөөдөр найруулгыг тэдгээр олон эрдэмтдийн санал бодол дээр тулгуурлан дараах 5 зүйлд хувааж байна. Үүнд: 1. Албан бичгийн найруулга 2. Шинжлэх ухааны найруулга 3. Сонин нийтлэлийн найруулга 4. Ярианы найруулга 5. Уран зохиолын найруулга.

Уран зохиолын найруулга: Хэлний дүрслэх болон яруу хэрэглүүрийг өргөн ашигладаг, уран дүрийг бүтээдэг, үгсийн сангийн бүхий л нөөцийг хэрэглэх боломжтой байдгаараа бусад найруулгаас ялгардаг.

Үгийн сангийн онцлогоос:

- Үг шууд утгаараа байх нь харьцангуй ховор, дүрслэн илэрхийлэх, шилжсэн утга зонхилно.
- Зохиолын баатрын дүр, үг хэллэгнийн онцлогийг гаргах зорилгоос үүдэн хуучин үг хэллэг, нутгийн аялгууны үг, этгээд бүдүүлэг үг хэллэг, хар ярианы үг, гадаад үг, мэргэжлийн үг хэллэг зэрэг утга зохиолын хэлний идэвхгүй үгс уран зохиолын найруулгад орно.
- Үгсийн сан арвин, ойролцоо үг, эсрэг үг, төсөөтэй үгийг сүүл, толгой холбох, өгүүлбэр, үг хэллэгийг тэнцүү хэмнэл хэмжээтэй болгох, яруу сонсголон нэмэх зэрэг өвөрмөц үүргээр сонгон найруулах нь элбэг.
- Зүйр цэцэн үг, ардын аман яруу үг элбэг орно.
- Дуу чимээ, дүр дүрслэл заасан дайвар үг уран зохиолын найруулгад зонхилон орно.
- Өвөрмөц утга хэлбэртэй (зохиолын болон зохиолын баатрын) нэр элбэг тохиолдоно.

Авиан зүйн онцлогоос:

- Тухайн зохиолд гарч буй юм үзэгдэл, үйл явдлыг хүний нүдэнд үзэгдэж, чихэнд сонсогдтол тод дүрслэхэд дуу сонсголонг харгалзах нь чухал

Үгзүйн онцлогоос:

- Монгол хэлний үйл үгийн айн дотроос байдлын дагаврууд, үйлдэлдэх болон үйлдэлцэх хэвийн дагавар, захиран хүсэх болон мөрөөдөн хүсэх утгатай нөхцлүүд элбэг. Жинхэнэ нэрд залгадаг нөхцөл дагавар /-гч, -тан, -хай, -дай, -гтай/ тухайн юмс үзэгдэлд хандсан сэтгэлийн аясыг илэрхийлэх үүргээр ордог.

Өгүүлбэрзүйн онцлогоос:

- Олон гишүүнт хавсарсан нийлмэл өгүүлбэр болон холимог нийлмэл өгүүлбэр элбэг.
- Хэлэх аялгаар холбогдсон энгийн нийлмэл өгүүлбэр олон.
- Өгүүлбэрийн гишүүдийн байрыг зориуд өөрчлөх арга бий.
- Хоршоо үгийн өвөрмөц хэлбэрийг уран дүрслэлтэй яруу сонсголонтой болгох зорилгоор хэрэглэсэн нь их. / Ц. Сүхбаатар, 2012:432-434/

Уран зохиолын орчуулга: Уран зохиолын орчуулга өөр хоорондоо нягт уялдаа холбоо бүхий хоёр ухагдахууныг тэмдэглэдэг. Үүнд: 1. Нэг хэлнээ байгаа зохиол бүтээлийг өөр хэлнээ хөрвүүлж гаргаж буй бүтээлч явц; 2. Энэхүү явцын үр

дүн орчуулгын зохиол; / Д. Дашдаваа, 2010:152/ Аль ч нийгэмд уран зохиолын орчуулга нь хүний нийгмийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэсээр ирсэн. Үүний хажуугаар уран зохиолын орчуулга нь зохиолчийн цаасан дээр буулгасан уран сайхан дүр, төсөөлөл болон эх зохиолын найруулгын онцлогийг уншигчдад амьдчилан дамжуулах үүрэгтэй байдаг учраас орчуулагч хүний нэг том сорилт юм. Тийм ч ураас “... уран зохиолын орчуулгын тухай шинжлэх ухаан бий боллоо. Түүний үндэс суурийг К.М.Чуковский, А.В.Федоров тавьсан гэж үзэж болох талтай” / Д. Дашдаваа, 2010:154/

Монголын зохиолчдын 7-р их хурал дээр академич Ц. Дамдинсүрэн уран зохиолын хэл найруулгын талаар хэлэхдээ, “хэтэрхий хуучирсан үгийг олон хэрэглэх, өгүүлбэр зүйн зарчмыг эвдэж буруу найруулах, хэт чамин үгээр өгүүлбэрийг хэт ээдрээтэй болгох зэргээр ойлгомж муутай бичихийг цээрлэх хэрэгтэй” гэсэн нь зохиолчдод хандсан үг боловч уран зохиол орчуулахад үүнийг мөн адил анхаарах ёстой. / Д. Дашдаваа, 2010:154/ Товчхондоо сайн орчуулга нь эх зохиолоосоо ялгагдахааргүй уншигчийн сэтгэлийн утсыг хөдөлгөж чаддаг байх ёстой.

“Бүх төрлийн орчуулгаас уран зохиолын орчуулга нь Ландерс, Буш, Ламберт, Ньюмарк зэрэг онолчдын сонирхлыг ихээр татсан байдаг. Тэд бүгд уран зохиолын орчуулгын явц, орчуулагч болон уншигч гэсэн гурван хүчин зүйлд анхаарлаа хандуулжээ. Энэ төрлийн орчуулгын талаар тэд хэд хэдэн санал дэвшүүлсэн байдаг бөгөөд тусгайлан соёлтой холбон тайлбарласан юм.” /Phd. Ilda Poshi, ‘Culture - Specific Items And Literary Translation’, Mediterranean Journal of Social Sciences, Vol 4, 2013/

- **Ландерсын** үзсэнээр уран зохиолын орчуулга нь “орчуулгын бүтээлч үйл явцыг байнга хуваалцах боломжийг олгодог” (Ландерс 2001:4-5); “уран зохиолын орчуулга нь дуусашгүй сонголтын гогцоог үүсгэдэг” (Ландерс 2001:9).
- **Бушийн** үзсэнээр уран зохиолын орчуулга бол “нийгэм, соёлын өвийн цогцолборын төв хэсэгт орших анхны субъектив үйл ажиллагаа юм” (Буш 1998:127)
- **Ламбертын** үзсэнээр “хэвлэгдсэн орчуулга гэдэг нь орчуулгын субъектив үйл ажиллагаа, нийгмийн практикийн гол төлөөлөгч болсон орчуулагч хүний бүтээлч хүчин чармайлтын үр дүн юм”.

Бид дээр дурдсан Ц. Сүхбаатар гуайн найруулгын алдааны ангилал дээр тулгуурлан “Морь унасан толгойгүй хүн” романы орчуулгыг найруулгын ур маягийн талаас авч үзсэн юм. Ингэхдээ жишээ болгон зарим хэсгүүдээс оруулсан болно.

Үг буруу сонгосон хэсгүүд:

Үгээ онож сонгоогүйгээс илэрхийлэх гэсэн зорилгодоо хүрч чадахгүй, тэр ч байтугай огт өөр ойлголт төрүүлэх; /Энэ алдаа давтагдаагүй тоогоор зохиолд 48 удаа гарав./

Эх хэл дээр	13.72. "I reckon, thet out on the purayra, thur'll be some folks ud prefar a leetle <u>corn</u> to any o' thet theer furrin French stuff. Sham-pain, ye call it, I b'lieve." "Prefer <u>corn</u> to champagne! The horses you mean?" "Hosses be durned. I ain't talkin' 'bout hoss <u>corn</u> . I mean M'nongaheela."
Орчуулга	<i>"Тал хээр нутагт энэ бүх гадаадын хачин юмс, энэ оргилуун дарс мэтийн зүйл таалагдахгүй ба арай энгийн <u>бантанг</u> дээрд үзэх хүн байгаа гэж надад санагдана."</i> <i>"Оргилуун дарснаас <u>бантанг</u> дээр үзэх гэж үү? Ноён Стумп, та морины тухай яриад байна уу?"</i> <i>"Чиний морьдыг чөтгөр ав. Би морины <u>бантангийн</u> тухай яриагүй. Харин Мононгахилийн вискиний тухай яриад байна."</i>

- Эхэд эрдэнэ шишийн архи гэсэн утгаар орсон үгийг бантан гэж оновчгүй орчуулжээ. Хэдий жирийн ундаа гэсэн санааг төлөөлүүлэн илэрхийлсэн байж болох ч бантан гэх утга санаанд буухад бэрх. Тиймээс эрдэнэ шишийн архи гэж буулгах нь зүйтэй.

Эх хэл дээр	55.264. She even proposes making the journey <i>alone</i> ! Don Silvio offers an escort—half a score of his <i>vaqueros</i> , <u>armed to the teeth</u> . The offer is rejected. Will she take Benito? No. She prefers journeying alone. In short, she is determined upon it.
Орчуулга	<i>Тэр ганцаар явахаар шийджээ! Ноён Сильвио <u>шүдээ хүртэл зэвсэглэсэн</u> арван малчинг дагалдуулан хамгаалах санал тавив. Исидора эрс татгалзжээ. Тэгвэл Бенитог авч явах уу? Үгүй. Тэр ганцаар явахыг эрхэмлэнэ. Тэр ингээж шийджээ.</i>

- ...шүдээ хүртэл зэвсэглэсэн... гэсэн нь 'armed to the teeth' гэх өвөрмөц хэлцийг үгчлэн орчуулчихжээ. Уг хэлц нь бүрэн зэвсэглэх гэсэн утгатай. /Oxford Dictionary of Idioms, 2nd edition, 2004, х.х-9/ Тиймээс махчилж орчуулалгүй өвөрмөц хэллэгийн үндсэн утгыг барих нь зүйтэй.

Үг илүүдсэн хэсгүүд:

Шаардлагагүй илүү үг нуршсанаас чухам юу гэж өгүүлэх гэж байгааг ойлгоход бэрх болдог; /Энэ алдаа давтагдаагүй тоогоор зохиолд 17 удаа гарав./

Эх хэл дээр	55.260. "I must send someone back to release him. One who can keep my secret—who? Benito, the mayor-domo—faithful and brave. <i>Gracias a Dios!</i> Yonder's my man—as <u>usual</u> busied in counting his cattle. Benito! Benito!"
Орчуулга	<i>"Түүнийг чөлөөлөхөөр хэн нэгнийг илгээх хэрэгтэй. Гэхдээ миний нууцыг хадгалах хүн хэрэгтэй. Даамал Бенито яг тохирно. Тэр эрэлхэг ба үнэнч хүн. Бурханы авралаар тэр ирлээ. <u>Үргэлж тэгдэг зангаараа</u> малаа тоолж явна. Бенито! Бенито!"</i>

- Энд 'тэгдэг' гэсэн сул үг хэрэглэхээс зайлсхийж ...Сурсан зангаараа... гэж цомхон буулгавал тохиромжтой санагдана.

Эх хэл дээр	48.223. And this, too, despite the round hat upon the head—despite the serapé upon the shoulders, worn as a protection against the chill morning air—despite the style of equitation, sooutré to European ideas,
Орчуулга	<i>Морьтой хүний толгой дээрх дугуй малгай, өглөөний хүйтнээс болж мөрөндөө тохсон цув, тэр хүн Европт бол эмэгтэй хүнд зүй зохисгүйд тооцогддог эрэгтэй маягаар мориндоо заларсан зэрэг нь энэ таамагт харилахгүй.</i>

- ... тэр хүн... буюу өгүүлбэрийн эзнийг дахин дурдах нь илүүц байна.

Үг дутсан хэсгүүд:

Учир шалтгааны шаардлагатай зайлшгүй байх үгийг орхисноос утга ойлгомжгүй болох, илэрхийлэх гэсэн санаагаа гаргаж чадахгүй байх; /Энэ алдаа давтагдаагүй тоогоор зохиолд 11 удаа гарав. /

Эх хэл дээр	65.315. "... That same Mexikin <i>montay</i> too. I reckon they've larned it from thar Mexikin captives; <u>of the which they've got as good as three thousand</u> in thar different tribes. Yes, sirree!" concludes the trapper. "The Keymanchees <i>do</i> play cards—sure as shootin'."
Орчуулга	<i>"... Тэд олзны хүмүүсээс сурсан бололтой яг энэ мексик монтег тоглодог байсан. Янз бүрийн омогт 3 мянга хүртэл хүн бий. Ямартаа ч команчууд хөзөр тоглодог нь чин үнэн."</i>

- ...3 мянга хүртэл хүн бий... бус ...3 мянга хүртэл олзлогдогч бий...
/'олзлогдогч' гэх санааг тодорхой гаргаж өгөхгүй бол нэг омог нийтдээ 3 мянган хүнээс бүрддэг гэсэн ойлголтыг өгч байна./

Эх хэл дээр	84.383. "Well," said Calhoun, apparently in reluctant utterance, as if shy about entering upon the subject, or pretending to be so, "I—I— <u>wanted</u> —"
Орчуулга	<i>"Тэгэхээр ийм байна." гэж Колхаун энэ яриаг эхлэх эсэхээ шийдээж ядах юм уу эсвэл тээнэгэлзээж байгаа дүр исгэн хэлээд, "Би... Би хүсэхдээ..."</i>

- Уг өгүүлбэрийн дуусгаагүй санааг яг байгаагаар нь буюу ...Би хүсэхдээ... гэж орчуулсан нь найруулгыг модон болгож байгаа тул зохиолын энэ хэсгийн өрнөлийг төсөөлөн бодолцож ...Би нэг юм хэлэх гэсэн юм... гэж дуусгавал зохимжтой юм.

Үгийн өнгө аясыг гажуудуулсан хэсгүүд:

Ганц үгийн өнгө аяс тохироогүйгээс тухайн тухайн өгүүлж буй зүйлд алдаа үүсэх; /Энэ алдаа давтагдаагүй тоогоор зохиолд 9 удаа гарав. /

Эх хэл дээр	18.101. "Why do you ask that, Loo? <u>I reckon you know as well as I.</u> "
Орчуулга	"Лу, чи яагаад надаас үүнийг асууна вэ? <u>Би тэдний талаар чам шиг л мэдлэгтэй байгаа.</u> "

- "know" буюу "мэдэх" гэсэн санааг мэдлэг гэх нэр үгээр гаргасан нь арай учир дутагдалтай тухайн харилцан ярианы өнгө аясд зохицохгүй мэт. Тиймээс ...Адилхан явж байж хэн нь хэнээсээ асуух вэ дээ... гэвэл зүйтэй.

Эх хэл дээр	29.144. "But the time's not come, <i>nor capitan</i> ; <u>nor yet</u> the opportunity, <i>Carajo!</i> "
Орчуулга	"Гэвч цаг нь болоогүй. Тохиромжтой тохиолдол ирэхгүй <u>байсан</u> . Чөтгөр ав!"

- Тус өгүүлбэрийг -сан⁴ буюу өнгөрсөн цагийн өнгөөр орчуулсан нь найруулгын алдаа үүсгэж байгаа учир одоо цагийн өнгөнөөс ...ирэхгүй байна... гэж орчуулах нь зүйтэй.

Дүрслэх буюу яруу хэрэглүүр оновчгүй сонгосон хэсгүүд:

Аливаа зүйлийг уншигчийн урмыг сэргээж, сонирхлыг татахаар бичихэд уран дүрслэлийн арга, хэлний яруу хэрэглүүр тусалдаг. Гэвч оновчгүй болсон яруу хэрэглүүр уншигчийн итгэл үнэмшлийг алдуулан, инээд хүргэхээс хэтэрдэггүй. /Энэ алдаа давтагдаагүй тоогоор зохиолд 7 удаа гарав. /

Эх хэл дээр	83.380. Among the populace there was the usual clamoring for prompt and speedy justice; fortified by that exciting phrase, <u>old as the creation itself</u> : "that the blood of the murdered man was calling from the ground for vengeance."
Орчуулга	Тосгоны олонх оришин суугчид <u>дэлхийтэй адил өндөр настай</u> 'алагдсан хүний цус өшөө авахыг хашиглан шаардаж байна,' гэсэн хэллэгийг удиртгал болгон гэмт хэрэгтнийг нэн даруй шүүхийг шаардав.

- Зохиол дээрх дүрүүд аль эртнээс өшөө авахыг шаардаж байгааг ...дэлхийтэй адил өндөр настай... гэсэн адилтгал ашигласан нь дүрслэлийн хувьд нэг л оновчгүй, санаанд нийцэхгүй байна. Харин энгийнээр ...улиг домог болсон... гэж буулгавал тохирох юм.

Эх хэл дээр	9.52. "Oh, indeed!" drawled the lieutenant of rifles, in a tone that told of his being chafed by this representation. "Miss Poindexter must be <u>deuced good-looking</u> , then."
Орчуулга	"Тийм гэж үү! Тэгвэл Пойндекстер авхай авхай <u>чөтгөр шиг сайхан</u> хүүхэн болж таарлаа." гэж буучдын хорооны дэслэгч догдлон хэлэв. Түүний дууны өнгөнөөс үзвэл энэ мэдээ түүнийг байж ядуулах бололтой.

- Зүс царай сайтай хүнийг чөтгөртэй зүйрлэх нь тун тохиромжгүй бөгөөд гоё сайхан гэх утгаас хол зөрж байна. Тиймээс ...жигтэйхэн сайхан... гэж буулгая.

Үг нуршин давтсан хэсгүүд:

Нэг үг юм уу, нэг үндэстэй үгийг ойр ойрхон давтан хэрэглэхэд тухайн найруулгын яруу сайхан, хурц тод, ур чадал суларч улмаар найруулгын алдаа болдог. Энэ алдаа давтагдаагүй тоогоор зохиолд 21 удаа гарав. /

Эх хэл дээр	5.30. He was a round plump specimen, with a shock of <u>carrot-coloured hair</u> and a <u>bright ruddy skin</u> , habited in a suit of stout stuff—half corduroy, half cotton-velvet.
Орчуулга	Энэ бол <u>улаан нүүртэй</u> , <u>улаан үстэй</u> тарган эр байв. Хагасыг нь хилэн, хагасыг нь бүдүүн ширхэгтэй нарийн хилэн давуугаар оёсон хослол өмсжээ.

- Хэдий 'carrot-coloured', 'bright ruddy' гэх тэмдэг нэрс нь хоёул улбар, улаан гэх санааг агуулах боловч монгол хэлнээ найруулгын өнгө төрхийг бодон 'хонгор үстэй', 'час улаан царайтай' гэх зэргээр зүс царайг ялгах хэрэгтэй.

Эх хэл дээр	55.259. Miguel Diaz spoke the truth, when he said he was in danger. Well might he believe it.
Орчуулга	<u>Түүнд</u> аюул нүүрлэж байна гэж батлан хэлэхдээ Мигуэль Диас үнэн хэлсэн юм. <u>Түүнд</u> ингэж бодох бүрэн үндэс байв.

- Эхний өгүүлбэрийг Өөрт нь... гэж эхлүүлэх нь хэнд аюул нүүрлэж байгаа буюу утгыг илүү ойлгомжтой болгож байна.

Дүгнэлт





Диаграмаас харахад үг буруу сонгосон (48) алдаа нь хамгийн өндөр бол үг нуршин давтсан (21) үг илүүдсэн (17) алдаа нь ойролцоо тооны, харин үг дутсан (11) үгийн өнгө аяс гажуудуулсан (9) яруу хэрэглүүр оновчгүй (7) алдаанууд нь бусад гурван төрлийн алдаатай харьцуулахад бага гэж болохоор байна.

Эндээс дүгнэхэд орчуулгын найруулгад алдаа дутагдал гарснаар эх зохиол хичнээн сайхан бичигдсэн байлаа гээд үнэ цэнэ нь алдагдаж, өөр хэлээр уншиж буй уншигчдад сэтгэгдэл төрүүлэхгүй байх аюулд хүргэдэг байна. Тиймээс орчуулагчид дан ганц өөрт бус бусдад хамаарах үйл хийж байгаагаа ухааран хариуцлагатай хандах шаардлагатай.



“...Тэрээр зохиолынхоо найруулгыг ямагт цэвэршүүлэн шүүж, хэлийг нь уйгагүй засч сайжруулдаг байлаа. Жишээ нь Горький “Эх” романаа 8 дахин засч, нийтдээ 2 мянгаад засвар оруулжээ. Зохиолынхоо үг бүрийг бодож, тунгаан дээд зэргийн яруу, тодоор, энгүүнээр, сэтгэл хөдлөлийн их хүчээр дүрсэлж чаддаг байв” / Д. Дашдаваа, 2010:146 / Үүнтэй нэгэн адилаар орчуулагч хүн зохиогч шиг зохиолд чухал ач холбогдол өгөн орчуулгын эцсийн хувилбараа гаргахаас өмнө хэдэнтээ засаж засварлаж, аль ч талаас уншигчийн сэтгэлд хүрэхийг эрмэлзэх учиртай.

Ном зүй

1. Ц. Сүхбаатар, Монгол хэлний найруулга зүй. УБ, 2012
2. Ч. Чойсамба, Сонины хэл найруулга. УБ, 2000
3. Ц. Сүхбаатар, Хэл соёлын тулгамдсан асуудлууд, “Найруулгад эрхэмлэх зүйл”. УБ, 2002
4. Д. Отгонсүрэн, Монгол хэлний найруулга зүй. УБ, 1975
5. Д. Дашдаваа, Орчуулгын найруулга зүйн бүтэц – утга зүйн үндэс. УБ, 2010
6. Oxford Dictionary of Idioms, 2nd edition, 2004
7. Б. Энхзул, “Оливер Твист” зохиолын орчуулга, найруулгыг шинжихүйд: магистрын зэрэг горилсон судалгааны ажил, МУИС-ШУС, УБ, 2014
8. Phd. Ilda Poshi, ‘Culture - Specific Items And Literary Translation’, Mediterranean Journal of Social Sciences, Vol 4, 2013
9. <https://mongoltoli.mn/>



ХАВСРАЛТ



С. Пүрэв

НЯЛХ САЛХИ

Цав цагаан тал дээгүүр хөл хөнгөнтэй нялх салхи тоонон чинээ том хамхуулыг хөдөлгөж ядан өмнө уулын зүг өнхрүүлж нэг үзсэнээ байчаад баруун тийшээ, тэгснээ зүүн зүг эргэлдүүлнэ. Зүггүй ч амьтан бол доо. Энэ нялх салхины оронд азарган салхи байсансан бол тэр муу хамхуулыг аль хэдий нь хэдэн уул давуулаад чулуудчихсан байх.

Цасан дороос цухуйх өвсний цантсан саадагт орооцолдон хөлд орох нялх салхи миний Алтайнх. Миний нутгийн салхи даахин хонгор сэвлэгтэй, тэнтэр тунтар явдалтайг би бүр багаасаа мэдэх юм байна.

Эцэж цуцахыг мэдэхгүй өдөр шөнө, өглөө оройгүй хаа л бол хаа гүйж дэгдүүлж явна. Бас эргэх дөрвөн улирлыг ч ялгахгүй.

Нялх юм болохоор хааяа бас саваагүйтнэ ээ. Хүн амьтны хормой хотоор оролдож, уулга алдуулах нь энүүхэнд. Хамхуул тээж дийлэхгүй мөртлөө гэрийн бүрээс урж, зуух яндангаар нь тоглоно. Бодвол яндан хонгинох чимээ өөрт нь зугаатай юм болов уу даа.

Манай Алтайн нялх салхи дээвэр дэлдэх хөлгүй салхины өмнө жирийлгэн гүйж айл айлд зар түгээн “Цаана чинь сүйдлэх гэж байна шүү” хэмээн сануулж, айл хотынхон ч тэр мэдээгээр гэр бараагаа бөхөлж, аргал түлшээ бүтээн хамаг ажлаа амжуулаад амарна. Ингээд бодоход нялх салхи хүнд тусархуу аж.

Энэ нялх салхийг дэлхийн настай чацуу, магадгүй түүнээс ч ах байж мэднэ гэж би олонтоо боддог байлаа. Хавар намартаа зэрэглээ татан жирэлзүүлж, их говийн минь энгээр нэг тоглоом өрчихнө. Нялх юм чинь тоглохоос биш яахав.

Ээж минь надад нэгэнтээ нялх салхины тухай хуучилснаас үүдэн би эрх танхил насандаа ийн бодож биширч өсчээ. Хожмоо эргээд санахад газар тэнгэртээ сүсэлж явдаг ээжийн минь ухаан надад энэ бүхнийг хайрласан байх юм.

Манай Алтайд салхи нь хүртэл жаргалтай сайхан.

S. PUREV

L'INFANTILE ZÉPHIR

Traduit par Galsanjamtsyn Bouyannemekh

Dans la steppe couverte de neige l'infantile zéphyr agile et rapide essaie de rouler un panicaud grand comme l'ouverture du toit de la yourte, d'abord vers la montagne au sud, puis vers l'ouest et enfin vers l'est. Quel coquin ! Mais si cela avait été un vent plus vigoureux, alors il aurait déjà jeté ce malheureux panicaud par delà les montagnes.

Cet infantile zéphyr qui commence à faire ses premiers pas en se mêlant aux extrémités givrées des herbes perçant la neige, c'est celui de notre Altaï. Depuis ma tendre

enfance je sais que notre zéphyr est doux comme les cheveux d'un bébé, qui va en se dandinant de-ci, de-là.

Il court partout de jour comme de nuit, du matin au soir et en toute saison, sans jamais connaître la fatigue.

Comme c'est un bébé, il est parfois pris de curiosité. Il fait sursauter les gens en soulevant leur pan de robe. Bien qu'il ne puisse soulever le panicaut, il déchire quand même la couverture de la yourte et joue avec le poêle et son tuyau. Peut-être que faire ronfler le conduit l'amuse.

L'infantile zéphyr de notre Altaï file avant qu'un vent fort ne frappe le toit, avertir chaque famille : "Attention! Voilà un vent sans précédant qui arrive!". Et les gens consolident tout de suite leurs yourtes, couvrent le bois et le fumier pour le chauffage après quoi ils se reposent. C'est ainsi que notre infantile zéphyr apporte son aide aux gens.

Moi, j'ai pensé à plusieurs reprises que cet infantile vent avait le même âge, ou même était peut-être plus âgé que notre terre. Au printemps et en automne parcourant l'étendue du grand Gobi, tel un mirage, il crée avec le sable différents jouets. Comment pourrait-il se dispenser de jouer, c'est un bébé?!

J'ai cru le récit de ma mère à propos de l'infantile zéphyr toute ma tendre enfance. Plus tard, en y songeant, je comprenais que le bon sens /esprit, intelligence/ de ma mère qui vénérât le monde m'avait apporté tout cela.

Dans notre Altaï, tout, même le vent est beau et heureux.

Tchadrabalyn Lodoïdamba

A la mémoire d'un père exceptionnel

TAMIR, RIVIERE A L'EAU LIMPIDE

*Traduit par Galsanjamtsyn Bouyannemekh
Alain Desjacques*

C'était le jour du premier mois estival de la quatrième année¹ sous le règne du VIII^e Bogdo Gueguen². Un homme d'une trentaine d'années menait une charrette à cheval, bien chargée, sur le chemin longeant la rive nord de la rivière Grand Tamir. Il portait une robe en lambeaux imprégnée de crasse, tannée par le vent et le soleil, rapiécée de tissus multicolores. On ne pouvait plus distinguer le tissu d'origine.

Il portait à l'épaule, à la forme carrée, un vieux fusil à pierre en bandoulière dont la grosse tresse broussailleuse était relevée par un fichu bleu usé en toile de coton. Sous d'épais sourcils grisonnant de poussière, ses grands yeux clignaient lentement. Sur le visage bronzé transpirant apparaissait la fatigue d'un long voyage. En se plongeant dans

¹C'était en 1914.

²Le dernier théocrate de la Mongolie autonome.

ses pensées il devenait maussade. Il était difficile de deviner, par quoi il était préoccupé: soit par la fatigue, soit par l'irritation. De temps en temps l'homme se retournait, en regardant le chemin parcouru, et s'arrêtait parfois pour rajuster la charge. Lorsque le soleil couchant effleurait le sommet de la montagne, il s'est dirigé vers la rivière, en quittant la route. Arrivé sur la berge, il a retiré habilement le fusil, et l'a mis sur pied. Ensuite il a dételé le cheval, l'a laissé en l'entravant. Puis il s'est assis confortablement les jambes croisées à l'ombre du char, en sortant du revers de sa robe une pipe, il fumait sans se presser en frôlant avec ses doigts le haut des herbes.

Cet homme s'appelait Erdene. Il était originaire du clan 'Olgonuud' de la bannière de Zassagte khan³. Du côté de son père ils étaient deux. Orphelins dès leur prime jeunesse, ils faisaient paître les troupeaux dans différentes familles.

Son frère cadet s'appelait Tumur. A 16 ans, il était allé se joindre aux brigands justiciers des montagnes. Peu après, il est devenu célèbre grâce à son courage, sa force et son bon esprit. Alors on l'a surnommé 'Tumur-le-silex de Zassagte khan', d'où il tire son nom. Des histoires presque légendaires couraient à travers quatre régions et cinq circonscriptions lamaïstiques.

Il y a trois ans, en pleine nuit Tumur est venu chez son aîné avec deux inconnus et en est reparti au point du jour, en lui laissant un lingot d'argent et trente roubles russes tsaristes.

Depuis ce temps-là les frères ne se voyaient plus et n'échangeaient des nouvelles que par hasard. Et voici un an déjà qu'Erdene n'avait plus entendu parler de lui.

En ce qui concerne Erdene, dans son enfance, il était berger chez le prince Donoï et coursier lors des compétitions équestres. Quand Tchouloun, fils de Donoï apprit l'écriture, Erdene eut la chance de l'apprendre aussi. L'esprit vif, et se passionnant pour la lecture il lisait «Clé de la sagesse», «Le conte de l'oiseau en papier», «L'histoire de trois pays», «Altan tobtchi» et tout ce qui lui tombait sous ses yeux. Il écrivait des lettres et des requêtes à la demande, et c'est pourquoi on l'appelait Erdene-le-scribe.

A dix-huit ans il s'était marié avec Dolgor, une jeune fille du coin et a acquis sa propre yourte. Ce ménage possédait une dizaine de yaks, deux trois montures et quelques moutons.

Il aurait pu vivre comme les autres, souffrir du malheur, avoir faim en temps de disette, se réjouir du bonheur et être mécontent face à l'indignation. Mais le seigneur héritier du trône, Gombajav, avait un caractère dur. Il tourmentait beaucoup trop le peuple. Alors, Erdene avait porté plainte contre lui à l'assemblée locale et au ministère mongol et mandchou.

Ce n'est pas en vain qu'on dit que se brouiller avec le seigneur entraîne des châtiments physiques. Aussi, en donnant des pots de vin abondants du trésor de la bannière aux responsables hiérarchiques, Gombojav a réussi à faire mettre le rebelle dans la prison d'Ouliastaï. Il y a passé plus d'un an, où sa longue chevelure se couvrait de poux. A ce moment-là s'étant délivrée du joug mandchou, la Mongolie a accédé à l'autonomie, et le régent théocrate intronisé, Bogdo Javzandamba, a annoncé l'amnistie. Erdene fut donc

³L'un des quatre aïmaks de cette époque.

libéré. Mais, En prison il avait rencontré un homme qui lui avait raconté beaucoup d'histoires quasi légendaires sur son frère.

Ce codétenu racontait qu'ils avaient dérobé ensemble des chevaux du prince Bon-viseur du Gobi et les avaient emmenés dans la bannière de Sartes sagaces. 'En un clin d'œil il reconnaît un bon coursier. Son âme est pure et il a la force du lynx. Il supporte la faim pendant une semaine en chantant, et passe 70 örtö⁴ sur les étriers' dit-il en faisant l'éloge de lui.

Erdene est revenu dans sa contrée, mais l'oppression du prince courroucé ne le laissait pas vivre, et il a dû tout donner pour payer différents impôts. Et en chargeant ses derniers biens dans un char à cheval, il a pris le chemin de la capitale avec sa femme et son fils pour aller prier Bogdo.

Après avoir fumé avidement en quelques bouffées sa pipe, Erdene regarda le chemin parcouru. En voyant descendre sa femme et son fils par le chemin du côté sud du mont, il s'est levé, mis la pipe encore fumante dans la doublure de ses bottes. Une fois le char déchargé, il a dressé une petite tente imprégnée de fumée et rapiécée comme sa robe. Ensuite il a ramassé des bouses sèches, et entre trois grandes pierres il a fait du feu et préparé du thé.

Quand le thé commençait à bouillir dans la petite marmite, sa femme et son fils sont arrivés. Dolgor a alors déposé des fumiers séchés qu'elle avait ramassés dans le revers de sa robe et elle s'est assise sur l'herbe les jambes tendues. Sur son visage brûlé par le soleil et la poussière on pouvait lire la fatigue d'un long voyage. Pourtant dans ses yeux noirs plein de jeunesse on pouvait remarquer la beauté des femmes des steppes.

- Le fils allait très lentement dit-elle en souriant, et les dents aussi blanches qu'un nacre ont étincelé.

- 'Repose-toi un peu. Je vais rincer la théière et y mettre le thé ' dit-il en prenant de la charrette la cruche en cuivre. Il s'est dirigé vers la rivière, scintillante sous les rayons du soleil couchant.

Accroupi sur le bord de la rivière à l'eau limpide il s'est mis à rincer la cruche. Il se rappelait un oui-dire : ' Qui regarde l'eau ne s'ennuie pas'. Et il s'est lavé le visage, s'est essuyé avec le pan intérieur de sa tunique.

Il s'est levé et revenu près du feu. Le thé bouillant à gros bouillons, il en prit dans une petite louche en fer et fit une libation à l'ouest, en murmurant 'mon Taïchir qan'. Prenant encore une louchée, il procéda à une nouvelle libation vers la grande montagne verdoyante au sud en murmurant 'mon Khangai '.

Fatigués du voyage, assis sur l'herbe verte l'un en face de l'autre, ces trois prenaient joyeusement les galettes odorantes de la farine d'orge sautées et le thé chaud pour le repas, ayant oublié tout le malheur de l'univers, ne pensant plus aux malaises du passé et à l'avenir.

- 'Papa, quand arriverons-nous à Khuree ? ' a demandé Bat. Erdene avalant une bouchée, pris une gorgée de thé et dit :

⁴ örtö ~ örtege : une trentaine de kilomètres.

- Bientôt, mais si tu te laisses aller à la paresse comme aujourd'hui, le chemin de Khuree deviendra plus long.

- Moi, je veux y aller, seulement ces pieds-ci se fatiguent, répondit Bat. A ces mots, les parents ont souri tendrement.

- Le grand rocher rencontré sur notre droite c'était bien celui de Taïkhar? demanda Dolgor.

- Oui. Comme il est gigantesque!

Erdene avait raconté la légende du rocher Taïkhar à sa femme et à son fils dès l'apparition de 'la route de serpent' derrière le col de Eg.

Croyant profondément à la magie du vénérable Gueguen, Dolgor s'était prosternée plus que de coutume, plus de dizaine de fois en demandant grâce pour leur trois âmes, quand ils passaient au nord de ce grand rocher.

- Maman, qui est-ce que vous priez ? demanda Bat qui était debout près d'elle.

- Je prie Zaya Gueguen, fiston, répondit la mère en chuchotant.

- Pourquoi le priez-vous ?

- Je le prie pour qu'il nous accorde un bon destin.

- Demandez-lui du sucre candi pour moi, maman.

- Mon fils, prie-le toi-même.

- Mon Gueguen, donnez-moi du sucre candi, prie Bat agenouillé.

L'an dernier, pendant la fête, Bat gagna la course de chevaux en montant le coursier bai du prince Donoï. Il reçut de la femme de ce dernier des petits sucres candi. Depuis, Bat pense que le sucre candi est la meilleure chose du monde.

Mère et fils ont admiré de cette façon le rocher Taïkhar érigé au milieu de la steppe par les forces extraordinaires de la nature.

- Papa, peux-tu porter sur le dos cette pierre en l'attachant par ton orkhimji⁵ demanda Bat. Alors le père sourit en caressant la tête de son fils et dit:

- Moi, je suis un laïc, c'est pourquoi je n'ai pas de orkhimji. De plus je ne possède pas de force magique comme Zaya pandita.

En réfléchissant, s'étant assis un peu, Bat en clignotant des yeux regarde son père et demande : 'Papa, qu'est-ce que c'est la magie ?'

- La magie ? C'est une grande force. Celui qui la possède, peut nous transférer en un clin d'œil à Khuree, dit-il.

- Mais pourquoi vous ne la possédez pas? Si vous en aviez ... ce disant, Bat reste un petit moment les yeux fermés en agitant les bras comme s'il s'envolait ... et poursuit: nous y serions parvenus sans nous fatiguer les pieds. C'est vrai, n'est-ce pas maman, dit le fils avec regret dans sa voix.

'Je n'avais pas le temps' répondit le père en embrassant la tête de son fils qui sent le soleil et la poussière du chemin.

- 'Pourquoi?' demande Bat à plusieurs reprises. Les parents rient de bon cœur de la naïveté de leur fils. Du côté de la tente usée et imprégnée de fumée s'élèvent les voix

⁵large bande d'étoffe rouge que les lamas portent au-dessus de robe.

joyeuses qui se mêlent au clapotement des ondes fluviales. L'homme naît pour le bonheur, et aucunes difficultés de la vie, aucunes souffrances ne peuvent étouffer en lui l'aspiration à la joie et au bonheur. C'est sans doute, pourquoi la vie dure et les chemins difficiles n'arrivent pas éteindre la joie et le petit bonheur de ces trois-là, après le souper frugal. Sans connaître encore ce que le jour suivant leur apportera, ils parlaient joyeusement sans remarquer la fin du crépuscule et le début de la nuit tombante. Dans le ciel commencent à briller les étoiles, et dans la vallée de la rivière Tamir souffle le vent frais qui exhale les odeurs suaves de steppe.

En amenant son cheval, Erdene l'attache au pieu par une longue longe et regarde quelques instants vers la direction de sa contrée natale. Il prie tout doucement en joignant les mains : 'Mon Taïchir khan, mon Tarlan khaïrkhan, mon Ata tengueri, mon Gombo bienfaisant, aidez- moi ! ' Il entre dans la tente et bientôt un sommeil profond s'y installe.

Au point du jour Erdene se lève et sort de la tente en jetant sa tunique sur le corps. Le cheval attaché par la corde a disparu. Il ne reste que les entraves et la corde par terre. Erdene veut regarder un peu plus loin, mais il lui semble que la montagne noire devant lui s'approche soudain en grandissant et il recule deux pas en arrière. Il reste stupéfait quelques instants. Il fit quelques pas en concentrant tous ses efforts, pareil à quelqu'un brièvement blessé et murmura en regardant au-dessus des montagnes noires à l'ouest :

'Mon Taïchir khan, mon Ata tengueri, mon Gombo bienfaisant pourquoi vous ne me menez pas ?'

Dès que Erdene rentra, Dolgor qui s'était réveillée à la sortie de Erdene, lui demanda en se redressant :

-Il fait beau ?

S'arrêtant au seuil de la tente, Erdene sans dire un mot jeta la longe et les entraves au sol de la tente et dit: on a volé le cheval.

- Quoi ! Notre cheval? crie Dolgor en bondissant.

- Oui, dit-il. Et il s'assit sur le matelas sans alèse sur lequel il s'était couché la nuit.

- Que faire, maintenant? Dans cette région étrangère à la notre, sans cheval, où peut-on aller ? dit-elle en pleurant. Des larmes coulaient sur ses joues.

Paraissant indifférente au malheur qui frappait cette tente, la rivière Tamir gazouillait harmonieusement et l'aube matinale de plus en plus blanchissante à l'est annonçait joyeusement la naissance d'un nouveau jour en ce monde encore endormi.

Il ne faut pas pleurer ... eh bien ... dit-il. Il voulait sourire à sa femme, mais il ne pouvait pas. Sa bouche tremblait et un tic nerveux remuait ses sourcils épais. Alors, saisissant sa pipe, il la bourrait de tabac et il fuma en plusieurs bouffées.

Maintenant que faire? Cette question sans réponse venue à son esprit lui restait dans la gorge et sa vue se troublait de temps en temps. Ainsi, en regardant Dolgor du coin de l'oeil, il attacha sa ceinture et s'assit confortablement en croisant les jambes, comme s'il ne voulait plus partir d'ici.

'Eh bien, on reste sans monture, mais on n'est pas mort. Faisons bouillir le thé. 'Un homme vivant a toujours des moyens, le feu du fumier séché a des braises' murmurait Erdene entre ses dents serrées.

Sur ses pommettes couraient de petites convulsions. Ses yeux restaient fixés sur un point devant lui et une fumée bleue sortait de temps en temps de son nez et de sa bouche. Dolgor voulait dire quelque chose, mais resta sans dire un mot et sortit.

Pareil à des panicaux automnaux, les formes noires luisantes roulaient ça et là dans la vallée de la rivière Orkhon inondée par des rayons de soleil.

En faisant du feu, elle murmurait toujours 'Mon Gombo, Mon Taïchir'. Mais ne sachant plus elle-même ce qu'elle leur a demandé.

II

Le matin précédent la triste nuit où Erdene avait perdu son cheval, il s'était passé encore un autre événement dans la vallée de la rivière Tamir.

Trois yourtes avec une bergerie au milieu se distinguaient sur la large terrasse à la sortie d'une longue vallée provenant du nord, à la droite de la rivière.

Au point du jour, un homme sortit de la grande yourte du sud-ouest, regarda attentivement en direction des quatre points cardinaux. Il avait un visage rond bronzé, de grands yeux brillés courant et de grosse tresse noire sur le dos. Il portait une tunique de coton bleu et des bottes un peu usées. De sa ceinture pendait un briquet en fer ciselé et un couteau avec le manche en écorce de bouleau.

Cet homme s'appelle Itguelt. Il a 32 ans. Il n'a aucune origine aristocratique. Quoique les biens hérités de son père soient modestes, il est devenu en quelques années un des plus riches hommes dans la bannière de comte Lou. Il était capable de tout faire, sauf ronger des pierres. A dix-neuf ans il s'était marié avec la fille du prince Louvsan de la bannière du seigneur Dalaï tchoïnkhor et pour la dot il reçut un grand troupeau d'où venait sa richesse. En ayant peu de bétail chez lui, Itguelt faisait garder le gros de ses troupeaux par les pauvres de quelques bannières.

Ils sont quatre dans la famille. Sa femme s'appelle Doljin. Le fils, Khongor, a dix ans et la fille, Solongo a sept ans.

Dès le point du jour jusqu'au crépuscule du soir Itguelt travaillait sans relâche. Il demandait aux autres d'en faire de même. C'est pourquoi sa femme, Doljin, se levait d'habitude avant les autres. Elle trayait les vaches, les menait sur le pâturage. Si quelqu'un se levait plus tôt d'elle, elle restait silencieuse et mécontente toute la journée.

Les domestiques qui connaissaient cela ne se levaient qu'après avoir entendu le bruit du mortier concasser le thé dans la grande yourte.

Itguelt se tint immobile un instant puis s'étirait à plusieurs reprises.

-Doljin! Réveille le fils, qu'il aille chercher les vaches. Aujourd'hui, il devrait faire beau, dit-il d'une voix grêle. Et en courant il est venu à la yourte du nord et a ouvert la couverture carrée en feutre du toit.

-Dulma! Tu ferais mieux de te lever! Ensuite il s'est dirigé vers la yourte à gauche. Mais une femme âgée, sortie de la yourte, tirait la couverture du toit.

Le gardien de chevaux Galsan vivait dans la petite yourte du nord avec sa femme Dulma. Dans la yourte à gauche le berger Nyam vivait avec sa femme Hishigt et Suren, leur fille de six ans.

Itguelt est de petite taille. Il est maigre, mais tout à fait musclé. Il paraît que son corps est destiné à courir et à sauter. C'est pourquoi les gens du pays l'ont surnommé 'Itguelt-la sauterelle'. Il s'est dirigé vers sa yourte. Son fils est sorti à sa rencontre, en se frottant les yeux.

'Le paresseux est toujours incliné à dormir, le badaud dépense toujours trop de la salive', dit le proverbe. Encore ensommeillé, malheureux! Rassemble rapidement les vaches et conduis-les ici, ordonna Itguelt. Sur le versant sud de la colline nord en broutant l'herbe paissait un troupeau de yaks et de *khainaks*⁶, pour la plupart.

Khongor saisit sa gaule de saule et, l'enjambant comme pour un cheval, se précipita vers le troupeau. Mais son père lui interdit: 'Ne monte pas sur la gaule comme un cheval, malheureux!', dit-il avec reproche.

Itguelt regarda pendant un moment les deux chevaux qui paissaient sur le versant nord de l'autre côté du Tamir, puis il vint directement à l'enclos de moutons et ouvrit la porte.

A ce moment-là Nyam s'approcha de lui et dit :

- Avez-vous passé une bonne nuit ?

Mais qui de nous deux est le riche Itguelt, qui est le berger Nyam ? Les gens se le demandent toujours et n'arrivent pas à le deviner.

- Qu'ils restent à deviner, dit Itguelt en souriant malicieusement. Et, montrant les deux chevaux, il ajouta: ce sont les chevaux que le gardien de chevaux du prince Purev demandait.

- Il faudrait les prendre, et aller rassembler les brebis jusqu'à ce que les maîtres les emmènent, dit Nyam.

- Quand le troupeau de chevaux viendra, montez à cheval et amenez-les.... Allons boire du koumis dit Itguelt en se dirigeant vers sa yourte. Nyam le suivit.

Khongor voulait passer le ravin en courant, mais s'arrêta brusquement. D'en bas quelqu'un l'a appelé. Il prêta attention.

- Hé! Garçon ! Viens ici, appelait quelqu'un de la profondeur du ravin.

- Khongor fit quelques pas hésitants, il lui semblait qu'il y avait une personne au fond du ravin.

- Oh ! oui, n'aie pas peur ! Je suis complètement impuissant, dit la même voix basse.

Descendant encore plus bas Khongor vit quelqu'un couché. Avec étonnement il baissa la tête et demanda :

- Vous ... vous êtes un être humain ?

- Oui, bien sûr, je suis un homme. Ne crains rien! Viens ici.

Sur le sol il y avait vraiment un homme, mais apparemment sans bras. Son visage était couvert de boue, et seulement ses yeux brillaient vivement.

- Un homme ne devrait pas avoir peur d'un homme, dit-il en souriant.

- Mais je n'ai pas peur, répondit Khongor.

Il s'approcha lentement près de lui, mais prêt à s'enfuir s'il arrivait quelque chose.

⁶ *Vache croisée avec un yack.*

Le corps de la personne était enveloppé dans une peau de bœuf séchée, seulement la tête sortait du sac et ses yeux brillaient. Il regardait le ciel bleu sans cligner de l'œil.

- Monsieur, vous pouvez vous lever ?

- Moi, je ne peux pas me lever.

- Pourquoi vous ne pouvez pas vous lever?

Cet homme restait bouche cousue quelques instants et l'observa du coin de l'œil.

- Je suis enveloppé dans une peau de boeuf crue. Écoute, mon garçon, je me suis enfui de la prison. Si quelqu'un le sait, on va me tuer. Cependant 'un homme aidera toujours un homme'. J'espère que tu m'aideras aussi.

Ces mots 'un homme aidera toujours un homme' se sont gravés immédiatement dans le cœur de Khongor. Il sourit fièrement et s'éclaircit la gorge avec dignité.

- Comment puis-je vous aider? demanda-t-il, essayant de parler à voix basse.

- Si tu peux, apporte-moi un couteau tranchant, des vêtements, une bride et quelque chose à manger. Seulement ne dis rien à personne, dit l'homme et souriant, cligna de grands yeux noirs au garçon.

-Vous êtes un homme, et moi, je suis aussi un homme. Je ne dirai rien, même si on me bat, dit Khongor, - mais d'abord je rassemble les vaches et les conduis à la maison. Vous m'attendez, je viendrai certainement.

La personne enveloppée dans la peau s'appelait Tumur. L'automne dernier, il avait volé un grand nombre de chevaux du troupeau même de ce comte Lou, mais passant par la Tamir en crue sa monture s'est noyée. Quant à lui, il s'en est sorti à peine. Plutôt mort de fatigue que vif, il a été rattrapé et arrêté. Pendant plusieurs jours on l'avait interrogé, en le torturant. Il n'a jamais avoué son nom. Cependant quelqu'un l'avait reconnu.

- 'Non, en vous trompant, vous faites un péché' avait simplement déclaré Tumur.

Le brigand justicier des montagnes ne peut pas donner le nom de sa bannière et de sa contrée natale, sinon le malheur s'écroulera sur ses compatriotes. C'est pourquoi il ne dit rien.

Bien que pendant les interrogatoires Tumur se soit tu, il avait quand même été pris en flagrant délit. Il a été enveloppé dans une peau humide bovine et mis dans une fosse. Dans ces vêtements terribles, il resta dans la fosse près d'un an, et il réussit à s'échapper il y deux jours. Deux jours et deux nuits il roula par la steppe et la nuit passée il se trouva dans ce ravin. Il s'était recroquevillé tout à fait, mais encore la famine se faisait sentir, depuis deux jours qu'il n'avait rien mangé. C'est pourquoi Tumur s'était risqué à appeler le garçon.

Quand le garçon, conduisant les vaches, s'approcha de la yourte, il rencontra Galsan, revenant de garder la nuit le troupeau de chevaux, et qui rentrait lentement en traînant son lasso.

- Khongor, as-tu bien dormi cette nuit ?

Sans réponse, Khongor passa à côté de lui. Il n'a aucune envie, et pas le temps de parler avec Galsan, parce qu'il était pris par une seule pensée: comment imperceptiblement aider la personne se trouvant dans le ravin.

- Pourquoi tu te tais? Ou tu as reçu un bon savon d'un parent? demanda Galsan en riant.

Quand Galsan entra chez lui, sa femme tenait un seau dans l'intention de traire les vaches.

- Dulma, tu es complètement paresseuse!

- Pourquoi ?

- Chaque matin la couverture de toit de notre yourte est ouverte par le maître. En faisant la grasse matinée, tu te laisses servir par lui. Regarde, comme tu laisses échapper ton bon destin! Tu ne pourras garder ses bienfaits.

- Je n'ai pas de bon destin à venir dit-elle avec un sourire amer, elle est sortie en claquant la porte.

- Femme stupide ! lui cria Galsan en jetant fâcheusement sur le lit l'imperméable en grosse toile.

Pendant la traite des vaches, et la prise des poulains, Khongor, en saisissant le bon moment, prit le couteau tranchant paternel, l'imperméable en drap de laine fin, la bride, du beurre blanc et il les cacha dans un endroit, un peu loin de sa yourte.

Puis, conduisant les juments stériles dans le pâturage, il rencontra Dulma qui poursuivait le troupeau de moutons.

- Qu'est-ce qu'il y a dans ton sac? demanda Dulma.

En se mordant la lèvre inférieure, Khongor fit signe de silence par son fouet. Et s'approchant d'elle, il dit :

- Un homme aide toujours un homme.

- Quoi? Tu dis qu'un homme aide toujours un homme! Dulma l'observa en éclatant de rire et demanda :

- Tu veux jouer dans la steppe ?

- Tante, pas un mot aux autres.

- D'accord, je ne dirai rien.

Khongor conduisit les juments au pâturage et se précipita vers le ravin. Cependant, il ne trouva pas Tumur à l'endroit prévu.

- Monsieur, où êtes-vous? appelle-t-il doucement.

- D'un côté du ravin, une voix: 'Je suis ici. Viens !'

Après plusieurs essais, Khongor réussit à séparer le cuir séché par un couteau tranchant. C'était écœurant de voir les poux qui étaient sur son habit.

- Pourquoi tant de poux? demanda Khongor.

Tumur essaya en vain de se lever, n'arriva point et il se rallongea en chuchotant 'Mon Taïchir'. Puis il ferma les yeux et bougea lentement ses quatre membres.

J'ai le vertige, murmure-t-il.

Bien qu'il fut enveloppé dans du cuir si dur, cet homme est venu de loin. Khongor le voyait avec admiration et se souvenait des récits entendus plusieurs fois dans sa courte vie à propos d'un brigand justicier des montagnes.

-Vous êtes le brigand justicier des montagnes?

L'homme ouvre lentement les yeux et sourit en le fixant longuement.

‘As-tu entendu parler de Tumur-Le-Silex de Zassagte khan? L’an dernier une rumeur a couru que le célèbre Tumur-Le-Silex de Zassagte khan a été arrêté et qu’il était en train d’être interrogé à la chancellerie de la bannière.’

- Je l’ai entendue. Donc vous êtes Tumur-Le-fer?

- Oui, Je le suis.

Khongor, heureux d’aider un homme si célèbre parmi le peuple et de parler avec lui. Il rit naïvement en ouvrant de grands yeux.

- Et quel est ton nom, fiston? demanda Tumur.

- Khongor, fils du riche Itguelt de la bannière du comte Lou, répond-il joyeusement d’une voix grêle.

Bientôt, en se levant Tumur enleva ses vêtements et en enterra certains, mis les autres en les secouant. Puis il mit l’impermeable en tissu de laine fine apporté par Khongor et se ceintura. Chaque mouvement de cet homme magnifique semblait incroyable, surtout lorsqu’il avala en quelques prises le beurre blanc, s’essuya la bouche fortement par sa manche et jeta les poches vides très loin. C’était vraiment fascinant. Nul ne pourrait le faire pensa Khongor.

-Eh bien, je te souhaite une longue vie heureuse. Moi, je peux rendre un bienfait pour mon bienfaiteur. ‘L’échine du chemin est longue et le cou de l’éléphant est court’, dit-on. Nous allons nous revoir. Maintenant, rentre chez toi, dit Tumur.

Reprenant le couteau, Khongor monta à cheval et se dirigea lentement vers son campement. Il se répéta : ‘un homme aide un homme’, et se retournait souvent. Quand il arriva chez lui, il y avait deux chevaux inconnus au poteau.

‘Qui est venu chez nous?’ pensa le garçon et il entra dans la yourte. Deux hommes, également vêtus de vieux gilets en tissu de soie jaune, étaient assis, buvaient du koumis et parlaient avec son père.

-Monsieur, si vous aviez vu quand il a été torturé! Même lorsque le sang de ses fesses jaillissait sur leur face, il ne faisait aucun bruit, excepté des grincements de dents. Tumur-le-Fer, un vrai homme. Je vais l’attraper et le débiterai en morceaux, le gratterai jusqu’à l’os, dit un homme à la poitrine large avec un visage boutonneux et il rit bruyamment, au point que la yourte en tremblait, paraît-il.

Cet homme s’appelle Badarči. Dès l’âge de dix-sept ans il était huissier à la chancellerie de la bannière du comte Lou. Maintenant il a trente ans. Il est cruel envers les criminels. En plus, il est très fort. C’est un lutteur ayant le titre ‘éléphant’ de sept bannières. Devenu huissier il accumulait des biens en prenant des pots de vin. Les derniers temps, il blessait de plus en plus les autres en les insultant de ‘mauvais gueux’.

L’année dernière, après avoir attrapé Tumur qui surnageait dans l’eau, il l’emmena en prison. Badarči lui-même le frappa avec une planche et l’enveloppa dans une peau bovine crue. Depuis qu’il était huissier, il pratiquait ce supplice à plusieurs reprises, mais pas un seul détenu n’avait encore réussi à lui échapper. Pourtant Tumur-Le-Silex s’est échappé. C’était vraiment agaçant pour lui.

L’année dernière, en frappant Tumur avec la planche, Badarch admirait son courage et son endurance. Il arrive parfois qu’en attrapant un loup, un homme prenne plaisir à voir

sa résistance en le martyrisant. Badarči avait le même sentiment quand il tortura Tumur. Avant Tumur, pas un seul homme ne pouvait supporter ses vingt coups de planche. Il l'a frappé quarante fois, mais Tumur n'a même pas gémi. Il entraîna lui-même Tumur meurtri dans la cellule et pensa avec admiration: 'Oui, c'est un vrai homme, mais demain il parlera'. Le lendemain, après vingt coups de planche, Badarči le voyait dire vingt, en remuant les jambes pour s'étendre. Bien que Badarči, fâché, le frappa jusqu'à la coupure d'une planche, Tumur restait comme avant, avec des yeux vitreux et ne grinça que des dents.

- Es-tu humain ou de pierre? demanda Badarči, épuisé.

- 'Humain, avec deux jambes et une tête', répondit Tumur ironiquement.

Et quand Badarči l'enveloppa dans une peau, Tumur, en clignotant des yeux, a fermement dit:

- 'Je vais fuir quand même.'

- Ah, malheureux, essaie, si tu as assez de génie. Le premier jour du nouvel an lunaire, Badarči alla le voir dans la prison avec un gigot gras de mouton cuit et lui en donna en coupant des tranches épaisses. Tumur les mangea en mâchant fortement et lui demanda de couper les cheveux et la barbe.

- Fais les couper quand tu t'échapperas dit-il méchamment.

Et pourtant Tumur s'échappa. Cela le déshonora complètement. Il faut saisir le fugitif et ainsi restaurer sa réputation. Aussi, la gloire d'attraper deux fois le célèbre brigand des montagnes me reviendrait' pensa Badarči.

Le petit bonhomme, assis à côté de Badarči, s'appelle Damdin. Depuis l'année dernière, il devint également l'huissier. Mais il n'a aucun désir d'attraper Tumur. Il a peur de lui. C'est pourquoi il tressaillit à chaque bruissement suspect : le déplacement d'un spermophile, un chant de traquet ...

- Fils, tu n'as pas rencontré quelqu'un quand tu conduisais les juments? demanda Itguelt à son fils qui était debout devant l'outre à koumis.

- 'Non, personne', répondit Khongor.

Le cœur du garçon battait fortement, il pouvait à peine respirer, mais il se répétait: 'Un homme aide un homme'.

Il voulait déjà partir, mais, se retournant, il trébucha sur un seau et se cogna à Badarči.

- Quel coquin! Si tu fais encore des espiègleries, je te fais châtrer dit cet homme d'une voix basse et sonore, en fronçant sévèrement le sourcil.

Khongor s'éloigna de lui et le regarda avec effroi, comme un chat persécuté par un chien.

'Il sait probablement que j'ai vu Tumur, mais je ne dirais toujours rien, quitte à me faire châtrer. Je ne crierai pas comme un chevreau, resterai muet comme un agneau et je m'en irai. 'Un homme aide un homme' pensa Khongor et cria avec arrogance:

- 'Essaie, je ne gémirai jamais : aïe.' Les larmes sont venues à ses yeux.

- Voyez, fils unique d'un homme riche, il est courageux dit Badarči en riant avec les yeux étroits.

- 'Fils, tu ne peux pas parler aux aînés comme ça', reprocha Itguelt, mais il pensa fièrement que son fils serait un vrai homme.

- Donc, même enveloppé dans une peau, il s'est enfui? Vraiment un gars courageux!- dit Itguelt en secouant lentement la tête.

- Mais, avant cela il n'a jamais été attrapé' dit Badarči. Il y avait dans la voix une sorte de vantardise : 'C'est seulement moi qui l'ai attrapé'.

L'année dernière Itguelt rencontra Tumur dans la prison de sa bannière. Plus d'une fois il avait entendu que tout le monde peut se rendre en prison. Et Itguelt décidait d'y passer avant son tour, en soudoyant le surveillant. Il passa toute la journée en prison, donnant gratuitement de la nourriture aux prisonniers. Là, il a vu Tumur enveloppé dans une peau, échangea même quelques mots en lui donnant de la nourriture.

Khongor se tenait là et écoutait ce que les adultes avaient dit à propos de Tumur. Il était très fier du fait que Tumur l'appelait un homme.

Nyam est entré dans la yourte en suçant du fromage frais séché.

- Bonjour. Passez-vous bien l'été?

- Bien, et vous? C'est un bon été. Une belle pluie abondante. Où allez-vous, cher Badarči?

- Tumur s'est échappé. Nous le recherchons. Nyam-guai, ne fais-tu pas de divinations? dit Badarči.

- Oh, Notre Nyam est un astrologue sachant même où est la viande frite, dit Itguelt ironiquement.

- Je deviens vieux, je vieillis, c'est probablement pourquoi j'ai souvent fait des erreurs, a déclaré Nyam, et il sortit de sa poitrine neuf pièces soigneusement enfilées.

Il commença à souffler sur elles, puis, fermant les yeux, chuchota quelque chose. Puis il souffla à nouveau, ses lèvres battant ridiculement.

- C'est incroyable! Les pièces montrent qu'il tombera entre vos mains. Il ne pourra pas vous échapper, et cela arrivera avant le coucher du soleil, a dit Nyam, et enfilant les pièces de monnaie, il les remit cachées dans sa poitrine.

Badarči avala un grand bol de koumis et partit avec Damdin. Khongor était convaincu que même si ces deux-là apercevaient Tumur, ils ne pourront pas l'attraper. Tumur est si fort! Mais il regardait encore anxieusement vers le ravin.

Itguelt rassembla ses gardiens de chevaux et les informa de l'évasion de Tumur. 'La nuit, allez garder les chevaux tous les deux. Il ne vaut pas plus que quelques chevaux, mais, c'est risqué de le rencontrer seul' dit-il.

En quittant la yourte, Galsan a dit:

'Itguelt, comme notre propre père, s'inquiète pour nous'.

Itguelt a toujours une arrière-pensée. 'Penser à l'or, c'est aussi penser à son coffre' dit Nyam calmement.

Мо Янь

ЭРЭГЧИН¹

Англи хэлнээс орчуулсан Д.Золбоо²

Нядлагааны малын уушгины артери руу даралттай ус шахах шинжлэх ухааны аргыг Лао Лан нээсэн юм. Хуучин арга ашиглан нядалгаанд орсон үхрийн шинэ мах руу хагас хувин ус арай чамай шахдаг байсан бол энэ аргаар хоёр зуун жин³ гахайнд нэг хувин ус юүлчихдэг болжээ. Манай тосгоноос мах худалдан авч байна гэж боддог байсан хотын ухаалаг хүмүүс энэ олон жил өөрсдөө ч мэдэлгүй усанд хэдий хэрийн мөнгө зарцуулсныг хэн ч хэлж чадахгүй ч сэртхийлгэм өндөр үнэ байх болно гэдэгт би итгэлтэй байна.

Лао Лан бэлхгэр бие, ягаан хацар, хонх хангинах лугаа жингэнэсэн хоолойтой хүн байлаа. Товчхондоо гэхэд тэрбээр баян, эрх мэдэлтэй нэгэн болох гэж л төрсөн хүн аж. Тосгоны тэргүүний албан тушаалд очсоныхоо дараа тэр тосгоны нөхөддөө ус шахах аргаа зааж өгсөн, мөн нутгийн луйвраар хөлжигчдийн хөдөлгөөний удирдагч болсон юм. Тосгоны зарим иргэн түүнийг бухимдан эсэргүүцдэг байхад зарим нь тосгоны ажилчин ангийн тогтоол журмыг уландаа гишгэх гэсэн газрын эздийн ангийн гишүүн хэмээн дуудаж, ханан дээрх зурагт хуудас руу нь давшилдаг байлаа. Гэвч эсэргүүцлийн ийм хэлбэр аль хэдийн үеэ өнгөрөөжээ. Лао Лан тосгоны иргэдэд хаягласан үгэндээ, “Луу лууг өсгөдөг, галт шувуу галт шувууг өсгөдөг бол харин огтоно нүх ухахын төлөө төрдөг” хэмээсэн юм. Үүнээс хэдэн өдрийн дараа бид түүнийг шавь нартаа мэдлэгээ бүхэлд нь өвлүүлдэггүй, амьдралын баталгаа болгон хангалттайг өөртөө хураадаг кун-фу мастер адил болохыг ойлгосон юм. Лао Ланы зардаг мах бусдынхтай л адил ус шахсан байдаг ч илүү сайхан үнэртэй, шинэ харагддаг байв. Наранд хоёр өдөр байлгахад бусад худалдаачдын махан дээр өт, авгалдай арвалзаж байдаг бол Лао Ланых янзаараа л. Шинэ мэт харагддаг түүнийх шиг мах өдөртөө зарагдахгүй байлаа ч ямар ч аюулгүй, үнээ буулгах талаар Лао Лан санаа зовох хэрэггүй байв.

Миний аав Луо Тун, Лао Лан мах руугаа ус биш формальдегид шахдаг гэж надад ярьсан юм. Аав минь Лао Лангаас хувь илүү ухаантай хүн байлаа. Тэр физикийн шинжлэх ухаан хэзээ ч судалж байгаагүй ч эерэг, сөрөг цэнэг, биологийн шинжлэх ухаан хэзээ ч судалж байгаагүй ч эр бэлгийн эс, эм өндгөн эсийн мэргэжилтэн, мөн тэр химийн шинжлэх ухааныг хэзээ ч судалж байгаагүй ч формальдегийг бактери устгаж, махыг муутгахаас сэргийлж, уургийг тэнцвэржүүлдэг гэдгийг мэддэг байсан тул Лао Ланыг махандаа формальдеги шахдаг хэмээн тааж байсан хэрэг. Аавын минь хийх ажлын жагсаалтанд чинээлэг

¹ <https://www.newyorker.com/magazine/2012/11/26/bull-2>

² МУИС-ын Урлаг Судлалын 4-р ангийн оюутан

³ Нэг жин 0.5 килограмтай тэнцүү

болох гэсэн зорилт байсан бол тосгоны хамгийн баян хүн болоход түүнд ямар ч асуудал байхгүй байсан гэдэгт би хамгийн ихээр итгэдэг. Тэр бол хүмүүсийн дундах луу, бас бар байсан юм. Луунд хөрөнгө хуримтлуулах сонирхол байдаггүй. Хэрэм, оготно шиг амьтад хоолоо хадгалах гэж нүх ухдагийг чи харсан ч араатны хаан барыг тиймэрхүү зүйл хийж байхыг хараагүй л биз дээ? Бар ан хийхээс бусад цагийг унтаж, хэвтэж өнгөрөөдөг. Үүнтэй адил аавын минь өл л түүнийг мөнгө олж ирэхийг шахахгүй бол амьдралынхаа ихэнх цагийг тэр гэртээ, идэж, ууж, зугаацаж өнгөрөөдөг байлаа. Цагаан хутга дүрээд улаан болгон гаргаж ирдэг, цуст мөнгө цуглуулдаг Лао Лан болон түүний төрлийн хүмүүстэй адил зүйлийг тэр хумсын төдийхнийг ч хийж байгаагүй. Мөн галт тэрэгний зогсоол руу очиж хамаг хүчээ дайчлан үйлчлэгч хийн хөлс авах ч сонирхол түүнд байсангүй. Аав амьдрах мөнгөө нударгаараа олж байв.

Эрт цагт үхрийн мах шулахдаа гарамгай Пао Дин хэмээх алдартай тогооч байжээ. Орчин үед үхрийн махыг хэмжихдээ гарамгай нэгэн байсан нь миний аав юм. Пао Динийн нүдэнд үхэр бол яс, тэгээд идэж болох махнаас өөр юу ч биш харагддаг байжээ. Эцгийн минь нүдэнд мөн л тэгж харагддаг байв. Пао Динийн хараа нь хутга шиг хурц байсан бол эцгийн минь хараа хутга шиг хурц, жинлүүр шиг нарийн байв. Хэрэв чи үхэр туугаад аав дээр минь ирвэл тэр хоёр, ядахдаа л гурван удаа тойрч хараад, хааяа зүгээр л зугаацуулахын тулд малыг урд хөлнөөс нь өргөж үзээд юу ч болоогүй аятай биеийн нийт жин болон зөвхөн идэж болох махны хэмжээг английн хамгийн том мал нядалгааны үйлдвэрт хэрэглэдэг дижитал жин дээр тавьж үзээд хэлж байгаа мэт килограммаар мэдээлэх болно гэж би хэлмээр байна. Эхлээд хүмүүс түүнийг зүгээр л сайрхагч гэж боддог байсан бол хожим, хэд хэдэн удаа шалгаж үзээд түүнд итгэх болсон билээ. Үхэрчин, мах нядлагч хоёрын наймаанд тэр оролцоход сохор азыг үгүй хийж, тэнцүүлж, шударга байдлыг тогтоодог байв. Түүний эрх мэдэл нэгэнт тогтвол үхэрчин, мах нядлагчийн аль аль нь илүү авахын төлөө түүнийг зулгуйдана. Алсын хараатай хүний хувьд тэр их ашгийн төлөө өөрийн нэр сүрээ эрсдэлд оруулах хүн биш. Тийм зүйл болвол тэр будааны аягаа хагалснаас өөрцгүй. Үхэрчид дарс, тамхи зэрэг бэлэг сэлттэй гэрт ирвэл аав минь тэднийг нь гудамж руу чулуудаад цэцэрлэгийн шавар хашаан дээр авирч гараад чангаар хараадаг байв. Мах нядлагчид гахайн толгой, бэлэг сэлттэй гэрт ирвэл аав минь түүнийг нь гудамжинд хөсөр хаяж орхиод цэцэрлэгийн шавар хашаан дээр авирч гараад чангаар хараадаг байлаа. Луо Тун зүүлэг ч гэлээ тэдний таньдаг хамгийн шударга эр хэмээн үхэрчин, мах нядлагч нар ярьдаг байв.

Хүмүүс түүнд эргэлзээгүй итгэсэн. Наймаа мухардвал хоёр тал асуудлаа нэг тийш болгохыг хүсэж, эцсийн шийд гаргуулахаар түүн рүү хардаг байлаа. “Хангалттай л маргалдлаа, Луо Тун юу гэж хэлэхийг сонсоцгооё!”, “Тийм ээ, тэгье. Луо Тун чи шүүнэ шүү!” Бардам аав минь малын эргэн тойрноор хоёронтоо алхаад, худалдагч, худалдан авагч руу харалгүй, тэнгэр өөд хялайснаа нийт жин, цул махны жинг үнийн хамт мэдэгдэж, дараа нь тамхилахаар холдоно. Худалдагч, худалдан авагч хоёр бие биедээ ойртон гар барьцгаана. “Сайн! Ингэж тохирлоо!” Наймаа дууссаны дараа тэд аав дээр ирээд арав, арван юаний дэвсгэрт өгөөд хийсэн ажилд

нь талархана. Аавыг үнэ хаялцуулсан үхрийн худалдаанд очихоос өмнө хаанаас ч юм бэ мэргэшсэн, өргөн, давхар оёдолтой ханцуйндаа хурууны тэмдгээ нууж үнэ булаалцдаг урлагт туршлагатай, нуруу руугаа сүлжсэн гэзэг унжуулсан, өнгөрсөн үеийн зуучлагч, хар, эцэнхий, муухай хөгшин хүмүүс тохиролцоог явуулдаг байсныг энд тодорхой болгох нь зүйтэй. Аав гүйлгэнэсэн харцтай зуучлагчдыг түүхийн тавцангаас амжилттай зайлуулсан юм. Амьд үхрийн наймаанд гарсан энэ гайхамшигтай амжилтыг бага зэрэг хачирлавал хувьсгалч шинэчлэл гэж нэрлэж болно. Аавын минь гярхай нүд зөвхөн үхрээр хязгаарлагдсангүй гахай, хонийг ч тэр “жинлэж” байв. Ширээ, бас сандал хийж чаддаг мастер мужаан илүү авьяаслаг бол авс урлаж чаддаг шиг аав минь тэмээг төвөггүй жинлэдэг байв.

Зуны нэгэн өглөө аав минь намайг мөрөн дээрээ суулгаад үтрэмийн талбайгаар явж байв. Бид өвөөгөөс өвлөгдөн ирсэн гурван өрөөтэй оромжиндоо амьдарсаар байлаа. Манай оромж нооронхой, муухай харагдана. Улаан вааран дээвэртэй шинэхэн байрнууд баригдсан учир оромж минь тэдний дунд далдлагдаж яг л торго дурдан өмссөн газрын эзэн, баян худалдаачдын сарвууны өмнө өвдөг сөгдөн гуйлга гуйх мэт. Манай оромжийг тойрсон хашаа насанд хүрсэн хүний бүсэлхийд арай ядан дөхөн очих бөгөөд дээр нь зэрлэг ургамал ургасан байлаа. Цаг сайхан бол зуухан дээр тогоо дүүрэн мах, муу үед хоосон байдаг эсрэг тэсрэгийн туйлын амьдрал өгсөн залхуу, ховдог эцэгтээ талархъя. Ээжийн минь галзуу хараалын бай болохоороо тэр, “Удахгүй, тун удахгүй, газрын шинэчлэлийн хоёр дахь аян эхэлнэ, тэр үед чи надад талархах болно. Лао Ланд хором ч атаархах хэрэггүй. Тэр газрын эзэн эцэг шигээ л дуусна. Ядуу тариачдын танхай бүлэг түүнийг түшиц газраас нь чирж гаргана” гэж хэлээд ээжийн толгойд төсөөллийн гар буу чиглүүлээд гохыг нь дардаг: Пүн! Ээж хоёр гараараа толгойгоо барин айдандаа зэвхий царйлдаг байлаа. Газрын шинэчлэлийн хоёр дахь аян болсонгүй, хөөрхий эх минь аргагүйн эрхэнд хүмүүсийн хаясан муудсан амтат төмсийг авчирж гахайнуудаа хооллох хэрэгтэй болсон юм. Манай хоёр тоорой хэзээ ч цадатлаа идэж байсангүй. Өлссөндөө цаг үргэлж орилдог сон. Ядаргаатай байлаа.

Өглөө нь аав уурсан зэмлэж, “Ямар чөтгөрөө орилоод байгаа юм бэ? Орилоод бай, тогоонд хийгээд оройн хоол болгохоо нэг мэдье ээ!” гэв.

Гэтэл гартаа заазууран хутгатай ээж аав руу муухай харснаа, “Бодсоны ч хэрэггүй. Тэд чинь минийх. Би тэжээсэн, ганц ширхэг үсийг нь тасдах эрх хэнд ч байхгүй. Үхсэн ч, сэхсэн ч”

“Тайвшир. Яс арьс болсон амьтдыг чинь би яах ч үгүй” хэмээн аав хөгжилтэй инээж хэлэв.

Би торойнуудыг удаан ажиглав. Тэд хангалттай таргагүй гэдэг нь үнэн ч махлаг дөрвөн чих нь сайхан амттай амны зугаа болохоор харагдаж байлаа. Гахайн толгойн хамгийн амттай хэсэг нь миний хувьд өөхгүй, тос багатай, шаржигнасан дуутай өчүүхэн жижиг ястай чих юм. Чихийг өргөст хэмхтэй, өргөстэй хэсгийг нь

цэцэгтэй, эсвэл нухсан сармис, гүнждийн тостой идвэл үнэхээр амттай. “Бид чихийг нь идэж болно шүү дээ!” гээд би хэлчихлээ.

“Эхлээд чиний чихийг огтлоод иднэ дээ, бяцхан зулбасга минь” гэж ээж хэлээд чихнээс минь атгаж, хүчтэй чимхэхэд аав намайг түүнээс салган авах гэж хүзүүнээс минь татав. Харин би чихгүй болчих вий гэсэндээ байдаг чадлаараа орилж байлаа. Эцэст нь аав хүчээр давамгайлан намайг мулт татаж дөнгөв.

Уур хилэн ээжийн царайг цонхийлгож, уруулыг нь хүрэлтүүлэв. Тэр толгойноосоо хөлийн хуруу хүртлээ чичрэн зуухны хажууд зогсож байлаа. Аавын нөмөрт зориг орсон би, “Ян Юйжэнь, муу өмхий хөгшин авгай, амьдралыг минь там болгож байна!” хэмээн түүний бүтэн нэрийг хэлэн хараав.

Аав инээд алдан намайг авч гэрээс гарахад гэнэтийн тэсрэлтэнд минь гайхширсан ээж над руу зүгээр л ширтэж байлаа. Бид цэцэрлэг рүү гарч ирээд ээжийн хангинасан чарлааныг сонсов. “Үхлээ, галзуурах нь, муу бяцхан зулбасга....”

Аав толгой руу минь тоншоод, “Бяцхан чөтгөр, эхийнхээ нэрийг чи яаж мэдсэн юм бэ?”

Би түүний бор, дүнсгэр царай өөд хараад, “Хэлж байхыг чинь сонссон юм!” гэв.

“Түүнийг Ян Юйжэнь гэдэг гэж би чамд хэзээ хэлсэн юм бэ?”

“Та авга эгч Зэрлэг Лууст хэлж байсан. Та, ‘Ян Юйжэнь, өмхий хөгшин авгай, амьдралыг минь там болгож байна’ гэсэн.

Аав амыг минь гараараа таглаад амьсгаагаа даран байж, “Амаа хамхи, хараал идсэн хог. Өдийг хүртэл гайгүй сайн эцэг байлаа. Хамаг юм битгий сүйдэлчих”

Эх гартаа заазуур барьсаар байшингаас гараад ирэв. “Луо Тун, Луо Шятун, муусайн зулбасганууд, заваан шаарнууд, өнөөдөр та хоёртой хамт үхсэн ч надад хамаа алга. Өнөөдөр энэ гэр бүлийн төгсгөлийг үзье!” гэж орилох нь тэр.

Түүний аймаар царайнаас түүнийг тоглоогүй гэдгийг би ойлгож байв. Аав минь амьдралаа үрэн таран хийсэн ч тэр тэнэг байгаагүй. Ухаантай хүн аюулаас зайлсхийдэг. Тэр намайг өргөн сугандаа хавчуулаад эргэн харж хашаа руу гүйн нэг мэдэхэд л нөгөө талд гарсан байв. Бид бүх асуудлаа солиорсон ээжтэй хамт ардаа үлдээв. Түүнийг бидэн шиг хашаа даваад ирэх чадвартайд нь эргэлзээгүй учир бид нуугдав. Гэвч ээж хашаа давахгүй байхаар шийджээ. Тэр биднийг хашаанаас гаргасныхаа дараа хөөхөө болив. Хашааны захад хэд хэдэн удаа үсэрснээ муудсан амтат төмснүүдээ хэрчиж дуусахаар буцаж алхахдаа орчноо муу үгээр дүүргэн чангаар харааж байлаа. Энэ бол уур хилэнгээ гаргах хамгийн шилдэг арга: цусгүй, будлиангүй, хууль зөрчихгүй мөртлөө тэдгээр муудсан төмснүүд түүний балмад дайснуудын толгойг орлоно гэдгийг би мэдэж байлаа.

Түүний толгой дахь жинхэнэ балмад дайсан нь аав ч биш, би ч биш, харин Зэрлэг Луус байсныг би сүүлд ойлгосон юм. Тэр завхай эм аавын толгойг эргүүлсэн гэдэгт ээж итгэжээ. Харин би үүнийг нөхцөл байдлын бодит үнэлгээ мөн, бишийг хэлж чадахгүй нь. Аав, Зэрлэг Луус нарын харилцааны тухайд хэн нь хэнийхээ толгойг эргүүлж, анхны сээтэнг хэн хаясныг мэдэх хүн нь тэд л байв.

Биднийг үтрэмийн талбайд очиход долоо, найман үхрийн худалдаачин талбайн эрмэг дээр цомцойн суугаад тамхи татан нядлагчдыг ирэхийг хүлээж байв. (Тосгон минь томоохон мал нядалгааны үйлдвэр болон хувирсны дараа, тариан талбай атаршиж, бүх зорилго, зориулалт нь үгүй болж үтрэмийн талбай үхэр худалдаалах газар болсон юм) Үхэрнүүд хөдөлгөөнгүй зогсон, хайнгадуухан сэвсээгээ зажилна, үхэл нь ойртож буй нь тодорхой. Баруун зүгийн хошуунаас ирсэн ихэнх худалдаачид яг л радио жүжгийн жүжигчид шиг инээдэмтэй аялгаар ярьж байв. Хүн бүр хоёр, заримдаа гурван үхэр хөтөлсөөр наанатай, цаанатай арван өдөрт нэг удаа ирдэг байв. Тэд ихэвчлэн ачаа, зорчигч холилдсон удаан галт тэргээр, хүн, амьтан нэг машинд явж нар жаргахын үес манай тосгоны ойролцоох буудалд ирдэг байв. Өнөөх буудал манай тосгоноос дөнгөж арван *ли*⁴ зайтай ч гэлээ шөнө дундаас өмнө ирж амждаггүй байлаа. Ганцхан цаг зарцуулах ёстой энэ зугаалга худалдаачид болон тэдний үхэрнүүдийн хувьд өлхөн найман цаг авдаг. Тэд яагаад шөнө дунд манай тосгонд ирэхийг илүүд үздэг юм бол оо? Энэ бол тэдний нууц байв. Би бага байхдаа яг энэ асуултыг эцэг эх болон тосгоны буурал сахалтай хэдэн хүнээс асуусан юм. Гэтэл тэд намайг хэний ч хариулж мэдэхгүй асуулт, эсвэл амьдралын утга учрын тухай асуусан аятай ямар ч хувиралгүй, хүйтэн царайгаар харсан билээ.

Үхэрний айлчлал нохдыг хоороороо хуцалдахад хүргэж, эр эм, хөгшин залуу гээд бүх хүмүүсийг сэрээж, бидэнд үхрийн худалдаачдыг ирснийг мэдэгддэг дохио болдог байв. Багад тэд нууцлагаар дүүрэн санагддаг байлаа. Учир нь тэд тосгон руу шөнийн цагаар орж ирдэгтэй бат нот холбоотой юм. Сар туссан шөнийн аниргүйг нохдын хоор дуу цочрооход ээж өндийн дулаан алчуураар биеэ ороож суугаад цонх руу нүүрээ ойртуулан гадаах үйл явдлыг ажигладаг байв. Энэ бол аав минь ээж бид хоёрыг орхин Зэрлэг Луустай явахаас өмнөх явдал юм. Гэсэн ч тэр үед эцгийн эзгүй шөнүүд гэж байдаг байв. Би ч бас чимээгүйхэн өндийн суугаад шаазангийн аварга том хэлтэрхий шиг гялалзах дөнгөж усанд орсон үхэрнүүд, тэднийг туун байшингийн минь хажуугаар өнгөрөх үхрийн худалдаачдыг ээжийн араас цонхоор хардаг байлаа. Ноход хуцалдан үймээгүй байсан бол энэ бүхэн зүүдний үзэсгэлэнт ертөнцийг харж байгаа мэт санагдах байв. Эргэн дурсахад ноходтой байсан ч зүүдний ертөнц шиг санагдах юм.

Манай тосгон хэдэн дэн буудлаараа сайрхдаг байсан ч худалдаачид хэзээ ч тэнд хоноглож байсангүй. Харин үхрээ шууд үтрэмийн талбай руу тууж, салхи исгэрч, бороо шаагиж байсан ч, эсвэл жихүүцэм хүйтэн, бүгчим халуун байлаа ч тэд тэндээ үүр цайтал хүлээдэг байв. Салхи, шуургатай шөнөөр дэн буудлын эзэд

⁴ Нэг ли 0.5 километртэй тэнцүү

зочдын сэтгэлийг татахаар гарч, хэнгэрэг нүддэг байсан ч, урилга заллага нь ямар ч чамин байлаа гээд худалдаачид үхэртэйгээ хүйтэн чулуун хөшөө шиг хөдөлгөөнгүй зогссоор л байдаг сан. Зоос зарах зүйл хийхийг тэд хүсдэггүй байсан болоод тэр юм болов уу? Үгүй. Хүмүүс тэднийг үхрээ худалдсан даруйдаа л буцах удаан галт тэргийн нэг замын тасалбар худалдан авах мөнгөтэй хоцрох хүртлээ архи дан сохтуурч, хүүхэн эргүүлэхээр хот ордог гэгцгээдэг байв. Тэдний амьдралын хэв маяг тариачдын амьдралаас тийм ч өөр байгаагүй байх. Бодол санаа ч мөн адил. Манай тосгоны хүндтэй хүмүүс, “Хай яа, ямар гээчийн хүмүүс вэ? Тэдний толгойд юу болж байдаг юм бол доо?” хэмээн халаглан хэлж байхыг хүүхэд байхдаа хэд хэдэн удаа би сонссон. Тэд зээл дээр ирэхдээ бор үнээ, хар үхэр, хар үнээ, тугал, бяруу, усны домбо шиг дэлэнтэй гунжин үнээ хүртэл авчирдаг байв. Гунжин үнээнийн дэлэнг идэж болдог эсэхийг мэддэггүй байсан учраас аавд минь үнийг нь тооцоолоход хүнд байдаг байлаа.

Аавыг хараад үхрийн наймаачид байрандаа зогсоно. Өглөө эрт тэд толин тусгалтай нарны шил зүүсэн байх нь сүнс шиг харагддаг ч хүндлэл үзүүлэн инээмсэглэдэг байлаа. Аав минь намайг мөрөн дээрээ өргөөд худалдаачдаас гурав орчим метрийн зайд өлмий дээрээ доош суун тамхины үнгэгдсэн хайрцаг гаргаж ирээд чийгтэй муруй тамхи сугалдаг байв. Үхрийн худалдаачид хайрцагтай тамхиа гаргаж ирэхэд аавын хөлд арав, эсвэл илүү олон тамхи унаж ирнэ. Тэр тэднийг түүж аваад газарт нямбайлан буцааж тавина. “Лао Луо, муу хөгшин зөнөг толгой. Тат л даа. Шалихгүй хэдхэн тамхиар бид чиний дэмжлэгийг худалдан авах гэж санаархаж байна гэж чи бодоогүй биз дээ, тийм үү?” хэмээн худалдаачдын нэг нь хэлнэ. Аав зөвхөн инээмсэглээд өөрийнхөө хямдхан тамхийг асаана.

Энэ үед тосгоны мах нядлагчид хоёр, гурваараа ирэх бөгөөд саяхан усанд оржээ гэмээр харагдах ч гэлээ тэдний биеэс цусны үнэр үнэртэнэ. Энэ нь үнээнийх ч бай, гахайных ч бай цус хэзээ ч арилдаггүй гэдгийг илтгэнэ. Мах нядлагчдын цусны үнэр авсан үхэрнүүд дуу дуугаа авалцан мөөрөхөд нүдэнд нь айдас гялсхийнэ. Залуу үхэр гэнэт чацга алдах бол хөгшин үхэр илүү тайван харагдах авч тэд гэдэс дотроо хоослохгүйн тулд сүүлээ хоёр гуяныхаа завсар хавчуулныг хараад тэд зүгээр л дүр үзүүлж байгааг би мэдсэн юм. Салхи салхилахад цөөрөм долгиолдог шиг тэдний хөл чичирхийлж байлаа.

Мал нядлагчдыг цугалмагц наймаа эхэлдэг. Энгийн ажиглагч тэднийг малаа тойруулан байрлуулсныг харвал алийг нь худалдан авахаа шийдэж чадахгүй байгаа хүмүүс байна бодохоор. Хэрэв тэдний нэг нь малын хүзүүвчээс барьж авбал гурван агшны дараа бусад нь мөн адил үйлдэл хийх ба хоромхон зуурт бүх мал эзэнтэй болсон байна. Нэг малын төлөө хоёр худалдан авагч маргаж байсныг санах хүнгүй ч хэрэв тийм зүйл тохиолдвол маргаан тэр дороо шийдвэрлэгдэх байлаа. Ихэнх эзэмшигч, өрсөлдөгч нар эсрэг талууд байдаг ч гэлээ манай тосгоны мах нядлагч нар өрсөлдөгч байсан ч ахан дүүгийн ёсоор даван гарах нөхөрлөлөөр холбогдсон байлаа. Хүн бүр гартаа малын хүзүүвч атгасны дараа мах нядлагч залхуутайяа дөхөн очиж наймаа эхэлнэ. Харин одоо аав эрх мэдлээ тогтоосон учир энэхүү наймаа түүнд

үлдээсэн төгсгөлийн үг гэлтээ нэг их чухал бус, хэлбэр төдий заншил болсон. Эрчүүд нааш цааш холхиж байснаа аав дээр ирж эгээ л хотын захиргааны газар гэрлэлтийн зөвшөөрөл мэдүүлэх гэж буй аятай сөгдөн мөргөнө.

Тэр өдөр нэгэн онцгой явдал болов. Үхэр рүү шууд явахын оронд мах нядлагчид талбайн ирмэгээр нааш цааш алхаж байлаа. Тэднийг харсан хүн бүрийг мах нядлаачдын ноцтой инээмсэглэл тавгүйтүүлж байв. Дараа нь тэд эцгийн минь урдуур өнгөрөв. Тун удахгүй хуйвалдаан явагдах гэж байгаа мэт тэдний инээмсэглэлийн цаана ямар нэгэн таагүй зүйл нуугдан байгаа нь мэдэгдэж байлаа. Хямдхан тамхиныхаа нэгийг татан хөдөлгөөнгүй суух аав руугаа би зориг муутайхан харц шидлэв. Тэр өдөр бүр ингэж суудаг байлаа. Худалдаачдын чулуудсан арай дээр тамхинууд түүний өмнө янзаараа л хэвтэнэ. Наймаа дуусахад худалдаачид ирж өнөөх тамхинаасаа авч татна. Тамхилж байхдаа тэд аавын шударга занг магтана. “Лао Тун, хэрэв хятад хүн бүр чам шиг байсан сан бол арван жилийн өмнөөс л коммунизм эхлэх байлаа” хэмээн нэг нь хагас тохуурхсан байдалтай хэлнэ. Харин аав юу ч хэлэхгүй инээмсэглэнэ. Энэ мөчид миний сэтгэл бахдалаар дүүрч, ийм л хүн болно, ингэж л юмыг хийнэ гэж өөртөө амладаг байв. Тэр өдрийн жигтэй уур амьсгал худалдаачдад ч тодорхой байв. Ямар нэг юм болох гээд байгаа нь худалдаачдад ч тодорхой байв. Харин өнгөрч явахдаа хүйтнээр ажих хэдэн мах нядлагчаас бусад нь аав руу эргэн харав. Нууцлаг хэлэлцээр эцэслэв. Жүжиг эхлэхийг хүлээж буй үзэгч шиг хүн бүхэн юу болохыг ажин зогсож байлаа.

Зүүн зүгт талбайгаас дарханы улайсан царай шиг тод улаан нар ургаж, жүжгийн гол дүр хагалсан газарт арай гэж гарч ирэв: Өндөр, зангирсан булчин, эрүүл биетэй Лао Лан. Бавгар сахалтай нь адил бор өнгийн нүдийг нь хараад түүний үндэс угсаанд эргэлзэх вий. Талбай дээгүүр том том алхан гарч ирэхэд нь хүн бүр түүнийг харна. Нарны туяа түүний царайг гэрэлтүүлнэ. Тэр аав руу алхаж байсан ч нүд нь намхан зузаан шавар хананы алсад гялбуулсан хурц өглөөний нар туяарсан тариан талбайг ширдэж байв. Ургацын талбай ногоорон, цэцэг дэлбээлж, сайхан үнэрээ агаарт цацаж, болжмор сарнайн ягаан тэнгэрт дуулалдан байлаа. Лао Ланы хувьд хэн ч биш аав минь хананы дэргэд сууж харагдаагүй ч байж мэдэх юм. Хэрэв аав минь түүний нүдэнд хэн ч биш юм бол би түүний хувьд юу ч биш байсан байх нь. Магадгүй нар нүдийг нь гялбуулсан биз гэж балчир толгойд минь хамгийн эхэнд орж ирсэн ч удалгүй Лао Лан аавыг минь өдөж байна гэсэн бодол харван орж ирсэн юм.

Тэр мах нядлагч, худалдаачин нартай ярихаар толгойгоо өндийлгөхдөө өмднийхөө цахилгааныг доошлуулж, “хар багаж” аа гарган ирээд аав бид хоёрын урд халуу дүүгсэн шар шээсэн гол урсгаж орхив. Муухай үнэр хамрыг минь сэнхийлгэлээ. Тэр аавыг минь доромжлох гэж үүнийгээ шөнөжин тэвчин байж цуглуулсан болов уу гэлтээ маш их шээсэн. Газарт байсан тамхинууд түүний шээсэнд эргэлдэн өнхөрч, хэлбэрээ алдатлаа бэмбийв.

Лао Ланыг “багаж” аа далд хийхэд бөөгнөрсөн мах нядлагч, худалдаачдын зүгээс жигтэй инээд гарлаа. Гэвч аварга том гар тэднийг багалзуурдаад авчихвуу гэлтээ гэнэтхэн дуугүй болов. Тэд бидэн рүү амай ангайж, бүлх залгисан мэт гайхсан байдалтай ширтэж байв. Лао Ланыг аавтай зодолдохыг хүсэж байгааг мэдэж байсан мах нядлагч нар хүртэл түүнийг ийм зүйл хийнэ чинээ төсөөлөөгүй байв. Тэр бидний хөл, гуян дээр шээж, зарим нь нүүр, ам руу үсэрч байсан юм. Би уурандаа үсрэн боссон ч аав ганц хуруугаа ч хөдөлгөсөнгүй. Тэр яг л чулуу шиг суусаар байлаа. “Эхийн чинь!” гэж би хараав. Аав минь чимээ ч гаргасангүй. Лао Ланы царайнд бардам инээмсэглэл тодорлоо. Дээврээс ус дуслахыг харан баярлаж байгаа тариачид шиг аавын нүдэнд нулимс цийлэгнэжээ.

Лао Лан шээж дуусаад өмдөө татаад үхэрнүүдийн байгаа газар руу очлоо. Мах нядлагч, худалдаачны санаа алдахыг би сонсож байсан ч ямар ч зүйл болоогүйгээс үү, эсвэл ямар нэг зүйл болоогүй учраас баярласандаа тэгсэн үү гэдгийг хэлж мэдэхгүй нь.

Худалдаачид ирж наймаа эхлэв. Гэвч тэдний анхаарал наймаанаас өөр зүйлд хандсан байсныг хэлж чадахаар байв. Тэд аав руу минь харахгүй байсан ч түүний тухай бодож байсан гэдэгт би итгэлтэй байна. Тэр юу хийж байсан бэ? гэвэл, тэр эгээ л модны мөчрийн салаанд унтаж буй шонхор шиг өвдгөө тэврэн царайгаа нууж суув. Түүний царай харагдахгүй байсан учир яг тэр агшинд түүний царай ямар байсныг мэдэх аргагүй байлаа. Гэсэн ч тэр сул дорой хүн шиг харагдсанд сэтгэл минь тавгүйрхэв. Би жирийн нэг жаал байсан ч Лао Лан аавыг минь ямар ихээр доромжилсныг ойлгож, мөн ямар ч хүн нэр төрийнхөө төлөө энэ бүхнийх зүгээр өнгөрөөхгүй байх байсан гэдгийг ч мэдэж байв. Би хараалаараа хариугаа авав. Аав минь үхсэн юм шиг чимээгүй байсаар л байлаа.

Аавын оролцоогүй тэр өдрийн наймаа өндөрлөв. Наймаагаа дуусмагцаа худалдаачид түүн дээр ирж хөлд нь хэдэн юань шидэв. Энэ нь Лао Ланы үйлдлээс ялгагдах юмгүй байлаа. Эрлийз зулбасга аавын минь нүүр рүү шээж чадаагүй учраас сэтгэл нь ханаагүй байв. Хоёр шинэ аравтын дэсгэрт аваад аавын анхаарлыг татах гэж няслав. Гэтэл аав хөлнийхөө араар нуугдсан хэвээр байсан нь Лао Ланыг гонсойлгосон бололтой. Тэр эргэн тойрноо харснаа аавын хөл доор хоёр дэвсгэрт шидэхэд нэг нь түүний шээснээс үүсэж, уур савссаар байгаа шавар дээр унахдаа норж, бутарсан тамхинд наалдав. Тэр мөчид, аав минь үхсэн байж болох юм. Тэр өөртөө ч, өвөг дээдэсдээ ч харуулах царайгүй болсон. Нэр төр нь өрсөлдөгчийнх нь шээсэнд хөвж буй хөөсөн янжуурын түвшинд хүртэл унаж, тэр эр хүн байхаа больсон. Лао Лан мөнгөө шидсэний дараа үхрийн худалдаачин, мах нядлагч нар түүнийг дагаж, тэдний харууслыг хүртэх ёстой гуйлгачин аав, хүү хоёрыг харж байгаа мэт өрөвдсөн царай нүүрэндээ тодруулав. Тэд түүнийг эсэргүүцээгүйнх нь төлөө бас Лао Ланы өрөвч сэтгэлийг хуулбарлахыг оролдсондоо өгдөг байснаасаа хоёр дахин илүү мөнгө шидэв.

Хөл доор минь үхсэн навчис шиг унаж буй дэвсгэртүүдийг хараад намайг уйлж эхлэхэд аав минь арай гэж дээш харлаа. Түүний царайд уур хилэн, эсвэл уйтгар гунигийн сэжим байсангүй. Тэр модны хатсан холтос шиг царайтай болсон байлаа. Тэр намайг яагаад уйлж байгааг ойлгохгүй байгаа мэт хүйтэн, эргэлзсэн харцаар над руу цоо ширтэв. Би түүн рүү ойртож, хүзүүгээр нь тэврээд, “Дие⁵, одооноос та миний аав биш. Би хэзээ нэг өдөр Дие гэж ахин дуудахаасаа өмнө Лао Лан Дие гэж дуудаж байх болно!” гэв.

Намайг орилоход гайхсан хүмүүс нирхийтэл инээв. Лао Лан над руу эрхий хуруугаа гозойлгов. Тэр, “Шяотун, чи үнэхээр онцгой, яг л надад хэрэгтэй хүү юм. Одооноос эхлээд чи манайд хэдийд ч ирж болно. Гахайн мах идмээр байвал тэрийг чинь өгнө, үхрийн мах идмээр байсан ч өгнө гэж мэд. Хэрэв ээжтэйгээ хамт ирвэл би алгаа тосоод хүлээж авна шүү” гэлээ.

Тэр бол татгалзахад хэтэрхий сайхан доромжлол байсан тул би түүн рүү хилэнтэйгээ дайрав. Лао Лан надаас амархан бултаж, би газарт унаж, шалбарч, цус гарсан уруултай доош харан хэвтэж байлаа.

Тэр тас тас хөхрөнгөө, “Бяцхан зулбасга, Дие гэж дуудчихаад над руу дайрна гэнэ ээ! Ухаантай хүн чам шиг хүүтэй болохыг хүсэх үү?” гэлээ.

Хэн ч надад туслаагүй учир би өөрөө хөл дээрээ босож аав дээр очин гансрал гомдлоо тайлах гэж хөл рүү нь өшиглөв. Энэ үйлдэл түүнийг уурлуулсангүй, тэр үүнийг анзаарах ч сөхөөгүй байлаа. Тэр зүгээр л нүүрээ том, зөөлөн гараараа үрж байв. Дараа нь тэр залхуу, том муур шиг гараа сунган эвшээлгээд доош харан удаан, чин сэтгэлээсээ, болгоомжтойгоор Лао Ланы шээсэн дээр байсан дэвсгэртүүдийг түүгээд хуурамч эсэхийн шалгах гэсэн шиг нэг нэгээр нь гэрэлд харав.

Эцэст нь тэр өмдөн дээр нь хатаж, шээсэнд заваарсан Лао Ланы шинэ дэвсгэртийг авав. Дэвсгэртүүд түүний хөл доор цэвэрхэн нуруулдан хэвтэнэ. Тэр үүнийг зүүн гарынхаа голын хоёр хурууны завсар хавчуулаад баруун гарынхаа эрхий болон долоовор хуруу руугаа нулиман тоолов.

Би аав, хүү хоёрыг доромжилсных нь төлөө өшөө авахаар мөнгийн урж, Лао Ланы нүүр рүү цацахын тулд гар руу нь дайрав. Тэр намайг бодвол хурдан байлаа. Тэр үсрэн босч зүүн гараа агаарт өргөөд, “Тэнэг хүү, чи өөрийгөө юу хийж байна гэж бод оо вэ? Мөнгө бол мөнгө. Мөнгө биш хүмүүс буруутай. Уураа мөнгөнд бүү гарга” гэж үглэв.

Тохойноос нь би зуураад гараас нь ичгүүртэй мөнгийг авч тастах гэж бие рүү нь авирахыг оролдлоо. Том хүний дэргэд миний чадал хүрсэнгүй. Би дэлбэртлээ уурласан байсан тул түүний ташаанд толгойгоо цохисоор байв. Гэтэл тэр толгой дээр минь хөнгөхөн алгадаад, элэг зүрхнийхээ угаас, “Одоо болно доо, хүү минь, сэтгэлээ чилээх хэрэггүй. Тэнд байгаа Лао Ланы үхэрыг хар даа. Тэр ууртай байна”

⁵ Уламжлалт хятад ханзанд энэ нь 爹 буюу аав гэсэн үг.

гэв. Тэр бол шулуун эвэр, мөн хожим нь миний зурагтаар харсан тамирчид шиг торгомсог үсэн доор нуугдсан долгионтсон булчин, том биетэй, *Лүши*⁶ үхэр байлаа. Нүүрэн хэсгийнх нь үс л цагаан бусад нь алтан шар өнгөтэй байгаа нь гайхмаар байв. Би өмнө нь хэзээ ч цагаан нүүртэй үхэр харж байсангүй.

Түүнийг агталсан байсан бөгөөд нүднийхээ булангаар чам руу харах нь л үс босоход хангалттай аймаар байв. Одоо бодоход тэр үед хүмүүс тайган хүнийг дүрслэн хэлэхдээ ийм л зүстэй хүнийг хэлдэг байсан байх гэж санагддаг. Хөнгөлөх нь хүний байгалийн шинжийг өөрчилдөг шиг үхрийг ч өөрчилдөг. Үхэр рүү заасан нь миний мөнгөний тухай бодлыг мартуулав. Ядахдаа л ганц хором. Сагсуу Лао Ланыг үхрээ хөтлөн талбайгаас гарч явж буй яг тэр мөчид би эргэн харлаа. Номхон аавыг минь тэгж доромжилсных нь дараа сагсуу гэхгүй байж болох уу? Тосгоныхны, мөн үхрийн худалдаачдын дунд түүний алдар нэр огцом өссөн. Тэр өөрийг нь илүүдэл амьтан шиг зайлуулсан ганц хүний эсрэг хөдөлж, ялсан. Ахин тосгоны нэг ч хүн түүнийг үл тоомсорлохгүй. Үүнээс болж дараагийн үйл явдал болсон юм. Олон жил өнгөрсөн ч одоо ч би энэ явдал болсон гэдэгт эргэлздэг юм.

Өнөөх үхэр нь замдаа зогсчихов. Лао Лан түүнийг хөдөлгөх гэж хүзүүвчээс нь татав. Тэр хөдөлсөнгүй. Ямар нэгэн оролдлогогүйгээр үхэр Лао Ланы гаргасан хүчийг тохуурхаж байлаа. Мах нядлагчдад зориг муутай тугалыг навч шиг бөмбөгнүүлдэг үнэр байдаг. Учир нь ихэнх зөрүүд амьтан гартаа хутгатай нядлагчийг хараад үхлээ хүлээн номхон зогсдог аж. Үхрийг хүзүүвчээс нь татсан ч хөдөлгөж чадахаа байсан учир тэр түүнийг тойрон явж, хаа, гуя руу нь алгалан, чих цоолом хараал тавьж байлаа. Ихэнх амьтан хүчтэй алгадалт, чанга хараалаас нь болж удирдлагаа алдах байсан ч Лүши үхэр өчүүхэн ч хөдөлсөнгүй. Харин аавын минь ялагдлын дараа байгуулсан ялалтын гялбаандаа тэр баяссаар, бардам цэрэг шиг л аашлан байхад Лао Лан түүний гэдэс рүү төрөлх занг нь бодолцон үзэлгүй өшиглөж орхив. Тэр бөгсөө хөдөлгөж, чанга дуу тавьж, толгойгоо доошлуулан эврээрээ Лао Ланыг сүрлэн дэвсгэрээс ч хөнгөн юм шиг өлхөөн өргөөд агаарт шидчихэв. Болсон үйл явдлыг хараад мал нядлагч, худалдаачин нар алмайрч, хэлэх ч үгүй болсны дээр Лао Ланд туслахаар хэн ч очсонгүй. Үхэр толгойгоо дахин доошлуулж, дайрав. Тэр жирийн нэгэн байсангүй. Нөгөө эвэр өөр рүү нь зүглэж явааг хараад Лао Лан замаас өнхрөн зайлав. Нүдэнд нь уур хилэн дүрэлзэж эргэн ахин дайрахад Лао Лан хоёр дахь, гурав дахь удаагаа замаас өнхрөн зайлж амиа аварлаа.

Эцэстээ тэр хөл дээрээ алхаж эхлэхэд бид түүнийг маш бага гэмтсэн байхыг харлаа. Тэр толгойгоо доошлуулан үхэр рүү харан зогсоход үхэр ташаагаа нэг тал руугаа шилжүүлэн түүнээс хором ч харцаа салгасангүй. Үхэр дайралтанд ахин бэлдэж байна уу гэлтэй толгойгоо доошлуулж, амных нь булангаар шүлс сахран, чанга амьсгаадан байв. Үхрийн анхаарлыг саринуулахаар Лао Лун гараа өргөсөн ч зөвхөн зоригтой дүр эсгэх гэж л тэгсэн нь тодорхой байлаа. Тэр нэр төрөө авч

⁶ Шаньдун нутгийн үхрийн нэг үүлдэр

гарахын тулд юу ч хийхээс буцахгүй үхтлээ айсан бухтай тулалдагч шиг харагдаж байв. Тэр урагшаа болгоомжтойгоор нэг алхав. Үхэр хөдөлсөнгүй. Эцэст нь тэр чадалтай төрхөө гээж, сүүлчийн удаа орилон эргэж нэг хараад ухаангүй зугтав. Үхэр араас нь хөөхөд сүүл нь төмөр саваа шиг хатуурч, тэгширсэн байв. Эгээ л шүршдэг бууны гал шиг түүний туурай шаврыг тал тал тийш нь цацаж байхад Лао Лан өөрийн ухаангүй зугтааж, зөн совингоороо, олон хүнээс аврал найдан хүмүүс рүү зүглэлээ. Гэтэл түүнийг аврах тухай тэдний хэн нь ч бодоогүй байв. Орилж чарласаар тэд ч бас амиа бодон, хоёрхон хөл заяасан эцэг эхээ хараасаар зугтав. Аз болоход үхэр бусдад уураа гаргах биш харин зөвхөн Лао Ланыг онилох хангалттай ухаантай байв. Хашаа, мод руу авирахдаа худалдаачин, мах нядлагч нар элс цэцнэ. Хүнд байдалд орж тэнэглэсэн Лао Лан аав бид хоёр руу чиглэв.

Цөхрөнгөө барсан аав өнөөх хараал идсэн Лао Ланыг түүний араар орж нуугдан араас нь холдохгүйн тулд хувцаснаас зууран, түүгээр бамбай хийн зогсохоос хэдхэн хормын өмнө нэг гараараа миний хүзүүнээс, нөгөө гараараа өгзөгнөөс бариад намайг хашаа давуулан шидчихлээ. Аав минь ухрахад Лао Лан ч ухран тэд хамтдаа хашаа налан зогслоо. Аав гар дахь мөнгөө үхрийн өмнө даллаад, “Үхэр, ээ, үхэр ээ, бидний дунд өс хонзон үгүй, одоо ч байхгүй, хэзээд үгүй, тэгэхээр зөвшилдөгцөө...” хэмээн үглэв. Энэ бүхэн үгээр дүрсэлснээс ч хурдан болж өнгөрсөн: Аав үхрийн нүүр рүү мөнгөө шидээд түүнийг юу болоод байгааг ойлгоогүй байхад нуруун дээр нь үсрэн гарав. Тэгээд тэр хуруугаа үхрийн хамарт хийгээд дөрнөөс нь атгаад толгойг нь арагш татав. Үхэрнүүдийг худалдаачид баруун хошууны фермээс авчирдаг байсан тул бүгдийнх нь хамар дөртэй байв. Үхрийн хамар тэдний эмзэг газар гэдгийг ямар ч үхэрчнээс илүү аав сайн мэднэ. Хашаан дээр сууж байхад нүднээс минь нулимс урсаж байлаа. Эцгээрээ би маш их бахархаж байна гэж би бодсоноор доромжлол ч үгүй болов, мөн ухаалаг, зоригтой үйлдэл нь бидний нэр төрийг сэргээв. Цагаан нүүрт шар үхрийг газарт унагаахад мах нядлагч болон худалдаачид аавд туслав. Ахин босч, хэн нэгнийг гэмтээхвий гэсэндээ мах нядлагчдын нэг нь хутга авч ирэхээр туулай шиг хурднаар гэр рүүгээ гүйлээ. Авчирсан хутгаа тэр үхмэл царайлсан Лао Ланд өгөх гэхэд тэр арагш ухран, өнөөх эрийг гараараа хөөж, энэ ажлыг өөр хэн нэгэн рүү шилжүүлэв. Гартаа хутгатай мах нядлагч: “Хэн үүнийг хийх вэ? Хийх хүн алга уу? Тийм бол би л шийдье” гээд ханцуйгаа шамлан гутлын уландаа ирийг нь арчиж явган суун тэгшлүүртэй мужаан шиг нэг нүдээ анин харав. Үхрийн цээжинд багахан эсгэлт гаргаснаа хутгаа дүрэн авахад цус олгойдон гарч аав улаан цусанд будагдлаа.

Үхэр үхэж, хүн бүр авирсан зүйлээсээ бууж ирлээ. Хөндсөн хэсгээс хүрэн улаан цус урсан оргилуурын ус шиг оргилж, тасралтгүй урсахдаа өглөөний цэнгэг агаарт пүн хийсэн үнэр тавив. Эргэн тойронд яагаад ч юм хий нь гарсан бөмбөлөг шиг хорчийж, агшсан эрчүүд зогсоно. Тэдэнд хэлэх зүйл олон байсан ч хэн нь ч үг дуугарсангүй. Толгойгоо доошлуулан хоёр мөрнийхөө хооронд хавчсан аав минь эрүүл атлаа шар өнгөтэй шүдээ гарган, “Дээдэс минь ээ, айсан гэж!” гэв.

Тэр үед хүн бүр нүх рүү орчихъё гэж санаж байсан Лао Лан руу эргэн харав. Тэр ичгүүрээ нуухыг оролдон доош хөл нь шулуун сунаж, гуяных нь махлаг хэсэг татвагнасаар байгаа үхэр рүү харах аж. Хорсол зэвүүцлээ илэрхийлэх шиг үхрийн өрөөсөн цэнхэр нүд нээлттэй байв. Лао Лан үхсэн амьтныг өшиглөөд, “Хараал ид! Насаараа зэрлэг галуу хөөсөн байж дэгдээхийд сохлуулах дөхлөө” гээд аав руу хандан, “Луо Тун, би чамд өртэй боллоо, гэвч бидний хооронд юм дуусаагүй шүү” гэв.

“Юу дуусаагүй гэж? Бидний хооронд юу ч байхгүй”

“Түүнд хүрээд үзээрэй!” Лао Лан шивнэв.

“Би биш тэр надад хүрэхийг хүсдэг” гээд аав минь бахархалтайгаар жуумалзаад, “Тэр чамайг нохой гэдэг, бас тэр чамайг өөртөө ахин хүргэхгүй” гэлээ.

Тэр үед би энэ бүхэн юун тухай болохыг ойлгоогүй ч хожим тэднийг Зэрлэг Луусын тухай ярьж байсныг мэдсэн юм.

Намайг, “Дие, та юун тухай яриад байна вэ?” гэж асуухад тэр, “Хүүхэд мэдэх хэрэггүй ээ” гэсэн юм.

“Хүү минь, чи Лан овогтны гишүүн болохыг хүсэж байна гэж хэлээгүй билүү? Тэгээд юунд түүнийг Дие гэж дуудна вэ?” хэмээн Лао Лан асуув.

“Чи бол нохойн овоолсон өмхий бааснаас өөр юу ч биш!”

Харин Лао Лан, “Хүү минь, гэртээ хариад аав Зэрлэг Луусын агуйд орчихоод гарч чадахгүй байна гэж ээждээ хэл” гэв.

Энэ үг аавыг минь саяын үхэр шиг хилэгнүүлж, тэр толгойгоо доошлуулаад Лао Лан руу дайрав. Тэр бие биеийнхээ хоолойг хором хүрэхгүй хугацаанд базаад байтал хүмүүс тэднийг салгав. Гэвч тэрхэн зуур Лао Лан аавын чигчий хурууг хугалж, аав Лао Ланы чихний талыг тас хазаж дөнгөв. Аав чихнийх нь хэсгийг ууртайгаар нулимж хаяад, “Хүүгий минь хажууд ийм зүйл яаж хэлж чадаж байна аа, нохойн зулбасга чинь!” гэлээ.♦

**УМАРШ ДАЙЛСАН ХОЙДОХ ТЭМДЭГЛЭЛ ХЭМЭЭХ
СУРВАЛЖИЙН ЭРТНИЙ ХЯТАД ХЭЛНЭЭС
ОРЧУУЛСАН МОНГОЛ ОРЧУУЛГА**

**Д. Ундрах¹
Б. Отгонгэрэл²**

Юнлө (永樂) -гийн арван хоёрдугаар оны гуравдугаар сарын арван долооны цагаан барс өдөр [1414.04.06], Дээр өөрийн биеэр зургаан замын цэргийг манлайлж, Ойрадын зэрлэг дээрэм Дэлбэг, Махмуд, Тайпин, Батболод нарыг дайлаар мордов. Морьт явган ноёд цэрэг таван зуун мянга илүү байлаа. [Бичгийн утгач] бичгийн сайд Ху гүн Гуан Да, зөвлөгч түшмэл Ян гүн Мян Рэнь нар хамт дагалдав. Мөн өдрийн луу цагт замд мордож, Энх тогтох хаалгаар гарч, үд хэвийхэд Чин голын доод хуаранд хүрэв. Орой нь багавтар бороо орсоор шөнө улам ширүүсч, таван жингийн үест зогсов.

Арван наймны өдөр [04.07] [тэнгэр] цэлмэг. Өглөө, Чин голоос хөдөлж, үдийн алдад Ша голд хүрэв. Бадрангуйг тэмдэглэх захиргаанд тушааж, [цэрэг ноёдод] архи хүнс соёрхов.

Арван есний өдөр [04.08], үүрээр бороо орж байсан [агаад], өглөө нь Ша голоос хөдлөхөд зам зуур бороо зогсов. Үдэд Лунхү тай-д буудаллав. Үдээс хойш бороо дахин орлоо.

Хорины өдөр [04.09] цэлмэг. Үүрээр Лунхүтай-гаас мордож, Цавчаал боомтоор өнгөрөв. Замд намаг шавар ихтэй [тул] мориор явахад хэцүү байлаа. Үдээс хойш Лунчин жөү-д хүрч хуарагнав.

Хорин нэгний [04.10] өдрийн өглөө бүрхэг. Үүрээр Лунчин жөү-гээс мордож Юй лин-д хүрэхэд бороо орж [байлаа]. Үдээс хойш Хуайлай хүрч буудаллав. Бороо зогссонгүй.

Хорин хоёрны [04.11] өдрийн өглөө бороо зогсов. Хуайлай-гаас гарч, үдээр Шачөн хотод хүрэв. Үдэш [тэнгэр] цэлмэг байв.

Хорин гуравны өдөр [04.12] [тэнгэр] цэлмэг. Өглөө Шачөн [хотоос] гарч, үдээр Жимин ууланд буудаллав. Их салхитай.

Хорин дөрөвний өдөр [04.13] цэлмэг. Өглөө Жимин уулнаас гарч, үдэд Ни голд буудаллав.

Хорин тавны өдөр [04.14] цэлмэг. Үүрээ Ни голоос гарч, үдэд Шюаньфү-д буудаллав. Их салхитай, бороо ормогцоо зогсов. Энэ өдөр тариалангийн хурын [улирал] эхлэв.

Хорин зургааны өдөр [04.15] цэлмэг. Шюаньфү-д буудаллав.

¹ МУИС, ШУС, ХУС-ын Ази судлалын тэнхимийн дэд профессор, доктор

² МУИС, Олон улс орон судлалын хөтөлбөрийн магистрант

Хорин долооны өдөр [04.16] цэлмэг. Өглөө Шюаньфү-гээс гарч үдээр Шюаньпин-д буудаллав. Их салхитай.

Хорин наймны өдөр [04.17] өглөө цэлмэг. Үүрээр Шюаньпин-гээс гарч, үдэд Дөшөн аманд буудаллав. Үдэш их салхитай. Цас оров.

Хорин есний өдөр [04.18] бүрхэг. Өглөө Шюаньпин-гээс гарч, Ехүлин-ийг өнгөрөв. Салхи жихүүн, үдийн хойно Шинхө-д буудаллав.

Гучны өдөр [04.19] жихүүн салхитай. Шинхө-д буудаллав. Хянагч түшмэл Ли Дү-гээр Бээжин рүү “Гэрийн бичиг” илгээв.

Дөрөвдүгээр сарын шинийн нэгний хөх луу өдөр [04.20], цэлмэг. Шинхөд буудаллав.

Шинийн хоёрны өдөр [04.21], цэлмэг. Шинхө-д буудаллав. Ёслол эрхэлсэн түшмэл Жу Шаочин-гээр Бээжин рүү “Гэрийн бичиг” илгээв.

Шинийн гуравны өдөр [04.22], цэлмэг. Шинхө-д буудаллав.

Шинийн дөрөвний өдөр [04.23], цэлмэг. Шинхө-д буудаллав..

Шинийн тавны өдөр [04.24], хуарангаа Шинхө-гөөс умар зүгт арван газар дахь Шачөн (沙城)-д нүүлгэв.

Шинийн зургааны өдөр [04.25], цэлмэг. Шачөн-д буудаллав. Цэргийг ихээр шалгав.

Шинийн долооны өдөр [04.26], цэлмэг. Шачөн-д буудаллав.

Шинийн наймны өдөр [04.27], цэлмэг. Шачөн-д буудаллав..

Шинийн есний өдөр [04.28], цэлмэг. Шачөн-д буудаллав. Хянагч түшмэл (御史) Ли Дү (李都) ирж, гэрийн захидлыг авав.

Шинийн арваны өдөр [04.29], цэлмэг. Өглөө Шачөн-гээс хөдөлж, үдээс хойно Хун Чяо /Улаан гүүр/-д буудаллав. Тус өдөр зуны уур улирал эхлэв.

Арван нэгний өдөр [04.30], бүрхэг. Өглөө Хун Чяо-гаас мордож үдээс хойш Лин Шяо Фөн (凌霄峯)-д хүрч буудаллав. [Энэ газрыг] мөн Өчүүхэн баян [兀出千伯顏] [хэмээмүй]. Бороо шөнөдөө зогссонгүй. Маш хүйтэн. Түлш тасрав. Харанхуй болсны сүүлээр Бадрангуйг тэмдэглэх захиргаанаас сая хоол хүргэв. Хоол идэж дуусгасангүй. Шөлгүй учир орхив. Шөнө нь морьд өвсгүй, өмссөн хувцас цөм норж хоол олж чадсангүй.

Арван хоёрны [05.01] өдрийн өглөө, бороо зогсов. Бүрхэг. Хоолны дараа Лин Шяо Фөн-гөөс хөдлөв. Үдэд Лин Шяо Фөн хойш Да Шы Жэн /Их чулуун балгас/-д буудаллав. Усгүй, харанхуй хонов.

Арван гуравны өдрийн [05.02] өглөө, бүрхэг. Бага зэрэг бороотой. Үдээс өмнө Ү Юнь гуань /Таван үүлт боомт/-д буудаллав. [Энэ газрыг] мөн Харган [хэмээмүй], устай.

Арван дөрвөний өдөр [05.03], цэлмэг. Хяруутай. Хүйтэн. Ү Юнь гуань-д буудаллав.

Арван тавны өдөр [05.04], цэлмэг. Өглөө Ү Юнь гуань-аас гарч үдэд Гаопин фу-д буув. [Энэ газрыг] мөн Хуй салхитай [хэмээмүй].

Арван зургааны өдөр [05.05], цэлмэг. Өглөө Гаопин фу-гаас гарч үдэд Ша Лу Чөн-д буув. [Энэ газрыг] мөн Дару хот [хэмээмүй].

Арван долооны өдөр [05.06], цэлмэг. Ша Лу Чөн-гээс мордож үдээс Лун Ша Дин-д буув. [Энэ газрыг] мөн Налан нуур [хэмээмүй]. Үдээс хойш бороотой.

Арван наймны өдөр [05.07], бүрхэг. Өглөө Лун Ша Дин-гээс гарч үдээр Жин Юнь Чи-д буув. Үдээс хойш их салхитай. Бороо цастай. Үдэштээ цэлмэв.

Арван есний өдөр [05.08], цэлмэг. Өглөө Жинюнь Чи-гээс мордож үдэд Шяогань чуань-д буув.

Хорины өдөр [05.09], цэлмэг. Өглөө. Шяогань чуань-аас гарч Дагань чуань-д буув.

Хорин нэгний өдөр [05.10], цэлмэг. Өглөө Дагань чуань-аас гарч үдэд Чиншүй юань-д буув. [Энэ газрыг] мөн Мадама [хэмээмүй].

Хорин хоёрны өдөр [05.11], цэлмэг. Чиншүй юань-д буудаллав.

Хорин гуравны өдөр [05.12], цэлмэг. Чиншүй юань-д буудаллав.

Хорин дөрвөний өдөр [05.13], цэлмэг. Үдээр Чиншүй юань-аас гарч орой Түньюнь гү-д буув. Усгүй, Чиншүй юань-аас ус тээж хүрч, оройн хоол хийв.

Хорин тавны өдөр [05.14], цэлмэг. Өглөө Түньюнь Гү-гээс гарч үдэд Юйшюэ ган-д буудаллав. Энэ өдөр бол өчүүхэн дүүрэн хэмээх өдөр.

Хорин зургааны өдөр [05.15], цэлмэг. Үдээр Юйшюэ ган-аас гарч орой нь Шюаньшы пө-д буув. Их салхитай.

Хорин долооны өдөр [05.16], цэлмэг. Өглөө Шюаньшы пө-с гарч үдэд Минчэ жэн-д буув.

Хорин наймны өдөр [05.17] үдээр Минчэ жэн-ээс гарч орой Чин фөн голд буув. Усгүй, салхи их. Яр өвчин гарч моринд мордоход сэдрэв.

Хорин есний өдөр [05.18], цэлмэг. Үүрээр хүйтэн. Өглөө Чин фөн голоос гарч үдэд Гүйхуа дин-д буув.

Тавдугаар сарын шинийн нэгний харагчин тахиа өдөр [05.19], цэлмэг. Өглөө хүйтэн. Гүйхуа дин-гээс гарч үдээр Янлин Шү-д буув.

Шинийн хоёрны өдөр [05.20], цэлмэг. Өглөө Янлин ху-гээс гарч үдэд Чин Ху (禽胡山) ууланд буув.

Шинийн гуравны өдөр [05.21], цэлмэг. Чин Ху ууланд буудаллав. Яр нь хүндэрч Дээр Их отчийн хүрээлэнгийн захирагч (太醫院判) Хан Гүнда (韓公達)-г зарлигдан гоёо эм соёрхов.

Шинийн дөрвөний өдөр [05.22] цэлмэг. Чин Ху ууланд буудаллав.

Шинийн тавны өдөр [05.23] цэлмэг. Чин Ху ууланд буудаллав. Үдэш их салхитай, шөнө бороотой.

Шинийн зургааны өдөр [05.24], цэлмэг. Чин Ху ууланд буудаллав. Их салхитай.

Шинийн долооны өдөр [05.25], бүрхэг. Их салхитай, хүйтэн. Өглөө Чин Ху уулнаас гарч орой Шянчюань шу-д буудаллав.

Шинийн наймны өдөр [05.26], бүрхэг. Салхитай хүйтэн. Могой цагт Шянчюань шу-гээс гарч үдээс хойш Гуан Ү жэнь-д буудаллав. [Энэ газрыг] мөн Хар манлай [хэмээмүй]. Шөнө бороотой.

Шинийн есний өдөр [05.27], бүрхэг. Гуан Ү жэнь-д буудаллав. Үдээс хойш аянгат бороо оров. Цас мэт мөндөр бууж газарт 2-3 ямх хурав.

Шинийн аравны өдөр [05.28], цэлмэг. Өглөө Гуан Ү жин-гээс гарч үдээр Хуайюань сай (懷遠塞)--д буудаллав.

Арван нэгний өдөр [05.29], цэлмэг. Өглөө Хуайюань сай гаас гарч, үдэд Юйдай чюань (玉帶川)-д буув. [Энэ газрыг] мөн Бор толгой (紫髯) [хэмээмүй]. Шарх анив. Тус өдөр бол буудай боловсрох өдөр³ болой.

Арван хоёрны өдөр [05.30], цэлмэг. Өглөө Юйдай чюань-аас гарч үдэд Фүпин жэнь-д буув. [Энэ газрыг] мөн Үр толгой. [хэмээмүй].

Арван гуравны өдөр [05.31], цэлмэг. Үдэд Фүпин жэнь-ээс гарч орой Цуймү дин-д буув. Ус үгүй, харанхуйгаар хонов.

Арван дөрвөний өдөр [06.01], цэлмэг. Өглөө Цуймү Дин-гээс гарч үдэд Чаншань ся-д буув. Ус дутуу.

Арван тавны өдөр [06.02], цэлмэг. Өглөө Чаншань ся-гаас гарч үдээр Жыши чуань-д буув.

Арван зургааны өдөр [06.03], цэлмэг. Жыши чуань -д буудаллав.

Арван долооны өдөр [06.04], цэлмэг. Өглөө Жыши чуань -аас гарч үдэд Хуаньшю ган-д буув.

Арван наймны өдөр [06.05], цэлмэг. Үдэд Хуаньшю ган-аас гарч бүрий болоход Еэма чуань /Хулангийн ус/-д буув. Харанхуйгаар хонов.

Арван есний өдөр [06.06], цэлмэг. Еэма чуань -аас гарч үдээр Мөншань хай-д буув.

Хорины өдөр [06.07], цэлмэг. Үдэд Мөншань хай –гаас гарч үдшээр Вэй Ү жин-д буув.

Хорин нэгний өдөр [06.08], цэлмэг. Үдийн өмнө Вэй Ү жин-гээс гарч орой Тунчуань бө-д буув.

Хорин хоёрны өдөр [06.09], цэлмэг. Тунчуань бө-д буудаллав.

Хорин дөрвөний өдөр [06.10], цэлмэг. Иньма (飲馬河) голд буудаллав.

Хорин тавны өдөр [06.11], цэлмэг. Иньма голд буудаллав.

Хорин зургааны өдөр [06.12], цэлмэг. Иньма голд буудаллав. Тус өдөр бол зуны туйл [эхэлсэн өдөр] юм.

Хорин долооны өдөр [06.13], бүрхэг. Өглөө Иньма голоос умарш арван газарт нүүдэллэж таван голыг гаталж буудаллах газарт хүрэв. Бороотой. Үдийн хойно дахин цэлмэгшив. Бүрийгээр аянгат бороо оров.

Хорин наймны өдөр [06.14], бүрхэг. Иньма голд буудаллав.

Хорин есний өдөр [06.15], цэлмэг. Өглөөний хоолны дараа дахин Иньма голоос умарш таван голыг гатлав. Үдийн өмнө Иньма голын баруунтай Сань фөн (三峯山) ууланд буудаллав.

Зургадугаар сарын шинийн нэгний хар барс өдөр [06.18], цэлмэг. Үдээс өмнө Сань фөн уулнаас хөдөлж орой Иньма голын Чинлю ган-д буудаллав.

³ 6-р сарын 5-6-ны өдрөөс 21-22 хүртэл үргэлжилдэг.

Шинийн хоёрны өдрийн [06.19] өглөө, бага зэрэг бороотой. Өглөө Чинлю ган-аас хөдөлж Иньма голыг дагаж, хорин таван газар явав. Тэнгэр цэлмэгшихэд буудаллан үдийн хоол хийв. Үдэд дахин явж бүрий орох үед Чүншан У-д хүрэв. Усгүй харангуйгаар хонов.

Шинийн гурваны өдөр [06.20] цэлмэг. Өглөө Чуншань У-оос хөдлөв. Үдийн хойно нэгэн уулын хавцалд оров. Урт нь хэдэн арван газар. Устай. Буудаллав. Үдээр хооллов. Хоолны дараа дахин явж оройн Шуанчуань хай-д буудаллав. [Энэ газрыг] мөн салхичирт [хэмээмүй], Юань Тайзү-гийн мөрөө үлдээсэн газар болой. Хуучны ордон барилга байх бөгөөд жил бүр энд зусдаг байжээ. Уулын ам нь дугуйрсан байх бөгөөд хэдэн арван газрын өргөнтэй ажээ. Өмнө нь хоёр булаг байх агаад нэг нь давстай, нөгөө нь тунгалаг ажээ. Баруун өмнө арван газарт булгийн устай нэгэн газар буй. Чюань шуйхайзы-гийн нэгэн хэсэг байна. Баруун хойд ууланд гурван амтай ба, Иньма гол, Туул гол урсаж, [энэ нь] Ху нарын үргэлж орж гарах газар болно.

Шинийн дөрвөний өдөр [06.21], бүрхэг. Багавтар бороотой. Үдэд цэлмэг. Шуанчюань хай /Хос булгийн далай/-д (雙泉海)-буудаллав. Өмнө харуулын морьтон ирж мэдүүлэв. Харуул бүдүүлэг дээрэмчин хэдэн зуун хүн багахан тулалдаад, цөм буцахыг харав [гэлээ].

Шинийн тавны өдөр [06.22] цэлмэг. Үдэд Шуанчюань хай-гаас гарч бүрий болоход баруун хойнох Санься көү /Гурван хавцалт ам/-д хүрэв. Энэ газрыг мөн Хангалаг хэмээмүй. Усгүй. Энэ өдөр өмнө харуулын морьтон бүдүүлэг дээрэмтэй таарч тулалдан бүдүүлэг дээрмийг хэдэн зуугаар нь алахад [тэд] шөнөөр зайлав.

Шинийн зургааны өдөр [06.23] цэлмэг. Өглөө Санься көү-гөөс гарч, үдэд Цанян шя-д хүрэв.

Шинийн долооны өдөр [06.24], цэлмэг. Өглөө Цанян шя-гаас хөдөлж үдэд Хулан хошуунд буудаллав. Дээрмийн түрүү Дэлбэг, Махмуд, Тайпин, Батболд нар ойртон ирж байлдав. Хуарангаас арван газарт дээрэм дөрвөн бүлэг цугларч өндөр ууланд жагссан нь бараг гурван түм гаруй хүн байв. Хүн бүр 2-3 хөтөлгөө морьтой байлаа. Хаан нум сум агсаж, хуяг дуулга асаан, ноён цэргийг удирдан шилдгийг урьдаар явуулж эл цэрэг цөм хойноос хүрч, тэгш жагсаж, дээрэмтэй тулалдав. Дээрэм уулнаас бууж угтан байлдахад галт буугаар дөрвөнтэй галлав. Дээрэм цочиж морио орхин явав. Дахин уулын оройд цуглаж, зүүн баруунаа үймэлдэн урагшлав. Дээрэм байлдахын дагуу ухрав. Бүрий болоход хаан шилдэг хэдэн зуун хүнтэйгээ үлдэн нэхэж, үргэлжлэн галт буугаар буудав. Дээрэм дахин угтан байлдсан ч шууд тулсангүй. Галт бууг сэмээр буудаж, шилдэг цэргүүд зориг зүрхтэйгээр урагшлан хүчлэн байлдахад, нэг зуу хүрсэнгүй. Дээрэм цөм ялагдаж, шархадсан морь хүнийг тоолошгүй болов. Бүдүүлэг дээрэм өвдсөндөө ухран, шөнө зайлан одов. Туул гол хүрэхэд, хаан цэргээ хурааж хуарандаа ирэхэд хоёр жин болж байв. Тэр газарт Шаху жин /Бүдүүлгийг алсан балгас/ хэмээх нэр хайрлав.

Шинийн наймны өдөр [06.25] цэлмэг. Шаху жин-д буудаллав. Тус орой нь морьт өвсгүй, хээр болон халиун морийг алдав. Үүрээр зарлигдан дөрвөн зүгт гарч эрэлхийлээд олсонгүй. Бүрий болоход сая хуарандаа эргэн ирэв.

Шинийн есний өдөр [06.26] цэлмэг. Шаху жин-д буудаллав. Үдийн хойно хуаранг нүүлгэв. Жинь бүгдийг захирагч (金都督) хошуучлагч хоёр цэргийг зарлигдаж алдсан морийг олж авчрав. Асууж лавлахад, хуарангаас гарч арав гаруй газрын баруун хойд булаг дээр харуулын морьтон олов. Жинь бүгдийг захирагч морь гээснийг мэдэж тусгай хүргэж ирсэн юм. Цөмөөр ихэд баярлаж хоёр аяга гурилтай шөлөөр түрүүг шагнав. Тус өдөр баруунш арав гаруй газар хуаран шилжүүлэв. Орой бороо орж салхитай хүйтэн.

Шинийн аравны өдөр [06.27], цэлмэг. Тус өдөр цэргийг хөхүүлэв. Үдэд Хуйлю дянь (回流甸)-д буув. Орой бага бороотой, салхи хүйтэн.

Арван нэгний өдөр [06.28], цэлмэг. Өглөө Хуйлю дянь-ээс гарч, үдэд Саньша көү-г давав. Үлдсэн дээрэм хавцлын амны ууланд цугларч бас хэдэн зуун хүн хоёр булгийг эзлэв. Олон цэрэг мөн галт буугаар булгийг эзлэгсэдийг буудахад, дээрэм эсэргүүцэж дийлэхгүйгээ мэдээд дараалан зугатав. Үлдсэн дээрэм уулын хавцалд байснаа дахин галт буугаар буудахаас айж цөм зайлан одов. Орой нь Шуанчюань хай- д буув.

Арван хоёрны өдөр [06.29], цэлмэг. Өглөө Шуанчюань хай-гаас гарч үдээр Пиншань жэнь (平山鎮)-д буув.

Арван гуравны өдөр [06.30], цэлмэг. Өглөө Пиншань жэнь-гээс гарч үдээр Иньма голын Чинюань шыа-д буув. Тус өдөр бол бага халуун.

Арван дөрөвний өдөр [07.01], цэлмэг. Өглөө Чин Юань Шя-гаас гарч үдэд Иньма голын Пинчюань жөү (平川洲)- д буув.

Арван тавны өдөр [07.02], цэлмэг. Өглөө Пин Чюань Жөү-гээс гарч үдэд Иньма голын Чинян вань (青楊灣)- д буув.

Арван зургааны өдөр [07.03], цэлмэг. Өглөө Чинян вань-аас гарч үдээр Иньма голын Саньфөн ууланд буув.

Арван долооны өдөр [07.04], цэлмэг. Өглөө Саньфөн уулаас гарч, үдээр Иньма голыг гаталж баруун хойш Саньфөн уулын зүүн өмнө буудаллав. Хонин цагт аянгат бороо орж хэд дуслaad зогсов. Урьдаар түрүү хэдэн хүнийг томилон хуарангийн үүдэнд бараалан хаанаас цөм хувцас, торго дурдан, будаагаар соёрхож дахинтаа архи махаар дайлж тэднийг буцаав.

Арван наймны өдөр [07.05] цэлмэг. Мөн л тус газартаа буудаллав.

Арван есний өдөр [07.06] цэлмэг. Өглөө хуарангаа Иньма голын умардын хуучин хуаранд нүүлгэв.

Хорины өдөр [07.07], цэлмэг. Үдийн хойно Иньма голыг гаталж гурвантаа усыг туулан голыг дагаж хэдэн газар яваад буудаллав.

Хорин нэгний өдөр [07.08], цэлмэг. Иньма голын өмнө эргийг дагаж зүүнш хэдэн арван газар яваад буув.

Хорин хоёрны өдөр [07.09], цэлмэг. Мөн Тунчюань бө-доо буудаллав.

Хорин дөрөвний өдөр [07.10], бүрхэг. Өглөө Чиншань шыа-гаас гарч орой Мөн Шань хай-д буув.

Хорин тавны өдөр [07.11], цэлмэг. Үдийн хойно Мөншань хай (蒙山海)-гаас гарав. Зам зуур ширүүн бороо орсноо зогсов. Бүрийд Еэма чюань (野馬泉)-д буув.

Хорин зургааны өдөр [07.12] цэлмэг. Еэма чюань-аас гарч оройдоо Хуаньшю ган-д буув.

Хорин долооны өдөр [07.13], цэлмэг. Өглөө нь Хуаньшю ган-аас гарч орой нь Шуан чюань-д /Хос хөндий/ хүрч буув. Бүрийгээр дахин арван газар явж буудаллав.

Хорин наймны өдөр [07.14], цэлмэг. Луу цагт Ши чюань-аас гарч үдэд Хэйшань гү-д буув. Энэ өдөр бол их халуун.

Хорин есний өдөр [07.15], үдийн хойно Хэйшань гү-гээс гарч орой нь Цуймү дян-д буув.

Гучны өдөр [07.16] өглөө Цуймү дян-аас гарч үдэд Фүпин жэнь (富平鎮)-д буув.

Долдугаар сарын шинийн нэгний өдөр [07.17] өглөө, Фүпин жэнь-ээс гарч, үдэд Юйдай чуань (玉帶川)-д буув. Их салхитай. Багавтар бороотой.

Шинийн хоёрны өдөр [07.18], цэлмэг. Их салхитай. Мөн л Юйдай чуань-д буудаллав.

Шинийн гуравны өдөр [07.19], цэлмэг. Өглөө Юйдай чуань-аас гарч, Хуай юань сай (懷遠塞)-д буув.

Шинийн дөрвөний өдөр [07.20]. Өглөө Хуай юань сай-гаас гарч, үдээр Гуан Ү жэнь (廣武鎮)-д буув. Хорин газар өнгөрөөд буудаллав. Үдийн хойно их салхитай. Багавтар бороотой.

Шинийн тавны өдөр [07.21], бүрхэг. Өглөө Гуан Ү жэнь-ээс гарав. Үдийн өмнө Шянчюань шү (香泉戌)-г өнгөрөөд, үдийн хойно Чиньху (禽胡山) ууланд буудаллав. “Бүдүүлгийг төвшитгөсөн зарлиг”-ийг бичив. Энэ орой бүгдийг захирагч (都指揮) Ли Ин (李英)-ийг дотоод түшмэл (中官) Жи (齋)-тэй хамт илгээж, Бээжинд буцаав.

Шинийн зургааны өдөр [07.22], цэлмэг. Өглөө Чиньху уулаас гарч, үдэд Янлин шү (楊林戌)-д буув. Шөнө бороо оров.

Шинийн долооны өдөр [07.23], бүрхэг. Өглөө Янлин шү-гээс гарч, үдэд Гүйхуа дян (歸化甸)-д буув. Орой бага бороотой байснаа цэлмэв.

Шинийн наймны өдөр [07.24], бүрхэг. Үдийн өмнө Гүйхуа дян-аас гарав. Зам зуур бороо орлоо. Орой Чинфөн хө (清風壑)-д буув.

Шинийн есний өдөр [07.25], бүрхэг. Өглөө Чинфөн хө-гөөс гарч, үдээр Жигү жэнь (雞轂鎮)-д буув. Үдийн хойно хуарангаа босгож, орой Шюаньшы пө (玄石坡)-д буув.

Шинийн арваны өдөр [07.26] цэлмэг. Өглөө Шюаньшы пө-гөөс хөдөлж, үдэд Юйшюэ ган (玉雪岡)-д буув. Үдийн хойно хөдөлж, орой Түньюнь гү (屯雲谷)-д буув.

Арван нэгний өдөр [07.27], цэлмэг. Өглөө Түньюнь гү-гээс хөдөлж, үдэд Чиншүй юань (清水源)-д буув.

Арван хоёрны өдөр [07.28], цэлмэг. Өглөө Чиншүй юань-аас хөдөлж Дагань чюань (大甘泉)-ийг өнгөрөв. Орой нь Шяогань чюань (小甘泉)-д буув.

Арван гуравны өдөр [07.29], цэлмэг. Өглөө Шяогань чюань-аас хөдөлж үдэд Жиньюнъчи (錦雲磧)-д буудаллав. Хаан хонь шарж, архи соёрхохыг зарлигдав. Энэ өдөр бол намрын уур [орсон өдөр юм].

Арван дөрвөний өдөр [07.30], бүрхэг. Өглөө Жиньюнъчи-гээс хөдөлж, үдэд Лунша дянъ (龍沙甸)-д буув. Үдийн хойно бороо оров.

Арван тавны өдөр [07.31], бүрхэг. Өглөө Лунша дянъ-аас хөдөлж үдэд Шалу чөн (殺虜城)-д буув. Бороо шивэрч байснаа орой [тэнгэр] цэлмэв.

Арван зургааны өдөр [08.01], цэлмэг. Өглөө Шалу чөн-гээс хөдөлж, Гаопин фу (高平阜)-г өнгөрөв. Бороо оров. Үдийн хойно У Юнь гуань (五雲關)-д буудаллав. Улмаар уулыг өнгөрөөд хорин газар яваад буудаллав.

Арван долооны өдөр [08.02], цэлмэг. Өглөө У Юнь гуань-аас хөдөлж Дашы жэнь (大石鎮)-ийг өнгөрөв. Үдийн хойно Лин Шяо Фөн (凌霄峯)-д буув. Хаан хонь шарж, архи соёрхохыг зарлигдав.

Арван наймны өдөр [08.03] цэлмэг. Өглөө Лин Шяо Фөн-өөс хөдөлж үдэд Хун Чяо (紅橋) /Улаан гүүр/-д буув.

Арван есний өдөр [08.04], цэлмэг. Өглөө Хун Чяо-гаас хөдөлж үдээр Шинхө (興和)-д буув.

Хорины өдөр [08.05]. Мөн Шинхө-д буудаллав.

Хорин нэгний өдөр [08.06], цэлмэг. Өглөө Шинхө-гээс хөдөлж Ехулин-г өнгөрч Дө шөн көү-г өнгөрөх [үед], хүн морь цугларан, морьд шаварт шигдэж, Тү Чөн-г өнгөрөх үед гайгүй болов. Үдийн хойно Вань Чюань-д буув. Их салхитай, бороотой. Морьд өвсгүй. Түлээгүйн [учир] оройн хоол хийж чадсангүй.

Хорин хоёрны өдөр [08.07], цэлмэг. Өглөө Вань Чюань-аас хөдөлж, үдэд Шюаньфү-д буув. Үдийн хойно бороо ороод Гөн Жин хүрэхэд бороо зогсов.

Хорин гурваны өдөр [08.08], цэлмэг. Өглөө нь Шюаньфү-гаас мордож, Гуан Да-гийн хамтаар хот руу орж Же Вэнфу (解文夫)-тай уулзаж, хэсэг хугацаанд үлдэж даруй салав. Үдийн хойно Ни голд буудаллахад бороо оров.

Хорин дөрөвний өдөр [08.09], бүрхэг. Өглөө нь Ни голоос мордож, үдэд Жимин ууланд буув. Зам зуур шиврээ бороотой. Орой хаан тоор болон хонины мах, архи соёрхохыг зарлигдав.

Хорин тавны өдөр [08.10], цэлмэг. Өглөө Жимин уулаас хөдөлж, үдэд Түмү-д буув.

Хорин зургааны өдөр [08.11] цэлмэг. Өглөө Түмү-гээс хөдөлж, үдэд Хуайлай-д буув.

Хорин долооны өдөр [08.12], цэлмэг. Өглөө Хуайлай-гаас хөдөлж, үдэд Юнаньдянь-д буув.

Хорин наймны өдөр [08.13], бороотой. Энэ өдөр бол газрын халууны [улирал] амуй. Өглөө Юнаньдянь-аас хөдөлж, Цавчаал боомтыг өнгөрч, үдийн хойно Шиньдянь-д буув. Ширүүн бороотой. Гэрийн зарц нар ирж тосов. Орой нь Гуан Да,

Мянь Рэн нар зарлигийг дагаж, түрүүлэн харив. Мянь Рэн хуучин замаараа баруун тийш явахад, үлдсэн нь Гуан Да-тай Шиньдянь-ийг өнгөрөн, гүүрийг давж зүүнш явав. Бүрий болоход нэг тосгонд орж айлд хонож авч явсан архиа хамтаар идэж тэр дороо унтацгаав. [Хаан] шөнийн хагасыг өнгөрсөн ч цурам хийсэнгүй.

Хорин есний өдөр [08.14], гурван жингээр босч хөдлөв. Лаа асаан арван газар явж Чанпин-гийн их замд оров. Шахө-д хүрэхэд үүр цайв. Айлын гэрт орж, хоол хийж идээд, хоолны дараа цааш замнав. Чин голыг өнгөрөх үед ширүүн бороотой, зам усаар дүүрч, шавар шавхай маш их байлаа. Үдийн хойно, гэртээ хүрэв.

Наймдугаар сарын шинийн нэгний [08.15] өглөө, [тэнгэр] цэлмэг. Бичиг цэргийн олон түшмэд [эзэн хааны] хөсөг тэргийг угтахад [эзэн хаан] Энх тогтох хаалгаар оров. Дээр харшид залрахад олон түшмэд “Бүдүүлгүүдийг төвшитгөсөн бодрол бичиг”-ийг дэвшүүлэн өргөж, баяр хүргэн, [эзэн хаанд бараалхах ёслол] тарав.

МАЛЧНЫ ХҮҮ

А.Цэрэнчулуун⁴

Тэр үед, миний хүүхэд ахуй цагт хүмүүс хүүхдээ сургуульд явуулах тун дургүй байсан үе. Харин ч би азтай шүү, аав бичиг үсэг мэддэг, тоо бодож чаддаг байсан тул надад цагаан толгойн үсэг зааж, тоо бодож сургасан байлаа.

Хүүхэд нас:

1945 оны 9-р сард би 11 настай Богд сум -ын бага сургуульд орлоо. Бас хэдэн долоо хоногоор хожимдоод шүү. Намайг хүүхдүүдийн ард нэг урт бандан дээр суулгаад цагаан толгой бичүүлэв. Би ч мэддэг болохоор түргэн гэгч нь зөв биччихлээ. Намайг бусад хүүхдүүдтэй адил нэг партанд суулгав. Тэдний хийж байгааг адилхан хийхийг зөвшөөрлөө.

Хагас жилээр онц гарлаа. Сайн сурлагатай гээд ангийн дарга болгов. Бодвол онц сурлагатай хүүхдийг ангийн дарга болгодог байсан юм болов уу даа. Намайг гэртээ суулгаж байсан айл их сайн айл байв.

Намайг 2-р ангид орох жил нөгөө сайн айл маань хөдөө гарах болж, намайг хоршооны дарга Жамбал гэдэг айлд суулгадаг юм байна. Одоо чи хуучин сурагч болсон болохоор ганцаараа яваад сумын төв хүрч чадна гээд ээж намайг сумын төв хүргэж өгсөнгүй. Бас ес эхэлтэл эргэж очиж чадахгүй гээд үзүүрсгэн дээлээ авч явах болов. Дотуур хувцас, хичээлийн хэрэглэл, суух айлдаа өгөх ааруул, гүзээнд хийсэн өрөм нийлээд дааж ядсан их ачаатай болов.

Авч явах юмаа бага болгохын тулд үстэй дээлээ өмсөж орхилоо. Сумын төв дээр нөгөө суух айлдаа очсон хүн алга. Өнөөдөр сумын наадам болж байгаа гэнэ. Сумын төвийн бүх хүмүүс тэнд наадаж байгаа ажээ. Авчирсан юмаа гэр дээр нь тавьчихаад наадмын талбай дээр очлоо. Бөхийн барилдаан эхэлж байна. Нэг гоё ногоон торгон тэрлэгтэй хүн ирээд намайг барилд гэж байна. Үгүй би барилдахгүй, үстэй дээлтэй яваа, хүмүүсийн өмнө гарахаас ичиж байна гэсэн авч хэлэлцдэггүй. Тайлбар тавихгүй, шууд л барилд, гүйцээ гэлээ. Хөөе, тэр үстэй дээлтэй хүүхэд явж байна гээд хүмүүс нэг нэгэндээ шивгэнэж байна. Эвэртэй туулай үзсэн юм шиг харцгааж байна. Бөхийн талбай дээр гараад ирсэн манай багийн нэг хүү зогсож байна. Барьж аваад тонгорчихлоо. Тэгсэн биш, чи энэ хүнтэй барилдана гэнэ. Тэр нь нэг том хүн байна. Шууд давхиад орсон өнхрөөд өглөө. Гэвч би том алдаа гаргажээ. Багийн дарга гэж тийм нэр хүндтэй том хүнийг нэг муу нусгай жаал унагаж болохгүй гэдгийг хэрхэн мэдэх вэ дээ. “Манай багийн дарга нээрэнгээсээ унаагүй, тооцохгүй ээ” гээд нэг нь хашгирч байна. Хоёр хүн унагасан боловч, алийг нь ч тооцсонгүй.

Тэр жилийн Богд сумын наадамд улсын начин Аюуш хэмээх хүн түрүүлээ. Тэр хүн сүүлд улсын наадамд түрүүлж, заан цол хүртсэн билээ.

Энэ айлд нэг жил болоход чамгүй их зүйл хийж сурлаа. Мөс шиг хүйтэн гэрт өглөө эхлэн босч зууханд галлана. Сүх авч, араг үүрээд гол руу явж даахынхаа

⁴ Орчуулагч, судлаач

хэрээрээ мөс үүрч ирнэ. Заг хугачина. Загийн нэг үзүүрийг нэг чулуун дээр дамнуулж, нөгөө үзүүрийг газар тавиад, өөр нэг арай том чулууг хөндий байгаа цэгийг оноон шидэхэд яг эгц хугална. Хэрэв сүхээр цохих юм бол хатуу загийн үзүүр нь үсрээд толгой, нүүр ам онож мэднэ. Тийм учраас говийнхон заг хагалахдаа зөвхөн хоёр чулуу хэрэглэж заншсан билээ. Бас оройн хоолны гурил зуурч, хавтгайлж элдэж, жигд нарийхан хэрчинэ. Харин миний идэх хоолны хувь бол авсаархан. Өдөр жаахан хуймаг, орой бол нэг аяга гурилтай хоол эсвэл хонь юм уу ямааны нэг богтос, богино хавирга зэрэгхэн оногдоно.

Ээж намайг эмчлэв:

Хавар хичээл тарахад ээж нэг хөтөлгөө тэмээтэй ирж, намайг хөдөө гэрт аваачлаа. Миний бие базаахгүй, нэг нүдэнд нь цагаа унаад бараг юм харахаа больчихсон, шилэн дээгүүр хатиг дүүрчихсэн, бас нэг хөл өвдөөд доголчихсон байв. Ийм нэгэн хүүгээ аваад ээж минь гэртээ ирлээ. Ээжийн аав “Ламын гэгээний хийд”-ийн маарамба байсан гэдэг. Тэр лам ээжид нүдэнд цагаа унах өвчнийг маш сайн анагаадаг “пэлдэн” хэмээх нэгэн чухал эм өгчээ. Хүмүүс “пэлдэн шиг эрхэмлэн хадгалах” гэж ярьдагийг бодоход тун чухал эд байсан байж таараа. Тэр нь одоо бодоход нэг шар будааны дайтай чулуу ч шиг хатуу юм байсан санагдана. Эхлээд нүд нухаж байснаа сүүлдээ больсон. Нилээн хэд хоноод юм харах нь үү, үгүй юү гэж нэг туршиж үзлээ. Гэрэл гэгээ мэдэрч байна. Баярлаад ахиад даруулан боолгож орхилоо. Дахиад нэлээд хоносны дараа нүд маань зөв зүгээр болсон, дажгүй сайн харж байлаа. Ийнхүү пэлдэн гэж нэг тийм сайн юмаар ээж маань миний цагаа унасан нүдийг эмчилсэн юм. Сумын эмнэлгийн сувилагчийн өгсөн эмийг хүртэж, айраг, сүү ууж, цагаан идээ идээд, эрүүл агаарт байгаад хатиг маань ч арилж, хөл маань ч гайгүй болж, гүйж харайхтайгаа болов. Монгол нутгийн агаар, байгалийн цэвэр бүтээгдэхүүн хоол, хүнс над тус болсон хэрэг.

Аав багийн агентаар ажиллаж, тооцоо гаргахад нь би тусалдаг байлаа. Бас үржүүлэхийн хүрдийг хэдийн цээжилж, хятад сампин дээр дөрвөн аргын тоо бодож сурлаа. Энэ сампин дээр 379,25 гэсэн тоо хийсэн байна. Хятад сампин 13 эгнээ голтой, өөрөөр хэлбэл 13 оронтой тоо хийж болно гэсэн үг. Голдоо модон хөндөлтэй. Хөндлийн зүүн гар талд тав, баруун гар талд хоёр эрхитэй. Хоёр эрхиний нэгийг таван эрхинд тооцож буулгана. Хятад сампинд тоо бодоод сурчихсан хүн, одоогийн тооны машин дээр тоо бодохоос бараг хоцрохгүй байх. Зүгээр ч үгүй “эрхий нь цуцахгүй, эрхи нь гацахгүй бол алдах гэж үгүй” гэсэн бардам үг гарсан хэрэг.

Би агент боллоо:

Төдөлгүй аав агентаар ажиллахаа болив. Хоёр жилийн боловсролтой би гэдэг хүн ийнхүү Баянхонгор аймгийн Богд сумын 4-р багийн агент боллоо. Агентийн урамшуулал сарын 50 төгрөг байв. Тайлан гаргаад мөнгө дутвал түүнээс суутгана. Агент сумын хоршооноос цай, гурил, будаа, элчин чихэр аваад өөрийнхөө унаагаар багийнхаа хүмүүст хүргэж, худалдана. Намайг сумын агентаар ажиллаж байх үед зарим төрлийн хүнсний бараа хөдөөд ийм үнэтэй байв. Үүнд:

1 ширхэг шахмал орос цай	10,00 ₮
1 килограмм элсэн чихэр	4,00 ₮
1 килограмм 1-р гурил	1,60 ₮
1 килограмм кг 2-р гурил	1,00 ₮
1 килограмм шар будаа	1,00 ₮
1 килограмм цагаан будаа	2,20 ₮
Сумын зарим нэг албан хаагчийн сарын цалин	
Сумын дарга	450,00 ₮
Сумын намын үүрийн н/б дарга	450,00 ₮
МХЗЭ-ийн үүрийн н/б дарга	300,00 ₮
Шүүхийн дарга	500,00 ₮
Багийн дарга	80,00 ₮
Агент	50,00 ₮
Түүхий эд бэлтгэлийн үнэ	
1 ширхэг үнэгний арьс	21,00 ₮
1 ширхэг хярсны арьс	6,00 ₮
1 ширхэг мануулын арьс	6,00 ₮
1 ширхэг хөлдөөсөн ятуу	1,50 ₮
1 ширхэг хөлдөөсөн ногтруу	1,50 ₮

Жинд явлаа:

Т.Нацагдоржийн 1936 оны шүлэг
 Идэр жинчин
 Алс холын замаар
 Алхлан сажлан туулж
 Аян жингийн хүндийг
 Амар сайнаар нэвтрүүлэгч
 Атан олон тэмээд минь
 Арын говийг бүрхжээ.
 Шингэн лимбийн дуугаар
 Миний нутгийг санагдуулж
 Ширээ тэгшхэн бөхөөрөө
 Жингийн хүндийг өргөгч
 Шилдэг олон ат минь
 Шилийн говийг бүрхжээ.

Идэр жинчин бид
 Эрэмгий чадлаа гаргаж
 Ингээд аяны замаар
 Эрх тааваараа туулаад
 Энэ орны ардыг

Эд бараагаар хангацгаая.

Манай багийн айлууд гурил, будаа, цай, давс гээд ер нь идэх юмаар тун дутмаг, тарчигдуухан амь зуудаг байлаа. Сумын хоршооны дэлгүүрт ч тэр болгон зүйл байхгүй байсан цаг. Улаанбаатар руу тэмээн жингээр түүхий эд тээвэрлээд буцаж ирэхдээ хүнсний зүйл: будаа, гурил, цай болон өргөн хэрэгцээний бараа авчран малчдынхаа хэрэгцээг бүрэн хангаж орхимоор санагдаад болох биш ээ. Энэ санаагаа аавд хэлэх гэсэн эмээгээд байдаг. Нэг өдөр аавдаа хэлэх гэтэл аав гэртээ цааш хараад дээс томоод ер завгүй, юм сонсох шинжгүй. Ээждээ хэллээ. Би жинд явмаар байна, та аавд хэлээд өгөөч, би өөрөө хэлэхээсээ нэг л эмээгээд байна гэлээ. Ээж гэрт орлоо. Ээж, аавд хэлж байна. Өөрөө тэгэж байна уу? хэмээн аав лавлаж байна. Эр хүн болж байгаа нь тэр дээ. Тэгвэл явуулдаг хэрэг ээ гэж байна.

Манайх 40-50-иад тэмээтэй байсан юм. Аавын зөвшөөрсөнд би гэдэг хүн баярлаж байгаа гэж жигтэйхэн. Жинд явна гэдэг их л сайхан санагдана.

Тэмээний хом:

Тэмээний хом нь тэмээг ачаа дарж нухах, холгохоос хамгаалдаг болой. Тэмээг хомнохдоо 1 ширхэг урт хомон ширдэг, 2 ширхэг бамбай ширдэг, хоорондоо дээсэн холбоо бүхий хоёр шат мод, шатны тушаа хоёр дээснээс бүрдэнэ. Таван эр хүн 40 орчим тэмээнд малын ноос, хялгас ачиж аваад Улаанбаатарын зүг хөдөллөө. Өлзийт сумын Довгор хэмээх нэгэн туршлагатай эр жингийн даамлаар явав. Би хорин тэмээ ачаатай, сумынхаа нэг арай ахмад хүнтэй цуг явж байна. Ноосоо тааран шидмэгт хийн олсоор дөрвөлжлөн хүлэв. Нэг шидмэг 100 орчим килограмм жин татна. Нэг тэмээнд хоёр шидмэг буюу хоёр тэн ноос тэгнэнэ. Хомтойгоо нийлээд нэг тэмээнд 250 килограмм орчим ачаа ноогдоно.

Хоёр хүн 20 тэмээ ачааг хэрхэн авч явсан бэ?

Эхний ачаатай тэмээний бурантгийг жингийн ахлагч гартаа хөтлөөд нэг жигд яаралгүй алхуулна. Хоёр цувааныхаа эхний тэмээдийг нөгөө ачаатай тэмээнийхээ буруун, зүүн гар талаас нь сэлхэрнэ. Жингийн цувааны эхэнд бага, залуу тэмээг хөтөлдөг, том биетэй тэмээ хөтлөх юм бол арын тэмээд алхааг нь гүйцэхгүй ядардаг юм. Тэмээдийн бурантгийг уртхан шиг тэмээ явуут дундаа бут зулгаах боломжтой хавчуулдаг. Бас угзрахад амархан хөврөх боломжтой хавчуулахгүй бол тэмээ хамраа гэмтээх, буйлаа хугалах аюултай. Хоёр дахь хүн цувааныхаа ард явж, суулт хөөгч болон, тэмээ замдаа алдуурч үлдэхийг ачаа суух гэнэ. Тэр хүн тэмээ сууж үлдэх, ачаанаас юм унах зэргийг сайн анхаарч явах үүрэгтэй. Зарим жингийн цувааны сүүлчийн ачаатай малын хүзүүнд хонх зүүн дуугаргаж явдаг. Гурав дахь хүн жингийн даамал байх бөгөөд эхэнд нь цувааны ахлагчтай зэрэгцэн явах бөгөөд зарим үед түрүүлэн явж замын бартаа, эрэг, гуу жалга, хальтаргаа гулгааг ажиглан жингийн цуваагаа хаагуур явуулахыг шийднэ. Жинг эхлэхэд хөсөг ямар дараалалтай байсан тэр дарааллаар нь жин дуустал явуулна. Жинд гарахын өмнө тэмээгээ 2 долоо орчим бага идүүлж, уяж, сойно. Үнсэн дээр уяна. Жинд явахдаа жигд яаралгүй явна. Их удаан явбал, амархан эцэж турна. Их хурдан явбал улдана.

Ус, өвс, тэмээний хүч тэнхээ, ачааны байдлаас шалтгаалан жинг дөрвөн янзаар явуулдаг. Үүнд:

1. Идэр халх

Шөнийн 11 цагийн үед ачиж марал, мичид хөөрөх үед хөдлөөд шөнөжин явсаар маргааш өглөөний нарнаар түр зогсож, тэмээдээ шээлгэж, жинчид бэлэн хоолоо идээд, явсаар байгаад өдөр үдээс хойно бууж, тэмээгээ нэг нь хариулж идээшлүүлэн хоёр дахь хоол цай хийж, гурав дахь ачаа бараагаа янзална. Нар жаргахын урдхан тэмээгээ хурааж, ээлжлэн амраад, марал мичид хөөрөх үед ахин хөдөлнө. Нэг удаад нэг бүтэн шөнө, өдрийн хагас аялна. Нэг удаагийн аялал 18 цаг орчим үргэлжилнэ.

2. Хөгшин халах

Шөнө хагаслан хөдлөөд маргааш дээр нартайд бууна. Ийнхүү бүтэн өдөр, шөнийн хагас хугацаанд аялна. Нэг удаагийн аялал 16 цаг орчим үргэлжилнэ.

3. Хөх харчин

Үүрээр буугаад нар ханын толгойд ирэхэд ачаалан хөдөлнө. Нэг удаагийн аялал 17 цаг орчим үргэлжилнэ.

4. Үдтэй харчин

Шөнө дундыг өнгөрөөж буугаад өглөө хөдлөөд дээр нартайд бууж, үдлээд дахин хөдлөөд шөнө хагасыг өнгөрөөж бууна. 15 цаг ийн турш аялна.

Алинаар ч аялсан нар тусангуут зогсон “шээр шээр” гэж хэлэхэд бүх тэмээ зэрэг шээдэг байна. Тэмээ өглөөд босоод шээдэг амьтны байгалийн зохицлыг жинчид ийнхүү ашигладаг. Атан тэмээний нэг удаагийн шээх хугацаа 30 минут орчим үргэлжилдэг. Тэмээг өглөө, үдээс өмнө усална. Аяны эхэнд аль маягаар явахыг ярьж тохирно. Тэгээд тэр л маягаараа явж дуусгана. Өглөө барагцаалбал бага үдийн алдад буюу 11 цагийн орчимд ачаалаад, өдөржин, шөнө хугасалж яваад үүр цайх шахуулж буудаллаж, ачаагаа буулгаад тэмээгээ амрааж, өөрснөө хоолоо хийж идээд хоноглоно. Өглөө эрт тэмээдээ идүүлж, услаад мөн л бага үдийн алдад буюу 11 цагийн орчимд ачаалж эхлээд замд гарна. Жинд явах гэдэг санасныг бодоход амар ажил биш, жинхэнэ эрийн чадал, тэвчээр сорьсон айхтар ажил юм билээ. Цас, борооны усанд норсон олс дээс чивчирчихнэ. Дээс -ний цаагуур гар орохгүй, хуруу хөндүүр болж орхино. Нойр хүрээд тэмээн дээрээ үүрэглэж гарна.

Хайрхандулаан сумын нутагт ирээд нэг хар атанд “ороох” гэдэг өвчин тусаад хойд хоёр хөлөө хөдөлгөж чадахаа болиод хоцорлоо. Уул нь хатгаж, ханаад эдгээдэг гэнэ. Тэгдэг хүн бидний дотор байсангүй. Тэр нутгийн нэг өвгөнд захиад орхилоо. Манай энд чоно элбэг идчихвэл надад хамаагүй шүү гэж байна. Нутгаас гараад хоёр долоо хоног яваад Хөшигийн давааг давж, Арвайн тал, Гэрлийн тал хэмээх хоёр их талыг туулаад хамгийн сүүлд Туул голыг өгсөн 3 өдөр яваад Улаанбаатарын Буянт Ухаагийн онгоцны буудалд орж ирлээ. Онгоцны буудал дээр хэдэн жижиг онгоц сойлттой харагдаж байлаа. Уул нь жинчид 16 хоног явдаг гэсэн. Манай жингийн дарга жаахан довтолгосон шиг байгаа юм. Яармагийн гүүр гэж Туул гол дээгүүр тавьсан хоёр салаа модон гүүр байв. Урд талын гүүрээр нь гараад өглөө эрт Үйлдвэр комбинат дээр ирвэл, Өмнөговийн олон жинчид ирчихсэн байна. Орой нь ч ирсэн

юм уу, ноос, хялгасаа тушааж байна. Бид ч ноос, хялгасаа тушаах гэж ноцолдсоор байгаад бүр харуй бүрий болсон хойно ажлаа дуусгав. Ядарсан тэмээд хэвтэн тусаад, бид яарч сандран байж, бараагаа буулган, том том пүүн дээр давхарлаж тавиад жинлүүлж дараа нь төмөр дэгээ барьсан монгол, хятад, япон хүмүүс түргэн, түргэн аваад явчих юм. Бид ч өрсөлдөн санд мэнд олсоо тайлж, мулталж авч байлаа. Ашгүй ноосны маань жин хэмжээ ч сайхан таарлаа. Тэмээд маань ачаанаасаа салж, бид ч бараагаа тушааж, нэг амс хийв. Орой харанхуй болоход, гэдэс өлсөж байгаа ч гэж жигтэйхэн. Дунд голыг дагаж явж, нэг тохойд буудаллаа. Тэмээдээ уяад, эсгийгээр нэг оромж барьж, хоол цай чанаж идлээ. Жингийн даамал Довгор гуай тэмээдээ сайн харж байгаарай гэж байна. Өглөө боссон миний нэг тэмээ буйлаа хугалаад алга болсон байлаа.

Тэмээний эрэлд:

Довгор даамал ч их ууртай байна. Чи одоо хоёр тэмээний өрөнд уналаа л гэнэ. Хайрхандулаан суманд нэг ат өвчин олгоод орхисон, одоо нэг тэмээ алдаж орхилоо. “Санаа сохор бол нүд сохор” гээд л загнаж гарав. Цай ч орох юм биш, өглөө эрт босоод тэмээнийхээ эрэлд гарлаа. Эхлээд ирсэн зүг рүүгээ явлаа. Яармагийн зүг хайлаа. Жинчид буцаж байна. Тэмээгээ хоёр эгнээ болгоод хөтөлчихсөн явах юм. Эхлээд баруун гар талаар нь яваад тэмээгээ хайлаа. Яармагийн хойд талын модон гүүрээр амдаад гарах гэсэн нэг буутай хүн зогсчихоод үүгээр гарахгүй, үүгээр чинь машин, тэрэг явдаг юм түүгээр яв гэнэ. Буцаад л урд талын гүүрээр нь гараад очвол нөгөө аянчид аль хэдийн яваад өгчээ. Хойноос нь довтолгож явж нэг юм гүйцлээ. Тэмээгээ сураглалаа, тоож байгаа хүн ч алга. Энэ хүүхэд юу яриад байна аа гэх шүү юм хоорондоо ярьж байна. Өдөржин ингэж эрээд харанхуй болж орхив. Алдсан тэмээгээ олох байтугай буусан газраа эргээд олохгүйд хүрдэг юм байна. Дугуйтай, явган хүмүүс ганц нэгээрээ явж л байх юм. Хааяа нэг шонгийн модноос гэрэл зүүсэн байх юм, тэр нь тэндээ ёлтойчихоод гэрэлтүүлж гийгүүлж байгаа юм ч алга. Дугуйтай хүнээс тэмээ үргээд болох биш, буугаад тэмээгээ хөтөллөө. Ашгүй нөгөө гол маань дайралдаж, голоо дагаж яваад буусан газраа олж ирлээ. Даамал ч царай өгөхгүй байна. Нэг цай уусан болоод хэвтлээ. Цуг яваа, надаас хэд ах Өлзийт сумын Жанцанд маргааш хоёулаа тэмээнд явъя гэвэл" тэгье" гэж байна.

Энэ удаа хотоос зүүн тийш явж эрлээ. Сураглалаа. Гандан хийдийн урдуур яваад одоогийн 1-р хорооллын орчим, ирвэл нэг хар модон шургааган хашаа байна. Дотор нь жинчид тэмээгээ уясан байх ажээ. Гурван залуу гарч ирж байна. Бүгдээрээ бидний ижил хар бараан царайтай аянчин хүмүүс байна. Тэмээгээ сурсан үзээгүй л гэнэ. Нэг нар салхинд борлосон үрчгэр хар царайтай өвгөн гадаа сууж байна. Бид хоёр ч явлаа. Гэтэл нөгөө өвгөн араас дуудаж байна. Эргээд очсон, та нар тэмээ эрж яваа юм бол тэмээгээ шүүж үзэх хэрэгтэй. Дан ганц сургаар олохгүй шүү дээ гэнэ. Хашаанд ороод үзсэн, эрж яваа тэмээ маань уяатай байна. Шинэ буйл хийчихэж, хомыг нь буулгачихаж. Өвгөнд баярлаж байгаа гэж жигтэйхэн. Юм өгч баярлуулмаар байдаг. Юугаа өгөх вэ? Олж авсан тэмээгээ өгөлтэй биш, Арвайхээрээс авсан миний ганц гангараа болсон нарийн цагаан эсгий гутлаа тайлаад өгөлтэй ч биш. Надад нэг гар хийцийн сайхан тонгорог байдаг юм.

Түүгээрээ би мах иднэ, тэмээний буйл зорно. Надад их хань болдог эд байв. Хаана л хутга хэрэглэж болох газар байна, түүнийгээ би бахархалтай гэгчээр гаргаж ирнэ. Буцаж очоод нөгөө хутгаа “май үүнийг танд” гээд өгч орхивол дуртай нь аргагүй авч байна. Та хаанахын хүн бэ гэсэн. Өвөрхангай аймгийн Нарийн Тээл сумынх гэнэ. “Мунхагийн ухаан үдээс хойш” гэж хэзээ хойно нэрийг асуухгүй яав даа гэж бодож байна. Тэмээгээ олж хөтлөөд очвол Жингийн даамал маань баярлаж байгаа гэж жигтэйхэн. Хоол цай ч сайхан орж байна. Хичнээн их өлсөж явснаа сая л нэг мэдлээ. Би гурав хоног хотод үлдлээ.

Жингийн даамал шийдвэр гаргаж байна. Чи бичиг үсэгтэй хүн хотод үлд, Октябрийн баяр өнгөрч ажил цуглахаар төв бараа бааз дээр очиж, захиалгаа өгөөд байж бай. Би чамайг Лувсанвандан ахынд аваачиж орхино гэлээ. Их эрдэмтэй хүн бий. Маршалтай байнга ярьж байдаг, маршал гадаад яваад ирэхдээ энэтхэг шатар авчирч өгсөн байна билээ. Бид хэд хоног тэмээгээ идүүлж, амраагаад ирнэ гэнэ. Тэгэлгүй яахав, ачааны хүндийг тэмээд маань л үүрч зовж яваа юм хойно доо. Хэд хоног тэмээгээ амрааж, идүүлээд авбал аятай юу даа гэсэн юм бодогдож байна.

Ингээд Лувсанвандан гуайн гэдэг айлд намайг аваачив. Эхнэр нь хэдэн хүүхэдтэйгээ байна. Өрхийн тэргүүн алга. Ажилдаа явсан дэгээ. Орой нь нэг том шар халзан хүн ирлээ. Энэ хар хүүхэд юун хүн бэ? гэж байна. Жинчин гэнэ. Довгор ах авчирч орхиод явсан юм гэж байна. Лувсанвандан гуай нэг хайрцаг заагаад чи үүнийг мэдэх үү гэж байна. Мэднэ ээ л гэлээ. Юу юм? гэж байна. Хайрцаг гэлээ. Инээж байгаа гэж жигтэйхэн. Араажав гэдэг юм гэнэ. Нэг юм эргүүлээд тор гэсэн хүн яриад эхэллээ. Дотор нь хүн багтмааргүй юм. Араар нь шагайж харлаа, хүн алга. Тэгсэн нөгөө хайрцаг “Солонгосын байдал тун хүнд байна. Тэнд дайн болж байна. БНМАУ-аас Хойд Солонгос улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Жамсрангийн Самбуу ойд амьдрахад хүрч байна” гээд л ярьж байна. Солонгос ч гэж хаана байдаг юм бүү мэд, Самбуу ч гэж хэн билээ. Мэдэхгүй юм. Бодвол ойрхон л байдаг байх гэсэн юм бодогдож байна.

Хоттой танилцсан минь:

Хоёр гурван өдөр хотоор тэнэлээ. Үйлдвэр комбинатад монгол, хятад, орос, япон хүмүүс ажиллаад, ёстой түм түчигнэж, бум бужигнаж байлаа. Өргөн төмөр замыг оросууд тавьж байна. Орос хүмүүс биднээс монгол хэлээр тамхи, чүдэнз гуйж байна. Тэр үед тамхи татаж сураагүй байсан тул юугаа өгөх вэ дээ. Хүмүүс нэг дан байшинд ороод байна. Ороод очсон кино гарч байна. Дандаа оросууд байна. Нүцгэн хөлтэй, том гэгчийн үстэй малгайтай хүүхнүүд сууж байна. Нэг дасаагүй үнэртэй газар байна, тэвчсэнгүй гараад явлаа. Өлсч байна, нэг мухлагт орсон нэг өвгөн хужаа гоймон, гурилан боов зарж байна. Том, дунд, жижиг төрөл бүрийн еэвэн байна. Би нэг тогооны таг шиг том “еэвэн” авлаа. Бас “сарлаг” гэж сүүтэй чихэр байна. Нэг кикийг авлаа. Еэвэнгээ жаахан мэрлээ. Чихэрнээсээ хэдийг идлээ. Юм уумаар болж байна. Нэг байшинд хэдэн хүмүүс ширээнд суучихсан хар цай шиг юм аягалаад тавьчихсан балгаж тавиад л сууж байх юм. Хөдөөнийхөө зангаар тоох ч үгүй нэг аягатайг аваад балгасан хачин жигтэйхэн амттай, сайхнаасаа муухай нь дийлсэн юм байна. Нөгөө хүн уурлаж байгаа гэж жигтэйхэн, чиний энэ уусан юмыг чинь хэн уух

юм гээд загнаж байна. Золтой л барьж авч зодсонгүй өнгөрлөө. Тэр нь ч тийм хүн уумаар сайхан юм биш л дээ. Манай хөдөө бол тэр цагт, хэн нэгний ууж байсан аягатайг амсаж үзэх гэдэг тийм сүртэй айхтар юм ч биш л байлаа л даа.

Төв бараа бааз дээрх адал явдал:

Баярын дараа ажил цуглахад барааныхаа захиалгыг өгөхөөр төв бараа бааз дээр очлоо. Номер авсан уу гэнэ. Барааны захиалга авдаг хүн нь Баянхонгор аймгийн Өлзийт сумын харъяат Адъяа гэж нэг сайхан, ганган залуу байна. Номергүй бол болохгүй, чи маргааш эрт ирээд номер аваад ир гэж байна. Маргааш өглөө нь эрт хүрээд очсон хоёр гурван хүн ирчихсэн зогсож байна. Тэгсэн би захьсан гээд хүн ирж урдуур орсоор миний урд арваад хүн орчихлоо. Тэр янзаараа байгаад байвал би хамгийн сүүлийн хүн болох дэгээ. Миний урд нэг хар царайтай аянчин байрын хүн байна, хоорондуураа хүн оруулахгүй гээд бүснээс нь тас зуурч орхилоо. Ажил цуглах цуг цаг болов бололтой хаалга нээлээ. Би номер хариугүй авах гэж байтал нөгөө Адъяа маань, өө би чамд номер авчихсан гээд 6 номер өгч байна. Захиалгаа өглөө. Манай дарга овъёос л авч болохгүй, бусдыг нь болно гэсэн гэлээ. Танай дарга хэн юм бэ гэж байна. Довгор гуай гэлээ. Тэр ах миний хүссэн бүх барааг бичиж өглөө. Ашгүй манайхан ч цөөхөн тэмээ аваад ирлээ. Эхлээд будаагаа авах юм боллоо. Будаа, гурилыг байшин шиг өндөрлөн хураачихсан байх юм, дороос аваад ачаад байлаа. Гэтэл нөгөө хураалттай будаа хэлтийгээд хариугүй нурж байна. Жанцан нэг будаа үүрчихсэн явж байна. Наад будаагаа хаяад зугтаагаарай гээд би ч тэмээ рүү гүйлээ. Гэтэл ойчиж орхилоо. Миний дээрээс хэдэн шуудай будаа дараад уначихжээ. Босох гэсэн нэг хөл хөндүүр гэж жигтэйхэн байна. Нөгөө Жанцангийн маань хамраас цус гарчихсан, шуудайтай будаан дунд хэвтэж байна. Манайхан будаагаа буулгаад Жанцанг нэг тэмээ унуулаад аваад явлаа. Миний хөл доголоод байна. Орой буусан газраа очвол нөгөө хөл маань хөрч байгаа гэж жигтэйхэн. Хөл маань хавдаж орхижээ. Арай чамай гэж ноцолдож байж, гутлаа нэг юм салгалаа. Манайхан миний хөлийг давстай өтгөн хар цайгаар шавшин, утаатай шар эсгийгээр боолоо. Тэгээд жингийн даамлын ямаан дэгтийг нөгөө хөлдөө углаад эрүүл хөлдөө нөгөө гоё нарийн цагаан эсгий гутлаа өмслөө. Манайхан дэгтийг баартаг гэгцгээнэ. Ингээд нэг хөлдөө баартагтай, нөгөө хөлдөө ганган цагаан эсгий гуталтай хүн явлаа даа. Хоноглох газраа давстай хар цайгаар нэмж шавшина.

Нутгийн зүг жингийн цуваа эргэлээ:

Нэг тэмээнд далан килийн 4 шуудай будаа гурил ачиж аваад нутгийн зүг эргэлээ. Яармагийн гүүрээр гарсан уурганы толгой хийх бургас байна. Жанцанг надад хэдэн уурганы толгой хийх бургас аваад өгөөч гэсэн, арваадыг аваад иржээ. Манай нутагт ямар бургас ургах биш, уурганы толгой гэдэг “нүдний гэм” билээ. Хэд хоноод миний хөл гишгихтэйгээ болов. Жанцан маань ч гайгүй, зүгээр боллоо. Хөлний хавдар харьж, би ч гутлаа өмслөө. Нэг хөлдөө баартагтай яваххаасаа жаахан ичээд байсан юм. Хайрхандулааны наана очоод би орхисон тэмээгээ сурахаар түрүүлээд явлаа. Нөгөө айл маань өвөлжөөндөө буучихаж нилээн зайтай аж. Олоод очлоо. Хэдэн уурганы толгой гадаа нь шидчихлээ. Ороод очсон дөрвөн ханатай

гэртэй, хэдэн бор хүүхэдтэй эхнэр нөхөр хоёр байна. Хэдэн ямаатай нэг бор гэртэй ядуувтар айл аж. Би нөгөө хажуугаас нь мэрсэн еэвэн, сарлаг чихрээ өглөө. Нөгөө эр маань сайхан зантай байна. Чиний тэмээний хөл гайгүй болсон, одоо бүр тэмээ болоод байгаа. Гэхдээ одоо авч явж болохгүй. Хавар ирж аваарай гэж байна.

Гэртээ ирлээ:

Аав ээж хоёр баярлаж байгаа гэж жигтэйхэн. “Сайн явна уу” гээд хоёулаа зоос гүйлгээд байж, “сайн яваа” гэсэн утгатай зоос буудаг байж. Би багийнхандаа баахан будаа, гурил өгнө гэж бодсон чинь, санаснаар болдоггүй ажээ. Сумын захиргаа хуваарилдаг юм байна. Сумын хоршоо, сумын захиргаа, эмнэлэг, дотуур байр аваад багуудад жаахан оногдлоо. Жинд явах гэдэг хэцүү ажлаас салж нэг амарлаа. Намайг хамгийн их санасан хүн эмээ маань байлаа. Жингээс ирж нэг амарлаа. Гэлээ ч гэсэн би ахиад хоёр жил дараалан жинд яваад дараа нь багийн дарга болж дэвшсэн билээ. Би МАХН-ын гишүүн боллоо. Миний ажил, амьдралын зам цаашаа өгсөж эхэлсэн билээ.

Эх сурвалж: Энэхүү түүхийг одоо Улаанбаатар хотын Сонгино хайрхан дүүргийн 17-р хорооны 34 Б байрны 5-р орцны 3 давхарт оршин суудаг 82 настай Ч.Шийрэвдорж гуай 2016 оны 9-р сарын 12 –нд ярьж өгснийг А.Цэрэнчулуун би бээр тэмдэглэн авсан билээ.

Ein Nomadenjunge

Damals, als ich noch klein war, schickten die Nomaden ihre Kinder nur ungern zur Schule. Aber ich hatte Glück: Mein Vater war in der Lage, mir das kyrillische Alphabet beizubringen und das Rechnen zu lehren.

Ich wurde Schüler

Im September 1945 kam ich dann auch erst mit 11 Jahren in die Grundschule unserer Kreisstadt “Bogd” im Bayankhongor Aimak. Dort kam ich einige Wochen zu spät zum Schuljahresbeginn. Ich wurde auf eine lange Bank hinter den Schülertischen gesetzt und musste das Alphabet abschreiben. Da ich die Buchstaben aber schon kannte, schrieb ich sie schnell und richtig. Endlich saß bei den anderen Schülern und schrieb das, was die anderen auch schreiben mussten. Im neuen Jahr wurde ich der beste Schüler und Klassensprecher. Damals war es wohl üblich, dass der beste Schüler Klassensprecher wurde.

Die Familie, die mich bei sich aufgenommen hatte, war sehr nett zu mir. Als ich in die zweite Klasse kam, musste diese nette Familie auf das Land ziehen und ich wurde bei der Familie von Jambal untergebracht, dem Chef des Ladens der Genossenschaft (Negdel). Da ich nun ja schon ein alter Schüler geworden war, konnte ich schon allein in die Kreisstadt reiten. Meine Mutter begleitete mich nun nicht mehr in die Kreisstadt. Ich sollte jetzt schon im Sommer meinen dünnen Pelzmantel mitnehmen, denn meine Mutter würde bis zu Wintersonnenwende nicht mehr in die Kreisstadt kommen. Meine

Sachen, Schulzeug, Aaruul und Milchrahm im Schafpansen waren sehr viel Gepäck geworden. Um mein Handgepäck klein zu halten, hatte ich meinen Pelzmantel gleich angezogen.

Ich kam zu dem Ger, wo ich das Schuljahr verbringen sollte. Doch niemand war zu Hause. Denn an diesem Tag fand das Naadamfest statt. Alle Stadtbewohner feierten auf dem Naadaamplatz. Meine Sachen legte ich auf das Ger-Dach und ging zum Naadaamplatz. Gerade fand der Ringkampf statt. Ein Mann in einem schönen grünen seidenen Mantel kam mir entgegen. Er sagte, "Du sollst gleich ringen". Ich erwiderte: "Nein, ich habe einen Pelzmantel an, ich schäme mich, so vor die Leuten zu treten". Er sagte "Das macht nicht, du sollst ringen, basta".

"Guck mal den an, er hat einen Pelzmantel an" flüsterte einer dem anderen. Sie guckten mich blöd an, als ob sie einen Hasen mit Hörnern gesehen hätten.

Auf dem Platz der Ringer stand ein Junge aus unserem Bag. Ich packte ihn gleich und warf ihn zu Boden. Mir wurde gesagt: "Nein, du sollst mit diesem Mann ringen". Da stand ein dicker Mann. Ich stieß ihn an und auch er fiel hin. Doch ich habe nicht damit gerechnet, dass dieser Mann der Bag-Vorsitzende war, eine Respektperson, die ein kleiner Nomadenjunge auf keinen Fall besiegen durfte. Schon schrie einer „Schiebung“, unser Bag-Vorsitzender wurde nicht regelgerecht besiegt. Alle beiden Siege wurden mir aberkannt. Herr Ayusch, der den Titel eines "Falke"n des Staates trug, war der Sieger im Ringen bei diesem Naadam geworden. Er errang später den Titel des Elefanten.

In jenem Jahr, bei dieser Familie, da habe ich viel gelernt. Im eiskalten Ger musste ich morgens als erster aufstehen und das Feuer im Ofen anmachen. Mit einer Axt und einer Kiepe ging ich jeden Tag zum Fluss um Eisklumpen zu holen, so viel, wie ich tragen konnte. Eisklumpen wurden aufgetaut und wurden als Trinkwasser benutzt.

Saxaulholz zerstückelte ich auch. Ich will nun erzählen, wie man das Saxaulholz in Stücke haut. Dazu legt man das eine Ende des Saxaulstammes quer auf einem Stein, das andere Ende legt man auf den Boden. Man wirft einen größeren Stein auf die lockere Stelle. Das Holz bricht dann durch. Würde man das harte Holz mit der Axt hacken, würde das kurze Ende des harten Holzes in die Luft wirbeln und könnte womöglich den Kopf verletzen. Deshalb benutzen die Gobi-Leute gewöhnlich zwei Steine um den Saxaul durchzubrechen.

Am Abend musste ich Teig kneten, diesen dann flach rollen und gleichmäßig in dünne Streifen schneiden. Meine Tagesarbeit war relativ viel. Dafür war meine Essensration recht überschaubar. Am Tag gab es etwas Huimag und am Abend eine Schale Nudelsuppe oder einen gekochten Hammeloberarm und ein Rippchen oder ähnliches.

Meine Mutter pflegt mich gesund

Als die Schule im Frühling beendete, kam meine Mutter mit einem Handkamel in die Kreisstadt und nahm mich nach Hause. Mir ging es im Frühjahr jenes Jahres nicht gut. Ein Auge war an grauem Star erkrankt, so dass ich auf diesem Auge nicht sehen konnte;

im Nacken hatte ich lauter Furunkel. Außerdem tat mir ein Bein weh und ich humpelte. Einen derart kranken Jungen brachte meine Mutter nach Hause. Der Vater meiner Mutter war ein lamaistischer Arzt im Kloster von Lamyn Gegeen. Er gab ihr ein Naturheilmittel "Pelden" gegen den grauen Star. Im Volksmund heißt es "gut aufbewahren, wie Pelden". Demnach musste es ein sehr wert volles Zeug gewesen sein.

Wenn ich mich recht erinnere, so war das Zeug klein wie ein Stuck von einer Hirse und hart wie Stein. Mit einem Stück Stoff auf das Auge gebunden, drückte es zuerst sehr unangenehm auf dem Auge. Nach einigen Tagen testete ich, ob ich mit dem erkrankten Augen etwas sehen konnte. Ich bemerkte das Licht der Sonne. Ich war froh und band das Auge wieder zu. Nach ein paar Tagen konnte ich mit dem geheilten Auge wieder gut sehen.

So hat Mutter mit jenem Pelden mein an grauem Star erkranktes Auge geheilt. Ich nahm zusätzlich das Medikament, das mir die Krankenschwester des medizinischen Stützpunkts gegeben hatte, trank Airag und Milch, aß Milchprodukte, und die frische Luft tat mir gut. Die Furunkel gingen weg, und mein Bein war gesund. Ich konnte wieder gut laufen. Die mongolische frische Luft und die ökologisch reinen Produkte taten ein Übriges.

Mein Vater war wandernder Händler in unserem Bag. Ich half ihm immer bei der Abrechnung. Ich konnte die Multiplikationstabelle auswendig. Auf dem chinesischen Abakus hatte ich die vier Grundrechenarten zu beherrschen gelernt.

Der Abakus

Auf diesem Abakus steht die Zahl 379,25. Der chinesische Abakus hat 13 Reihen, d. h. man kann mit 13-stelligen Zahlen rechnen. Er hat ein Trennholz in der Mitte auf der linken bzw. unteren Seite gibt es fünf Kugeln oder Steine und auf der rechten bzw. oberen Seite gibt es zwei Kugeln oder Steine. Eine Kugel auf der rechten Seite hat den Wert fünf. Wenn man den chinesischen Abakus gut beherrscht, kann man genau so schnell rechnen, wie auf einem Taschenrechner. Nicht um sonst gab es ein stolzes Sprichwort: "wenn meine Daumen nicht ermüden, und die Kugeln zum Rechnen nicht hängen bleiben wird, werde ich mich nicht verrechnen."

Ich werde Agent – der Wanderhändler

Vater hörte auf als Wanderhändler zu arbeiten. Mit meiner zweijährigen Schulbildung wurde ich Wanderhändler im vierten Bag des Sumons Bogd des Bezirkes Bayanhongor Aimak. Als solcher bekam ich monatlich fünfzig Tugrik Gehalt. Wenn bei der Abrechnung etwas fehlte, musste ich dafür gerade stehen und die Summe wurde mir abgezogen. Ich bekam Tee, Mehl, Reis, Hirse und Zucker aus dem Depot der Konsumgenossenschaft, brachte die Waren mit eigenen Kamelen zu den Nomaden im Bag und verkaufte sie dort. Damals, als ich Bag - Agent war, kosteten einige Lebensmittel auf dem Lande, wie folgt:

1 Stuck Ziegeltee	10,00₮
1 Kilogramm Zucker	4,00₮

1 Kilogramm Mehl I	1,60₮
1 Kilogramm Mehl II	1,00₮
1 Kilogramm Hirse	1,00₮
1 Kilogramm Reis	2,20₮

Gehälter in der Kreisverwaltung:

Chef der Kreisverwaltung	450,00₮
Sekretär der Gruppe der MRV Partei	450,00₮
Sekretär der Gruppe MRJ Verbandes	300,00₮
Chef des Gerichtes	500,00₮
Bag Chef	80,00₮
Bag - Wanderverkäufer	50,00₮

Ankaufpreise der Rohstoffe

1 Fuchsfell	21,00₮
1 Korsak Fuchsfell (Steppenfuchs)	6,00₮
1 Manula Fell (Wildkatze)	6,00₮
1 gefrorenes Steppenhuhn	1,50₮
1 gefrorenes Sandhuhn	1,50₮

Ich werde Kamelkarawanenführer

T. Nazagdorj schrieb im Jahre 1936
diesen Text zu einem Lied
Die jungen Karawanenführer
gleichmäßig schreitend bewältigt Ihr
den weiten Weg - meine Kamele
geduldig und tapfer meistert Ihr
jede Schwierigkeit - meine Kamele.
so zahlreich seid Ihr- meine Kamele
fern auf der Weide der Gobi.

Euer dunkles Brummen- meine Kamele
klingt wie der Höömi – Gesang meiner Heimat
steht aufrecht der Höcker meiner Kamele
so tragen sie die größte Last.
unübertroffen unsere Kamele,
die in der weiten Gobi weiden.

geduldig und kraftvoll

reiten die jungen Karawanenführer
Sie meistern mit Freude und frei
den weiten Weg der Karawane.
Last uns das Volk in der Heimat
mit allem Nötigen versorgen.

Unsere Nomaden im Bag hatten stets Mangel an Lebensmitteln Mehl, Reis, Tee und Salz. Sie lebten recht armselig. Die genannten Waren gab es oft nicht einmal im Depot der Genossenschaft.

Mir kam immer wieder die Idee in den Kopf, eine Kamelkarawane mit Rohstoffen nach Ulaanbaatar zu transportieren und eine Karawane voll Lebensmittel und Konsumgüter zurück zu bringen, um den Bedarf der Nomaden zu decken. Diese Idee meinem Vater zu erzählen, dazu fehlte mir aber irgendwie der Mut. Doch eines Tag fasste ich mir ein Herz und wollte meinem Vater den Plan erzählen. Doch er war sehr beschäftigt, saß vor dem Ger an der Wand aus Weidenruten und drehte Kamelhaarseile. So bat ich Mutter, es dem Vater zu sagen.

Mutter ging in den Ger und sagte es dem Vater. Er vergewisserte sich, dass ich das wirklich so meinte.. Er sagte lächelnd: "Mein Sohn wird nun ein richtiger Mann. Na, nun bleibt es nichts übrig als ihm zu helfen".

Unsere Familie besaß damals vierzig bis fünfzig Kamele. Ich freute mich riesig, als ich das Einverständnis meines Vater bekam.

Der Khom

Der Khom ist eine Vorrichtung aus Filz, Kamelhaarseilen und aus Holzstangen. Sie schützt den Rücken und die Flanken des Kamelkörpers vor Scheuern, Reiben und Verletzungen durch die Traglasten. Der Khom muss richtig angelegt sein. Den Khom richtig anlegen ist das A und O der Karawanenführer

Es war üblich, dass fünf Männer vier Karawanenzüge von insgesamt ungefähr 40 Kamelen voll beladen mit Tierwolle und Haaren zum Ziel führten. Unser Team des Karawanenzuges leitete ein erfahrener Herr namens Dovgor.

Ich hatte ungefähr zwanzig Kamele gemeinsam mit einem Mann, der älter und erfahrener als ich war. Die Wolle und Haare wurden in einem Jutesack gestopft und mit Seilen zu einem viereckigen Ballen zusammen gebunden. Ein solcher Ballen wog ungefähr 100 Kilogramm. Auf einem Kamel luden wir zwei solche Ballen; ein Kamel musste einschließlich des Packsattels also ungefähr 250 Kilogramm Last bewältigen.

Wie haben zwei Leute zwanzig Kamele geführt?

Der Karawanenführer hielt die Nasenleine des ersten Kamels in der Hand und ritt im gleichmäßigen langsamen Tempo. Diesem ersten Lastkamel rechts und links werden die Nasenleinen des ersten Kamels der in zwei Reihen nachfolgenden Kamele angebunden. Das erste Kamel, dessen Nasenleine der Karawanenführer in der Hand hielt,

musste das kleinste und jüngste Kamel sein, sonst können die anderen Kamele nicht den Schritt mithalten und wurden schnell müde.

Die Nasenleine jedes Kamels musste so locker am Packsattel des vor ihm gehenden Kamels angebunden sein, dass das Kamel im Laufen vom den Büschen am Wegesrand abbeißen konnte. Außerdem durfte die Leine nicht ganz festgebunden werden, so dass der Knoten beim starken Ziehen aufgehen konnte; sonst könnte die Nase des Kamels verletzt werden oder der Nasenpflock durchbrechen. Der zweite Mann folgte der Karawane und hatte die Aufgabe aufzupassen, ob sich ein Kamel aus der Reihe losriss oder irgend etwas von dem Gepäck der Karawane verloren ging.

Bei einigen Karawanen hingte man eine Glocke an den Hals des letzten Tieres der Karawane. Die gleichmäßige Klingeln der Glocke gab den Kamelen das Signal, immer weiter zu gehen und dem Führer das Zeichen, dass alles in Ordnung war, und kein Kamel sich losgerissen hatte.

Deshalb sollte man beim Anhalten der Karawanen die Glocke abnehmen, denn das Klingeln der Glocke gibt den Kamelen den Startbefehl. Die Reihenfolge der Tiere wurde während der ganzen Reise unverändert beibehalten.

Die verschiedenen Arten der Karawanenwanderung

Die Kamele wurden etwa zwei Wochen trainiert, das heißt, sie bekamen wenig zu fressen und wurden auf dem Ascheplatz angebunden. Die Reisetempo musste gleichmäßig sein. War es zu langsam, dann magerten die Kamele schnell ab. War es zu schnell, wurden die Schwielen wund. Welche Art und Weise des Karawanenzuges gewählt wurde, hing von der Stärke der Lasttiere, dem Gewicht der Ladung, der Nahrung und dem Wasser ab.

Die Fahrweise des Karawanenzuges war wie folgt:

1. Junge Khalch Methode,
2. Ältere Khalch Methode
3. Blauer Kharchin Methode
4. Kharchin Methode mit Mittagspause

Die Methode wurde am Anfang der Reise festgelegt und bis Ende der Reise durchgehalten.

1. Junge Khalch Methode

In der Nacht gegen dreiundzwanzig Uhr, wenn Orion und Siebengestirn im Südosten der Sternenhimmel zu sehen sind, wird aufgeladen und man marschiert die Nacht durch; bei Sonnenaufgang wird eine kurze Pause gemacht, die Kamele leeren die Harnblasen und die Menschen essen etwas. Am Nachmittag macht man Feierabend. Die Kamele werden abgeladen (der Khom bleibt bis zum Ende der Tour auf dem Kamelrücken) und auf die Weide gebracht, einer macht Essen, ein anderer prüft das Gepäck und der dritte kümmert sich um die Kamele. Vor dem Sonnenuntergang werden die Kamele

wieder von der Weide geholt. Die Männer schlafen abwechselnd und gegen dreiundzwanzig Uhr wird wieder aufgeladen und aufgebrochen. Der Tagesetappe dauert jeweils eine ganze Nacht und einen halben Tag, zirka achtzehn Stunden.

2. Ältere Khalch Methode

Bei dieser Methode bricht man mitten in der Nacht auf und kurz vor Sonnenuntergang wird Feierabend gemacht. Die Reise dauert einen ganzen Tag und eine halbe Nacht. Die Tagesetappe dauert zirka sechzehn Stunden.

3. Höch Kharchin Methode

Hier wird im Morgenrot Feierabend gemacht und gegen 11 Uhr am Vormittag wird aufgeladen und die Reise fortgesetzt. Die Tagesetappe dauert ungefähr siebzehn Stunden.

4. Kharchin Methode mit Mittagspause

Gegen Mitternacht wird Feierabend gemacht und bei Sonnenaufgang wieder aufgebrochen. Am Nachmittag gibt es eine Pause und es wird bis Mitternacht weiter marschiert. Die Etappe dauert jeweils ungefähr fünfzehn Stunden.

Unabhängig von der ausgewählten Methode gibt es bei Sonnenaufgang eine Pinkelpause. Die Kamele pinkeln einmal am Morgen, worauf man auch bei einer Reise achten soll. Die Aufforderung hierzu lautet „sheer, sheer“. Ein Kamelwallach braucht zirka dreißig Minuten um sein Blase zu entleeren...

Die Kamele werden am Morgen und am Vormittag getränkt.

Wir luden auf unserer Reise nach der Höch Kharchin Methode gegen elf Uhr Vormittages auf und setzten unsere Reise fort. Wir marschierten den ganzen Tag und die halbe Nacht. Bei Morgenrot machten wir Feierabend. Die Kamele und Menschen konnten sich erholen. Früh morgens brachte man die Kamele zum Tränken und Fressen. Gegen elf Uhr fingen wir wieder an, die Kamele zu beladen und brachen auf. Der Karawanentransport war keine leichte Arbeit, wie man sich leicht denken kann. Das war eine Arbeit, die viel Geduld und Ausdauer verlangte. Bei Regen und Schnee wurden die Seile steif und hart. Die Finger wurden wund. Man wurde müde und schläfrig. Tagsüber, auf dem Kamel schlief man unwillkürlich ein.

In der Nähe der Kreisstadt "Khairkhandulaan" mussten wir ein Kamel stehen lassen, es war an "Orooch" erkrankt, es konnte die beiden Hinterbeine nicht bewegen. Durch einen Aderlass kann man dies heilen, aber keiner von uns war dazu in der Lage. Ich bat einen alten Mann aus dieser Gegend, sich um das Kamel zu kümmern. Er aber sagte: "Hier gibt es Wölfe, wenn es von Wolf gefressen wird, übernehme ich keine Verantwortung".

Wir überquerten die Ebenen Arwain Tal, Gerliin Tal sowie den Paß Höshgiin dawaa. Zum Schluss folgten wir drei Tage lang dem Fluss Tuul. In vierzehn Tagen bewältigten wir diese Reise und kamen beim Flughafen auf den Hügel Buyant Ukhaa. Da war der Flughafen, wo einige kleine Flugzeuge „angebunden“ waren (parkten).

Für diese Strecke braucht man normalerweise sechzehn Tage, doch unser Chef war etwas zügiger geritten. Über den Fluss Tuul gab es zwei Holzbrücken gebaut. Die

hießen "Yarmag"-Brücken (Yarmag ist heute ein Stadtteil von Ulaanbaatar an der neuen Flughafenstraße).

Wir ritten über die südliche Brücke und kam ganz früh auf das Gelände des Industriekombinats um unsere Tierwolle und –haare abzuliefern. Dort waren schon viele Karawanen aus der Südgobi, die wohl schon am Vorabend angekommen waren.

Das Abladen der Wolle und Haare dauerte lange, und erst beim Einbruch der Dunkelheit waren wir mit der Arbeit fertig. Für die Kamele war es schwer. Sie können mit der schweren Last nicht lange stehen und versuchten, sich hinzuhocken. Die Wolle und Haare wurden auf eine großen Waage gelegt und Männer mit Eisenhaken nahmen die Ballen schnell weg. Wir hatten unsere liebe Not, rechtzeitig die Seile zu entfernen, die wir wieder brauchten. Zum Glück stimmten die Gewichtsangaben überein. Die Kamele hatten jetzt nur noch ein Fünftel der Last zu tragen und wir hatten die Hälfte unserer Arbeit hinter uns. Nun suchten wir ein Nachtlager. Wir übernachteten an einer Biegung des Flusses "Dund Gol" (Mittelfluss). Herr Dovgor ermahnte uns aufzupassen, dass kein Kamel sich losrisse und abhaute. Trotzdem war am frühen Morgen eines meiner zwanzig Kamele weg, der Nasenpflock war durchgebrochen.

Auf der Suche nach dem entlaufenen Kamel

Herr Dovgor war sehr aufgeregt und beschimpfte mich heftig: "was man nicht im Kopf hat, sieht man auch nicht" heißt es im Sprichwort. „Jetzt hast du zwei Kamele in der Kreide stehen". Der Morgentee ging mir nicht herunter. Ich ritt auf der Suche nach dem entlaufenen Kamel. Zuerst ritt ich in die Richtung, aus der wir gekommen waren. Ich ritt zum Yarmag. Andere Karawanenleute zogen zurück. Sie hatten zwei Reihen Kamele. Ich wollte alle Karawanenzüge durchsuchen und dabei die obere Brücke benutzen. Da stand ein Wächter mit einem Gewehr. Er sagte, dass ich die untere Brücke benutzen sollte. Ich musste wieder zurück. Die Karawanen waren schon fort. Ich beeilte mich und versuchte alle Karawanen durchzusuchen. Ich fragte nach dem Kamel, aber die Leute reagierten kaum auf meine Frage. „Was will denn der Junge?" fragten sie erstaunt einander. Den ganzen Tag über suchte ich. Erst bei Einbruch der Dunkelheit kehrte ich zurück, es war stockdunkel. Fast hätte ich außer dem entlaufenen Kamel auch unser Nachtlager nicht gefunden. Ab und zu kam mal ein Radfahrer und davor scheute mein Kamel, also ging ich zu Fuß. Hier und da hing am Straßenmast eine Lampe, aber das brachte nicht viel Licht. Glücklicherweise fand ich den Fluss. Von dort aus fand ich leicht zu unserem Lager. Der Chef war immer noch schlecht gelaunt. Ich trank etwas Tee und legte mich hin, um zu schlafen. Am nächsten Tag bat ich einen jungen Mann namens Janzan, mit mir das Kamel zu suchen. Er war einverstanden.

Dieses Mal ritten wir nach Osten, suchten und fragten danach. Südlich vom Kloster "Gandan" kehrten wir zurück. Wo heute das erste Wohnviertel ist, war damals ein Hof aus dünnen Kieferstangen. Darin waren Kamele anderer Karawanen angebunden. Drei junge Leute kamen heraus mit dunklen, sonnenverbrannten Gesichtern wie wir, also

ebenfalls Karawanenführer. Wir fragten nach unserem Kamel; sie behaupteten, es nicht gesehen zu haben. Ein alter Mann sonnenverbrannten, wettergegerbten Gesicht voller Falten saß am Hof. Wir beide ritten weiter, doch der Mann rief nach uns hinterher. Er sagte uns, beiden: "Wenn Ihr nach dem Kamel suchtet, solltet Ihr selber unter den Kamelen nachschauen – Fragen allein nützt wenig". Wir gingen in den Hof hinein. Mein Kamel stand angebunden, man hatte ihm einen neuen Nasenpflock verpasst und den Packsattel abgemacht. Dem alten Mann hatte ich viel zu danken. Aber wie sollte ich meinen Dank offenbaren, was sollte ich ihm geben? Das wieder gefundene Kamel konnte ich ihm nicht geben, die beiden Stiefel, die ich im Südlichen Khangai (in der Provinz Uvurkhangai) kaufte, konnte ich ihm auch nicht geben. Denn sie waren mein ganzer Stolz. Das Taschenmesser fiel mir ein, das ich immer mitnahm. Ich benutzte es beim Fleisch essen und Schnitzen der Nasenpflocke - wo immer ich es brauchen konnte. Ich gab es ihm und sagte: "Nehmen Sie es, das ist für Sie". Er freute sich sehr. Ich fragte woher er sei; „Aus Nariin Teel von Südlichen Khangai“ sagte er. Später bereute ich, nicht nach dem Namen gefragt zu haben. Wie wahr ist doch das Sprichwort: "die Besinnung eines Dummen kommt erst am Nachmittag". Als wir mit dem gefundenen Kamel zurückkam, freute sich der Chef sehr. Essen und Trinken schmeckten mir endlich wieder. Ich merkte erst jetzt, wie hungrig ich war.

Drei Tage in der Stadt

Der Chef unseres Teams ordnete folgendes ein: Ich als einziger Mann, der lesen und schreiben konnte, sollte in der Stadt bleiben. Nach dem Oktoberfesttagen sollte ich die Warenbestellung machen. „Ich werde dich zu meinem Bruder Luwsanwandan bringen und dort bleibst du ein paar Tage“. Der Chef sagte: "Mein Bruder ist ein hoch gebildeter Mann, Er spricht ständig mit dem Marschall. Neulich, als der Marschall aus dem Ausland zurück kam, brachte dieser ihm ein Schachspiel mit. Wir werden ein paar Tage unsere Kamele auf eine gute Weide bringen und ausruhen lassen". Das war dringend nötig dachte ich mir, denn die Kamele hatten am schwersten zu arbeiten. Der Chef brachte mich zur Familie Lunsanwandan; er selbst war nicht zu Hause, nur seine Frau mit den Kindern. Am Abend kam Herr Luwsanwandan nach Hause, ein dicker älterer Herr mit etwas Glatze. Er fragte seine Frau, wer der dunkle Junge sei. Bruder Dovgor habe ihn gebracht, antwortete seine Frau. Herr Luwsanwandan zeigte auf einen Kasten und fragte mich:

"Weißt du, wie das heißt?"

„Ja, ich weiß“.

"Was ist das?"

"Das ist ein Holzkasten".

Er lachte ganz amüsiert und sagte, das ist ein Radio. Er hatte daran irgend etwas gemacht und der Kasten fing an zu sprechen. Ein Mann konnte darin keinen Platz finden, ich ging, sah dahinten, keiner war zu sehen. Der Kasten sprach: "Die Lage in Korea ist

sehr schwer geworden. Da ist Krieg, der außerordentliche und bevollmächtigte Botschafter J. Sambuu muss im Wald leben."

Ich wusste nicht, wo Korea lag und wer Herr Sambuu war. Wenn sogar der Kasten das wusste, musste es nicht weit von der Stadt sein, so dachte ich mir.

Zwei bis drei Tage nutzte ich, um die Stadt kennenzulernen. Im Industriekombinat arbeiteten Mongolen, Russen, Chinesen und Japaner; die Russen fragten auf Mongolisch nach Tabak und Streichhölzern. Ich konnte keine anbieten, denn ich rauchte damals nicht. Die Menschen gingen in ein Haus, ich ging mit hinein, da wurde ein Film gezeigt, ich sah gern Filme an. Da saßen nur Russen, mit nackten Beinen und mit großen Fuchsmützen und Pelzkragen. Darin stank es entsetzlich. Dies konnte ich bald nicht mehr ertragen, Ich musste hinausgehen. Nun spürte ich Hunger. In einem Laden stand ein älterer Chinese und verkaufte Teigwaren und Kuchen. Es gab große, mittlere und kleine „Yeven“. Ich kaufte mir eine ganz große runde Kuchen„Yeven“, so groß wie der Deckel eines Kochtopfs. Es gab auch das Konfekt „Sarlag“, es war sehr nahrhaft. An dem Kuchen knabberte ich etwas, und aß einige Stück von den Süßigkeiten, nun spürte ich Durst. In einem Zimmer saßen einige Leute und tranken ein dunkles Zeug aus der Tasse und stellten sie immer wieder weg. Ich nahm einen Schluck aus einer Tasse, schmeckte ganz ungewöhnlich, eher ekelig als angenehm. Ich stellte die Tasse wieder hin, der Mann schimpfte mich heftig und schlug mich beinahe. Wer sollte jetzt noch davon trinken, wo du davon getrunken hast, sagte er. Bei uns, in jener Zeit, auf dem Land wäre es nicht so dramatisch aus der Tasse von jemandem zu kosten. Ich ging schnell heraus.

Das Abenteuer auf dem Lagerplatz des Zentrallagers

Nach den Oktoberfeiertagen ging ich zum zentralen Warenlager, um die Bestellungen zu machen. Ein eleganter Herr namens Adya aus dem Kreis Ulziit war da. Er fragte, ob ich meine Nummern bekommen habe. Er sagte: "Ohne Nummern geht es nicht, du sollst morgen früh kommen und deine Nummern bekommen". Am nächsten Morgen ging ich, um die Nummern zu holen. Es standen zwei, drei Leute da. Weitere Leute kamen und sagten: "Ich habe hier bestellt", "Ich habe ihm gesagt" und alle drängelten und alle stellten sich vor mich. Wenn so weiter ginge, würde ich sicherlich der letzte in der Schlange sein, der seine Nummern bekäme. Ich hielt mich an dem Deelgürtel des Vordermannes fest, damit keiner weiter sich durchdrängeln konnte. Der Mann, der vor mir stand, war auch einer aus dem Land. Das merkte ich an seinem braunen Gesicht. Als die Tür aufgemacht wurde, hatten die Leute ihre Nummern bekommen; doch als ich fast daran war, kam Herr Adya und sagte: "Du brauchst keine Nummer zu bekommen, ich habe für dich die Nummern schon bekommen". Als ich die Warenbestellung machte, fragte er mich:

"Welche Waren willst Du?". Ich erwiderte:

"Mein Chef sagte, ich soll alles nehmen außer Hafer".

"Wer ist dein Chef?".

"Herr Dovgor aus dem Kreis Ulziit". Er hatte mir dann alles gegeben, was ich wollte.

Bald kamen unsere Leute mit ein paar Kamelen. Zuerst luden wir den Reis auf. Die Reissäcke waren so hoch gestapelt, wie ein Haus. Wir nahmen sie immer von unten weg. Plötzlich kippte der ganze Stapel um und wir rannten schnell weg zu den Kamelen. Es ging alles so schnell. Herr Jantsan lag in Blut gebadet zwischen den Reissäcken, ich lag unter den Säcken. Der Knöchel eines Fußes tat kräftig weh, aber ich konnte gehen. Herrn Jantsan brachte man nach Hause. Wir luden unsere Waren auf und kamen zum Lager. Als ich zu unserem Lager kam, war mein Fuß eiskalt und ich konnte nicht laufen, da mein Fuß stark angeschwollen war. Mit großer Mühe zogen wir den einen Stiefel aus. Unsere Leute kochte starken schwarzen Tee mit reichlich Salz und mein Fuß wurde in warmem Tee gebadet und in nassen alte geräucherte Filzmatten gepackt. Dies Prozedur wurde jeden Abend wiederholt. Ich konnte an dem verletzten Fuß keinen Stiefel anziehen. So zog ich den Überziehstiefel aus Pelz unseres Chefs an. Solche Überziehstiefel aus Pelz nennt man bei uns "Baartag". So musste ich an einem Fuß einen eleganten Filzstiefel aus Schafwolle und an anderem Fuß einen hässlichen Baartag aus Pelz tragen.

Nach ein paar Tagen konnte ich wieder gehen, aber nur humpelnd. Herr Jantsan war auch wieder gesund geworden. Ich zog meinen eigenen Stiefel an, damit ich nicht ganz so hässlich aussah, denn an beiden Füßen hatte ich nun gleiche Stiefel an. Ich schämte mich nämlich mit dem Baartag zu laufen.

Die Karawane kehrt zurück

Jedes Kamel wurde mit vier Säcken Reis mit einem Gewicht von je 70 Kilogramm beladen. Als wir an der Brücke von Yarmag kamen, entdeckte ich dort Weiden am Fluss, die für das Vorderteil von Fangstangen geeignet waren. Ich hatte den Herrn Jantsan gebeten, für mich einige zu holen, und er besorgte etwa zehn Stück. Diese Vorderteile für Fangstangen waren bei uns sehr gefragt, Weiden wachsen bei uns nicht.

Vor der Kreisstadt Khairkhandulaan ritt ich voraus, um nach dem zurückgelassenem Kamel zu fragen. Der Mann, der mein Kamel beaufsichtigen sollte, war nun im Winterlager. Ein paar Weidenstücke warf ich bei ihm draußen hin, zu Hause waren der Mann, seine Frau und einige Kinder. Ein kleiner brauner Ger und ein paar Ziegen. Eine eher ärmliche Familie. Ich gab ihnen den Rest des Konfekts Sarlag und dem abknabberten Yeven. So hatte ich bei dem Mann „gut Wetter gemacht“. Er sagte:

“Dein Kamel geht es nun schon viel besser. Es weidet mit unserem Kamel. Aber jetzt kannst du es nicht mitnehmen, du kannst es erst im Frühling abholen”.

Ich komme nach Hause

Vater und Mutter freuten sich riesig, als ich nach Hause kam. Die beiden hatten immer Münzen geworfen. Und der daraus gewonnen Weissagung zufolge sollte es mir gut gehen. Das beruhigte meine Eltern.

Ich hatte mir so schön ausgemalt, wie ich unsere Bag Familien mit genügend Lebensmitteln versorgen würde. Doch weit gefehlt. Es geschah ganz anders, als ich gedacht hatte. Die Kreisverwaltung verteilte die Waren. Die Konsumgenossenschaft, die

Stadtverwaltung, Krankenhaus und Schulinternat mussten alle vorrangig beliefert werden. Die Bag Familien kamen als letzte dran.

Ich konnte mich von der schweren Karawanenarbeit etwas ausruhen und einige Tage schlief ich aus. Es war eine harte Arbeit und ich war froh, dass es vorbei war.

Trotzdem war ich auch in den folgenden zwei Jahren an den Karawanentransporten beteiligt. Dann wurde ich Bag-Vorsitzender. Ich wurde Mitglied der MRVP (Mongolische Revolutionäre Volkspartei). Damals gab es nur eine Partei in der Mongolei. Meine Karriere ging aufwärts und Ich wurde am letzten Ende Jurist.

Quellenhinweis:

Diese Geschichte erzählte mir der 82 jährige Herr Ch. Shiirevdorj am 12. September 2016.

Фү Лэй

ЗАХИДАЛ

Хятад хэлнээс орчуулсан Р.Оргил¹

1954 оны 1-р сарын 30 ний орой

Хайрт хүү минь ээ, чи гэрээсээ яваад дөнгөж хоёр хоног өнгөрөхөд л бид сэтгэл зовнин, чамайг санаж энэхүү захиаг бичиж сууна. Чамайг уурлуулж, гомдооё гэж огт бодсонгүй шүү. Гэхдээ нэг өдөр ч бүтэн нойртой унтаж чадахгүй, орондоо нааш цааш хөрвөөсөөр байгаад өглөөний 6-7 цагийн үед өөрийн эрхгүй сэрчих юм. Яагаад ингээд байгаагаа өөрөө ч сайн мэдэхгүй юм. Яг л Кристоферийн ээж гэртээ ганцаараа үлдээд хүүгийнхээ багын дүр төрхийг төсөөлөн боддог шиг. Чиний 2-3 наснаас 6-7 нас хүртэлх амьдралын хүнд хүчир, хатуу чанга замыг туулах энэхүү зовлон бэрхшээлийг ээж аав хоёр чинь үргэлж л бодон суудаг. Энэ зүйлийг чамд хичнээн удаа хэлье гэж бодсон ч сэтгэлийн зориг маань хэзээ ч хүрдэггүй. Чиний энэ нас бол хойшоо ухарч болохгүй, зөвхөн урагшаа тэмүүлэх, магадгүй бид нар чиний өлгийтэй байх үеийг дурсаж чамайг уурлуулж гомдоож болно.

Гэхдээ хүү минь, энэхүү аавынхан сэтгэл дотор минь шингэсэн чиний багын дүр төрхийг төсөөлөөд чиний талаар байнга яриад байгааг чи ойлгож байгаа байхаа, ээж нь ч гэсэн ойлгож байгаа, учир нь бүх л амьдралын турш бидний оюун бодолд чиний дүр төрх, зан араншин, үйл хөдөлгөөн нь төсөөлөгдөж, биднийг үргэлж баярлуулж, гомдоож гутрааж явдаг. Үнэндээ, чи гэртээ ирээд 1 жил хагас сар боллоо. Энэ бол бидний хамгийн баяр баясгалантай үе мөч, энэхүү баяр баясгалантай, жаргалтай үе мөчийг хаанаас ч ирээд олохгүй, шашин шүтлэггүй ч гэсэн бурхан багшдаа үнэхээр их баярламаар. Миний баярлаж байгаа зүйл бол миний хүү нас бие гүйцээд миний сайн найз боллоо. Хүү маань миний хамгийн сайн найз боллоо. Хорвоо ертөнц дээр байгаа ямар ч зүйл миний энэхүү аз жаргалтай яаж зүйрлүүлэх юм бэ! Хэдийгээр эцэг хүү хоёр хоорондоо уулзаж учрах нь багасаж, салж явах нь ихэссэн ч гэсэн, бидний оюун санаанд чиний дүр төрх үргэлж төсөөлөгдөж бидэнд дулаан уур амьсгал бэлэглэж, ганцаардаж зовохгүй байх юм шиг.

Гэхдээ чи намайг өндөр уулын орой дээр гарчхаад өөрийн санаж байгаа, үзэж харсан зүйлээ ярьж байна, бидний одоо үетэй нийцэхгүй гэж бодож магадгүй. Хүн хөгшрөхөөрөө урдаа байгаа зүйлээ илүү хол давж харах юм, олон зүйлийг чи бодохдоо таны харж байгаа зүйл бидний үеэс ондоо гэх байх л даа. Гэхдээ цаг хугацаа өнгөрөхөөр миний ярьсан зүйл чамд ямар ч буруу зүйл биш юм байна гэж бодогдох болно. Хүү минь, би чамаас олон зүйлийг сурч авсан, харин чи надаас сурсан зүйл бага байх гэж сэтгэл зовниж байна. Ялангуяа ойрын 3 жилдээ бодогдох

¹ МУИС, ШУС, ХУС-ын Гадаад хэлшинжлэлийн докторант

болсон, хүн болж төрсөн тэр үеэс л надад чи амьдралын гоё сайхныг мэдрүүлж, тэсвэр тэвчээр хатуужилтай болгож сургасан. Чамайг явсны дараа 2 дэх өдөр ээж нь уйлсан. Нүд нь улайж хавдаад хоёр өдөр болж байна. Гэхдээ үүнийг баяр, гунигийн нулимс гэж хэлэх байх л даа. Бид нар чамайг санаа зовчих болов уу гээд хэлэхгүй байж болох л байсан. Гэхдээ хүн гэдэг чинь сэтгэлийн амьтан учраас, хэзээд ч нулимс гаргасан энэ бол ичгүүртэй зүйл огтхон бишээ. Харин ч ээжийн чинь гаргаж байгаа энэхүү нүдний нулимс нь үүрд мөнхийн энэрэнгүй сэтгэл, ариун нандин хайрын дусал юм шүү.